



# МОНГОЛЫН МАЛ АЖ АХУЙН ИРЭЭДҮЙ

---

*Олон нийтийн санаа бодлыг тандах судалгаа*

Улаанбаатар хот  
2004 он

DDC  
636.084 5  
M-692

## НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамьян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,  
Монгол Улс  
Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб хуудас: <http://www.forum.mn>

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэхийг хүсвэл ННФ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна.

ISBN 99929-83-09-4

“BCI” компанид хэвлэв.  
Утас: 318632, 319032

## СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ТАНД ХҮРГЭХИЙН УЧИР

Нээлттэй Нийгэм Форум бодлогын судалгаа, шинжилгээний ач холбогдлыг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгынхоо хүрээнд 2003 – 2004 онд арав гаруй сэдэв сонгон ажиллаж байгаагийн нэг нь бэлчээрийн мал аж ахуйн хөгжилтэй холбоотой болой. Бэлчээрийн мал аж ахуй Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд цаашид хэрхэн хөгжиж болох, малчдын хувьд амьжиргаагаа зохих түвшинд авч явах ямар хувилбарууд байж болох, сонголт байгаа нөхцөлд Монголчууд уламжлалт амьдралын энэ хэв маягаа хадгалсаар байх эсэх, малчин өрхийн аж ахуйг амиа аргацаасан байдлаас хэрхэн гаргаж үйлдвэрлэл болгож хөгжүүлэх зэрэг асуудлыг хөндсөн хэд хэдэн судалгаа хийсний нэг нь уншигч Танаа толилуулж буй “Монголын бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй” хэмээх олон нийтийн санаа бодлыг тандах судалгаа болно.


Судалгааны зорилго нь мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлагын талаарх олон нийтийн санаа бодлыг судлахад чиглэгдсэн бөгөөд судалгаанаас малчдын хүсэл эрмэлзэл, эрэлт хэрэгцээ, гэдэнд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, түүнээс гарах арга зам, ирээдүйгээ хэрхэн харж байгаатай танилцаж болно. Эл судалгааг бодлого боловсруулах үйл явцад оролцогч бүхий л талууд болох бодлого боловсруулагчид, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, судлаачид, оюутан сурагчид, Монголд хандивлагчид зэрэг тухайн сэдвийг сонирхсон хэн бүхэнд зориулан хэвлэж байна.

Судалгаанд зөвхөн малчид төдийгүй мөн мал аж ахуйн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж яваа мал аж ахуйн салбарын мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид мөн оролцсон юм.

Нээлттэй Нийгэм Форумын захиалгыг амжилттай гүйцэтгэж энэ судалгааны дүнг Танд хүргэх бололцоо олгосон Л. Эрхэмбаяр ахлагчтай Монголын эрчимжсэн хөдөө аж ахуйн Агро-Дэвшил холбооны хамт олонд талархлаа илэрхийлье.

Энэхүү судалгааны чанар, агуулгатай холбоотой санал хүсэлтийг [osf@Soros.org.mn](mailto:osf@ Soros.org.mn) хаягаар бид дуртайяа хүлээн авах болно.

П. Эрдэнэжаргал



Нээлттэй Нийгэм Форумын  
Гүйцэтгэх захирал

## О Р Ш И Л

Хөдөө аж ахуйн салбар нь тухайн жилийн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан манай улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 20.7-30 хүртэл хувийг үйлдвэрлэдэг бөгөөд түүний дотор мал аж ахуйн үйлдвэрлэл нь 2002 оны байдлаар хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүний 79.9<sup>1</sup> хувийг, экспортын нийт бүтээгдэхүүний 30 гаруй хувийг тус тус бүрдүүлсэн байна.

Мал аж ахуйн салбар нь хүн амыг мах, сүү, цагаан идээ зэрэг хүнсний бүтээгдэхүүнээр, боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах үндсэн эх булаг болохын зэрэгцээ энэ салбарт тус улсын нийт хөдөлмөрийн насны хүн амын 30 орчим хувь буюу 389.8 мянган<sup>2</sup> хүн ажиллаж амьдарч байна.

Ийм ч учраас мал аж ахуйн салбар, тэнд ажиллагсдын нийгмийн асуудал нь Монгол Улсын Засгийн газар болон хандивлагч улс орон, олон улсын байгууллагын анхаарлын төвд байсаар байна.

“Монголын мал аж ахуйн ирээдүй” сэдэвт энэхүү судалгааны ажлын тайлан нь мал аж ахуйн салбарын ирээдүйн хөгжил, малчдын амьжиргааны талаар бодлого, шийдвэр гаргах, бодлогыг хэрэгжүүлэх, судалгаа, шинжилгээ хийх байгууллага, хувь хүн хэнд ч болов уг салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, малчдын санаа бодлын талаар бодит мэдээлэл өгч чадвал захиалагч болон гүйцэтгэгчийн үндсэн зорилго хангагдах юм.

“Монголын мал аж ахуйн ирээдүй” сэдэвт судалгааны ажил нь малчид өөрсдийнхөө амьжиргааны түвшинг хэрхэн үнэлж, ирээдүйгээ хэрхэн төсөөлж байгаа, малчдад тулгарч буй хамгийн бэрхшээлтэй асуудлууд, нэн тэргүүний нийгэм, ахуйн болон, үйлдвэрлэлийн хэрэгцээ юу болох, мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр, засгаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар малчид ямар санаа бодолтой байгаа, малчдын сэтгэл түгшээж санаа зовоосон асуудлууд юу болох, малчин өрхийн орлогын байдал, тэдний мал маллаж байгаадаа сэтгэл ханамжтай байдаг эсэх, мал маллахаас өөрөөр амьдрах бодол, хүсэл эрмэлзэл байгаа эсэх, амьжиргааны өөр сонголт хийх бодолтой байгаа бол түүнийгээ хэрэгжүүлэхэд юу саад болж байгаа, мал аж ахуйг хөгжүүлэхийн тулд юу хийж хэрэгжүүлэх ёстой гэж үзэж байгаа зэрэг олон асуудлыг малчид болон орон нутгийн удирдах ажилтан, мал аж ахуйн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан нарын саналд тулгуурлан судалж уншигчдад хүргэж байгаагаараа өвөрмөц, шинэлэг ажил болсон гэж судалгааны багийнхан үзэж байгаа болно.

Цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хөгжүүлэх талаар төрийн болон холбогдох бусад байгууллагаас бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд малчдын санаа бодлыг судалсан энэхүү судалгааны ажлын дүн чухал гарын авлага болно гэж үзэж байна.

“Монголын мал аж ахуйн ирээдүй” судалгааны ажлыг санаачилж, санхүүжүүлж, хэвлэх боломж олгосон Монголын нээлттэй нийгэм хүрээлэнгийн Нээлттэй нийгэм форумд гүн талархал илэрхийлье.

<sup>1</sup> Статистикийн бюллетень, 2003 он, № 12.

<sup>2</sup> Мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогын дүн, УСГ, 2003.04.01.

Нээлттэй нийгэм форумын “Монголын мал аж ахуйн ирээдүй” судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн Монголын Эрчимжсэн Хөдөө аж ахуйн “Агро Дэвшил” холбооны судлаачдын баг:

Равдангийн Санжаатогтох /доктор, проф./	Зөвлөх
Ломбын Эрхэмбаяр /докторант/	Төслийн удирдагч
Санжаагийн Гомбо /доктор (Ph.D.) проф./	Судлаач
Агипарын Бакей /доктор (Ph.D.) проф./	Судлаач
Жамбалдоржийн Уртнасан /доктор (Ph.D.)/	Судлаач
Цэвэгдоржийн Болд /магистр/	Судлаач
Уртнасангийн Туул	Судлаач
Балын Тунгалаг	Судлаач
Д.Амарсайхан	Судлаач
Ж.Мөнхжаргал	Судлаач
Д.Кадирбек	Судлаач
<b>Хянан тохиолдуулсан:</b>	Ц.Гомбосүрэн
	Б.Мөнхсоёл



Г А Р Ч И Г

<b>О Р Ш И Л</b> .....	4
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: МОНГОЛЫН МАЛ АЖ АХУЙН ИРЭЭДҮЙ</b>	
<b>СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ</b> .....	9
1.1. Судалгааны үндэслэл .....	9
1.2. Судалгааны зорилго .....	10
1.3. Судалгааны зорилт .....	10
1.4. Судалгааны арга зүй .....	12
1.4.1. Судалгааны арга .....	12
1.4.2. Судалгаанд баримталсан зарчим .....	12
1.4.3. Судалгааны объект .....	14
1.4.4. Судалгааны ажлын хэмжээ .....	15
1.4.5. Судалгааны төлөөлөх чадвар .....	16
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ: МАЛ АЖ АХУЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....	18
2.1. Мал аж ахуй монгол орны эдийн засгийн гол салбар болох нь .....	18
2.2. Малын тоо толгойн өөрчлөлт, сүргийн бүтэц, байршил .....	19
2.3. Мал аж ахуйн салбарт олон улсын байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлсэн ажил .....	22
2.4. Мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр, засгаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, малчдын санаа бодол .....	26
2.4.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрх зүйн орчин, малчдын санаа, бодол .....	26
2.4.2. Мал аж ахуй дахь хууль, эрх зүйн орчинг сайжруулах талаарх малчдын санаа, бодол .....	28
2.4.3. Засгийн газраас мал аж ахуйг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх малчдын бодол .....	32
2.5. Мал эмнэлэг, үржлийн ажлын өнөөгийн байдал, цаашдын хандлага .....	33
2.6. Мал маллагааны технологи .....	35
2.7. Малын тэжээл үйлдвэрлэл .....	36
2.8. Дүгнэлт .....	37
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ: БЭЛЧЭЭР, ХАШАА, ХУДГИЙН ХАНГАМЖ, АШИГЛАЛТ</b> .....	39
3.1. Бэлчээр, худаг ус, хашаа хороо, хадлангийн талбайн хүрэлцээний талаарх малчдын санаа бодол .....	39
3.2. Бэлчээр ашиглах, эзэмших баталгааны талаарх малчдын бодол .....	42
3.3. Бэлчээрийн маргаан .....	42
3.4. Бэлчээрийг эзэмших, ашиглах, өмчлөх талаарх малчид, иргэдийн бодол .....	43
3.5. Дүгнэлт .....	44
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, ЦААШДЫН ХАНДЛАГА</b> .....	46
4.1. Хөдөлмөрийн бүтээмжийн өнөөгийн байдал .....	46
4.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх цаашдын хандлага .....	48
4.3. Дүгнэлт .....	49
<b>ТАВДУГААР БҮЛЭГ: БАЙГАЛЬ, ЦАГ УУР БА МАЛ АЖ АХУЙ</b> .....	50
5.1. Байгаль, цаг уурын төлөв байдал мал аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлөх нь .....	50
5.2. Байгаль, цаг уурын өөрчлөлтийн талаарх малчдын санал бодол .....	54
5.3. Дүгнэлт .....	55
<b>ЗУРГАДУГААР БҮЛЭГ: МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ СААД БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙГ ДАВАН ТУУЛАХ ТАЛААРХ МАЛЧДЫН САНАА БОДОЛ</b> ...	56
6.1. Мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хүнд хүчир ажил .....	56
6.2. Мал аж ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаарх малчдын бодол .....	61
6.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөлмөр, хөрөнгөө хоршиж ажиллах асуудал .....	62
6.4. Малчдын санааг зовоож буй асуудлууд .....	66
6.5. Дүгнэлт .....	68

<b>ДОЛООДУГААР БҮЛЭГ: МАЛЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ</b> .....	70
7.1. Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл ханамжтай байдаг эсэх .....	70
7.1.1. Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаагийн шалтгаан .....	71
7.1.2. Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаагийн шалтгаан .....	75
7.2. Малчид өөрсдийнхөө амьжиргааны түвшинг үнэлсэн нь .....	78
7.3. Төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний талаарх малчдын сэтгэл ханамж .....	80
7.4. Дүгнэлт .....	82
<b>НАЙМДУГААР БҮЛЭГ: МАЛЧИН ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА</b> .....	84
8.1. Малчин өрхийн орлого, түүний эх үүсвэр .....	84
8.2. Малчин өрхийн зарлага, түүний бүтэц .....	86
8.3. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулах зах зээл .....	90
8.4. Дүгнэлт .....	91
<b>ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: МАЛЧДЫН ЭН ТЭРГҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ</b> .....	93
9.1. Малчин өрхийн ахуйн хэрэгцээ .....	93
9.2. Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээ .....	96
9.3. Малчдын нийгмийн үйлчилгээний хэрэгцээ .....	98
9.4. Дүгнэлт .....	101
<b>АРАВДУГААР БҮЛЭГ: МАЛ АЖ АХУЙГ ЭРХЛЭХ АРГА, ХЭЛБЭРИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ</b> .....	102
10.1. Мал аж ахуйн эрчимжилт .....	102
10.2. Мал аж ахуйн даатгал .....	106
10.3. Мал аж ахуйн төрөлжилт .....	108
10.4. Дүгнэлт .....	108
<b>АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ: АМЬЖИРГААНЫ ТАЛААРХ МАЛЧДЫН САНАЛ, БОДОЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ</b> .....	109
11.1. Малчдын амьжиргааны түвшний өөрчлөлт .....	109
11.2. Мал маллахаас өөр амьжиргааны сонголтын талаарх малчдын ойлголт .....	111
11.3. Малчдын амьжиргааг сайжруулах, орлого нэмэгдүүлэх талаарх иргэдийн бодол .....	113
11.4. Хүүхдийнхээ ирээдүйн талаарх малчдын бодол .....	118
11.5. Малчдын ойрын ирээдүйн зорилт .....	119
11.6. Дүгнэлт .....	121
<b>АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ</b> .....	123
12.1. Монгол орны мал аж ахуйн өнөөгийн байдал .....	123
12.2. Бэлчээр, хашаа, худгийн эзэмшилт, ашиглалтын талаарх олон нийтийн санаа бодол .....	123
12.3. Мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн бүтээмж .....	124
12.4. Мал аж ахуй эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийн талаарх малчдын санаа бодол .....	124
12.5. Малчдын сэтгэл хангалуун байгаа эсэх .....	124
12.6. Малчин өрхийн орлого, зарлага .....	125
12.7. Малчдын хэрэгцээ .....	126
12.8. Малчдын цаашдын зорилт .....	126
<b>АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ: САНАЛ, ЗӨВЛӨМЖ</b> .....	127
<b>НОМ ЗҮЙД ХАМРАГДСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ</b> .....	130
Интернэт эх сурвалж .....	132
Хавсралт хүснэгтүүд .....	133
Хуулийн лавлагааны хавсралт .....	144



### “МОНГОЛЫН МАЛ АЖ АХУЙН ИРЭЭДИЙ” СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж, нэгдэл, сангийн аж ахуй алга болж, малыг малчдад хувьчилснаар эдийн засгийн чадавх сул, амиа аргацаасан 190 мянга гаруй хот айл үүсч бий болов. Хот айлууд нь хадлан тэжээл, хашаа хороо, отор нүүдэл зэрэг мал аж ахуйнхүнд хүчир боловч амин чухал ажлыг бусдын оролцоогүйгээр бие даан шийдвэрлэх сэтгэл зүйн бэлтгэл сул, эдийн засгийн чадавх дорой байлаа. Энэхүү шилжилтийн үе эхлээд 13 жил өнгөрч байгаа боловч мал бүхий иргэд зах зээлийн шинэ нөхцөл байдалд хэрхэн зохицож ажиллаж, амьдарч байгаа, тэдний сэтгэл зүйн болон эдийн засгийн чадавх хэрхэн өөрчлөгдөж буйг судалж тогтоосон судалгаа үгүйлэгдэж байна.

Эрчимжсэн мал аж ахуйн зарим үүсгэл болох саалийн механикжсан ферм, цэвэр үүлдрийн өндөр ашиг шимтэй мал, гахай, шувууны аж ахуй нь зах зээлийн нөхцөлд зохицон ажиллах туршлагагүй, эдийн засгийн чадамжгүй нэгж, хамт олонд /хоршоо, компани/ шилжиж очсоноор өмч хөрөнгө эзэндээ ойртох бус харин ч эзэнгүйдэж, үндсэндээ устаж үгүй болов. Малын үүлдэр угсааг сайжруулах, нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэх, малын тэжээлийн хангамжийг сайжруулах асуудлууд нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөлд шинээр шийдвэрлэгдэх болов. Мал аж ахуйг хэрхэн яаж эрчимжүүлэх, энэ салбарт ажиллаж буй малчдын санаа бодол ямар байгааг судлах асуудал чухлаар тавигдах болов.

Даяаршил, мэдээлэл, харилцаа холбооны хөгжил, өмч хувьчлал, малыг малчдад өгсөн зэрэг нийгэмд гарсан өөрчлөлт нь малчдын оюун санаа, сэтгэлгээний хэв загвар, ахуй амьдралд гүн гүнзгий өөрчлөлт оруулав.

Монгол орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр хүмүүсийн амьдралд шинэ хэрэгцээг /цахилгаан, телевиз, машин техник, гар утас, гоо сайхан, хүнсний шинэ хэрэглээ, мэдээлэл авах гэх мэт/ бий болгов. Ийм нөхцөлд амиа аргацаасан мал аж ахуй эрхлэх нь хүний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээ, хэрэгцээг хангаж чадах уу, үгүй юу, ялангуяа 200-гаас доош толгой малтай, нийт малчин өрхийн 88 хувийг төлөөлөх<sup>3</sup> хүмүүс цаашид мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлээд дунд буюу дундаас дээш амьдралтай болох ирээдүй байна уу, байхгүй бол тэд юу хийх вэ, тэд цаашид амьжиргааны өөр сонголтыг хүсэж байна уу, үгүй юу зэрэг шинэ асуудлууд урган гарч ирэх болов.

Малчид боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж хомс байгаа нь статистикийн тоо баримтаар нотлогдож байна. 2000-2002 оны байдлаар хөдөө орон нутагт эхийн эндэгдэл хотынхоос 2 дахин, нярайн эндэгдэл 46 хувиар, 0-5 насны хүүхдийн эндэгдэл 39 хувиар тус тус их байна. Ихэнх сум, багийн түвшинд хүүхдүүдийн гадаад хэл, компьютерийн мэдлэгийн түвшин туйлын хангалтгүй, багшлах боловсон хүчин дутагдалтай байдгийн дээр 329 сумын 40 гаруй хувь нь төвлөрсөн эрчим хүчний тогтвортой эх үүсвэрт холбогдоогүй байна. Малчдын сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалах тогтолцооны хоцрогдлыг хэрхэн шийдвэрлэх асуудал бүрхэг хэвээр байна.

Малчдын хөдөлмөрийн бүтээмжийн асуудал судалбал зохих асуудлын нэг болсон гэж үзэж байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн

#### 1.1. Судалгааны їндэслэл

<sup>3</sup> “Малтэжээвэр амьтад, тэжээлийн тооллогын дүн”, УСГ, 2003.04.01.

эдийн засагт шилжсэн 10 гаруй жилийн хугацаанд малчны тоо нэмэгдэж, хөдөлмөрийн чадвартай нэг малчинд ногдох малын тоо багасах хандлагатай болсныг тодруулан судлах шаардлагатай болсон байна.

Хандивлагчдаас Монгол Улсын мал аж ахуйн салбарт оруулсан хөрөнгө оруулалт, дэмжлэг туслалцааны хэмжээ, тэдгээрийн үр өгөөжийн талаарх малчдын мэдлэг, мэдээлэл, санаа бодлын тухай судалгаа үгүйлэгдэж байна. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хөдөөгийн ядуурлыг бууруулах, хөдөөгийн хөгжлийг дэмжих чиглэлээр НҮБ, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, ТАСИС, Европын Холбоо, Азийн Хөгжлийн Банк зэрэг олон улсын байгууллагууд, АНУ, Япон зэрэг хандивлагч орнууд ихээхэн хөрөнгө зарцуулсан боловч тэдгээрийн үр дүнгийн талаар малчдын санаа бодлыг судалж тогтоосон мэдээлэл дутагдалтай байна.

Нээлттэй Нийгэм Форумас Монгол орны мал аж ахуйн салбарт бий болсон дээрх тулгамдсан асуудлуудыг анхааран үзэж “МОНГОЛЫН МАЛАЖ АХУЙН ИРЭЭДҮЙ” сэдэвт судалгааны ажил хэрэгжүүлж байгаа нь цаг үеэ олсон чухал шийдвэр болсон юм.

Мал аж ахуйн хөгжлийн өнөө ба ирээдүйн асуудлыг судлах ажлыг юуны өмнө малчид, орон нутгийн удирдах ажилтан, мал аж ахуйн мэргэжилтэн, эрдэмтдийн санаа бодлыг судлахаас эхлэх ёстой гэж манай судалгааны баг үзсэн болно.

## 1.2. Судалгааны зорилго

Монгол орны мал аж ахуйн өнөөгийн бодит байдал, түүний ирээдүйн хөгжлийн талаар нийгмийн янз бүрийн давхаргын төлөөлөгчид, ялангуяа малчдын санаа бодлыг судлах, уг судалгааны дүнг мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр, засгаас хэрэгжүүлж буй эрх зүйн болон эдийн засгийн бодлого, хандивлагч улс орон, олон улсын байгууллагуудаас үзүүлж байгаа зээл, тусламжтай харьцуулан судлах, эцэст нь мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд ашиглах бодит мэдээлэл, санал, зөвлөмжийг гаргаж тавих нь уг төслийн зорилго байв.

## 1.3. Судалгааны зорилт

Төслийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тавьж тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, учир шалтгааныг нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх аргыг хэрэглэж үнэлэлт дүгнэлт, санал зөвлөмжийг гаргасан болно. Зорилтыг иргэд, малчдын нас, дадлага туршлага, боловсрол, малын тоо, амьдралын түвшин, байгаль, цаг уур, эдийн засгийн бүс, байршил зэрэг нөлөөлөх үндсэн үзүүлэлтүүдтэй /цаашид нөлөөлөх үндсэн үзүүлэлтүүд гэх/ холбон авч үзэж судалсан бөгөөд тийнхүү тодорхой ялгаатай байдлаар судалгааны дүнг тайланд тусгасан болно.

### 1.3.1. Бэлчээрийн мал аж ахуйн өнөөгийн байдал

Мал аж ахуйн салбар Монгол орны эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа, мал аж ахуйг хөгжүүлэх талаар Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, олон улсын байгууллагуудын оролцоо, малын арчилгаа маллагаа, тэжээлийн үйлдвэрлэл, мал эмнэлэг, үржлийн ажлын өнөөгийн байдал зэргийг малчдын санаа бодол, хоёрдогч мэдээлэлтэй харьцуулан судлав.

### 1.3.2. Өмчийн харилцааны гол объект-бэлчээр, хашаа, худгийн эзэмшил

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн өмчийн харилцааны гол объект болсон бэлчээр, хашаа, худгийг эзэмшиж, ашиглаж байгаа өнөөгийн байдал, цаашид

шийдвэрлэвэл зохих асуудлуудын талаар малчдын санаа бодлыг судалж, цаашдын чиг хандлагын талаар санал, зөвлөмж гаргав.

**1.3.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөр зохион байгуулалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлох**

Энэ зорилтын хүрээнд малчдын өнөөгийн хөдөлмөрийн бүтэээмж, нэг хүнд ногдох малын тоо толгой, хөдөлмөрийн бүтэээмжийн үр ашиг зэрэг үзүүлэлтийг тооцож тодорхойлов.

**1.3.4. Хууль, эрх зүйн орчныг сайжруулах талаарх малчдын санаа бодол**

Энэ зорилтын хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлд үйлчилж байгаа хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт болон цаашид хууль, эрх зүйн ямар орчинг малчид хүсч байгаа талаарх малчдын санал бодлыг эмхтгэн дүгнэв.

**1.3.5. Байгаль, цаг уурын эрс өөрчлөлт ба мал аж ахуй**

Байгаль, цаг уурын эрс өөрчлөлтүүдтэй холбогдож бэлчээрийн бүтэц, ургамлын бүлгэмдэл өөрчлөгдсөн эсэх, өөрчлөгдсөн бол мал аж ахуйн үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө, бэлчээрийн бүтэц, бүлгэмдлийн өөрчлөлтийн талаарх малчдын санаа бодол, эрдэмтдийн ажиглалт, дүгнэлтийг судалж тогтоов. Үүнд ойрын 40 жилийн цаг уурын өөрчлөлтийн тойм судалгааг цаг уурын бүс бүслүүрээр гаргасан болно.

**1.3.6. Мал аж ахуй эрхлэхэд тулгарч буй саад, бэрхшээлийг тодорхойлох**

Энэ зорилтын хүрээнд мал аж ахуйн хүнд хүчир хөдөлмөр, түүнийг хөнгөвчлөх боломжийн талаарх малчдын санаа бодлыг судлав. Тухайлбал, бэлчээр ашиглалт, өвс тэжээлийн хангамж, хашаа хороо, уст цэг, малын ашиг шим, үүлдэрлэг байдал, төл бойжилт, бүтээгдэхүүн борлуулах ажилд гарч байгаа бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх боломж зэрэг асуудлыг энэ зорилтын хүрээнд багтаан үзсэн болно.

**1.3.7. Малчдын сэтгэл ханамжийг судлах**

Малчин хүний сэтгэл ханамжийг мал аж ахуйн үйл ажиллагааны болон ахуй амьдралын, нийгмийн үйлчилгээний гэсэн гурван хэсэгт хувааж судлав. Энэхүү зорилтын хүрээнд малчид өөрсдийн эрхлэж байгаа хөдөлмөр болон амьдарч буй ахуй орчин, нийгмээс үзүүлж буй үйлчилгээнд хэр зэрэг сэтгэл хангалуун байгааг тодорхойлохыг хичээв. Энэхүү мэдээлэл нь цаашид мал аж ахуйн салбарыг хэрхэн хөгжүүлэх асуудлаар шийдвэр гаргахад ашиглах үнэтэй баримт материал болох ёстой.

**1.3.8. Малчдын орлого, зарлагын индсэн болон бусад эх ийсвэр, орлогын талаар малчдын санаа бодлыг судлан тогтоох**

Энэ асуудлын хүрээнд малчид орлого, зарлагын өнөөгийн байдалдаа сэтгэл ханамжтай байгаа эсэхийг тэдний орлогын түвшин, нэн тэргүүнд шаардлагатай гэж үзэж байгаа хэрэгцээтэй нь /хүүхдийн сургалтын төлбөр, цахилгааны эх үүсгүүр, машин техник авах гэх мэт/ харьцуулан судлав.

**1.3.9. Малчдын хісэн хілээж буй хэрэгцээ, шаардлагын эрэмбэ тогтоох**

Хүсэн хүлээж буй хэрэгцээг дотор нь мал аж ахуйн үйл ажиллагаа, амьдрал ахуйн орчин, нийгмийн харилцаа /эмнэлэг, сургууль, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо/, хууль, эрх зүйн орчин гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлов. Судалгаа хийхдээ дэд бүтэц, зах зээлийн орчин, хоршоо, өрх, хот айлын аж ахуй байдал зэргийг харгалзан үзсэн болно. Энэхүү зорилтыг хэрэгжүүлснээр малчдын нэн төргүүнд хүсэн хүлээж байгаа хэрэгцээг эрэмбэлэн тодорхойлсон болно.

**1.3.10. Мал аж ахуйг эрхлэх оновчтой хэлбэр**

Энэ асуудлын хүрээнд мал аж ахуйг эрхлэн хөтөлж байгаа одоогийн систем, түүнийг боловсронгуй болгох, мал сүргийн даатгалын талаар малчид, нийгмийн давхаргын санаа бодлыг тодорхойлов.

**1.3.11. Малчдын амьжиргааны талаарх ард иргэдийн болон малчдын еерсдийн бодол, тэдний ойрын ирээдүйн зорилт**

Энэ зорилтын хүрээнд малчид амьжиргаагаа сайжруулах, орлогын шинэ эх үүсвэр хайх, туслах аж ахуй, нэмэлт бизнес хийх талаар ямар бодолтой байгаа, хөдөөд орлого олох бусад ямар боломжууд байж болох түүнийг малчид хэрхэн ашиглаж байгаа, малчид үр хүүхдээ ямар мэргэжил, боловсролтой болгох бодолтой байгаа зэрэг асуудлыг багтаав. Түүнчлэн энэ зорилтын хүрээнд “Малчид цаашид малаа малласаар байх уу?”, “Амьжиргааны өөр сонголттой нөхцөлд малчид мал аж ахуйгаа орхих уу?”, “Малчдын ойрын ирээдүйн зорилт /1-2,5 жилээр/” гэсэн асуултад хариу өгөв.

**1.4. Судалгааны арга зүй**

**1.4.1. Судалгааны арга**

Тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд судалгааны дараах аргуудыг хэрэглэв. Үүнд:

1. Асуулгын арга
2. Фокус групп ярилцлагын арга

Санамсаргүй түүврийн аргаар цуглуулсан мэдээлэлд SPSS программаар боловсруулалт хийв. Судалгаагаар цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийх үед социологийн судалгаанд оролцсон малчдын цөөн хэсэг нь асуулгад хариулахдаа зааврын дагуу хариулаагүй, зарим асуултад хариулалгүй орхигдуулсан зэрэг байдал илэрсэн бөгөөд ийм шалтгаанаар асуулт бүрт оролцсон хүний тоо нийт оролцсон хүний тооноос бага зэрэг /10-30 хүртэл/ зөрүүтэй байгаа нь судалгааны нийт үр дүнд нөлөөлөхгүй юм.

**1.4.2. Судалгаанд баримталсан зарчим**

Судалгааг аль болох бодитой болгох үүднээс дараах зарчмыг баримтлав. Үүнд:

- **Нийгмийн олон давхаргыг хамарсан байх.** Судалгааны баг эхлээд мал аж ахуйн өнөө ба ирээдүйн талаар малчид, мал аж ахуйн мэргэжилтэн, удирдах албаны хүмүүс төдийгүй сумын төв, хот сууринд байгаа малгүй иргэдийн санаа бодлыг судлах зорилт тавьж байсан юм. Гэвч судалгааны арга зүйг турших явцад сумын төв, хотын иргэд нь мал аж ахуйн өнөө ба ирээдүй, малчдын талаарх ойлголт хангалтгүй, зарим нь энэ талаар сонирхолгүй учир судалгаанд оролцохоос татгалзсан зэргээс болж цаг хугацаа алдах, үр ашиггүй хөдөлмөр зарцуулах, эцсийн бүлэгт бидний тавьсан зорилгыг хангахад төдийлөн ач холбогдолгүй мэдээлэл цуглахаар байгаа нь ажиглагдсан юм. Иймд бид

судалгаа явуулахдаа малчид болон мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтэн, сум, орон нутгийн удирдлагын санаа бодлыг иргэдийн санал гэж үзсэн болно. Судалгаанд оролцсон малчид, иргэдийг асуудалд өөрийнхөөрөө хандах боломж олгож судалгааны асуулгыг аль болох өөрөөр нь бичиж бөглүүлэх, зарим ойлгохгүй зүйлд нь нийтлэг тайлбар өгөх, бичиг үсгийн чадвар сул хүмүүсийн судалгааны асуулгыг өөрсдийнх нь хэлснээр бичиж туслах, тэдний малын тоо толгой, өрхийн орлого, зарлага зэргийг хамтран тооцож гаргах зэргээр хээрийн судалгааг гүйцэтгэв.

- **Магадлал бодит байдал руу тэмүүлэх.** Судалгаанд хамрагдах субъектийг тоо, хэмжээ, газар зүйн байршил, бүс бүслүүрийн хувьд магадлалын хамгийн бодит байдлыг хамгийн бага олонлогоор төлөөлж чадахаар бодож сонголт хийв. Монгол орны өргөн уудам нутаг, байгаль, цаг уур, эдийн засгийн онцлог байдлыг судалгаанд хэрхэн тусгасныг **“судалгааны объект”** гэсэн арга зүйн хэсэгт тодорхой тайлбарлан оруулсан болно. Судалгааны төлөөлөх чадварыг бодитой болгох үүднээс санамсаргүй түүвэрлэлтийн арга болон судалгаа явуулж буй орон нутгийн статистик дундаж үзүүлэлтийг харгалзан зориудаар түүвэрлэх аргыг аль алийг нь хэрэглэв. Тухайлбал судалгаанд сонгон авсан сум, багийн удирдлагатай уулзаж малчин өрхийн малын тоо, амьжиргааны түвшин зэрэг холбогдох тоо баримтад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр судалгаанд хамруулах хот айлыг урьдчилан зориудаар сонгох, зам дагуу тааралдах хот айлыг санамсаргүй байдлаар судалгаанд сонгон оролцуулах зэргээр ажиллав. Харин судалгаанд хамрагдсан малчдын нас, хүйс, боловсролын байдал нь ерөнхийдөө санамсаргүй байдлаар сонгогдсон болно.

- **Бодитой хэмжих нэгжийг сонгох.** Малчдын амьжиргааны түвшинг үнэлэхдээ тэдний орлогын гол эх үүсвэр болох өрхийн малын тоо, толгой гэсэн үзүүлэлтийг сонгон авч хэмжих үзүүлэлт болгон ашиглав. Гэхдээ өрхийн малын тоо адил боловч ам бүлийн тоо харилцан адилгүй, бог болон бод малын тоо өөр өөр байгаа зэргийг харгалзан **“өрхийн нэг хүнд ногдох малын тоо /богоор/, өрхийн нэг хүнд ногдох орлого”** гэсэн үзүүлэлтүүдийг судалгаанд сонгон ашигласан нь судалгааны үр дүнг бодитой болгоход чухал ач холбогдолтой болсон гэж үзэж байна. Малчдын аливаа асуудалд хандах хандлага нь тэдний өрхийн орлогын түвшин, малын тооноос ихээхэн хамаарч байгаа учир дээрх үзүүлэлтүүдийг судалгаанд өргөн ашиглах зайлшгүй шаардлага тавигдаж байсан юм. Малчин өрхийн нэг хүнд ногдох малын тоог тооцохдоо дараахь аргыг хэрэглэв. Үүнд: тухайн өрхийн нийт малын тоог тооцохдоо 2002 оны жилийн эцсийн мал тооллогын дүнг /”А” данс/ суурь болгож, түүнээс хойш малын тоо толгойд гарсан өөрчлөлтийг тооцож одоо байгаа малын тоог тогтоов. Өрхийн нийт малыг богд шилжүүлэхдээ тэмээ, адууг 7, үхрийг 6, хонь ямааг тус бүр 1 богоор тооцож богд шилжүүлэв. Тухайн өрхийн нэг хүнд ногдох малын тоог /богд шилжүүлснээр/ тогтоохдоо өрхийн нийт малын тоог /богд шилжүүлснээр/ өрхийн ам бүлийн тоонд хувааж тогтоов. Жишээ нь: 6 ам бүлтэй, нийт 170 толгой малтай /Үүнээс тэмээ 5, адуу 10, үхэр 15, хонь 80, ямаа 60/ малчин өрхийн нэг хүнд ногдох малын тоог тодорхойлъё. Үүний тулд эхлээд тухайн өрхийн нийт малын тоог богд шилжүүлнэ.

$$\text{Малын тоо/богоор/} = 5/\text{тэмээ}/ \times 7 + 10/\text{адуу}/ \times 7 + 15/\text{үхэр}/ \times 6 + 80/\text{хонь}/ + 60/\text{ямаа}/ = 335/\text{бог}/$$

$$\text{ӨНХНМТ}^4 = 335:6 = 56/\text{бог}/$$

<sup>4</sup> Өрхийн нэг хүнд ногдох малын тоо /богоор/

Малчин өрхийн жилийн орлогыг тооцохдоо тухайн малчин өрхийн хүнсэндээ хэрэглэсэн сүү, цагаан идээ, мах зэргийг тухайн орон нутгийн зах зээлийн ханшаар худалдаж борлуулсан бүтээгдэхүүний үнийг өөрсдийн хэлж мэдүүлсэн болон зах зээлийн дундаж үнээр, малын нэгжийн ашиг шимийг тооцохдоо тухайн малын үүлдэрлэг байдал, нас, хүйс зэргийг харгалзан тогтоогдсон норматив болон малчдын өөрсдийн мэдүүлэг зэргийг үндэслэн тодорхойлсон болно. Малчин өрхийн нэг хүнд ногдох орлогыг тооцохдоо өрхийн жилийн орлогыг өрхийн ам бүлийн тоонд хувааж, сарын орлогыг тооцохдоо жилийн орлогыг 12 сард хувааж тооцов.

#### 1.4.3. Судалгааны объект

Судалгааны объектыг сонгохдоо эдийн засгийн бүс болон Монгол орны нутаг дэвсгэрийн газар зүйн байрлал, байгаль, цаг уурын онцлог аль алийг харгалзан үзсэн болно. Түүнчлэн судалгааны анхдагч материалд боловсруулалт хийж дүгнэлт гаргахдаа ихэнх тохиолдолд эдийн засгийн бүсээр, зарим тохиолдолд газар зүйн байрлалаар бүлэглэн судалгаа хийсэн болно. Аймгууд нь оршин байгаа байрлал, зах зээлийн харилцаа, байгаль, цаг уур, дэд бүтцийн хувьд төстэй байдлаараа эдийн засгийн бүсүүд болж хуваагдсан учир эдийн засгийн бүсээр судалгаа хийх нь судалгааны бодит байдалд илүү ойрдөхөм хэдий ч зарим нэг тохиолдолд эдийн засгийн Төвийн бүсэд багтах Сэлэнгэ, Өмнөговь аймгийг адил нөхцөлтэй гэж үзэх үндэслэл бага юм. Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж Монгол орны Алтай, Хангай, Хэнтий нурууны ай сав, ойт хээр, тал хээр, говийн бүс, хот, суурингийн орчим, газар тариалангийн болон эдийн засгийн бүсийг төлөөлүүлэн дараахь аймгуудад судалгааг явуулав. Үүнд:

- Алтайн уулархаг нутаг, баруун бүсийн эдийн засгийн бүс нутгийг төлөөлүүлж Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий аймгийн нэр бүхий 8 сумыг сонгов. Алтайн уулархаг нутаг нь алтай, говь, хээр хосолсон Өмнөговьос Баян-Өлгий аймаг хүртэл 2 мянга гаруй километр урт газар нутгийг хамарна. Алтайн нурууны салбар уулсын төв хэсэгт орших Говь-Алтай аймгаас сонгосон сумууд нь хил залгаа орших Баянхонгор, Завхан аймгийг төлөөлөх төдийгүй эдийн засгийн баруун бүсийн говь, тал хээрийг төлөөлөх байгаль, цаг уур, мал аж ахуй эрхлэх адил төстэй талуудтай. Ховд, Баян-Өлгий аймгаас сонгосон сумууд нь Увс, Баян-Өлгий аймгийн ихэнх нутгийн байгаль, цаг уур, орон нутгийн онцлогийг төлөөлөх боломжтой юм.
- Хангайн нурууны ай сав, ойт хээр, эдийн засгийн Хангайн бүсийг төлөөлүүлж Архангай, Булган аймгийн нэр бүхий 10 сумыг сонгов. Сонгосон аймгууд нь тухайн бүс нутагт байрлах Өвөрхангай, Хөвсгөл аймгийг төлөөлөх хангай, ойт хээр, тал хээрийн бүсэд багтаж буйн дээр байгаль, цаг уур, мал маллагааны ижил төстэй арга технологитой болно.
- Газар тариалангийн болон эрчимжсэн мал аж ахуйн бүс нутаг, говь, тал хээрийн бүс, эдийн засгийн төвийн бүсийг төлөөлүүлж Төв, Сэлэнгэ, Дундговь, Өмнөговь аймгийн 8 сумыг сонгов. Төв, Сэлэнгэ аймгаас сонгосон сумууд нь газар тариалангийн бүс болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх арга барилд түлхүү шилжсэн, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн зэрэг онцлогтой бол Дундговь, Өмнөговь аймгаас төлөөлөн сонгосон сумууд нь газар зүйн бүсчлэлийн хувьд говь, хээрийн бүсийн нийтлэг хандлагыг төлөөлөх юм.
- Хэнтийн нурууны ай сав, тал хээрийн бүс, эдийн засгийн зүүн бүсийг төлөөлүүлж Хэнтий, Сүхбаатар аймгийн нэр бүхий 8 сумыг сонгов. Сонгосон аймаг сумууд нь эдийн засгийн зүүн бүс, Хэнтийн нурууны ай сав, тал хээрийн байгаль, цаг уурын онцлогийг төлөөлж байгаа юм.


- Улаанбаатарын бүсийг төлөөлж Сонгинохайрхандүүргийн 21 дүгээр хороо /хуучнаар Партизаны сангийн аж ахуй/-г сонгож судалгаанд хамруулав. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо нь 1990 оноос өмнө нийслэлийг сүүгээр хангадаг, эрчимжсэн сүүний ферм бүхий бүс нутаг байсан бөгөөд одоо ч сүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон аж ахуйн нэгж, мал бүхий иргэдтэй хот орчмын эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг төлөөлж чадах нутаг юм.

**1.4.4. Судалгааны ажлын хэмжээ**

Өмнө дурьдсанчлан судалгаанд нийт 11 аймаг, нийслэл хотын нийт 34 сум, 1 дүүргийн нутаг дэвсгэрийг сонгон авч байгаль, цаг уур, дэд бүтэц, зах зээлийн хөгжлөөр адил төстэй сумдаас нэгийг төлөөлүүлэх байдлаар сонголт хийсэн болно /1 дүгээр график /.

**Судалгаанд хамрагдсан аймаг, сумын тэмдэглэл**

График 1



Эх сурвалж: “Монголын мал аж ахуйн ирээдүй” судалгааны багийн тэмдэглэл зураг

Малчдын санаа бодлыг судлах болон салбарын эрдэмтэн, мэргэжилтэн, удирдах ажилтны /иргэд/ санаа бодлыг судлах гэсэн хоёр чиглэлээр асуулга боловсруулан социологийн судалгаа явуулав.

Судалгааны ажлын хэмжээ нь 11 аймгийн 34 сум, нийслэлийн 1 дүүргийн нийт 773 малчнаас 680 хувилбараар хариулт өгөх 50 асуултаар, 234 салбарын эрдэмтэн, мэргэжилтэн, удирдах албан тушаалтнаас 117 хувилбараар хариулт өгөх 11 асуултаар социологийн судалгаа явуулж нийт 123.6 мянга гаруй нэгж үзүүлэлтэд SPSS программаар боловсруулалт хийж гарсан үр дүнг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргаар тодорхойлсноор хэмжигдэнэ.

Социологийн судалгаанд оролцсон 773 өрхийг төлөөлсөн малчидтай нэг бүрчлэн ярилцаж, судалгааны асуулгын хуудсыг өөрсдөөр нь хариулт бичүүлж, ойлгохгүй буюу лавлаж асуусан асуултад нь судлаачид тайлбар өгсөн болно.

Малчин өрхийн малын тоо, орлого, зарлага зэргийг тооцохын тулд малчин тус бүр нэг өрхийг төлөөлсөн байхаар сонголтыг хийсэн болно. Ийм учраас малчдын орлого, зарлага, малын тоо толгойн өөрчлөлттэй холбоотой судалгааны хэсэг нь малчин өрхийг төлөөлсөн судалгаа юм.

Социологийн судалгааны дүнг харьцуулах, зарим асуудлын учир

“Монголын мал аж ахуйн ирээдүй” судалгаанд сонгон авсан аймаг, сумд  
Хүснэгт 1

№	Газар зүйн болон эдийн засгийн бүсийн нэр	Аймгийн нэр	Судалгаанд хамрагдсан өрхийн тоо	Судалгаанд хамрагдсан сумын нэр
1.	Эдийн засгийн баруун бүс буюу Алтайн уулархаг нутаг	Ховд Говь-Алтай Баян-Өлгий	37 110 67	Ховд, Буянт, Бигэр, Цогт, Цээл, Халиун, Дэлүүн, Толбо
2.	Эдийн засгийн хангайн бүс буюу Хангайн нурууны ай сав, ойт хээр	Архангай, Булган	183 71	Эрдэнэбулган, Өгийнуур, Цэнхэр, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Хайрхан, Дашинчилэн, Гурванбулаг, Сайхан, Сайхан-Овоо
3.	Эдийн засгийн төвийн бүс буюу газар тариалангийн болон эрчимжсэн мал аж ахуйн бүс нутаг, говь, тал хээрийн бүс	Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв	53 41 41 33	Дэлгэрцогт, Хулд, Цогт-Овоо, Ханхонгор, Хушаат, Хүдэр, Батсүмбэр, Жаргалант
4.	Эдийн засгийн зүүн бүс буюу Хэнтийн нурууны ай сав, тал хээрийн бүс	Хэнтий Сүхбаатар	83 34	Бүрэнцогт, Түмэнцогт, Асгат, Баруун-Урт, Баянхутаг, Жаргал-хаан, Цэнхэрмандал, Мөрөн
5.	Улаанбаатарын бүс	Улаанбаатар	20	СХД-ийн 21-р хороо /хуучнаар Партизаны САА/
6.	Дүн	11 аймаг болон нийслэл хот	773	34 сум, 1 дүүрэг

шалтгааныг нарийвчлан тодруулах зорилгоор 5 аймагт тус бүр 15-20, нийт 100 орчим малчдын дунд мал аж ахуйн өнөө ба ирээдүй сэдэвт фокус группын ярилцлагыг зохион байгууллаа. Энэхүү судалгааны эцэст судалгаанд оролцогсод өөрийн эзэмшилд байгаа малын тоо толгой, өрхийн амьжиргааны түвшин, боловсрол, мэргэжил, оршин суугаа аймаг сум, бүс бүслүүр зэргээс хамаарч хэрхэн хариулж байгаад анализ хийж 400 гаруй хүснэгт, график гаргасан болно. Тайланг аль болох товч, тодорхой болгох үүднээс тайлангийн үндсэн хэсэгт 69 хүснэгт, 39 график сонгон авч 28 хүснэгтийг хавсралтаар оруулав.

Судалгааны арга зүй боловсруулах, социологийн судалгааны асуулгыг турших ажлаар Өвөрхангай аймгийн Тарагт, Бат-Өлзий, Төгрөг суманд ажилласан юм. Гэхдээ дээрх аймгийн сумдад ажилласан судалгааны материалыг тайланд оруулалгүй санал асуулгын асуултыг боловсронгуй болгох, судалгааны арга зүйг сайжруулахад ашигласан болно.

1.4.5. Судалгааны төлөвлөх чадвар

“Монголын мал аж ахуйн ирээдүй” судалгааны хээрийн түүвэр судалгаа нь нийт 21 аймгийн 55 хувийг, 326 сумын 10.4 хувийг хамарсан байна. Судалгаанд хамруулах аймаг, сумыг сонгохдоо байгаль, цаг уур, газар зүйн бүс бүслүүр, эдийн засгийн бүсчлэл, дэд бүтэц, малын байршил, төрөлжилт зэрэг олон үзүүлэлтийг тооцож, ижил төстэй шинж чанараар нь төлөөлүүлэх зарчмыг баримталсан тул төлөөлөх чадвар нэлээд өндөр болсон гэж судалгааны баг үзэж байна.

Монгол орны байгаль, цаг уур, алтай, хангай, говь, хээрийн бүс, эдийн засгийн бүс нутаг, зах зээлийн харилцааны хөгжлийн түвшин зэрэг үзүүлэлтүүдээр судалгаанд хамрагдах аймаг, сумыг хэрхэн сонгож бусад аймаг, сумыг төлөөлүүлсэн тухай 1.4.3-д тодорхой өгүүлсэн. Судалгаанд сонгож авсан 34 сум тус бүрээс санамсаргүй түүврийн арга болон дунджийг төлөөлөх зориудын сонголтыг хослуулан 20-25 малчин өрх /нийт 773 өрхийн малчин/,



3-5 удирдах ажилтан, мэргэжилтэн сонгож авсан нь судалгааны төлөөлөх чадварыг тодорхой хэмжээнд хангаж байна. Судалгаанд хамрагдсан аймгийн төвөөс 3-5 удирдах ажилтан, мэргэжилтэн, нийслэлээс 60 гаруй удирдах ажилтан, малаж ахуйн салбарын эрдэмтэн, мэргэжилтнийг хамруулж, нийтдээ 234 удирдах ажилтан, эрдэмтэн, мэргэжилтнийг судалгаанд хамруулсан болно.

Судалгаанд сонгосон малчин өрхүүдийн амьжиргааны дундаж түвшин, малын тоо толгойн дундаж үзүүлэлт зэрэг нь тухайн аймаг сумын болон улсын дундаж үзүүлэлтүүдтэй ойролцоо байхаар тооцож судалгаа явуулсан нь төлөөлөх чадварыг нэмэгдүүлсэн юм. Ерөөс судалгаанд хамрагдсан малчдын малын тоо толгой нь улсын дунджид хэр зэрэг ойр байгаа нь судалгааны төлөөлөх чадварыг харуулах гол үзүүлэлт юм.

Судалгаанд сонгож авсан малчдын малын тоо толгойг улсын дундаж үзүүлэлтүүдтэй харьцуулж 2 дугаар хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгтээс үзэхэд судалгаанд сонгосон малчин өрхийн малын тооны бүлэглэл нь улсын дундаж үзүүлэлтээс хамгийн их нь 3.6 хувиар зөрүүтэй байгаа нь судалгааны төлөөлөх чадвар боломжийн түвшинд байгааг илэрхийлнэ.

**Малчдын малын бүлэглэлийг 2002 оны улсын дундажтай харьцуулсан нь**  
**Хүснэгт 2**

Малын тооны бүлэглэл	2002 оны улсын дундаж *		Судалгаанд оролцсон малчин өрх		Улсын дундаж судалгааны дундаж зөрүү/+ - /
	Өрхийн тоо	Дүнд эзлэх %	Өрхийн тоо	Дүнд эзлэх %	
Дүн	243 234	100.0	773	100.0	-
10 хүртэл малтай	33183	13.6	117	15.1	1.5
11-30 хүртэл малтай	42796	17.6	123	15.9	-1.7
31-50 хүртэл малтай	36165	14.9	102	13.1	-1.8
51-100 хүртэл малтай	55905	23.0	207	26.8	3.6
101-200 хүртэл малтай	46051	18.9	126	16.3	-2.6
201-500 хүртэл малтай	25313	10.4	74	9.5	-0.9
501-999 хүртэл малтай	3160	1.3	16	2.1	0.8
1000- дээш малтай	661	0.3	8	1.1	0.8

*Эх сурвалж:* ҮСГ, “Мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогын 2002 оны дүнгийн танилцуулга”, (УБ., 2003), х-8 хуудас.

**ХОЁРДУГААР БІЛЭГ:**

**МАЛ АЖ АХУЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**


Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдлыг тодорхойлохдоо сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд тус салбар Монгол орны эдийн засагт ямар үүрэг гүйцэтгэж байгаа, малын тоо толгой хэрхэн өөрчлөгдсөн, төр, засгийн байгууллагаас мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж хичнээн хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа болон мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд хууль, эрх зүйн орчин, байгаль, цаг уурын нөлөөлөл, мал маллагаа, тэжээл бэлтгэл, малын үржлийн ажлын өнөөгийн түвшин зэрэг энэ чиглэлийн цогц асуудлаар малчид, мэргэжилтнүүдийн санаа бодлыг судалж хоёрдогч материалыг цуглуулж харьцуулсан судалгаа хийв.

**2.1. Мал аж ахуй монгол орны эдийн засгийн гол салбар болох нь**

Хөдөө аж ахуйн салбар түүний дотор мал аж ахуй нь Монгол орны эдийн засгийн гол салбарын нэг болохыг өмнөх хэсэгт нэгэнт дурдсан билээ. Хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг 2 дугаар графикаар тодруулан харуулж байна. 2 дугаар графикаас үзэхэд эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын гүйцэтгэх үүрэг 2000 оноос эхлэн буурах хандлагатай болсон байна. 1995 онд хөдөө аж ахуйн салбар нь ДНБ-ий 38.0 хувийг үйлдвэрлэж байсан бол 2002 онд 20.7 хувь болж буурсан байна. Энэ нь 1999-2001 онуудад малын тоо толгой 30 гаруй хувиар хорогдсонтой холбоотой.

**ДНБ-д хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эзлэх хувь**

График 2



Эх сурвалж: *Economic growth support and poverty reduction strategy (2003, Tokyo, Japan), p-112*

Монгол улсын төсөв эдийн засгийн салбаруудаар хэрхэн хуваарилагддаг, түүний дотор мал аж ахуйн салбарт хичнээн хэмжээний төсөв ногдож байгааг манай судалгааны баг сүүлийн 2 жилийн байдлаар судалж үзэв. /Хүснэгт 3/

Хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйн салбар нь ДНБ-д эзлэх хувь хэмжээгээр тээвэр холбоо, эрчим хүчний салбараас 6-16 хувиар илүү хэдий ч улсын төсвөөс ногдох хувь дээрх салбаруудаас 4-8 тэрбум төгрөгөөр бага байна. Энэ нь байгальдаа зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэлд бага зардал гардагтай холбоотой боловч нөгөө талаар мал аж ахуйг хөгжүүлэх талаар сүүлийн жилүүдэд төрөөс хөрөнгө, хүч бага зарцуулж байгаагийн нотолгоо юм.

2003-2004 онд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд улсын төсвөөс зарцуулагдаж байгаа 15.75 тэрбум төгрөгийн дийлэнх хувь нь салбарын ажилтан, албан хаагчдын цалин, урсгал зардал, үйлчилгээний зардалд хуваарилагдаж байгаа бөгөөд мал аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө өчүүхэн хэсгийг эзэлж байна. Тухайлбал 2003 онд мал үржлийн ажилд

Монгол улсын 2003-2004 оны төсвийн хуваарилалт

Хүснэгт 3

Үзүүлэлт	2003 он төлөвлөгөө /сая.төг/		2004 оны төсөл /сая.төг/	
	Нийт дүн	Хувь	Нийт дүн	Хувь
Зарлага ба цэвэр зээлийн дүн	579976.8	100.0	661188.4	100.0
Нийтлэг үйлчилгээ	105789.7	18.2	124693.6	18.9
Нийгмийн үйлчилгээ	311932.6	53.8	358901.5	54.3
Эрчим хүч, хангамж	16316.5	2.8	20136.9	3.0
Хөдөө аж ахуй	12733	2.2	15755.6	2.4
Уул уурхай, үйлдвэр, барилга	2891.5	0.5	3556.2	0.5
Тээвэр, холбоо	20747.9	3.6	24324.1	3.7
Бусад зардал	135084.8	23.3	144628.2	21.9
Тохируулгын үйлчилгээ	-37657.9	-6.5	45995.1	-7.0


Эх сурвалж: Монгол улсын 2004 оны төсвийн танилцуулга

улсын хэмжээнд дөнгөж 180 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол 2004 онд энэ ажилд 140 сая төгрөг, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд 50 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.<sup>5</sup> Бүтэн жилийн туршид улсын хэмжээний мал үржлийн ажилд төсвөөс дөнгөж 140 сая төгрөг зарцуулж байгаа нь эрчимжсэн мал аж ахуйн ганц ферм байгуулахад хүрэлцэхгүй хөрөнгө юм. 2004 оны байдлаар хөдөө аж ахуйн салбарт оруулах хөрөнгө оруулалт улсын төсвийн нийт хөрөнгө оруулалтын дөнгөж 0.7 хувь буюу 320 сая төгрөг байхад дэд бүтцийн салбарт нийт хөрөнгө оруулалтын 69.9 хувь нь ногдож байна.

Харин 1990 оноос хойшхи хугацаанд малыг эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт зах зээлийн нөхцөлд нийцэн сайжирч, малыг эмчлэх, өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны төсөв, зардал тогтвортой өсч ирснийг 3 дугаар графикаас харж болно.

Мал эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төрөөс зарцуулсан хөрөнгө

График 3



Эх сурвалж: “Монголын мал эмнэлэг” сэтгүүл №-6(53), (УБ 2003), х-22

Монгол Улс 2003 оны жилийн эцсийн байдлаар 25.3 сая толгой мал тоолуулсны дотор 255.6 мянган тэмээ, 1958.6 мянган адуу, 1784.3 мянган үхэр, 10706.2 мянган хонь, 10603.4 мянган ямаа байсан байна. Манай судалгааны багаас Монгол орны малын тоо толгойн өсөлт сүүлийн 10 гаруй жилд хэрхэн өөрчлөгдөж байгааг судлав.


Энэ хугацаанд Монгол орны малын тоо толгойн өсөлт тогтворгүй, **өсөх-буурах-өсөх-буурах** гэсэн хэлбэлзэлтэй байгааг 4 дүгээр графикаас харж болно.

2.2. **Малын тоо толгойн еерчлелт, сиргийн битэц, байршил**

<sup>5</sup> Монгол улсын 2004 оны Төсвийн тухай хуулийн төсөл, Төсвийн төслийн танилцуулга, УБ, 2003

**Нийт мал сүргийн тоо, толгойн өөрчлөлт /1980-2003 он/**

График 4



Эх сурвалж: УСГ-ын эмхтгэл (УБ 1985, 1990, 1995, 2002, 2003)


Малын өсөлт тогтворгүй байгаад нөлөөлж буй олон хүчин зүйлээс бэлчээрийн маллагаатай монгол малын хувьд хамгийн гол нь байгаль, цаг уурын нөлөөлөл юм. Тухайлбал, 1983, 1993, 1999-2002 онуудад малын тоо, толгой буурч байсан нь тухайн жилүүдэд зуд болж байсан үетэй давхцаж байна.

1999 оноос хойш тохиолдсон ган, зуд, аадар бороо, хүчтэй салхи, хурц нар, цочир хүйтрэл зэрэг байгалийн гамшигт үзэгдлүүд нь малын тоо толгойг эрс хорогдуулав. Ялангуяа 1999-2002 онуудад Монгол орны нутаг дэвсгэрийн 60-70 хувийг хамарсан ган, зуд жил дараалан болж энэ хугацаанд улсын хэмжээгээр нийт 11 сая мал хорогдож, 12 мянган малчин өрх малгүй болж, амьжиргаанаасаа салахад хүрсэн юм.

1999 онд Монгол Улс 3,1 сая толгой адуутай байсан бол 2002 онд 1,9 сая болж 1,2 сая толгойгоор буюу 38 хувиар хорогдов. Мөн хугацаанд үхэр сүргийн тоо 3,4 саяас 1,8 сая хүртэл /47 хувиар/ хорогдсон байна /5 дугаар графикаас үзнэ үү/.

**Бод малын тоо толгойн өөрчлөлт /1980-2003 он/**

График 5



Хонин сүргийн тоо толгой ч дээрх хугацаанд 15.2 саяас 10.7 сая толгой хүртэл буурсан байна. Ямааны тоо 1980 оны үед 4.9 сая толгой байсан бол 1999 он хүртэлх хугацаанд жил дараалан өссөөр 11 сая толгойд хүрч, 1999 оноос эхлэн зудын жилүүдэд 9.7 сая толгой хүртэл хорогдсон байна. Гэвч ямааны хорогдол нь бусад төрлийн малаас харьцангуй бага байна /6 дугаар графикаас үзнэ үү/.


Ямааны тоо толгой өссөн нь 1985 оноос хойш ноолуурын үнэ, ханш өссөнтэй голчлон холбоотой. Түүнчлэн, Алтайн уулархаг нутагт ямаан сүрэг нь

цаснаас дээш ургасан ямаан харгана зэрэг модлог ургамлаар хооллож чаддаг, зундаа бэлчээрийн ургамал тачир байлаа ч өвсийг газрын хөрстэй нь тэгшилж идэх чадвартай зэрэг нь ган зудтай жилүүдэд ямааны тоо харьцангуй бага хорогдох нэг хүчин зүйл болсон байна.

1999-2002 онд байгаль, цаг уурын хүндрэлээс Монгол Улс нийт малынхаа 29 хувийг хорогдуулсан байна. Малын тоонд механикаар нөлөөлөх өөр нэг хүчин зүйл нь мал тооллогыг бодитой, үнэн зөв /толгой дараалан/ явуулах явдал юм.

**Бог малын тоо толгойн өөрчлөлт  
/1980-2003 оны байдлаар/**


График 6



**Мал сүргийн байршил.** Нийт малын 32 хувь нь хангайн бүсэд, 29 хувь нь баруун бүсэд, 15 хувь нь зүүн бүсэд, 14 хувь нь говийн бүсэд, 9 хувь нь төвийн бүсэд байршин адгуулагдаж байна /7 дугаар график/.

**Мал сүргийн байршил /бүсээр/**

График 7



**Эх сурвалж:** УСГ “Мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогын 2003 оны дүнгийн танилцуулга” (УБ 2004) х-10

Сүүлийн жилүүдэд малын байршилд эдийн засгийн бүс нутгаар төдийлөн өөрчлөлт ороогүй бөгөөд баруун болон хангайн бүсэд байх мал сүрэг 1 хувиар буурч, зүүн бүсийн малын тоо 2 хувиар өссөн аж.


1990 оноос хойшхи хугацаанд нийт сүргийн дотор ямаан сүргийн эзлэх хувь хэмжээ 20-42 хувь хүртэл өсч, бусад малын тоо хэмжээ 1-16 хувь хүртэл хэмжээгээр буурсан байна /8 дугаар график/.

Тэмээг уналга, ачлагад ашиглах нь багассан, махны гарц ихтэй, нядалж зарахад 180-200 мянган төгрөг хүрдэг зэргээс шалтгаалан хүнсэнд их хэмжээгээр хэрэглэх болсон, адууны шир 20 мянган төгрөгт хүрсэн, адуу нь малчин хүний байнгын хараа хяналтад байдаггүй алсын бэлчээрт байдгаас

хулгайд их алдагдаж, сүүлийн жилүүдийн ган, зудад илүүтэй хорогдсон, үхэр сүрэг нь ган, зудад хорогдсоны дээр махны хэрэгцээнд зонхилон хэрэглэсэн зэрэг шалтгаанаар хорогдож сүрэгт эзлэх хувийн жин нь буурсан гэж малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүд үзэж байгаа аж.

**Сүргийн бүтцийг 1990/2003 оноор харьцуулбал:**

График 8



Ямаа өсч байгаагийн гол шалтгаан нь ямааг нядалж биш самнаж ашиг орлого олж байгаад л учир нь байгаа юм гэж Ховд аймгийн малчин Дулам ярьж байсан нь үнэнд ойрхон сонсогдож байлаа. Мөн түүнчлэн зуд болоход хамгийн түрүүнд үхэр, адуу хорогдоно, түүний дараа хонь, хамгийн сүүлд ямаа хорогддог гэж хашир туршлагатай малчид өгүүлж байна.

**2.3. Мал аж ахуйн салбарт олон улсын байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлсэн ажил**

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд гадаадын хөрөнгө оруулагч, хандивлагч орнуудын тусламжтайгаар хүнс, хөдөө аж ахуйн салбарт нийт 145.7 сая ам.долларын 35 төсөл хэрэгжүүлж дууссан бөгөөд 2003 оны байдлаар 115.42 сая ам.долларын 15 төсөл хэрэгжиж байгааг салбараар авч үзвэл мал аж ахуйн салбарт 13.4 сая долларын 4 төсөл, мал аж ахуй ба газар тариалан хосолсон чиглэлээр 48 сая ам.долларын 6 төсөл, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 50.2 сая ам.долларын 2 төсөл, хоршооллын чиглэлээр 3 сая ам.долларын 1 төсөл хэрэгжиж байна.<sup>6</sup>

Эдгээр төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар тодорхой мэдээлэл авах боломж бага, төслийг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллагууд мэдээлэл өгөх сонирхолгүй, мэдээлэл хомс байсныг зориуд тэмдэглэж байна.

Олон улсын байгууллага, гадаад орнуудын хөрөнгөөр мал аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа төслүүдийн чиглэлийг тоймлон авч үзвэл:

- малгүй иргэдийг малжуулах, ядуурлыг бууруулах;
- мал эмнэлгийн хувьчлалыг дэмжих;
- мал аж ахуй дахь эрсдлийг даван туулах асуудлаар судалгаа хийх, зарим малчдад мал аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх;
- хөдөө аж ахуйн хөгжлийн асуудлаар судалгаа хийх;
- олон нийтийг хамруулан тодорхой зорилго бүхий сургалт зохион байгуулах

1991–2001 онд Монгол Улс хандивлагч олон улсын байгууллага, орнуудаас 4 тэрбум 953 сая долларын зээл, тусламж авсан бөгөөд түүний 6.2 хувь буюу 308 сая ам.долларын хөрөнгийг хөдөө аж ахуйн салбарт зарцуулсан байна. Монгол Улсын эдийн засгийн гол салбарын нэг болсон хөдөө аж ахуй түүний дотор мал аж ахуйн

<sup>6</sup> Монголд хандивлагч орнуудын Токиогийн уулзалтад бэлтгэсэн Хүнс, хөдөө аж ахуйн яамны танилцуулга (УБ 2003 он).

салбарыг хөгжүүлэх талаар сүүлийн 10 гаруй жилд бусад салбараас бага анхаарч ирсэн нь эдгээр тоо баримтаар нотлогдож байгаа юм /4 дүгээр хүснэгт/.

**Хандивлагчдын зээл тусламжийн хэмжээ 1991-2001 он, салбараар**  
/сая ам.доллараар/

**Хүснэгт 4**

Салбар	Хөгжлийн хандив	Зээл	Тусламж	Бүгд	Хувь
Э/З 10 салбар	511.98	216.21	296.12	1024.31	20.7
Тээвэр	404.89	311.54	93.35	809.78	16.3
Т/тусламж	368.2	162.44	205.76	736.4	14.9
Эрчим хүч	253.41	130.52	122.9	506.83	10.2
Хүний нөөц	234.67	14.32	220.34	469.33	9.5
Аж үйлдвэр	195.71	142.14	53.58	391.43	7.9
Макро Э/З	188.19	90.28	97.91	376.38	7.6
Бусад	165.51	148.92	16.6	331.03	6.7
Хөдөө аж ахуй	154.41	38.99	115.42	308.82	6.2
Нийт	2476.9	1255.02	1221.97	4953.89	100

**Эх сурвалж:** “Effectiveness and contributions of official development assistance for Mongolia” (2003 Tokyo, Japan) p-11-13

Судалгааны багаас малчид, мал аж ахуйн мэргэжилтэн, орон нутгийн удирдлагаас **“Олон улсын байгууллагаас мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаарх таны бодол”** гэсэн асуулт асууж дүнг нэгтгэж 5 дугаар хүснэгтээр үзүүлэв.

Судалгаанд оролцсон малчдын 27.1-36.7 хувь нь төсөл арга хэмжээ чухал асуудалд чиглээгүй, нийтэд хүрэх хүртээмж муу, үр өгөөж нь ч хангалтгүй гэж хариулсан байна. Мал аж ахуйн мэргэжилтэн, удирдах ажилтны 14-20 хувь нь л олон улсын байгууллагын зээл тусламжийн үйл ажиллагаанд нааштай үнэлэлт өгч, 49.5-55.3 хувь нь төсөл, арга хэмжээний чухал асуудалд чиглэгдсэн эсэх, үр өгөөжтэй эсэх талаар санаанд огт нийцэхгүй буюу мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

Үүнээс үзэхэд мал аж ахуйн мэргэжилтэн, удирдах ажилтнууд төсөл арга хэмжээний зориулалт, хүртээмж, үр дүнд малчдаас илүү шүүмжлэлтэй хандаж, сэтгэл ханамжтай бус байгаа ажээ.

**Олон улсын байгууллагаас авч хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаарх олон нийтийн санаа бодол**  
/малчид, мэргэжилтэн, удирдах албаны хүмүүс/

**Хүснэгт 5**

Үзүүлэлт	Санал асуулгад оролцогсдын ангилал	Бүрэн нийцдэг /хувиар/	Зарим нь нийцдэг /хувиар/	Огт нийцдэггүй /хувиар/	Мэдэхгүй /хувиар/	Бүгд
Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл чухал асуудалд чиглэгдсэн эсэх	Малчид	42.6	9.7	27.1	20.6	100.0
	Мэргэжилтэн, удирдах хүмүүс	20.9	19.5	40.9	18.7	100.0
Төсөл, арга хэмжээний нийтэд хүрэх хүртээмж	Малчид	42.4	20.5	31.1	6.0	100.0
	Мэргэжилтэн, удирдах хүмүүс	14.2	39.9	36.7	9.2	100.0
Төсөл, арга хэмжээний үр өгөөж	Малчид	48.7	12.7	28.5	10.1	100.0
	Мэргэжилтэн, удирдах хүмүүс	16.6	28.1	36.4	18.9	100.0

**“Олон улсын байгууллагын хөрөнгийг мал аж ахуйн хөгжлийн ямар үйл ажиллагаанд чиглүүлэх нь зүйтэй вэ? /3 хүртэл хариултыг ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгоно/”** гэсэн асуултаар мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтэн,

удирдах албаны хүмүүсийн дунд явуулсан судалгааны дүнг 6 дугаар хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Нэг оролцогч нэг асуултад 2-3 хувилбараар ач холбогдлоор нь эрэмбэлэн нэгэн зэрэг хариу өгсөн асуулт, хариултыг судалгаанд түгээмэл ашигласан нь хариултын дүнг уншигчдад энгийн, ойлгомжтой байдлаар илэрхийлэхэд нэлээд төвөгтэй байсныг онцлон дурьдаж байна. Иймд хойшид тайланд гарах олон хувилбар бүхий эрэмбээр хариулагдсан асуултын үр дүнг уншигчдад ойлгомжтой болгох үүднээс **“Олон улсын байгууллагын хөрөнгийг мал аж ахуйн хөгжлийн ямар үйл ажиллагаанд чиглүүлэх нь зүйтэй вэ? /3 хүртэл хариултыг ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгоно/”** гэсэн асуулт, түүний олон хувилбарт хариултын дүнг тайлбарлахад ашигласан нэр томъёо, тэдгээрийн ач холбогдлыг тайлбарлах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

- **Оролцогчийн тоо.** Судалгаанд оролцсон хүний тоо. Судалгаанд оролцогчийн тоо болон хариултын тоо нь хоёр өөр үзүүлэлт болохыг сануулах үүднээс энэхүү нэр томъёог зориуд дурдаж байна.
- **Хариултын тоо.** Нэг оролцогч нэг асуултад хариулахдаа 1-3 хүртэл хариултыг сонгож байгаа учир хариултын тоо нь оролцогчийн тооноос заавал их байх бөгөөд хамгийн дээд хязгаар нь 3 дахин их байж болох юм. Оролцогч зөвхөн ганц хариултын хувилбар сонгох болзолтой асуулт тавих нь учир дутагдалтай, амьдрал дээр нэг асуудлыг шийдвэрлэх олон арга зам байгаа бөгөөд тэдгээрээс хамгийн чухлыг тодруулахын тулд оролцогч тус бүрт асуултад хариулахдаа хариултын олон хувилбараас ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгох боломж олгож байж асуудлын мөн чанарыг зөв тодорхойлох юм.
- **Нийт оролцогчийн дүнд эзлэх хувь.** 7 дугаар хүснэгтэд байгаа “Малын үүлдэр угсааг сайжруулах” гэсэн хариулт бол 8 хариултын доторх нэг л тухайн хариулт юм. Санал асуулгад оролцсон нийт 225 оролцогчийн 128 нь буюу 56.9 хувь нь энэ хариултыг сонгосон байна. Энэ үзүүлэлтээр гаргасан хувь хэмжээ нь эцсийн бүлэгт 100 хувиар тодорхойлогдохгүй. Учир нь нэг оролцогч 1 биш 3 хүртэл хариулт өгсөнтэй холбоотой нь ойлгомжтой. Аливаа асуудалд олон талаас нь хандаж байж зөв шийдвэр гаргах ёстой гэж үзвэл нийт оролцогчийн дүнд тухайн хариултын эзлэх хувь гэсэн энэхүү үзүүлэлт нь судалгаанд ашиглавал зохих чухал ач холбогдолтой үзүүлэлт болно. Түүнчлэн тухайн хариултын нийт дүн нь 1, 2, 3 гэсэн эрэмбэд хуваагдаж байна. Жишээ нь “Малын үүлдэр угсааг сайжруулах” гэсэн хариултыг нийт 128 хүн сонгосон бөгөөд тэдгээрийн 52 нь уг хариултыг ач холбогдлоор нь 1 дүгээр эрэмбээр, 43 нь хоёрдугаар, 33 нь гуравдугаар эрэмбээр тус тус сонгосон байна. Эрэмбэ тус бүр нь нийт оролцогчдын дүнд хэдэн хувийг эзэлж байгааг бас харж болно.
- **Нийт хариултын дүнд эзлэх хувь.** **“Олон улсын байгууллагын хөрөнгийг мал аж ахуйн хөгжлийн ямар үйл ажиллагаанд чиглүүлэх нь зүйтэй вэ? /3 хүртэл хариултыг ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгоно/”** гэсэн асуултад 225 хүн оролцсоныг дээр дурдсан. Эдгээр 225 хүн нь уг асуултад нийтдээ 672 хариулт өгсөн байна. Нийт хариултын дүнд эзлэх хувь гэсэн үзүүлэлт нь хариулт тус бүрийн нийлбэрээрээ 100 хувиар тодорхойлогдох үзүүлэлт юм. Тухайн хариултын эрэмбэ тус бүрийн нийт хариултын дүнд эзлэх хувь хэмжээг бас тодорхойлж болно.
- **Хариултын эрэмбэ.** Асуултад хариулахдаа 3 хүртэл хариултыг сонгож, тэдгээр гурван хариултаа ач холбогдлоор нь 1, 2, 3 гэж эрэмбэлэн хариулт өгсөн болно. Жишээ нь **“Олон улсын байгууллагын хөрөнгийг**



**мал аж ахуйн хөгжлийн ямар үйл ажиллагаанд чиглүүлэх нь зүйтэй вэ? /3 хүртэл хариултыг ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгоно/** гэсэн асуултын “Малын үүлдэр угсааг сайжруулах” гэсэн хариултыг 128 оролцогч сонгохдоо тэдний 52 хувь нь уг хариултыг 1 дүгээр эрэмбээр 43 нь хоёрдугаар, 33 нь гуравдугаар эрэмбээр сонгосон байна. Нийт 672 хариултын 7.7 хувийг малын үүлдэр угсааг сайжруулах гэсэн хариултын 1 дүгээр эрэмбэ эзэлж байгаа нь уг хариултад оролцогчид хамгийн их ач холбогдол өгч байгааг харуулж байна.

Нэг асуултад олон хариулт сонгож, сонгосон хариултаа эрэмбэлсэн нийлмэл асуулт, хариулт цаашдаа нэлээд түгээмэл гарах учир тэдгээрийн талаар уншигч та дээр дурдсанчлан ерөнхий ойлголттой болсон гэдэгт найдаж байна.

**“Олон улсын байгууллагын хөрөнгийг мал аж ахуйн хөгжлийн ямар үйл ажиллагаанд чиглүүлэх нь зүйтэй вэ? /3 хүртэл хариултыг ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгоно/**” гэсэн асуултад хариулсан нийт оролцогчийн 56.9 хувь нь малын үүлдэр, угсааг сайжруулахад, 47.1 хувь нь худаг усны хангамжийг сайжруулахад, 46.7 хувь нь малчдын амьжиргааг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх шаардлагатай гэж үзсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Удирдах ажилтан, мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтнүүд эдгээр хариултыг сонгохдоо аль асуултад хэр зэрэг ач холбогдол өгснийг 6 дугаар хүснэгтээр эрэмбэлэн үзүүлэв.

Тухайлбал, малын үүлдэр угсааг сайжруулах тухай хариултыг ач холбогдлоор нь 1 ба 2 дугаар эрэмбээр 95 малчин буюу нийт оролцогчдын 42.2 хувь нь сонгосон нь хамгийн өндөр үзүүлэлт болсон байна. Худаг усны хангамжийг нэмэгдүүлэх хариултыг ач холбогдлоор нь 1 ба 2 дугаар эрэмбээр 77 малчин буюу нийт оролцогчдын 34.3 хувь нь сонгосон нь ач холбогдлоороо хоёрдугаарт тавигдаж байна.

6 дугаар хүснэгтээр харуулсан судалгааг тоймлон дүгнэж үзвэл мал аж ахуйн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан, орон нутгийн удирдах албаны хүмүүс нь олон улсын байгууллагын зээл тусламжийг мал аж ахуйг хөгжүүлэхэд чиглүүлэхдээ **малын үүлдэр угсааг сайжруулах-худаг усны хангамж сайжруулах-бэлчээр, хадлангийн талбайг сайжруулах-бүтээгдэхүүн боловсруулах шинэ технологи нэвтрүүлэх-малчдын амьжиргааг сайжруулах** гэсэн дарааллаар хандахыг санал болгож байна.

**“Хадлангийн талбайг сайжруулах, тэжээлийн нөөц бэлтгэх”** гэсэн хариулт болон **“бэлчээр сайжруулах”** гэсэн хариултаудыг ижил төстэй гэж үзвэл мал аж ахуйд оруулах гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд **бэлчээр – хадлан - тэжээлийн нөөцийг** бий болгоход чиглүүлэх шаардлагатай гэсэн санал чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна.

Олон улсын зээл тусламж, төслийн хөрөнгийг мал аж ахуйн хөгжлийн ямар асуудалд нэн тэргүүнд чиглүүлэх шаардлагатай байгаа талаар удирдах ажилтан, мэргэжилтэн, эрдэмтэд хариултыг ач холбогдлоор нь хэрхэн эрэмбэлж байгааг авч үзвэл малын үүлдэр угсааг сайжруулах асуудлыг хамгийн өндөр хувиар /нийт оролцогчдын 23.1 хувь нь/ нэгдүгээр зэргийн ач холбогдолтой гэж үзсэн бол харин хөдөөгийн дэд бүтцийн асуудлыг нийт оролцогчдын дөнгөж 6.1 хувь нь нэгдүгээр эрэмбээр авч үзсэн байна.

**Жич:** Өмнөх жилүүдэд олон улсын байгууллагаас авсан санхүүжилтийг /зээл, тусламж гэх мэт/ ихэвчлэн мал аж ахуй дээр ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тухайн үед малчдын амьжиргааны хүнд хэцүү байдлыг бага ч болов хөнгөвчлөх, ядуурлын уршгийг зөөллөх чиглэлээр зарцуулж

Олон улсын байгууллагын зээл тусламжийг мал аж ахуйн хөгжлийн ямар үйл ажиллагаанд чиглүүлэх нь зүйтэй вэ?

Хүснэгт 6

Хариулт	Хариултын эрэмбэ	Хариултын тоо	Нийт хариултын дүнд эзлэх хувь	Нийт 225 оролцогчийн дүнд эзлэх хувь
Хадлангийн талбайг сайжруулах, тэжээлийн нөөц бэлтгэх	1	39	5.8	17.3
	2	27	4.0	12.0
	3	22	3.3	9.8
	Дүн	88	13.1	39.1
Бэлчээрийг сайжруулах	1	34	5.0	15.1
	2	35	5.2	15.6
	3	19	2.8	8.4
	Дүн	88	13.1	39.1
Худаг усны хангамжийг нэмэгдүүлэх	1	33	4.9	14.7
	2	44	6.5	19.6
	3	29	4.3	12.9
	Дүн	106	15.8	47.1
Малын үүлдэр угсааг сайжруулах	1	52	7.7	23.1
	2	43	6.4	19.1
	3	33	4.9	14.7
	Дүн	128	19.0	56.9
Бүтээгдэхүүн боловсруулах, шинэ технологи нэвтрүүлэх	1	18	2.7	8.0
	2	26	3.9	11.6
	3	35	5.2	15.6
	Дүн	79	11.8	35.1
Малчдын амьжиргааг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх	1	35	5.2	15.6
	2	23	3.4	10.2
	3	47	7.0	20.9
	Дүн	105	15.6	46.7
Хөдөөгийн дэд бүтцийг хөгжүүлэх	1	15	2.2	6.7
	2	24	3.6	10.7
	3	31	4.6	13.8
	Дүн	70	10.4	31.1
Бусад	1	1	0.1	0.5
	2	5	0.7	2.2
	3	2	0.3	0.9
	Дүн	8	1.2	3.6
Нийт дүн		672	100.0	100.0

байсан бол одоо мал аж ахуйг эрсдэл даах чадвар, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр дэлхийн чиг хандлагын дагуу хөгжүүлэхэд хөрөнгийг төвлөрүүлэх шаардлага бий болоод байна.<sup>7</sup>

2.4. Мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр, засгаас хэрэг-жийлж буй бодлого, ийл ажиллагаа, малчдын санаа бодол

2.4.1. Мал аж ахуйн ийлдвэрлэлийн эрх зийн орчин, малчдын санаа бодол

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 1923 онд “Малын зүйлийг эмчлэх ба боловсруулан сайжруулах газар” байгуулснаас хойш мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр төр, засгаас бодлогын шинжтэй олон хууль тогтоомж гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн байна. 2004 оны байдлаар малчин хүнд өдөр тутам үйлчилж байгаа зарим хууль, бодлогын бичиг баримтуудыг дурдвал:

**Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл.** Энэхүү баримт бичиг нь мал аж ахуйг хувийн өмчийн хэлбэрээр эрхлэн хөтлөхийг төрийн бодлогын чиглэл болгосон анхны баримт бичиг юм.

**Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай.** Энэ хуулиарулс, аймаг, орон нутагт мал аж ахуйн асуудал эрхэлсэн төсвөөс санхүүжих мэргэжлийн

<sup>7</sup> Өндөр уулын бүсийн Мал аж ахуйн Эрдэм шинжилгээний Станцын ажилтан доктор /Ph./ Ч.Гомбожавын ярианаас

төрийн байгууллага бий болгосны зэрэгцээ монгол малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах олон харилцааг зохицуулсан байна.

**Газрын тухай хууль.** Бэлчээр, хадлангийн талбайг нийтээр эзэмших асуудлыг эрх зүйн хувьд баталгаажуулсан.

Засгийн газраас мал аж ахуйн талаар дараахь хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Малын чанар, үржлийн ажлыг сайжруулах үндэсний хөтөлбөр;
- Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр;
- Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр;
- Мал сүргийг ган зудаас хамгаалах үндэсний хөтөлбөр;
- Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр;
- Хадлан гэжээл-2001 төсөл;
- Шилмэл хээлтүүлэгч дэд хөтөлбөр;
- Цагаан хувьсгал үндэсний хөтөлбөр;
- Усны үндэсний хөтөлбөр;

Мал аж ахуйн талаарх хууль тогтоомж амьдралд нийцэж байгаа эсэх тухай малчид, мал аж ахуйн мэргэжилтэн, удирдах ажилтан нараас асууж дүнг 7 дугаар хүснэгтээр үзүүлэв.

**Мал аж ахуйн салбарт үйлчилж байгаа хууль, тогтоомж амьдралд хэр нийцэж байгаа талаарх олон нийтийн үнэлгээ**

**Хүснэгт 7**

Эрхэлдэг ажил	хангалттай		дунд зэрэг		хангалтгүй		мэдэхгүй		дүн	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Малчид	154	20.9	63	8.5	376	51.0	144	19.5	737	100.0
Удирдах ажилтан, мал аж ахуйн э/ш-ний ажилтан, мэргэжилтэн бүгд	7	3.2	23	10.6	117	53.7	71	32.5	218	100.0
Үүнээс	Орон нутгийн ИТХТ болон Засаг дарга нар		4	6.0	37	55.2	26	38.8	67	100.0
	Мал аж ахуйн мэргэжилтэн, э/ш-ний ажилтан	7	4.6	19	12.6	80	53.0	45	29.8	151

Судалгаанд хамрагдсан малчдын 51.0 хувь, мал аж ахуйн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан нарын 53.7 хувь, орон нутгийн удирдах ажилтнуудын 55.2 хувь нь мал аж ахуйн талаарх хууль тогтоомжууд санаанд огт нийцдэггүй гэж хариулсан байна. Мал аж ахуйн талаарх ямар хууль, тогтоомж яагаад санаанд нийцэхгүй байгаа талаар малчдын санаа, бодлыг ярилцлагаар тэмдэглэн авч холбогдох хуулийн заалттай уялдуулан судалж энэхүү бүлгийн 2.4.2-г тусгав. Нийт малчдын 19.5 хувь нь мал аж ахуйн талаарх хууль тогтоомж хангалттай эсэхэд мэдэхгүй гэж хариулж байгаа бөгөөд уг хариулт нь малчдын боловсрол, нас зэргээс төдийлөн хамаарахгүй байв.

Мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтэн, удирдах ажилтнууд **мэдэхгүй** гэсэн хариултыг сонгохдоо мал аж ахуйн талаарх хууль, эрх зүйн актыг огт мэдэхгүйдээ бус, харин мал аж ахуйн талаарх хууль тогтоомжууд өнөөгийн нийгмийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлон хэлж чадахгүй байна, эргэлзэж байна гэсэн утга санааг санал асуулгад оролцогсод хэлж байсныг онцлон дурдаж байна. Түүгээр ч зогсохгүй орон нутагт хуулийн хэрэгжилтийг өдөр тутам зохион байгуулдаг удирдах ажилтнуудын 17.4 хувь нь мал аж ахуйн талаарх хууль тогтоомж дунд зэрэг, 55.2 хувь нь хангалттай биш, 38.8 хувь нь хэлж мэдэхгүй, нэг ч хүн хангалттай гэж хариулаагүй байна.

Мал аж ахуйн салбарт үйлчилж байгаа хууль тогтоомжууд нийгмийн харилцаа, хүмүүсийн хүсэн хүлээж байгаа хэрэгцээ шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байгаа нь олон нийтийн санаа бодлын судалгааны ажлын дүнгээр тогтоогдож байна.

Энэ байдлаас үндэслэн цаашид мал аж ахуйн салбарт үйлчилж буй хуулиудыг зах зээлийн харилцаанд нийцүүлэн өөрчлөн сайжруулах, хуулийн сурталчилгаа хийх зэрэг шаардлагууд урган гарч байна.

Өнөөгийн мал аж ахуйн салбарын хууль, тогтоомжууд олон нийтийн санаа бодолд төдийлөн таалагдахгүй байгаа ч гэсэн тэдгээрийн хэрэгжилт ямар байгаа талаар олон нийт ямар санаа бодолтой байгааг судлах нь басхүү сонирхолтой байж болох юм.

Малаж ахуйнталаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийнталаарх таны бодол гэсэн асуултаар малчид, орон нутгийн удирдах ажилтан, мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтнүүдийн санаа бодлыг судалж дүнг 8 дугаар хүснэгтээр үзүүлэв.

**Мал аж ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн үнэлгээ**

*Хүснэгт 8*

Эрхэлдэг ажил	хангалттай		дунд зэрэг		хангалтгүй		мэдэхгүй		дүн	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Малчид	200	27.9	134	18.7	325	45.3	58	8.1	717	100.0
Удирдах ажилтан, мал аж ахуйн э/ш-ний ажилтан, мэргэжилтэн	10	4.5	64	29.0	126	57.0	21	9.5	221	100.0
Дүн	210	22.5	198	21.1	451	48.0	79	8.4	938	100.0

8 дугаар хүснэгтээс үзэхэд малчдын 45.3 хувь, орон нутгийн удирдах ажилтан мал аж ахуйн эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжилтнүүдийн 57.0 хувь нь мал аж ахуйн талаарх хууль тогтоомжуудын хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Харин нийт санал асуулгад оролцогчийн 8.4 хувь нь **мэдэхгүй** гэсэн хариулт өгсөн нь мал аж ахуйн талаарх хууль тогтоомжийн ерөнхий агуулга нь удирдах ажилтан, мэргэжлийн хүмүүсийн санаанд төдийлөн нийцэхгүй байгаа хэдий ч хуулийн хэрэгжилтэд хандах тэдний үнэлгээ эерэг талдаа өсөлттэй харагдаж байна. Тухайлбал судалгаанд оролцогсдын 21.1 хувь нь хуулийн хэрэгжилт дунд зэрэг 22.5 хувь нь хангалттай гэж үзжээ.

**2.4.2. Мал аж ахуй дахь хууль, эрх зүйн орчинг сайжруулах талаарх малчдын санаа бодол**

Хууль, эрх зүйн ямар орчин бэрхшээл учруулж байгаа талаар малчдын ярьсан ярилцлагыг тэмдэглэн авч холбогдох хуулийн заалтуудтай уялдуулан илэрхийлэхийг чармайв. Мал аж ахуйн эрх зүйн орчны талаарх мэргэжилтэн, малчдын санаа, бодлыг тодорхойлохдоо фокус группийн ярилцлага, тандан судлах, сурвалжлан тэмдэглэх аргыг ашигласан болно.

**Газрын тухай хууль:** Хадлангийн талбайг ашиглаж байгаа өнөөгийн байдал нь шударга ёс, тэгш байдлыг хангаж байна гэж үзэхэд учир дутагдалтай. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хадлангийн нэг га талбай ашигласны төлбөр хураамжийг тогтоож, сумын Засаг дарга иргэн, аж ахуйн нэгжид хадлангийн талбайг ашиглуулах шийдвэр гаргаж зохицуулдаг хуулийн заалттай хэдий ч хэн түрүүлж өвсөө хадсан нь эсвэл хэн эд хөрөнгө, хүч тэнхээ сайтай нь, хэн тухайн сумын хуучин аж ахуйн нэгж, нэгдэл, сангийн аж ахуйн

суурин дээр байгуулагдсан хоршоо, компанийг эзэмшиж байгаа нь хадлангийн талбайг ашиглах, өвстэжээлийн бизнес арилжаа хийх хандлага нийт аймгуудад байсаар байгааг малчид хэлж байлаа.

Төв, суурин газрын ойролцоох бэлчээрийг тодорхой татвар хураамжтайгаар малчид, фермерийн аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлэхгүй аваас зах зээлд ойрыг нь бодож нийтээр эзэмших нэрийн дор бэлчээр их хэмжээгээр талхалагдах болсон байна.

Бидний судалгаанд хамрагдсан нийт удирдах ажилтан, хөдөө аж ахуйн мэргэжилтний 70.6 хувь нь эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид бэлчээрийг эзэмшүүлэх буюу өмчлүүлж тэдний бизнесийн тогтвортой үйл ажиллагааны баталгааг бүрдүүлж өгөх хэрэгтэй гэж үзсэн байна. Газрын тухай хуулиар дээрх хэрэгцээ, шаардлагыг зохицуулах боломж тун хомс байгаа юм. Тухайлбал малчин хүнд газрыг тухайн орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зөвхөн гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргахаас өөр боломжгүй аж.

Малын тоогоор малчдаас орлогын татвар авч байгаа боловч бэлчээр ашигласны төлбөр одоогоор авахгүй байгаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн эх ундарга болсон бэлчээрт хандах хүний үйл ажиллагааны хариуцлагыг сулруулж бэлчээрийг үнэгүйдүүлж байна.

Хадлангийн талбайгаас хадлан өвс бэлтгэхдээ иргэн, аж ахуйн нэгжийг тэгш, шударга зарчмаар, тодорхой нөхцөл болзолтойгоор тендерээр шалгаруулах журамд шилжих, тухайн аж ахуйн нэгж, байгууллага хадлангийн талбайг зориулалтын дагуу удаан хугацаагаар ашиглах, хадлангийн гарцыг сайжруулах, усалгаажуулах, хамгаалах сонирхлыг бий болгохуйц татварын бодлого явуулж гэрээгээр баталгаажуулж байх зэрэг асуудлыг авч үзмээр байна.

Газрын тухай хуулийн 8 дугаар зүйлд тодорхойлсон аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэс нь амьдрал дээр хуульд тодорхойлсон агуулгаараа малчдад ойлгогдохгүй, малчид аймаг, сумын хилийн цэсийг ёс төдий мэдэж мөрдөж байна.

Аймаг дундын отрын бэлчээр нь тусгай хэрэгцээний ангилалд байгаа боловч ердийн бэлчээрийн хэлбэрээр ашиглагдаж байна. Энд ямар нэг тусгай зохицуулалт одоогоор байхгүй, хүрч очсон малчин бүр уг бэлчээрийг эзэмших эрхтэй байгааг хэлж болно. Ийм учраас эдгээр бүс нутгийн бэлчээр, хадланг зөвхөн ашиглах талаасаа үйл ажиллагаа явагдаж, арчилж тордох ашиглалтын зөв менежмент хийх ажил үндсэндээ орхигдсон байна.

Сум, орон нутгийн түвшинд Газрын тухай хуулийн 52.1 дүгээр заалтын дагуу хийгдэх ёстой газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь бэлчээрийг зохистой хуваарилах, сэлгэж өнжөөх зэрэг шинжлэх ухааны үндэслэлээр зохиогдох биш дэд бүтэц, зах зээлд ойр бэлчээрийг жил дараалан талхагдалд оруулдаг хэвшмэл зуршил давамгайлах байдлаар хийгдэж байна.

Зуслангийн нутгийг ургамлын бутлалт, цэцэглэлт, үр боловсролын үед жил дараалан талхагдалд оруулж бэлчээрийн ургамлын бүрэлдэхүүнд байх малд идэмж сайтай ургамлын тоо хэмжээ улам цөөрч хогийн ургамал голлох болсон нь аль ч аймаг, сумын ойролцоох нутагт нийтлэг үзэгдэл болсон байна.

Орон нутгийн төрийн байгууллагуудад ажиллаж байгаа боловсон хүчний бэлчээрийг шинжлэх ухааны үндэслэлтэй ашиглах талаар мэдлэг, мэдээлэл хангалттай биш байна.

Газрын тухай хуулийн 52.2 дугаар заалтыг хэрэгжүүлж чадах аваас бэлчээрийг зөв зохистой ашиглах, ургамлын бүрэлдэхүүн, бүтцийг сайжруулахад чухал ач холбогдолтой боловч хэрэгжилт туйлын хангалтгүй, бүхэлдээ уг хуулийн заалтыг хэрэгжүүлж заншаагүй байгаа юм.

Газрын тухай хуулийн 52.5 дугаар заалт нь Монголын мал аж ахуйн ирээдүйн хөгжилд чухал ач холбогдолтой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа гэж дүгнэж болох юм. Хуулийн энэхүү заалт жинхэнэ утгаараа хэрэгжиж эхлэх аваас өндөр ашиг шимтэй мал өсгөж үржүүлэх ажилд иргэн, байгууллагын зүгээс хөрөнгө оруулалт хийх сонирхол нэмэгдэнэ.

Малчдын хоорондын харилцаанд гарч байгаа гол зөрчил, маргаан бол бэлчээр ашиглалтын асуудал байсаар байна. Нэгэнт нийтээр ашиглаж байгаа бэлчээрийг хэн нь илүү, хэн нь дутуу ашиглаж байгааг шүүж тунгаах нь адармаатай асуудал юм. Тэгээд ч бэлчээр ашиглах талаар зөрчил гаргасан хүнд хүлээлгэх шийтгэл, хариуцлага нь зөрчил гаргахгүй байх эрх зүйн нөхцлийг төдийлөн хангаж чадахгүй байна. Ойрын жилүүдэд бэлчээрийг тодорхой иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг ялангуяа төвийн бүсийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж болох нутагт хэрэгжүүлэх шаардлагатай болж байна.

Бэлчээрийг нийтээр ашиглаж байгаа өнөөгийн нөхцөлд хот, суурин бараадсан их нүүдэл нь бэлчээрийг талхагдалд оруулах үндсэн шалтгаан болоод зогсохгүй улмаар эрчимжсэн мал аж ахуй эрхлэх байгууллага, иргэдийг эрсдэлд оруулж, тэдний зүгээс мал аж ахуйд хөрөнгө оруулалт хийх эрх ашиг, сонирхолд чөдөр тушаа болж байна.

Ган, зуд, түймэр мэт байгалийн бэрхшээлтэй үед сумын Засаг дарга нар харилцан тохиролцож малчдыг сум дамжуулан өвөлжүүлж байгаа ч тухайн өвөлжсөн сумдад газрын төлбөрийн асуудал ямар ч байдлаар шийдэгдэхгүй өнгөрдөг байна. Бэлчээр ашигласны төлбөрийг харьяалагдаж буй суманд нь бус нутагласан сумын орлогод оруулдаг болох шаардлагыг сум, орон нутгийн удирдлагууд тавьж байна.

Газрын тухай хуульд зарим өөрчлөлт оруулах талаар малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүдээс гарсан саналыг тоймлон дурдвал:

- Эдийн засгийн бүс бүслүүр, дэд бүтцийн хөгжил, төв, суурин газраас алслагдсан байдал зэргээс хамаарч бэлчээрийн төлбөр хураамжийг харилцан адилгүй тогтоох.
- Малын ашиг шимийн татварыг бага, бэлчээр ашигласны хураамжийг түүнээс их байхаар тогтоох.
- Бэлчээрийг хаших, таримал тэжээл тариалах зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрчимжсэн арга ажиллагааг дэмжсэн уг хуулийн 52.5 дугаар заалтыг хөрөнгө оруулагч нарт сурталчлах, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг нь төрийн зүгээс бүрдүүлж өгөх.
- Өөрийн хилийн цэс дотор багтах бэлчээрийг хэрхэн яаж хэнд ашиглуулж эзэмшүүлэхийг тухайн шатны Засаг дарга шийдвэрлэх эрхтэй боловч, хэрэгжүүлэх боломжмуу байгааг харгалзан төрөөс нарийн зохицуулалт хийх.
- Цаашид аймаг дундын отрын бэлчээр болон улсын тэжээлийн сангийн хадлангийн талбайг хэрхэн ашиглах, эзэмших талаар судалгаа хийж тэнд бэлчээрийн менежментийн зөвхарилцаа үүсэх эрх зүйн орчинг бүрдүүлж өгөх.
- Бэлчээрийг зөв зохистой ашиглах, бэлчээрийн үр ашгийг дээшлүүлэх явдал нь бэлчээрийг тодорхой хэмжээний төлбөртэйгээр эзэмшүүлж ашиглуулж байж шийдэгдэнэ. Зах зээлд ойр бэлчээрт бог мал нутаглах нь зохимжгүй бөгөөд ямар бэлчээрт ямар төрлийн мал маллавал хичнээн хэмжээний төлбөр төлөхийг ч төлбөр хураамжаар нь зохицуулах шаардлагатай юм.
- Газрын тухай хуулийн 52.4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх ажлыг сум, орон нутагт эрчимтэй зохион байгуулж, аймаг, сум бүр өөрийн нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал маллагааны бүс нутгийг тогтоож, мал аж ахуйд хөрөнгө оруулалт орох боломжийг бүрдүүлэх.

- Ган, зудтай үед зэргэлдээ аймаг, сумын нутаг, отрын бүсийн нутгийг хэрхэн ашиглах, энэ үед бэлчээр ашигласны төлбөр хураамжийг хэрхэн зохицуулах асуудлыг уян хатан, тодорхой шийдэх.

**Газрын төлбөрийн тухай хууль:** Бэлчээрийн төлбөрийн одоо мөрдөгдөж байгаа үнэлгээ нь уг бэлчээрийн зах зээлийн ач холбогдол, үржил шим зэргийг огт харгалзалгүй тогтоогдсон учир байгууллага, иргэн хэн боловч бэлчээрийн үнэ цэнийг тодорхойлж хариуцлага хүлээх нөхцөл үүсэхгүй байна.

Тэр ч бүү хэл, уг хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт зааснаар малчин өрхийг бэлчээрийн төлбөрөөс чөлөөлсөн нь бэлчээрийг хайр гамгүй ашиглах, үнэгүйдүүлэх, эзэнгүйдүүлэх нэг нөхцлийг бий болгож өгч байна. Харин 8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт тэжээлийн ургамал тариалсан тариалангийн талбайг эзэмшиж ашигласны төлбөрөөс чөлөөлөхөөр заасан нь мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх хэрэгт таатай нөлөө үзүүлэх юм.

Бэлчээрийн төлбөр нь зөвхөн малын толгойн тоогоор бус уг бэлчээрийн үржил шим, алслагдсан байдал зэргээс хамаарч өөр өөр байх, бэлчээрийн төлбөрийн хэмжээг бэлчээрийн ашиглалт, хуваарилалт, сэлгэлтийг зохицуулах хөшүүрэг болгоход чиглүүлж болно.

Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хуулиас хасч бэлчээр ашигласны төлбөр хураамж авдаг болох, энэ хэмжээгээр мал аж ахуйн орлогын татварыг багасгах шаардлагатай.

Бэлчээрийн ургамлын бүтцийг сайжруулах, хашиж хамгаалах, хуваарьтай ашиглах талаар иргэд, байгууллагаас гаргасан санаачилгыг дэмжиж, тийм бэлчээр, хадлангийн талбай болон тариалангийн талбайг ашиглаж, эзэмшсэний төлбөрөөс чөлөөлөх асуудлыг авч үзмээр байна.

**Хоршооны тухай хууль:** 2002 оны 12 дугаар сард уг хуульд өөрчлөлт оруулж хоршоо нь хадгаламж зээлийн үйл ажиллагаа явуулдаг болсноор малчид гар дээр байгаа бэлэн мөнгөө хоршин төвлөрүүлж, малаа барьцаалан өөр хоорондоо зээлдүүлэх, зах зээлийн үйл ажиллагааны хариуцлага хүлээх боломжийг бүрдүүлж өгсөн юм. Гэвч малчид энэ боломжийг ашиглаж чадахгүй байгаа нь бидний судалгаагаар харагдсан болно.

Малчид хамтран дотоод нөөц боломжоо ашиглах, хамтын хүчээр зах зээлийн харилцааны асуудлыг шийдэхэд тэднийг хошуучлах, удирдах мэргэжлийн боловсон хүчин хөдөө орон нутагт дутмаг байгаа нь малчдын дунд хоршоо хөгжихгүй байгаагийн гол шалтгаан болж байна. Иймд хууль эрх зүй, зах зээлийн ерөнхий харилцааны талаар малчдын дунд сургалт явуулж, хорших үйл ажиллагааны хурдыг нэмэгдүүлэхүйц олон төрлийн ажил зохион байгуулах шаардлагатай байна.

**Эрүүгийн хууль:** Шинэхэн баталсан эрүүгийн хуулиар хэрэгтэн 1.5 сая төгрөг хүртэл эд зүйл хулгайлсан бол ял эдлэхгүй, зөвхөн торгуулах буюу түр саатуулагдаад л өнгөрдөг болсныг хулгайч нарыг урамшуулж муу зан сургасан хууль болсон гэж малчид үзэж байна. Айлын бүх хөрөнгийг /1.5 сая хүртэлх/ хулгайлчихсан хүн ял эдлэх биш торгуулаад, хэд хоног түр саатуулагдаад өнгөрдгийг малчид ойлгохгүй байна. Миний малыг л хулгайлаагүй бол бусдын малыг хулгайлах нь хамаагүй, мэдсэн ч мэдээгүй юм шиг байхаас өөр аргагүй, суллагдаж гараад л миний малыг хулгайлна гэсэн яриаг Төв аймгийн Жаргалант сумын малчидтай хийсэн фокус группын ярилцлагын үеэр малчид илэн далангүй ярьж байлаа. Иймд 1.5 сая төгрөгөөс доош эд зүйл хулгайлсан

хүнийг зөвхөн 150 000-1 500 000 төгрөгөөр торгох аль эсвэл торгохгүйгээр 100-250 цагийн хугацаагаар албадан ажил хийлгэх буюу 1-3 сарын хугацаагаар баривчлах ял оноож байгаа одоогийн Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 1 дүгээр заалтыг өөрчилж малын хулгай хийсэн л бол хорих ял оноодог болгох нь зүйтэй гэж малчид үзэж байна.

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль:** Энэхүү хуулийн дагуу 2000-2003 онуудад улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 4 тэрбум 534 сая төгрөг зарцуулснаас 130.1 сая төгрөгийг ажилгүй буюу ажил идэвхтэй хайж байгаа хүмүүст мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах ажилд, 1 тэрбум 31 сая төгрөгийг мэргэжил олгох давтан сургалтанд, 276.0 сая төгрөгийг ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд, 959.7 сая төгрөгийг нийтийг хамарсан ажилд зарцуулсан байна.<sup>8</sup>

770 гаруй малчин өрхөд хийсэн судалгаанаас үзэхэд төрөөс үзүүлж байгаа эдгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд малчин өрхийн ажилгүй иргэн хамрагдаагүй байна. Бодит байдлаар бол 100 бог хүрэхгүй малтай өрхийн нэгээс бусад хөдөлмөрийн чадвартай хүнийг ажилгүй хүн гэж үзэх үндэстэй. Гэтэл малчин өрхийн хөдөлмөрийн чадвартай хүн бүрийг ажилтай гэж үздэг нь энэ хуулийн дэмжлэгийг малчид хүртэж чадахгүй байгаагийн шалтгаан болж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээ ихэвчлэн аймгийн төв орчмоор хязгаарлагддаг учир малчид энэ чиглэлийн хөнгөлөлт, дэмжлэгийг хүртэж чадахгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийн 4 дүгээр зүйлийн 2.1-д “хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах” гэж заасны дагуу Монгол Улсын бүх иргэд энэ хуулиар ижил дэмжлэг авах учиртай. Ийм ч учраас малчдад энэ талын үйлчилгээг хүргэх талаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас зориуд бодлогын чиглэлтэй үйл ажиллагаа зохион байгуулах, тухайлбал, малчдыг аж ахуй эрхлэх, хамтрах хууль, эрх зүйн тодорхой мэдлэгтэй болгох, мал аж ахуйг эрхлэх дэвшилтэт арга барилд сургах сургалт явуулах, жижиг үйлдвэрлэл эрхлэх технологийн мэдлэг олгох зэрэг ажлыг зохион байгуулах шаардлагатай юм.

**Ан агнуурын тухай хууль:** Малчид ан амьтан агнахын тулд уг хуулийн 7.1-ийн дагуу эхлээд сумын төв орж байгаль орчны байцаагч, Засаг даргаас ан амьтан агнах зөвшөөрөл авах, дараа нь дахин сумын төв орж агнасан андаа мал эмнэлэг, хорио, цээрийн үзлэг хийлгэж, дахин байгаль орчны байцаагч дээр очиж гарал үүслийн бичиг авч байж борлуулах эрх үүсдэг нь ихээхэн чирэгдэлтэй байдаг аж. Энэ олон шат дамжлагыг арилгах, амьдралд хэрэгжихгүй байгаа хуулийн заалтыг хүчингүй болгох нь зүйтэй гэж ан хийж орлого олдог малчид үздэг байна.

#### **2.4.3. Засгийн газраас мал аж ахуйг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх малчдын бодол**

Засгийн газраас мал аж ахуйг хөгжүүлэх талаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар малчид ямар санаа бодолтой байгааг судлах зорилгоор “**Мал аж ахуйн талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар таны бодол**” гэсэн асуултаар нийт 728 малчин өрхөөс судалгаа авч дүнг нэгтгэн 9 дүгээр хүснэгтээр үзүүлэв.

<sup>8</sup> Хөдөлмөр эрхлэх газрын 2003 оны ажлын тайлан



**Мал аж ахуйн талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй ажлын талаарх малчдын санаа, бодол**

Хүснэгт 9

Үнэлгээ	Насны бүлгээр										Дүн	
	18-25		26-35		36-50		51-60		60-аас дээш		тоо	дүнд эзлэх хувь
	тоо	дүнд эзлэх хувь	тоо	дүнд эзлэх хувь	тоо	дүнд эзлэх хувь	тоо	дүнд эзлэх хувь	тоо	дүнд эзлэх хувь		
Бүрэн нийцдэг	24	49.0	58	29.7	75	26.2	30	28.3	25	27.2	212	29.1
Зарим нь нийцдэг	5	10.2	17	8.7	39	13.6	12	11.3	11	12.0	84	11.5
Огт нийцдэггүй	12	24.5	84	43.1	116	40.6	38	35.8	29	31.5	279	38.3
Мэдэхгүй	8	16.3	36	18.5	56	19.6	26	24.5	27	29.3	153	21.0
Дүн	49	100.0	195	100.0	286.0	100.0	106	100.0	92	100.0	728	100.0

Мал аж ахуйн талаар Засгийн газраас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар малчдын 29.1 хувь нь бүрэн нийцдэг, 11.5 хувь нь зарим нь нийцдэг, 38.3 хувь нь огт нийцдэггүй, 21.0 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Мал аж ахуйг хөгжүүлэх талаар Засгийн газраас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар хариулсан малчдын хариултад тэдний нас, оршин суугаа аймаг, эдийн засгийн бүс, амьжиргааны байдал зэрэг нь төдийлөн нөлөөлөхгүй байна.

1923 онд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр “Малын зүйлийг эмчлэх ба боловсруулан сайжруулах газар” байгуулснаас хойш 1990-ээд он хүртэлх 70 орчим жилийн хугацаанд байгалийн шалгарал, малчид, мэргэжилтэн нарын уйгагүй хөдөлмөр, шинжлэх ухааны үндэслэлтэй сонгон үржүүлгийн үр дүнд монгол малын нийт 17 үүлдэр, 4 үүлдрийн хэсэг, 5 үржлийн хэсэг, 15 шилмэл омгийн мал бий болгосон байна.<sup>9</sup>

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед төр засгаас зөвхөн нутгийн монгол малын чанарыг сайжруулах асуудалд анхаарч байсан төдийгүй сүүний болон сүү-махны хосолмол ашиг шимтэй Германы хар тарлан, ЗХУ-ын хар тарлан, Семменталь, Алатау, Талын улаан, махны чиглэлийн Герефорд, Казакийн цагаан толгойг зэрэг сайн үүлдрийн өндөр ашиг шимтэй үхрийг үржүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж, хотын хүн амын хэрэгцээнд жилийн 4 улиралд сүү, цагаан идээ нийлүүлж байсан юм.

1970-аад оноос эхлэн манай улс 200, 400, 800, 1200 үнээний 40 саалийн механикжсан ферм байгуулж 1989 оны байдлаар сүүний чиглэлийн цэвэр, эрлийз 19.6 мянган үнээ үржүүлж 46 сая литр сүү үйлдвэрлэж, тэжээлийн нэг үнээнээс 2558 литр сүү саах болсон байна.

1980-аад онд “Гүн хөлдөөсөн үрийн станц” байгуулагдаж 1980-1990 оны хооронд 82 бухнаас 1005.8 мянган тун үр үйлдвэрлэж, зохиомол хээлтүүлэгт 505.6 мянгыг ашиглан үйлчилгээ явуулсны үр дүнд 127.8 мянган үнээ төллөж 103.4 мянган тугал бойжуулж байсан байна /2002 оны Малын удмын сангийн тайлангаас/.

Дээрх тоо баримтууд нь 1990 оноос өмнөх жилүүдэд мал үржлийн ажил хэр зэрэг амжилттай явагдаж байсны тодорхой жишээ юм. Харамсалтай нь 1990 оноос өмч хувьчлалын ажилд алдаа гарч сүүний фермүүдийн бүтэц, үйл ажиллагааг хэвээр авч үлдэх ажил хийгдээгүйгээс сүүний фермүүд тарж, устаж үгүй болсон юм.

2.5. Мал өмнөлөг, иржлийн ажлын өнөөгийн байдал, цаашдын хандлага

<sup>9</sup>Д.Жадамба, Г.Дээшин нар “Монголын мал аж ахуй, мал үржүүлэг XX зуунд” (УБ 2003) х-9

1990 оноос хойшхи хугацаанд нутгийн монгол малын ашиг шимийг сайжруулах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах ажлын чанар эрс муудсан байна. Бидний судалгаа, ажиглалт, олон сувгаар олж авсан мэдээллээс үзэхэд Сэлэнгэ аймгийн Цагаан нуур сум, Хэнтий аймгийн Түмэнцогт, Дадал зэрэг суманд махны чиглэлийн цэвэр үүлдрийн үхрийг монгол үхэртэй эрлийзжүүлж байгаа бага хэмжээний туршилтын ажил, монгол ямааны ноолуурын чанар, гарцыг сайжруулах талаар үр хөврөл шилжүүлэн суулгаж селекцийн ажил явуулж буй зэргийг эс тооцвол малын удмын сан, үржлийн ажлыг сайжруулах талаар хийгдсэн тодорхой ажил сүүлийн жилүүдэд бараг алга гэж үзэж болохоор байна. Харин ч өмнөх үед бүтээн байгуулж бий болгосон цэвэр, эрлийз малын тоо эрс хорогдож устаж үгүй болоход хүрчээ.

Цэвэр, эрлийз малын тоо 1990 он хүртэлх хугацаанд жил бүр эрчимтэй өсч байсан боловч 1990 оноос хойш жил дараалан хорогдсон байна. Тухайлбал 1990 онд 80.5 мянган цэвэр үүлдрийн үхэртэй байсан бол 2000 онд дөнгөж 29.1 мянган толгой цэвэр үүлдрийн үхэр тоологджээ. /10 дугаар хүснэгт/

**Цэвэр, эрлийз малын тоо, толгойн өөрчлөлт**

Хүснэгт 10

Он	Үхэр			Хонь			Ямаа		
	Цэвэр	Эрлийз	Бүгд	Цэвэр	Эрлийз	Бүгд	Цэвэр	Эрлийз	Бүгд
1962	5.3	12.8	18.1	53.6	782.7	836.3	0.5	10.9	11.4
1970	6.8	54.1	60.9	69.4	1222.2	1291.6	1.6	48.9	50.5
1980	28.0	97.7	125.7	156.0	1145.0	1301.0	40.6	249.8	290.4
1990	80.5	117.9	198.4	33.6	837.4	871.0	91.9	336.0	427.9
2000	29.1	106.4	135.2	588.5	760.1	1348.6	113.9	243.1	357.0

Эх сурвалж: Д.Жадамба, Г.Дээшин нар “Монголын мал аж ахуй, мал үржүүлэг ХХ зуунд” (УБ 2003) х-33

10 дугаар хүснэгтээс үзэхэд 2000 оны байдлаар нийт 135.2 мянган цэвэр, эрлийз үхэр тоологдсон мэт харагдаж байгаа боловч бодит байдал дээр энэ үед цэвэр, эрлийз үхрийн тоо 50 мянгад ч хүрэхгүй болсон гэж мэргэжилтнүүд тооцож байна.

Цэвэр, эрлийз малын тоог тооцохдоо бодит байдлаар нүдээр үзэж тоолох бус өмнөх оны “А” дансны үлдэгдлийг бага зэрэг бууруулах байдлаар сумын мал аж ахуйн мэргэжилтний гаргасан таамаг дүн мэдээгээр гаргагдаас цэвэр, эрлийз малын тоо бага зэрэг буурч байгаагаар харагдаж байна.

Статистик тоо баримтаар бол цэвэр, эрлийз хонь, ямааны тоо сүүлийн арван жилд өссөнөөр харагдаж байна. Уг чанартаа бол өсөх биш буурсан гэж бид үзэж байна.

Ер нь мал тооллогын дүнгээр цэвэр, эрлийз малын тоог баримжаалах ямар ч боломжгүй, үнэмшил муутай, тэгээд ч мэргэжлийн бус тоологч нар малыг хараад цэвэр үүлдрийн, эрлийз, нутгийн монгол гэж ялгах боломжгүй юм.

Цэвэр, эрлийз үхэр сүрэг хорогдсоны гол шалтгаан нь уг мал нь өндөр өртөг зардалтай гэжээл, дулаан байр, арчилгааны өндөр нөхцөл шаарддагтай холбоотой юм. Цэвэр, эрлийз хонины тоо өссөн нь мал тооллого чанаргүй явагдаж байгаатай холбоотой гэж бид үзэж байна. Харин ч цэвэр, эрлийз хонины тоо цөөрч, чанар муудаж монгол шинжид буцах эрлийзжүүлэг явагдаж байгаа гэж үзэх үндэстэй байна. Энэ нь нарийн ноосны үнэ ханшнаас хамаарч буй хэрэг.

**Жич:** Сэлэнгэ аймгийн Ерөө сумын мянгат малчин Аюурзанын ярианаас: Манайх Ерөө үүлдрийн нарийн ноост хонь өсгөж үржүүлдэг. Гэхдээ сүүлийн жилүүдэд хониндоо монгол хуц тавих болсон. Монгол хуцны хурга амьдрах чадвар

сайн, тэжээл бага зарцуулдаг, өртөг хямд. Ер нь манай энэ хавийнхан сүүлийн жилүүдэд монгол хуц их тавих болсон.

Сүүлийн хоёр жилд сүүний чиглэлийн жижиг фермерийн аж ахуй эрхлэгчдийн тоо өсч, хэрэгцээгээ дагаад цэвэр үүлдрийн үнээний зах зээлийн үнэ ханш өссөн байна. 2003 оноос эхлэн сүүний чиглэлийн үхэр өсгөж үржүүлэх асуудалд иргэдаж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийх сонирхолтой болох хандлага ажиглагдаж байна. Жишээ нь Төв аймгийн Батсүмбэр суманд нэгэн америк иргэн Алатау-Монголын саалийн 20 эрлийз үнээтэй жижиг фермерийн аж ахуйг 2 жилийн өмнө байгуулсан байна. Угаж ахуй нь жижигхэн боловч орчин үеийн манай орны нөхцөлд зохицсон сүүний үхрийн эрчимжсэн аж ахуй юм. Үнээний өвлийн дулаан байрыг модоор хямд төсөр шийдэж, өвс хадлангаа зохих нормын дагуу бэлтгэж, жилийн турш сүү үйлдвэрлэх, байгалиас хараат биш, өвөл хавартаа суурин, зундаа байгалийн бэлчээр ашигладаг маллагааны хэлбэртэй загвар фермерийн аж ахуйг ийнхүү бий болгосон нь орон нутгийн нөхцөлд гойд зохицож тэр жилдээ нутгийн гурван ч өрх дуурайж фермерийн аж ахуй байгуулсан байна. Мөн хажууханд нь байгаа хуучнаар Партизаны сангийн аж ахуй одоогийн Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 21 дүгээр хорооны 6 өрх дараа жил нь тийм фермерийн аж ахуй байгуулсан байна. Өнөө жилийн намар Партизан, Батсүмбэрийн орчимд тийм жижиг фермерийн аж ахуй 50 гаруй бий болоод байна. Ийнхүү нутаг, орчинд нь зохицсон, бодитой, шинэлэг арга хэлбэрийг мал аж ахуйд загвар байдлаар бий болгож өгвөл малчид мал аж ахуйн үйлдвэрлэлээ эрчимжүүлэх, шинэ арга барил нэвтрүүлэх хүсэл эрмэлзэл их байгаа нь энэхүү жишээгээр нотлогдож байна. Цаашид монгол малын үүлдэр угсааг сайжруулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, үүний тулд өндөр ашиг шимтэй хээлтүүлэгч, үр, үр хөврөл гаднаас импортлох, энэ чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна.

1990-ээд оноос өмнө манай оронд мал маллагааны суурин, хагас суурин, бэлчээрийн маллагааны хэлбэрүүд аль аль нь байсан юм.

Нутгийн монгол мал нь жилийн аль ч улиралд нэмэгдэл тэжээл хэрэглэхгүй дан ганц бэлчээрийн маллагаагаар адгуулан маллагддаг. Харин эх мал, төлд хавартаа бага зэрэг хадсан ногоон өвс, хивэг, багсармал тэжээл хэрэглэдэг. Харин сүүний чиглэлийн цэвэр, эрлийз үхрийг өвөл, хаврын улиралд нэмэгдэл тэжээлээр тэжээж хагас суурин малладаг арга Архангай, Булган, Төв, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий зэрэг аймгуудад түгээмэл хэрэглэгдэж байв. Улаанбаатар, Дархан зэрэг хотод ойр саалийн механикжсан фермүүд нь үнээгээ өвөлдөө бэлчээрт гаргахгүй суурин маллагаанд хадлан, хүчит, шүүст тэжээлээр тэжээж маллаж байв. Түүнчлэн нарийн, нарийвтар ноост Ерөө, Хангай, Орхон хонийг бэлчээрийн маллагааны зэрэгцээ нэмэгдэл тэжээлээр тэжээж, төллөх эм хонь, төлийг маллах битүү дулаан байр, хашаа саравч, материаллаг баазыг бий болгосон байв.

Бидний судалгаагаар суурин маллагааны арга технологи үгүй болж, хагас суурин маллагааны арга технологийг Төв, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын сүүний чиглэлийн үнээ үржүүлдэг 50 гаруй фермерүүд 2001 оноос эхлэн ашиглаж байгааг эс тооцвол өнөөгийн Монголын мал аж ахуйд дан ганц бэлчээрийн мал маллагааны арга технологи ноёрхож байна.

Цаашид мал маллагааны арга хэлбэрийг өөрчилж, ялангуяа хот суурингийн ойролцоох мал бүхий иргэдийг аль болох суурин болон хагас

## 2.6. Мал малла- гааны технологи

суурин мал маллагааны аргад сургах, материаллаг бааз, тэжээлийн нөөцийг бэхжүүлэх шаардлага тавигдаж байна.


**2.7. Малын тэжээл  
ийлдвэрлэл**

Малын тэжээлийн үйлдвэрлэл 1985 оны үед хамгийн дээд хэмжээнд хүрч байснаа 1990-ээд оноос буурч эхэлсэн байна.

1970-1990-ээд он хүртэлх хугацаанд багсармал, холимог тэжээлийн үйлдвэрүүд хурдан хөгжиж 1976 онд 172.2 мянган тонн, 1980 онд 79,8 мянган тонн, 1990 онд 57,5 мянган тонн багсармал тэжээл үйлдвэрлэж байсан бол 2000 онд дөнгөж 1,1 мянган тонн багсармал тэжээл үйлдвэрлэсэн байна.<sup>11</sup> 1980-1985 онд жилд дунджаар 80-200 мянган тонн даршны ургамал тариалж сүүний чиглэлийн үнээний тэжээлд ашиглаж байсан бол 1990 оноос хойшхи хугацаанд даршны ургамал тариалах ажил үндсэндээ үгүй болсон байна.

**Тэжээл үйлдвэрлэлийн нийт хэмжээ  
/мян.тонн тэжээлийн нэгжээр/**

График 9



Эх сурвалж: “Статистикийн эмхтгэл” (УБ 1980, 1985, 1990, 2002)

2000 оноос хойшхи хугацаанд улсын нөөцийн өвсийг тодорхой гэрээ, захиалгаар хадаж өгдөг хувийн хэвшлийн өвс, хадлангийн жижиг аж ахуйнууд Сэлэнгэ, Хэнтий, Дорнод зэрэг аймагт бий болж, тэдгээр аж ахуйнууд энэ чиглэлийн үйл ажиллагаагаар төрөлжих хандлагатай байна. Гэвч малчдын хувьд өвс хадлан хадах талбайг эзэмших, ашиглах асуудал тодорхой биш, үүнээс улбаалан хадлангийн талбайг хамгаалах, сайжруулах талаарх малчдын эрмэлзэл хангалтгүй, хадлангийн механикжсан тоног төхөөрөмж дутагдалтай зэрэг хүндрэл бэрхшээл байсаар байна.

Одоогоор гурилын үйлдвэрүүд тодорхой хэмжээний хивэг үйлдвэрлэж байгааг эс тооцвол багсармал, холимог, шүүст тэжээл тариалж, үйлдвэрлэх явдал 1990-ээд он буюу хувьчлалаас хойш үндсэндээ байхгүй болсон байна.

Цаашид Улаанбаатар, Төвийн бүсийн хот айл, аж ахуй бүрийг таримал тэжээл тариалах боломжоор хангах, бэлчээрийг хамгаалсан, нөхөн сэргээсэн, тэжээлийн ургамал тариалсан аж ахуйн нэгж, иргэдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, санхүүгийн дэмжлэг олгох зэрэг төрөл бүрийн арга хэрэглэж тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

## 2.8. Дігнэлт

1. Сүүлийн жилүүдэд малыг эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд улсын төсвөөс гаргах хөрөнгө нэмэгдэж байгаа боловч мал аж ахуйд орчин үеийн арга технологи нэвтрүүлэх, малын үржил-селекцийн ажлыг эрчимжүүлэх талаарх хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа 1990 оноос өмнөх үеэс буурч уналтын байдалд орсон байна.

2. Монгол орны мал сүргийн бүтэц сүүлийн 10 гаруй жилд нэлээд өөрчлөгдсөн байна. Тухайлбал нийт мал сүрэгт ямааны эзлэх хэмжээ 20-42 хувь хүртэл өсч бусад төрлийн малынх 0.4-2 дахин буурсан байна.

3. Малчдын 27.1-36.7 хувь нь олон улсын байгууллагын төсөл, арга хэмжээ чухал асуудалд чиглээгүй, нийтэд хүрэх хүртээмж муу, үр өгөөж нь ч хангалтгүй гэж үзэж байгаа бол мал аж ахуйн мэргэжилтэн, удирдах ажилтны 49.5-55.3 хувь нь төсөл, арга хэмжээний чухал асуудалд чиглэгдсэн эсэх, үр өгөөжтэй эсэх тухайд санаанд огт нийцэхгүй буюу мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс үзэхэд мал аж ахуйн мэргэжилтэн, удирдах ажилтнууд төсөл арга хэмжээний зориулалт, хүртээмж, үр дүнд малчдаас илүү шүүмжлэлтэй ханддаг, сэтгэл ханамжтай бус байдаг байна.

4. Мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтэн нарын үзэж байгаагаар мал аж ахуйн салбарт оруулах хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бэлчээрийн хуваарилалт ашиглалтыг сайжруулан тэжээлийн нөөцийг бэхжүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, бэлчээрийг усжуулах гэсэн дарааллаар тогтоох шаардлагатай байгааг судалгааны дүн харуулж байна.

5. Улс орон социалист нийгмээс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Засгийн газраас мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь малыг эрүүлжүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, худаг засварлах, малгүй өрхийг малжуулах, улсын төсвөөс санхүүждэг мал аж ахуйн мэргэжлийн байгууллагын тогтолцоог хадгалж үлдэх зэрэг зайлшгүй эн тэргүүнд анхаарвал зохих ажилд чиглэж ирсэн байна. Цаашид Монгол орны мал аж ахуйг дэлхий нийтийн мал аж ахуйн хөгжлийн чиг хандлагын дагуу хөгжүүлэх үүднээс Засгийн газар энэ салбарын хөрөнгө оруулалтын болон бусад бодлого, үйл ажиллагаагаа нарийсган тодорхойлох шаардлага тавигдаж байна.

6. Мал аж ахуйн үйлдвэрлэлд мөрдөгдөж байгаа өнөөгийн хууль, тогтоомжууд нь нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг тэр бүрий хангаж чадахгүй байгаа нь олон нийтийн санаа бодлыг судалсан дүнгээс харагдаж байна. Тухайлбал, малчдын 51.0 хувь, аймаг, сум багийн дарга нарын 31.0 хувь, мал аж ахуйн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан нарын 40.2 хувь, иргэдийн 28.2 хувь нь мал аж ахуйн талаарх хууль тогтоомж санаанд нийцэхгүй байна гэж хариулсан байна. Иймд ойрын хугацаанд, цаг алдалгүй мал аж ахуйн салбарт хууль, эрх зүйн таатай орчныг бий болгох чиглэлээр төр болон холбогдох төрийн бус байгууллагууд идэвхтэй ажиллах шаардлага бий болж байна.

7. Мал аж ахуйн талаар төрөөс гаргасан хууль тогтоомжийг тухайн салбарын мэргэжилтэн, малчдад сурталчлах, ухуулан таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна. Үүний баталгаа нь “Мал аж ахуйн талаарх хууль тогтоомж таны санаанд хэр нийцдэг вэ?” гэсэн асуултад хариулсан аймаг, сум, багийн удирдах ажилтны 30.0 хувь, мал аж ахуйн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан нарын 20.8 хувь, малчдын 19.6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан явдал юм.

8. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын хэмжээнд үржил селекцийн ажил уналтад орж, өндөр ашиг шимтэй цэвэр, эрлийз малын тоо, толгой эрс хорогдсон байна.

**9.** Улсын хэмжээний цэвэр, эрлийз малын тооллогыг 3 жилд нэг удаа явуулж байх шаардлагатай. Цэвэр, эрлийз малыг мэргэжлийн төвшинд өсгөж үржүүлэх, ашиг шимийг нь нэмэгдүүлэх талаар иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулах хандлага нэгэнт бий болж байгаа өнөө үед төрөөс үүнийг татварын бодлогоор дэмжих, загвар аж ахуй, арга технологи нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийх, хөнгөлөлттэй зээл олгох шаардлага тавигдаж байна.

**10.** 1990 оноос хойшхи хугацаанд цэвэр, эрлийз малын тоо, толгой хорогдож, малын өвлийн дулаан байр, хашаа хороо тоногдон эвдэрч, хадлан тэжээл бэлтгэх ажил хумигдахын хэрээр Монгол орны мал аж ахуй дахь байран маллагаа, хагас суурин маллагааны арга технологи үндсэндээ устаж үгүй болж бэлчээрийн мал маллагааны арга голлоход хүрсэн байна.

**11.** Монголд тэжээлийн үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд уналтын байдалд орсон байна. Тэжээлийн үйлдвэрүүд хаагдаж, хүчит, багсармал, хорголжин тэжээлийн үйлдвэрлэл, даршны ургамал тариалалт бүрмөсөн үгүй болж гагцхүү байгалийн хадлан хадах, гурилын үйлдвэрийн хоёрдогч бүтээгдэхүүн болох хивэг үйлдвэрлэх байдлаар л тэжээлийн хэрэгцээг аргацааж байна. Ойрын үед тэжээлийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа сэргэх, тэжээлийн нэр төрөл нэмэгдэх найдвар харагдахгүй байна.

**12.** Тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох, төрөөс улсын нөөцийн өвс, хадлан бэлтгэхэд жил бүр зарцуулж байгаа 0,6-1,0 тэрбум төгрөгийг цаашид өөрийгөө тэтгэх чадамжтай хадлан тэжээлийн бааз суурь бүрдүүлэхэд зарцуулах боломжтой юм.

**БЭЛЧЭЭР, ХАШАА, ХУДГИЙН ХАНГАМЖ,  
АШИГЛАЛТ**

Малчдын өмчийн харилцаа нь үндсэндээ мал, түүнийг адгуулан маллах бэлчээр, малын хашаа хороо, өвөлжөө, хаваржаа, худаг усны асуудал юм. Малчин хүнөдөр тутам мал, бэлчээр, хашаа хороо, ус худагтай харьцаж, эдгээр өмчөөр бие биетэйгээ холбогдож улмаар нийгмийн харилцаанд орж байдаг. Ийм ч учраас энэ бүлэгт бид бэлчээр, худаг ус, хашаа хорооны хүрэлцээ, бэлчээр ашиглах, эзэмших, өмчлөх талаарх малчид, мэргэжилтний бодол, малчид бэлчээрийг эзэмшигч байгаагийн эрх зүйн баталгаа, бэлчээрийн маргааныг зохицуулж буй өнөөгийн байдал зэрэг асуудлаар малчдын санаа бодлыг судалсан судалгааг нэгтгэн оруулав.

Малчдаас **“Танай бэлчээр, худаг ус, хашаа хорооны хүрэлцээ ямар вэ?”** гэсэн асуултыг улирлын байдлаар ангилан асууж дүнг эдийн засгийн бүс нутаг болон малчин өрхийн малын тооноос хамруулан тодорхойлов. Асуултад хариулсан нийт 749 малчин өрхийн 62.9-64.8 хувь нь хашаа хороо хүрэлцээгүй, 27.8-34.3 хувь нь бэлчээр хүрэлцээгүй, 31.8-39.2 хувь нь худаг ус хүрэлцээгүй, 15.3 хувь нь хадлангийн талбай хүрэлцээгүй гэж хариулсан байна /11 дүгээр хүснэгт/.

**Бэлчээр, худаг ус, хашаа хорооны хүрэлцээ**  
*/малчдын үнэлгээ/*

Хүснэгт 11

Өмч	Улирал	Хүрэлцээтэй		Дунд зэрэг		Хүрэлцээгүй		Бүгд	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бэлчээр	өвөл, хавар	193	25.8	348	46.5	208	27.8	749	100.0
	намар, зун	133	17.8	360	48.0	256	34.3	749	100.0
Худаг, ус	өвөл, хавар	234	31.2	276	36.9	239	31.9	749	100.0
	намар, зун	140	18.7	315	42.1	294	39.2	749	100.0
Хашаа, хороо	өвөл, хавар	89	11.9	189	25.2	471	62.9	749	100.0
	намар, зун	72	9.6	192	25.6	485	64.8	749	100.0
Хадлангийн талбай	намар, зун	431	57.6	203	27.1	115	15.3	749	100.0

Бэлчээр, хадлангийн талбай, хашаа хороо, худаг усны хүрэлцээний талаар малчдын санаа бодол ямар байгааг эдийн засгийн бүс тус бүрээр авч үзэхдээ мал маллахад хүрэлцээгүй хүчин зүйлүүдийн шалтгааныг аль болох тодруулахыг хичээв.

**Бэлчээрийн хүрэлцээ.** Судалгаанд хамрагдсан нийт малчдын 27.8-34.3 хувь нь бэлчээрийн хүрэлцээ хангалтгүй гэж хариулсан байна. Эдийн засгийн зүүн бүсийн аймгийн малчдын 44,0 хувь нь өвөл хаврын улиралд, 56,4 хувь нь зун намрын улиралд бэлчээрийн хүрэлцээ хангалтгүй гэж хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Хэнтий, Сүхбаатар аймгийн ихэнх нутагт сүүлийн жилүүдэд үлийн цагаан оготно өсч бэлчээрийг сүйтгэсэн, бэлчээрийн ургац ихтэй нутагт усны хангамж хүрэлцээгүй, ус бэлчээр тэгширсэн нутагт Төв, Дорноговь, Нийслэлийн малчид олноороо ирж оторлон өвөлждөг, зундаа нутгийн малчид усаа бараадаж төвлөрдөг зэрэг нь дээрх аймгуудад бэлчээрийн хомсдол ихтэй гэж үзэх үндсэн шалтгаан болж байна. Улаанбаатарын бүсийн малчдын 52.6 хувь нь зун, намрын улиралд бэлчээрийн хүрэлцээ муу гэж хариулсан нь дээрх хугацаанд нийслэлийн ойр орчмын зуслангийн газарт нутгийн уугуул малчид

3.1. Бэлчээр, худаг ус, хашаа хороо, хадлангийн талбайн хирэлцээний талаарх малчдын санаа бодол

төдийгүй зэргэлдээ аймгуудаас мал бүхий иргэд олноор нүүдэллэн ирж, зах зээлд сүү, цагаан идээгээ борлуулж байгаатай шууд холбоотой байна.

**Бэлчээр, худаг ус, хашаа хорооны хүрэлцээний талаарх малчдын бодол**  
/эдийн засгийн бүсээр/

**Хүснэгт 12**

Үзүүлэлтүүд /хувиар/		Хангай	Баруун	Төв	Зүүн	УБ
Бэлчээрийн хүрэлцээ /өвөл, хавар/	1	31.6	26.3	26.2	8.3	47.4
	2	41.8	50.2	53.0	47.7	15.8
	3	26.6	23.5	20.8	44.0	36.8
Дүн		100.0	100.0	100.0	100.0	100.0
Бэлчээрийн хүрэлцээ /зун, намар/	1	19.6	14.8	26.5	3.0	26.3
	2	49.3	50.7	51.2	40.6	21.1
	3	31.1	34.5	22.3	56.4	52.6
Дүн		100.0	100.0	100.0	100.0	100.0
Худаг, усны хүрэлцээ /өвөл, хавар/	1	47.9	23.6	20.2	26.4	21.1
	2	27.7	40.9	44.2	43.4	21.1
	3	24.4	35.5	35.6	30.2	57.8
Дүн		100.0	100.0	100.0	100.0	100.0
Худаг, усны хүрэлцээ /зун, намар/	1	26.1	9.7	21.0	16.0	26.3
	2	39.4	44.9	38.3	49.0	26.3
	3	34.5	45.4	70.7	35.0	47.4
Дүн		100.0	100.0	100.0	100.0	100.0
Хашаа хорооны хүрэлцээ /өвөл, хавар/	1	6.1	21.9	9.9	9.7	5.3
	2	21.5	25.7	26.5	28.2	15.8
	3	72.4	52.4	63.6	62.1	78.9
Дүн		100.0	100.0	100.0	100.0	100.0
Хашаа хорооны хүрэлцээ /зун, намар/	1	7.0	14.1	7.7	10.9	5.3
	2	20.0	26.7	34.0	20.8	10.5
	3	73.0	59.2	58.3	68.3	84.2
Дүн		100.0	100.0	100.0	100.0	100.0
Хадлангийн талбай /зун, намар/	1	48.6	62.4	73.1	46.2	57.8
	2	31.6	26.1	16.2	31.7	21.1
	3	19.8	11.5	10.7	22.1	21.1
Дүн		100.0	100.0	100.0	100.0	100.0

**Тайлбар:** 1 - Хүрэлцээтэй; 2 - Дунд зэрэг; 3 - Хүрэлцээгүй

Ийнхүү малчид зах зээл, зам харилцаа, худаг усны ойр орчмын бэлчээрийн ачааллыг хэтрүүлэн ашиглах явдал нийтлэг байгаа нь цаашид бэлчээрийн талхагдлыг улам гүнзгийрүүлэх үндсэн шалтгаан болж байна. Бэлчээрийг хэт олон малаар сэлгээгүй ашиглаж талхагдалд оруулснаар хот орчмын бэлчээрийн 30 гаруй хувь нь шарилж, лууль зэрэг мал иддэггүй хогийн ургамалд эзлэгдсэн байна.

Бэлчээрийг ашиглагч малчид нь зах зээлийн жам ёсоор ашигтай байрлал бүхий бэлчээрийг “малын хөлийн зудаар” талхлах нь нэгэнтээ тодорхой байгаа эдүгээ цагт бэлчээрийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг төрийн онцгой бодлогын хэмжээнд тавьж, дорвитой арга хэмжээ авахгүй аваас ойрын 3-5 жилд Монгол орны бэлчээр нь хүний үйл ажиллагаа болон байгаль, цаг уурын дулаарлын хавсарсан нөлөөгөөр буцаад сэргэшгүй байдалд орж цөлжилт нүүрлэх дүр зураг харагдаж байна.

**Худаг, усны хүрэлцээ.** Судалгаанд хамрагдсан нийт малчдын 31.8-39.2 хувь нь худаг усны хүрэлцээ хангалтгүй гэж үздэгээ илэрхийлсэн бөгөөд Төвийн бүсийн аймгуудын малчид, тэдгээрийн дотор Өмнөговь, Дундговь, Төв аймгийн малчдын 70 гаруй хувь нь худаг усны хүрэлцээ зун, намрын улиралд хүрэлцээгүй байна гэж үзсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Учрыг нягтлан авч үзвэл 1990 оноос хойшхи хугацаанд гүнийн болон уурхайн



худаг эзэнгүйдэж ихэнх нь тоногдож, ашиглалтгүй болсонтой холбоотой байна.

Говийн аймгуудад зун цагт худаг усны хүрэлцээ хангамж өвөл цагийнхаасаа бараг 2 дахин доогуур байдаг гэж малчид дүгнэсэн байна.

Говийн аймгийн малчид заавал булаг шанд буюу худагтай нутагт өвөлжиж хаварждаг, зарим үед өвөлдөө байгалийн цасаар малаа ундаалдаг, зуны цагт өвөлжөө хаваржааныхаа бэлчээрийг аль болох хамгаалж ус, худагтай бэлчээр даган нүүдэллэх болдогоос усны хүрэлцээний талаар улирлаас хамааралтай хариулт өгч байгаа аж. Малчид ус, худгийн хүрэлцээ хангамжийн талаар санал бодлоо илэрхийлэхдээ малаа бодож хариулт өгснөөс бус хүний уух усны эрүүл ахуй, ариун цэврийн талаар төдийлөн бодолцохгүй байгаа нь ажиглагдаж байв. Улаанбаатарын бүсийн малчдын 57.8 хувь нь өвөл хаврын улиралд усны хүрэлцээ хангалтгүй байна гэж хариулсан нь нэлээд өндөр үзүүлэлт болж байна. Улаанбаатар орчмын малчдын дийлэнх нь малаа услахдаа мал бүрийн тоогоор тухайн нутагт байгаа худгийн эзэн, аж ахуйн байгууллагад тогтмол тарифаар үнэ төлдөг нь тэд усны хүрэлцээ муу гэж хэлэх нэг үндэслэл болж байна. Цаашид бэлчээрт худаг гаргах, өөрсдийн хөрөнгөөр худаг гаргасан малчинд тухайн худгийн ойр орчмын бэлчээрийг эзэмшиж ашиглах давуу эрх олгох зэрэг урамшууллын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

**Малын хашаа хорооны хүрэлцээ.** Судалгаанд хамрагдсан нийт малчдын 62,9-64.8 хувь нь малын хашаа хорооны хангамж хүрэлцээгүй гэж үзсэн байна. Малчдын мал маллахад дутагдаж, гачигдаж байгаа хүчин зүйлүүдийн дотроос хамгийн их дутагдалтай, хүрэлцээгүй асуудал бол малын хашаа хороо болох нь эндээс харагдаж байна. Эдийн засгийн бүс нутгаар авч үзвэл малын хашаа хорооны хүрэлцээ хангамж Улаанбаатарын бүсэд хамгийн муу байгаа боловч бусад бүсүүдэд ч энэ үзүүлэлт адил төстэй байна. Сүүлийн жилүүдэд малын тохилог хашаа хороо барих асуудал бараг үгүй болсон, шинээр малчин болсон малчин өрхүүд тэр бүр өвөлжөө хаваржааны хашаатай болж чадаагүй, бусдын хашаа, хороогтүр зуур ашиглах явдал түгээмэл байгаа, 1990 оноос өмнө баригдсан хашаа хороо ихэнхдээ хуучирч, элэгдэлд орсон, малын хашаа хороо шинээр барихад мод, чулуу, цемент зэрэг барилгын материал зайлшгүй шаардлагатайгаас гадна тээвэр, хүн хүч, хөдөлмөр их ордог зэрэг бэрхшээл байдаг тухай малчид өгүүлж байв. Малчдад тохиолдож байгаа хамгийн гол бэрхшээл, дутагдаж хомсдож байгаа зүйл нь бэлчээр, худаг усны хүрэлцээний асуудал гэж төсөөлж байсан бидний төсөөлөл буруу болж харин мал маллахад хамгийн хүрэлцээгүй байгаа зүйл нь хашаа хороо болох нь судалгааны дүнгээр тогтоогдож байна.

Малчид мал аж ахуй дахь элдэв бэрхшээлийн талаар ярихдаа хамгийн нийтлэг асуудал болох бэлчээр ашиглалт, худаг усны тухай асуудлыг ярьдаг боловч үнэн хэрэгтээ тэдний хамгийн чухал, хүрэлцээ багатай байдаг асуудал нь хашаа хорооны хүрэлцээний асуудал байна.


**Хадлангийн талбайн хүрэлцээ.** Хадлангийн талбайн хүрэлцээгүй байна гэж нийт малчдын 15.3 хувь нь үзэж байна. Хадлангийн талбайг зөв хуваарилж, малчин өрх бүрийг хадлангийн талбайтай болгох аваас хадлан хадах талбайн хүрэлцээтэй гэж малчдын дийлэнх нь үздэг аж.

**3.2. Бэлчээр ашиглах, эзэмших баталгааны талаар малчдын бодол**

Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлд “Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан багийн Иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно” гэж заасан байдаг.

**Бэлчээрийг эзэмшигч байхын баталгаа юу вэ?**

График 10



Хуулийн энэ заалтны хэрхэн хэрэгжиж байгаа, малчид өвөлжөө, хаваржаагаа өөрийн эзэмшлийн өмч мөн гэдгийг хэрхэн баталгаажуулж, ойлгож байгааг тодруулах зорилгоор малчдаас **Танд өвөлжөө, хаваржааны бэлчээрийг эзэмшигч байхын баталгаа нь юу вэ?** гэсэн асуулт тавьж хариулт авав /10 дугаар график/.

Энэхүү асуултад хариулсан нийт малчдын 43.3 хувь нь олон жил нутаглаж ирсэн уламжлал нь өвөлжөө хаваржааны бэлчээрийг эзэмшигч байхын баталгаа болж байна гэж үзсэн нь хариултын хамгийн их хувийг эзэлж байна.

Санал асуулгад оролцсон малчдын 28.3 хувь нь өвөлжөө, хаваржаанд манай хашаа, хороо байгаа нь, 15 хувь нь ямар ч баталгаа байхгүй, 11 хувь нь сум, багаас хуваарилж өгсөн нь бэлчээрийг эзэмшигч байхын баталгаа гэж ойлгож байна гэж хариулжээ.

Энэхүү судалгааны дүнгээс үзэхэд өвөлжөө хаваржааны бэлчээрийг сум, багаас хуваарилах, бэлчээрийн ашиглалт, эзэмшилтэд орон нутгийн төрийн байгууллагаас оролцох, зохицуулах үйл ажиллагаа хангалттай бус амьдрал дээр бэлчээрийг хуваарилах, зохицуулах үйл ажиллагаа нь мал аж ахуйн хэвшсэн уламжлалт байдал, нутаг бэлчээрийн онцлог, хүмүүсийн хоорондын харилцаагаар зохицуулагдаж байна гэж үзэж болохоор байна.

**3.3. Бэлчээрийн маргаан**

Бэлчээр ашиглалтын хувьд малчдын санааг яах аргагүй зовоож байгаа зүйл бол бэлчээрийн маргаан байдаг аж. Малчдын бэлчээрийн маргаан нь цаг үеийн шинжтэй, зуслан, намаржаанд буух, өвөлжөө, хаваржаанд орох яг тэр үед илүү их санаа зовоосон, зөрчил агуулсан асуудал байдаг боловч малчид тэр бүр ам муруйгаад байдаггүй байна. Нэгэнт зуслан намаржаанд хаяа хаяагаа дэрлээд буусан айлууд монгол ардын зүйр үгийг бодож, бэлчээр нийтийн өмч гэсэн хуулийг баримталж **“хаяа багтахаараа бууж, хамар багтахаараа иддэг”** байна. Бэлчээр нь хэн нэгний өмч биш, нийтийн өмч учир бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, зөв зохистой ашиглах талаар хүмүүс санаа зовохоос цаашгүй байдаг байна.

Судалгааны багаас **“Бэлчээрийн маргааныг хэн зохицуулж чадах вэ?”** гэсэн асуултаар малчдаас санал асуулга авч хариултыг тэдний нас, боловсролын байдлаар харьцуулж судлав.

Бэлчээрийн маргааныг хэн зохицуулж чадах вэ гэсэн асуултад малчдын 42.8 хувь нь малчид өөрсдөө, 39.2 хувь нь сум, багийн Засаг дарга, 10.3 хувь нь аль нь ч чадахгүй өөр арга олох хэрэгтэй, 5.3 хувь нь нутаг усандаа нөлөөтэй хүмүүс зохицуулж чадна гэж үзсэн байна. Бэлчээрийн маргааныг зохицуулах талаарх малчдын хариултыг тэдний нас, боловсролын түвшин, оршин байгаа бүс нутгаас хамаарч судалж үзэхэд төдийлөн ялгаа гарахгүй байв.

**“Бэлчээрийн маргааныг хэн зохицуулж чадах вэ?”**

*Хүснэгт 13*

Хариулт	Хариултын тоо	Нийт дүнд эзлэх хувь
Сум, багийн Засаг дарга	303	39.2
Нутаг усандаа нөлөөтэй хүмүүс	41	5.3
Малчид өөрсдөө	331	42.8
Аль нь ч чадахгүй, өөр арга олох хэрэгтэй	79	10.3
Бусад	9	1.2
Хариулаагүй	10	1.3
Бүгд	773	100.0

Түүнчлэн малчдын боловсролын түвшин нэмэгдэх тутам бэлчээрийн маргааныг сум, багийн Засаг дарга зохицуулж чадна гэсэн хариултыг сонгох сонголт нэмэгдэж байсан юм /Хавсралт 3, 4–р хүснэгт/.

“Бэлчээрийг ашиглах эзэмших талаарх таны бодол” гэсэн асуултыг малчин өрхүүдийн дунд тавьж хариулт авахад нийт малчин өрхийн 77.1-77.5 хувь нь бэлчээрийг нийтээр эзэмших, 11.0—13.9 хувь нь гэрээгээр ашиглах, 4.0-9.3 хувь нь бэлчээрийг хувьдаа өмчлөх нь зүйтэй гэж үзсэн байна /14 дүгээр хүснэгт/.

**Бэлчээрийг ашиглах, эзэмших талаарх малчдын бодол**

*Хүснэгт 14*

Хариулт	Улирал	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага		Дүн	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Нийтээр дундаа ашиглах	өвөл, хавар	12	42.9	50	70	384	77.8	109	85.4	556	77.1
	зун, намар	22	76	50	69	389	79	98	76.5	559	77.5
Гэрээгээр ашиглах	өвөл, хавар	7	25	7	10	58	11.7	7	5.4	79	11
	зун, намар	2	8	12	17	65	13.1	22	16.8	100	13.9
Гэрээгээр эзэмших	өвөл, хавар	2	3.6	3	4.5	6	1.2	2	1.5	12	1.7
	зун, намар	0	0	1	1.6	19	3.9	5	4.2	26	3.6
Хувьдаа өмчлөх	өвөл, хавар	8	28.5	10	13	40	8.2	9	6.9	67	9.3
	зун, намар	5	16	8	12	15	3	2	1.7	30	4
Мэдэжгүй	өвөл, хавар	0	0	2	1.6	5	1.1	1	0.8	8	0.9
	зун, намар	0	0	1	1.5	5	1	1	0.8	7	1
Дүн	өвөл, хавар	29	100	72	100	493	100	128	100	722	100
	зун, намар	29	100	72	100	493	100	128	100	722	100

Малчид бэлчээрийг ашиглах, эзэмших, өмчлөх асуудлаар өвөл-хавар, зун-намрын бэлчээр гэж төдийлөн ялгаатай авч үзэхгүй байна. Гэхдээ өвөл-хаврын бэлчээрийг өөрийн эзэмшил өмчид байлгаж, зун-намрын бэлчээрийг нийтээр эзэмших гэсэн санал арай илүү байгаа нь ажиглагдаж байна.

Бэлчээрийг хувьдаа өмчлөхийг хүсч байгаа малчдын 80 гаруй хувь нь сүүний чиглэлийн жижиг фермерийн аж ахуй эрхэлдэг, зах зээлд ойртон суурьшсан малчид байв. Түүнчлэн дээд болон тусгай дунд мэргэжилтэй малчид бэлчээрийг хувьдаа өмчлөх сонирхол илүү их байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна. Малчдын дийлэнх нь бэлчээрийг хувьд өмчлүүлэх асуудлаас нэлээд болгоомжилж байгаа тал ажиглагдаж байна. Тэдний дөнгөж 4-9.3 хувь нь уг асуудлыг зөвшөөрч байгаа юм.

**3.4. Бэлчээрийг эзэмших, ашиглах, өмчлөх талаарх малчид, иргэдийн бодол**

Мөн дээрх асуултыг удирдах ажилтан, эрдэмтэн мэргэжилтэнд тавьж саналын дүнг 15 дугаар хүснэгтээр үзүүлэв.

**Бэлчээрийг ашиглах, эзэмших, өмчлөх талаарх удирдах ажилтан, эрдэмтэн, мэргэжилтний бодол**

*Хүснэгт 15*

Мал аж ахуйг эрхлэх хэлбэр	Нийтээр ашиглах		Гэрээгээр ашиглах		Гэрээгээр эзэмших		Өмчлөх		Хариулт өгөөгүй		Бүгд	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бэлчээрийн	160	71.1	16	7.1	29	12.9	9	4.0	11	4.9	225	100.0
Хагас суурин	27	12.0	98	43.6	55	24.4	23	10.2	22	9.8	225	100.0
Суурин	18	8.0	39	17.3	59	26.2	78	34.7	31	13.8	225	100.0

Удирдах ажилтан, мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтнүүдийн дийлэнх нь буюу 71.1 хувь бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа нөхцөлд бэлчээрийг нийтээр ашиглах нь зүйтэй гэсэн саналтай байгаа нь малчдын саналтай /77.0 хувь/ бараг дүйж байна. Харин хагас суурин мал аж ахуй эрхлэхэд бэлчээрийг гэрээгээр ашиглах нь олонхийн саналыг буюу 43.6 хувийг авсан байхад бэлчээрийг нийтээр ашиглах саналыг дөнгөж 12.0 хувь нь сонгожээ. Гэтэл суурин мал аж ахуй эрхлэхэд бэлчээрийг өмчлөх санал хамгийн өндөр буюу судалгаанд оролцогсдын 34.7 хувийг, гэрээгээр эзэмших саналыг 26.2 хувь нь өгсөн байна. Эндээс үзэхэд бэлчээрийн мал аж ахуйгаас суурин маллагаанд шилжих тутам бэлчээрийг малчдад өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэх шаардлага урган гарч байна.

**3.5. Дігнэлт**

**1.** Малчдын хувьд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд дутагдаж байгаа хамгийн гол зүйл нь хашаа, хороо болох нь судалгаагаар нотлогдож байна. Тухайлбал судалгаанд оролцсон малчдын 64.8 хувь нь хашаа хороо хүрэлцээгүй гэсэн байна. Энэ байдлаас үндэслэн юуны өмнө малчдын хашаа хорооны хангамжийн асуудалд анхаарал тавих шаардлагатай болох нь харагдаж байна. Бэлчээрийг хуваарьтай ашиглах, зэлүүд бэлчээрийг ашиглах асуудал нь тухайн нутагт хашаа хорооны хүрэлцээг хэрхэн шийдвэрлэснээс хамаарч болох талтай байна.

**2.** Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд малчдад дутагдаж байгаа хоёр дахь зүйл нь малын усан хангамж юм. Малчдын 39.2 хувь нь зун, намрын улиралд худаг усны хангамж хүрэлцээгүй байна гэж үзэж байгаа бөгөөд энэхүү асуудлыг эдийн засгийн бүсээр авч үзвэл зун, намрын улиралд эдийн засгийн Төвийн бүсэд усан хангамжийн хүрэлцээгүй байдал 70 хувьд хүрч байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

**3.** Бэлчээрийн хангамж хүрэлцээгүй байна гэж малчдын 34.3 хувь нь дүгнэсэн байна. Усжуулах ажлыг шийдвэрлэж, бэлчээрийг зохистой ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлснээр бэлчээрийн хангамж, хүрэлцээг нэмэгдүүлэх боломжтой.

**4.** Малчдын дүгнэж байгаагаар бэлчээр, усны хангамж хүрэлцээ нь улирлын байдлаас хамаарч өөрчлөгдөж байна. Тухайлбал зун, намрын улиралд бэлчээр усны хүрэлцээ хангамж өвөл хаврын улирлаас илүү дутагдалтай байдаг байна. Иймд зуслан намаржааны бэлчээрийн усан хангамжийг сайжруулах асуудалд түлхүү анхаарах шаардлагатай байна.

**5.** Бэлчээрийн маргааныг бодит амьдрал дээр малчид өөрсдөө зохицуулж байна. Бэлчээрийн маргааныг зохицуулах, бэлчээрийн ашиглалт, хуваарилалтыг зохион байгуулах талаарх Газрын тухай хуулийн 52 дугаар заалт амьдралд нийцэхгүй, хэрэгжихгүй байна.

6. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа нөхцөлд бэлчээрийг нийтээр эзэмших нь зүйтэй гэж удирдах ажилтан, мэргэжилтэн, иргэд, малчид бүгд санал нэгтэй байна. Харин бэлчээрийн мал аж ахуйгаас суурин мал аж ахуйн хэлбэрт шилжих тутам бэлчээрийг өмчлүүлэх асуудал тавигдаж байна. Иймд мал аж ахуйд хөрөнгө оруулалт хийж, эрчимжсэн аргаар аж ахуй эрхлэх тохиолдолд бэлчээрийг эзэмших, ашиглах асуудлыг зохицуулах эрх зүйн зохих орчинг нь бүрдүүлэх шаардлагатай.

## ДЭРЭВДІГЭЭР БІЛЭГ:

### МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН БИТЭЭМЖ, ЦААШДЫН ХАНДЛАГА

#### 4.1. Хөдөлмөрийн битээмжийн өндөргийн байдал

Хөдөлмөрийн бүтээмж гэдэг үзүүлэлт нь тухайн салбарын эдийн засгийн үр ашгийг тодорхойлох гол үзүүлэлт юм. 1990 оноос өмнө нэг суурьт байх малын тоо толгойг тухайн үеийн Сайд нарын Зөвлөлийн тогтоол, Нэгдлийн Холбооны Дээд Зөвлөлийн шийдвэрээр тогтоож уг норм, нормативыг хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйд мөрдлөг болгон хэрэгжүүлж байв /16 дугаар хүснэгт/.

#### Хөдөө аж ахуйн нэгдлийн суурь зохион байгуулалтын норм

##### Хүснэгт 16

Малын төрөл	Нэг суурьт байх малын тоо	Богд шилжүүлснээр	Нэг суурьт ажиллах малчны тоо	Нэг хүнд ногдох мал, дунджаар /богоор/
Ингэ	70-90	490-810	3	216
Сувай тэмээ	175-225	1225-1575	3	466
Гүү	140-200	840-1200	2	520
Эр сувай адуу	360-600	2160-3600	4	720
Үнээ	90-150	540-900	2	360
Эр сувай үхэр	140-230	840-1380	2	555
Эм хонь	400-700	400-700	2	275
Төлөг, борлон	500-850	500-850	2	337
Эм ямаа	350-650	350-650	2	500

*Эх сурвалж:* Г.Чадраабал, Ч.Арилдий нар, “БНМАУ-ын малаж ахуйг хөтлөх систем” (УБ 1982)

Бодит байдал дээр ч 1990 оноос өмнө нэг суурьт байх малын тоо 16 дугаар хүснэгтэд үзүүлсэн хэмжээнд хүрч нэг хүнд ногдох малын тоо /богоор/ малын төрөл, нас хүйсээс шалтгаалан 275-720 толгойд хүрч байжээ. Харин 1990 оноос хойш малыг малчдад өгч өмч хувьчлал, зах зээлийн харилцаа эхэлснээс хойш байдал нэлээд өөрчлөгдөж мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хөдөлмөрийн бүтээмж үлэмж хэмжээгээр буурсан байна.

Тухайлбал, хөдөлмөрийн чадвартай нэг малчин хүнд хонин толгойд шилжүүлснээр хичнээн мал ногдож байгааг судалгаанд хамрагдсан 770 гаруй малчин өрх дээр тооцож үзэхэд хөдөлмөрийн чадвартай нэг хүнд ногдох малын тоо /богд шилжүүлснээр/ 70.1 толгой мал болж байна. Төслийн багийн гүйцэтгэсэн энэхүү судалгаа нь мал аж ахуйн хөдөлмөрийн бүтээмжийн өнөөгийн дүр төрхийг нэлээд ойролцоо илэрхийлж чадна гэж үзэж байна /17 дугаар хүснэгт/.

Хөдөлмөрийн бүтээмжийн тухай үзүүлэлтийг авч үзэхдээ нэг хүнд ногдох малын тоо толгойгоос гадна нэгж малаас авах ашиг шимийн өөрчлөлт, мал ажахуйн хүнд хүчир ажилд техник хэрэгсэл хэр зэрэг хэрэглэж хөдөлмөрөө хэрхэн хөнгөлж, бүтээмжийг нэмэгдүүлж байгаа зэрэг үзүүлэлтийг авч үзэх ёстой. Гэвч бодит байдал дээр Улаанбаатар хот орчмын сүүний чиглэлийн үхэр өсгөж байгаа цөөн тооны иргэн, аж ахуйн нэгжийг эс тооцвол нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэх, хүнд хүчир ажилд техник хэрэгсэл хэрэглэх зэрэг хөдөлмөрийн бүтээмж нэмэгдүүлэх хүчин зүйлүүд төдийлөн нэвтрээгүй байна. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан авч үзвэл өнөөгийн мал аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж нь гол төлөв хөдөлмөрийн насны нэг хүнд ногдох малын тоогоор тодорхойлогдоход хүрч байна.

**Судалгаанд сонгосон малчин өрхийн бүлэглэл**  
/хөдөлмөрийн насны нэг хүнд ногдох малын тоогоор/

Хүснэгт 17

Бүс		Хөдөлмөрийн насны нэг хүнд ногдох малын тоо /богоор/						Дүн	Нэг хүнд ногдох мал /богоор
		0-20	21-40	41-70	71-100	101-150	151-		
Хангай	Тоо	30	38	48	41	32	41	230	75.5
	Хувь	13.0	16.6	20.8	17.8	13.9	17.8	100.0	
Баруун	Тоо	18	34	67	28	31	22	200	72.3
	Хувь	9.0	17.0	33.5	14.0	15.5	11.0	100.0	
Төв	Тоо	21	29	32	26	16	29	153	74.7
	Хувь	13.7	19.0	20.8	17.0	10.5	19.0	100.0	
Зүүн	Тоо	12	6	10	10	21	47	106	66.9
	Хувь	11.3	5.6	9.4	9.4	19.8	44.3	100.0	
УБ хот	Тоо	4	3	5	2	3	1	18	61.2
	Хувь	22.2	16.7	27.8	11.0	16.7	5.6	100.0	
Дүн	Тоо	91	110	162	107	103	140	713	70.1
	Нийт малчдын дүнд эзлэх хувь	12.8	15.4	22.7	15.0	14.4	19.7	100.0	

Өнөөгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн бүтээмжийг нэг хүнд ногдох малын тоогоор авч үзэж 1990 оноос өмнөхтэй харьцуулбал ойролцоогоор нэг хүнд ногдох малын тоо 4-5 дахин буурсан дүнтэй байна. Ийм нөхцөлд малчдын ашиг, орлого нэмэгдэж, тэдний амьдрал сайжрах боломж улам бүр хязгаарлагдаж байна. Өнөөгийн байдлаар хөдөлмөрийн чадвартай нэг хүнд 70.1 толгой бог мал ногдож байгаа бөгөөд 70 толгой богоос жилдээ 200-300 мянган төгрөгийн бүтээгдэхүүн авна гэж үзэхэд өрх гэрийн амьдрал ахуйд яавч хүрэлцэхгүй тооцоо гарч байна. Мал аж ахуйн салбарт хөдөлмөрийн бүтээмж буурсан нь дараахь шалтгаантай байж болох юм. Үүнд:

- 1990 оноос хойшхи хугацаанд малчин өрх бүр зөвхөн өөрсдийн цөөн хэдэн малаа маллах болсон, аймаг, хот, сумын төв, суурингаас олон мянган хүн хөдөөг зорьж мал хувьчлалаар өөрт ногдох цөөн тооны малаа хариулан хөдөөд суурьшсан, малчны тоо өсч нэг хүнд ногдох малын тоо буурсан.
- Мал бүхий иргэд насанд хүрээгүй хүүхэд болон өөрийн ам бүлд багтдаг өндөр настан, насанд хүрсэн хүүхдээ тусад нь малчин өрх гэж бүртгүүлж тэдний нэр дээр мал тоолуулдаг. Энэ нь 150 хүртэл толгой малтай өрхийг мал аж ахуйн татвараас чөлөөлсөн 1996-2000 оны үеийн татварын бодлоготой холбоотой.


Эдгээр шалтгааны улмаас малчин өрхийн тоо сүүлийн 10 гаруй жилд 3 дахин өссөн дүн гарч байна. Тухайлбал, 2000 онд 191.5 мянган малчин өрх, 421.4 мянган малчин тоологдсон нь 1986 оныхоос малчин өрхийн тоо 128.8 мянгаар буюу 3 дахин, малчны тоо 297.9 мянгаар буюу 3.4 дахин өссөн байна.<sup>10</sup>

1990 онд нийт малчны тоо 147.5 мянга, нийт малын тоо 25.8 сая толгой байсан бөгөөд нэг малчинд дунджаар 175 толгой мал ногдож байсан байна. Харин 2000 онд хөдөлмөрийн бүтээмжийн гол үзүүлэлт болох дээрх үзүүлэлт 71.7 толгой мал болж буурсан байна /11 дүгээр график/.

<sup>10</sup> Мал тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогын 2002 оны дүнгийн танилцуулга, УСГ, 2003.04.01

Малчин өрх, малчны тооны өөрчлөлт

График 11



Эх сурвалж: Мал тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогын 2002, 2003 оны дүнгийн танилцуулга, ҮСГ, 2003.04.01, 2004.04.15

4.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх цаашдын хандлага

Монгол орны мал аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж 1990 оноос хойш 2-5 дахин буурсан тухай дээр өгүүлсэн. Хөдөлмөрийн чадвартай нэг хүнд<sup>11</sup> ногдох малын тоог нэмэгдүүлж хөдөлмөрийн бүтээмжийг хэрхэн өсгөх тухай асуудал нь мал аж ахуйн салбарын цаашдын хөгжлийн чиг хандлагын гол асуудал байх учиртай.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж хөдөлмөрийн чадвартай нэг хүнд ногдох малын тоог /богоор/ хамгийн бага норматив болох 200 толгойд хүргэж тооцож үзэхэд улсын хэмжээнд 227.7 мянган малчин байхад хангалттай байх тооцоо гарч байна. Гэтэл өнөөдөр мал аж ахуйн салбарт 380 гаруй мянган малчин ажиллаж байна /2003 оны мал тооллогын дүн/. Дээр дурдсан хоёр тооны зөрүүгээр тооцох аваас 160 мянган малчин мал аж ахуйн салбарт хөдөлмөрийн бүтээмж багатайгаас ашиг орлого олж амьдралаа дээшлүүлэх боломжгүй байдалд байна. Нөгөө талаар мал аж ахуйн салбарт 160 мянга гаруй хүний хөдөлмөрийн нөөц илүүдэж байна гэж үзэж ч болох юм. Бидний энэхүү дүгнэлт нь бусад судлаачдын дүгнэлттэй ойролцоо байна. Тухайлбал, С.Хандсүрэнгийн судалгаагаар (1998 он) “Малын тоог малчдын бүтээмжтэй уялдуулан тооцож үзэхэд 1997 онд Монголын мал аж ахуйд 167 мянган малчин илүүдэж байна”<sup>12</sup> гэсэн бол Эдийн засгийн ухааны доктор (Ph.) А.Бакей нарын гүйцэтгэсэн “Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөцийг зохистой ашиглах тухай”<sup>13</sup> судалгааны үр дүнд 1997 оны байдлаар Монгол улсын мал аж ахуйн салбарт 167.3 мянган малчин илүүдэлтэй байгааг тогтоожээ.

Мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн нөөцийн байдлыг нарийвчлан судлах асуудал салбарын чухал асуудлын нэг болж байна.

Хөдөөд мал аж ахуйгаас өөрөөр орлого олох боломжуудыг бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, тэжээл бэлтгэлийг нэмэгдүүлэх, мал аж ахуйд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн

<sup>11</sup> 18-60 настай эрэгтэй, 18-55 настай эмэгтэй болон албан ёсоор хөдөлмөр эрхлэх чадваргүй гэж эмнэлгийн магадлагаагаар тогтоогдсоноос бусад хүнийг хөдөлмөрийн чадвартай хүн гэж үзэж энэхүү үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан өрхийн доторх хөдөлмөрийн чадвартай хүний тоог тогтоосон болно.

<sup>12</sup> С.Хандсүрэн “Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөц ашиглалт” Доктор(Ph.D)-ын диссертаци. УБ, ХААИС. 1998. 182 хууд. Монгол.

<sup>13</sup> А.Бакей нар “Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөцийг зохистой ашиглах тухай” Төслийн тайлан. УБ, 2000. ХААИС, ЭЗФ, 2000. 41 хууд. Монгол.



дэмжиж хөлсний малчин бүхий мал аж ахуйн жижиг, дунд аж ахуйг олноор бий болгох зэргээр мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх нь мал аж ахуйн хөгжлийн цаашдын хандлага байх ёстой.

Хорших, хамтрах нь мал аж ахуйн салбарын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чухал аргамөн. Малчид, хувь хүмүүс, аж ахуйн нэгжүүд хоорондоо хорших үйл явцыг ямагт дэмжих ёстой.

**1.** Малаж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн бүтээмж сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд 4-5 дахин буурч малчдын 80 гаруй хувь нь өөрсдийн хөдөлмөрийн чадвараас харьцангуй бага тооны мал маллаж тэр хэмжээгээр амьжиргааны доройтолд орсоор байна.

**2.** Хувийн хэвшлийнаж ахуйн нэгж, байгууллагаас малаж ахуйн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг дэмжиж, нэг хүнд ногдох малын тоог цөөрүүлж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх уг салбарын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйг хөгжүүлэх нь хөгжлийн зөв чиг хандлага мөн.

#### **4.3. Дігнэлт**

БАЙГАЛЬ, ЦАГ УУР БА МАЛ АЖ АХУЙ

5.1. Байгаль, цаг уурын төлөв байдал мал аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлөх нь

Сүүлийн жилүүдэд Монгол орны эко системд мэдэгдэхүйц өөрчлөлт орж байгаа нь цөлжилт, хөрсний элэгдэл идэвхжих, усны нөөц, биологийн төрөл, зүйл хомсдох, байгалийн гамшигийн давтагдал ихсэх, гол горхи, булаг шанд ширгэх зэргээр илэрч байна.

Монгол орны хэмжээнд цаг уурын ажиглалт хийсэн сүүлийн 62 жилийн хэмжилтийн мэдээг дундажлан сар сараар нь авч үзвэл 4 болон 8 дугаар саруудад тодорхой дулааралт, сэрүүсэлт илрээгүй боловч, жилийн дундаж агаарын температур 1.56°C хэм, өвлийн улиралд 3.6°C хэм, хавар, намрын улиралд 1.4-1.5°C хэм, зун 0.3°C хэмээр тус тус дулаарсан төлөв байдалтай байна.

Жилийн дөрвөн улирлын туршид дан ганц бэлчээрийн өвс ургамалд шүтэн адгуулан маллаж ирсэн монгол мал, монгол малчны аж байдал нь байгаль, цаг уурын шууд нөлөөн дор оршин тогтносоор эдүгээ цагтай золгож буй аж. Урт удаан жилийн байгалийн шалгарлын нөлөөгөөр монгол хүн, мал нь Төв Азийн эрс тэс, хуурай, ширүүн уур амьсгалтай орчинд онцгой сайн зохицож, байгалийн гамшигт үзэгдэл ган, зудын үед малын тоо хорогдож, жирийн буюу өнтэй жилүүдэд малын тоо толгой өсч ирсэн юм. Товчдоо, монгол малын тоо толгойн өсөлт, бууралт нь байгаль, цаг уурын байдлаас шууд шалтгаалж ирсэн гэж дүгнэж болно.

“Монголын мал аж ахуйн ирээдүй” судалгааны багийн хамт олон байгаль, цаг уурын өнөөгийн байдалд Ус, цаг уурын хүрээлэнгийн эрдэмтэн мэргэжилтнүүдтэй хамтран товч үнэлэлт өгөх, цаг уурын гамшигт үзэгдлүүд нь мал аж ахуйн үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлдгийг товч тодорхойлох зорилго тавьж ажиллав.

Сүүлийн 60 гаруй жилийн судалгаанаас үзэхэд 1940-1960 оны хооронд 3 удаа, 1961-1980 онд мөн 3 удаа ган, зуд болж, өөрөөр хэлбэл 20 жилийн хугацаанд 3 удаа ган, зуд тохиожээ. Гэтэл 1993, 1996-1997 онуудад цаашилбал он дараалан 2000, 2001, 2002 онуудад нийт нутгийн 50-70 хувийг хамарсан ган, зуд болсон байна. Өөрөөр хэлбэл, 1995 оноос хойшхи 10 жилд ган зуд 5 удаа тохиосон нь өмнөх жилүүдээс 3 дахин их давтамжтай болсон байна.

2000 оноос хойшх хугацаанд болсон ган, зуд нь 1940-1997 он хүртэлх хугацаанд учирч байсан ган, зудаас нэлээд өөр шинж байдалтай байгааг хашир туршлагатай малчид, мэргэжлийн судлаачид тэмдэглэж байна.

1940-1997 он хүртэлх 57 жилийн хугацаанд 1944 оны мичин жил, 1967-1968 оны хонь-мичин жилийн зуны ган, өвөл хаврын цагаан зуд хавсарсан байгалийн гамшигийг эс тооцвол бусад 7 удаагийн зуд /нутгийн 50-иас дээш хувийг хамарсан зудыг энд оруулав/ нь “цагаан” зуд давамгайлж байсан байна. Өөрөөр хэлбэл, цас их орж бэлчээр цасан бүрхүүлд даруулсан зуд болж байжээ. Гэтэл 2000, 2001, 2002 онуудад дараалан нийт нутгийн 60 гаруй хувийг хамарсан “улаан” ган тохиосон нь өмнөх жилүүдийн байгалийн гамшгаас ихээхэн өөр байна.

Ганг “улаан” ган, ган, гандуу гэж ялгагдаг бөгөөд гангийн ерөнхий үнэлгээ хийхдээ улаан ганг байгалийн гамшигт үзэгдэл гэж үзэх аваас 1940-1997 оны хооронд улаан ган 2 удаа л нийт нутгийн 50-иас дээш хувийг хамарч тохиолдож байжээ.

Байгаль, цаг уурын гамшигт үзэгдэл малын тоо, толгойд хэрхэн нөлөөлж ирснийг дараахь хүснэгтээр харуулав. 1944 оноос хойшх 60 жилийн хугацаанд монгол улсын нутаг дэвсгэрт 50 хувиас дээш хувийг хамарсан ган зуд 11 удаа

тохиож, гамшгийн хохирол 28.7 сая толгой том мал, 11.5 сая толгой төл мал болсон байна /18 дугаар хүснэгт/.

**Ган, зуднаас мал аж ахуйд учирсан хохирол**

*Хүснэгт 18*

Он	Хамарсан нутаг дэвсгэр	Малын хорогдол /сая.толгой/			
		Том мал		Төл	
		Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
1944-1968	11 аймаг	14.2	14.9	4.0	13.7
1976-1993	10 аймаг	4.4	6.2	3.7	10.9
1996-2002	12 аймаг	10.1	9.2	3.8	13.3
Бүгд		28.7		11.5	

*Эх сурвалж:* 1998-2001 оны байгалийн гамшгийн сургамж дүгнэлт эмхтгэл

2000, 2001, 2002 оны жил дараалсан ган, зуд нь юуны өмнө 3 жил дараалан Монгол орны нутаг дэвсгэрийн 60-аас дээш хувийг хамарч цаг хугацааны хувьд хамгийн урт хугацааг хамарсан, хамгийн ойрхон давтамжаар тохиолдсон байгалийн гамшиг байв.

2000, 2001, 2002 оны байгалийн гамшиг нь зундаа ган болж бэлчээрийн ургамлын ургац алдагдаж түүнээс үндэслэн цас ороогүй орон нутагт харын зуд, цастай нутагт “цагаан” зуд болсон өөрөөр хэлбэл “улаан” гангаас эх авсан ган болоод зудын хосолсон гамшиг болсноороо өмнөх жилүүдийн гамшгаас хор хөнөөлтэй байв.

Сүүлийн 3 жилийн байгалийн гамшигт үзэгдлийн давтамжийн тоо маш их ойртсон байна. Тухайлбал 1997 оноос хойшх хугацаанд амьд амьтанд төдийгүй нийгэмд асар их хохирол учруулахуйц хүчтэй салхи, үер, аадар бороо, гэнэтийн цочир хүйтрэл /45-50 цельсийн градус/ зэрэг байгалийн онц аюултай үзэгдэл олон тохиолдох болов.

Монгол орны хэмжээнд 2002 онд ус, цаг агаарын 55 удаагийн аюултай үзэгдэл тохиолдсоны 19 нь гамшгийн хэмжээ /ямар нэг хохирол гарсан/-нд хүрч 43 хүний амь нас эрсдэж, улс нийгэмд 3.4 тэрбум төгрөгийн хохирол учирлаа. 2001-2002 оны зуд, 2002 оны гангийн улмаас малын хорогдол, үр тарианы ургацын алдагдлын хохирол 150. 5 тэрбум төгрөгт хүрчээ.<sup>14</sup>

**2001-2002 оны зуд**<sup>15</sup>. 2001 оны 11 дүгээр сарын сүүлчээр цас орж нийт нутгийн 70 орчим хувьд цасан бүрхүүл тогтож, 12 дугаар сарын эхээр ихэнх нутагт эрс хүйтэрч, хур тунадас олон жилийн дунджаас ахиу орж, цастай нутгийн хэмжээ **80** орчим хувьд хүрч, Баян-Өлгий, Увс, Завхан аймгийн ихэнх, Ховд, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай аймгуудын зарим сумдын нутгаар цасны зузаан дунджаар 10-27 см, хунгарласан газраа 30-130 см, нягт нь 0.16-0.34 г/см<sup>3</sup> хүрч нийт нутгаар өвөлжилтийн байдал хүндрэх нөхцөл бүрджээ.

**Агаар мандлын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал**

*Хүснэгт 19*

Он	Аюултай үзэгдлийн тоо	Гамшигт үзэгдэл	Үүнээс				Осолдсон хүний тоо	Сумын тоо	
			Салхи шуурга	Их цас бороо	Мөндөр үер	Бусад		Гантай ба гандуу - / -	Зудтай
<b>1990-1992</b>	58	26	8	8	9	1	27	43/113	29
<b>1993-1995</b>	75	41	15	17	6	4	104	20/56	85
<b>1996-1998</b>	142	62	11	5	42	4	68	33/77	128
<b>1999-2002</b>	201	77	22	12	31	14	136	212/530	487

*Эх сурвалж:* <http://env.pmis.gov.mn/Meteoins/>

<sup>14</sup> “Монгол орны байгаль, орчны төлөв байдлын үнэлгээний тайлан” 2002 он

<sup>15</sup> <http://env.pmis.gov.mn/Meteoins/>

2002 оны 1 дүгээр сарын эхний арав хоногт сүүлийн 20 жилд тохиолдоогүй дулааралт ажиглагдаж, ихэнх нутагт агаарын температур олон жилийн дунджаас 5-9 хэмээр дулаан болж, 2 дугаар сард олон жилийн дунджаас дулаан, өдөр шөнийн агаарын дулаан хэлбэлзэл ихтэйгээс цас нягтарч хатууран, өнгөн хэсэг нь мөстөж эхэлжээ.

**Монгол орны нийт нутагт эзлэх ган, зуншлагын байдал**  
/хувиар/

Хүснэгт 20

Он	Зуншлага сайн	Гандуу	Гантай
2000	40	55	5
2001	30	40	30
2002	30	50	20

Эх сурвалж: <http://env.pmis.gov.mn/Meteoins/>

2001-2002 оны өвөл Увс, Завхан, Говь-Алтай, Өвөрхангайн бүх сум, Баянхонгорын Эхийн голоос бусад, Ховдын Булган, Үенч, Алтай, Эрдэнэбүрэн, Мянгад, Дөргөн, Буянт, Чандмань, Манхан, Зэрэг, Дарви, Хөвсгөлийн Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Ханх, Сэлэнгийн Хүдэр, Баруунхараа зэрэг 8 аймгийн 114 сумын нутагт “цагаан” зуд болж, мал өвөлжилтийн байдал хүндэрч ирснээр 11 дүгээр сарын сүүлчээс малын хорогдол гарч эхлэн Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Сэлэнгэ, Өмнөговь аймагт нийт 2.4 сая толгой мал хорогджээ.

2002 оны зун нийт 20 аймгийн 251 сумын нутаг гандуу буюу гантай байснаас 13 аймгийн 77 сумын нутгаар гантай байв.

2002 оны 6-8 дугаар сард сүүлийн 50 жил болоогүй үргэлжилсэн их халуун боллоо. Тухайлбал, 2002 оны 6 дугаар сарын 1-3, 10-18, 24-29-нд, 7 дугаар сарын 2-9, 18-30-нд, 8 дугаар сарын 10-20-нд манай орны ихэнх нутгийг хамарсан агаарын үнэмлэхүй их хэм дулаан, 30°C хэмээс давж халжээ. Өмнөх жилүүдэд зундаа агаарын үнэмлэхүй их температур манай орны говь, талын аймгуудын нутгаар болон Орхон, Сэлэнгийн сав газраар 38-44°C хэм, бусад нутгаар 35-37°C хэм хүрч халж байсан боловч үргэлжилсэн хугацаа багатай байжээ. Харин 2002 оны зуны хувьд агаарын үнэмлэхүй их дулаан Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 28-33°C хэм, бусад бүх нутгаар 34-42°C хэм хүрч халж энэ зуны агаарын үнэмлэхүй их дулааны хэмжээ Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгуудаар сүүлийн 50 жилд хамгийн өндөр хэмжээнд хүрчээ.

2002 оны зун 6-8 дугаар саруудад Баян-Өлгий, Ховд, Завхан, Архангай, Хөвсгөл зэрэг аймгийн ихэнх нутаг, Говь-Алтай, Баянхонгор, Хэнтий аймгийн хойд, Сүхбаатар аймгийн зүүн, Төв аймгийн зүүн хойд, Дорнод аймгийн баруун хойд болон зүүн хэсгээр 20-иос цөөн өдөр, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Сэлэнгэ аймгийн ихэнх нутаг, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн өмнөд хэсгээр 40-77 өдөр, бусад нутгаар 21-39 өдөр 30°C хэмээс дээш халуун болжээ.

Зуны гурван сард хурц нартай аагим халуун өдрүүд олон хоногоор үргэлжилж, 6-7 дугаар сард нутгийн 70 орчим хувьд, 8 дугаар сард нутгийн 90 гаруй хувьд нь олон жилийн дунджаас бага бороо орсон нь зуны улиралд ой, хээрийн түймэр гарахад хүргэж, зөвхөн 7 дугаар сарын 23-27-ны их халсан 4 хоногт Монгол Улсын хэмжээнд 64 түймэр гарчээ. 2002 оны зун гол мөрөн, нуурын усанд 69 хүн усанд унаж бэртэж, 60 хүн анхаарал болгоомжгүйгээс амь насаа алдсан тохиолдол гарлаа. Ийнхүү олон хүн голын усанд орж эрсдсэн явдал нь олон хоногоор үргэлжлэн их халуун болсны дам нөлөө гэж үзэж болно.

**2002 оны уур амьсгалын онцлог.** Хаврын улирал ерөнхийдөө дулаан, хур тунадас олон жилийн дунджаас ахиу орж, 5 дугаар сарын 31 гэхэд нийт нутгийн 50 орчим хувьд ургамлын ургалт сайн, 40 гаруй хувьд дунд зэрэг байлаа. Гэсэн хэдий ч 2002 оны хавар салхи шуурга ихтэй мал хаваржилтад таагүй нөлөөлсөн байна.

Зуны саруудад зүүн 3 аймгийн нутгаас бусад бүх нутгаар олон жилийн дунджаас дулаан, үе үе хэт их халж, хур бороо бага орсноос нутгийн 70 гаруй хувь нь гантай юмуу гандуу зуншлагатай байсан нь 1940 оноос хойш тохиолдсон хамгийн бага хур бороотой жилүүдийн нэг тохиож, 6, 7 дугаар сард нутгийн 70 орчим хувьд, 8 дугаар сард нутгийн 90 гаруй хувьд олон жилийн дунджаас бага хур бороо орлоо. 1940 оноос хойш 4 жил дараалан ийм эрчимтэй гандах үе өмнө нь байгаагүй ажээ.

2002 оны зун 6, 7, 8 сард аагим халуу шатаж, “улаан” ган болж, 2002 оны 7-9 дүгээр сарыг дуустал бараг бороо оролгүй зусч, 9 дүгээр сард нутгийн 90 гаруй хувьд олон жилийн дунджаас бага хур тунадастай байсан нь тариа хураалтад таатай нөлөөлсөн боловч 10 дугаар сараас эхлэн зудын түрүүч Булган аймгийг нөмрөн, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгийн ихэнх нутаг, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий, Дундговь зэрэг аймгуудын зарим нутгаар мал өвөлжилт хүндэрч, хааяагүй хөр цас хучиж, 12 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 80 гаруй хувь нь цасан бүрхүүл тогтож, 30 орчим хувьд цасны дундаж зузаан 38 см хүрч, нягтрал нь 0,14-0,42г/см, тал газартаа 30-40 см цастай, хатуурч хунгарласан газартаа 60-120 см зузаан цас хурж, уулын бэлээр бог мал бэлчээрлэх боломж хэдийнээ алдагдаж, малын хамар хатгах өвс ил цухуйхаа байж, өвөлжилтийн байдал нэн хүндрэлтэй болжээ.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт хүний буруутай үйл ажиллагааны улмаас байгалийн гамшгийн давтагдал нэмэгдэж сүүлийн 4 жил дараалан манай орны бүх нутгийн 50 хувиас дээш хэсгийг хамарсан **ган**, сүүлийн 3 жил 100-аас дээш сумын нутаг хамарсан **зуд** болсны улмаас олон сая мал хорогдож, улс орны эдийн засагт хэдэн жилдээ нөхөгдөшгүй их хохирол тохиолдлоо. Иймээс байгалийн гамшигтай тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, агаар мандлын гаралтай байгалийн аюул гамшгийг урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох шаардлага тулгарч байна /Мэдээллийн эх БОЯ/.

Ийнхүү сүүлийн жилүүдэд дараалан ган зуд болж байгалийн онц аюултай гамшигт үзэгдлийн тоо, хохирлын хэмжээ нэмэгдэх болсноор түүний нөлөөн дор байгаа мал төдийгүй ан амьтан, араатан жигүүртэн, ургамлын аймаг бүхлээрээ байгалийн шалгаралд орж, орших, эс орших асуудал тавигдаж эхэллээ. 2000-2002 оныг дуустал 3 жилийн хугацаанд Монгол Улс байгалийн гамшгийн нөлөөгөөр нийт малынхаа 30 хувь буюу 10 гаруй сая малыг хорогдуулсан юм.

Дэлхийн агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийн өсөлтөөс болж Монгол орны нутаг дээрх хур тунадас, агаарын температурын өөрчлөлт огцом өөрчлөгдөж ган, зудын давтамж цаашид ч ихсэх хандлагатай байгаа гэж мэргэжилтнүүд тооцоолж байна. Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын судалгааны дүнгээс үзвэл ойрын 20-50 жилийн доторх уур амьсгал, Монгол орны хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд таагүй нөлөөлөх байдал шинэ зууны сүүлийн хагастаа бүр ч идэвхжиж болзошгүй гэсэн урьдчилсан баримжаа гарч байна.

Иймд мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх, түүний дотор мал аж ахуйн үйлдвэрлэлийг хэрхэн зохион байгуулах асуудлаар дунд болон урт хугацааны хөтөлбөр боловсруулж, одооноос ирээдүйгээ харсан бодлогоор мал аж ахуйн үйлдвэрлэлийг чиглүүлэн хөгжүүлэх шаардлага тавигдаж байна.

**5.2. Байгаль цаг уурын еерчлелтийн талаарх малчдын санал бодол**

Өнгөрсөн таван жилд байгаль дэлхий хичнээн ихээр өөрчлөгдөж байгааг судалгаахийсэн 11 аймаг, 34 сумын малчин, мэргэжилтэн хэн боловч халаглан ярьж байлаа. Үүний тодорхой жишээ бол 21 дүгээр хүснэгтээр үзүүлсэн судалгааны дүн болно.

**Таны бодлоор сүүлийн 10 гаруй жилд байгаль, цаг уур өөрчлөгдөв үү? Хүснэгт 21**

Асуулт	Хэвийн		Муудсан		Мэдэхгүй		Бүгд		
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
Ургамлын бүрэлдэхүүн	61	8.0	645	84.4	58	7.6	764	100.0	
Бэлчээрийн ургац	11	1.4	685	89.7	68	8.9	764	100.0	
Цаг агаар	Зун	27	3.5	586	76.7	151	19.8	764	100.0
	Өвөл	24	3.1	632	82.7	108	14.1	764	100.0
Булаг, шанд, гол горхи	Зун	44	5.8	555	72.6	165	21.6	764	100.0
	Өвөл	37	4.8	563	73.7	164	21.5	764	100.0

Судалгаанд хамрагдсан нийт 764 малчин өрхийн 84.3 хувь нь ургамлын бүрэлдэхүүн муудсан, 86.8 хувь нь бэлчээрийн ургац муудсан, 72.3-77.6 хувь нь цаг агаар муудсан, 67 гаруй хувь нь гол горхи, булаг шанд ширгэсэн гэж хариулсан байна.

**Сүүлийн 10 гаруй жилд байгаль, цаг уур сөргөөр өөрчлөгдсөн гэж үзсэн малчдын санал /эдийн засгийн бүсээр/**

**Хүснэгт 22**

Асуулт	Дундаж /хувиар/	Үүнээс эдийн засгийн бүсээр /хувиар/				
		Хангай	Баруун	Төв	Зүүн	УБ
Ургамлын бүрэлдэхүүн	84.3	94.4	65.2	95.2	80.0	94.7
Бэлчээрийн ургац	86.8	94.1	82.7	95.1	86.1	94.7
Цаг агаар/зун/	72.3	86.0	63.5	88.9	66.0	57.9
Цаг агаар /өвөл/	77.6	88.4	75.4	85.9	81.7	73.7
Булаг, шанд /зун/	67.9	71.4	56.3	89.0	82.8	73.7
Булаг, шанд /өвөл/	67.7	81.9	58.7	80.0	76.7	68.4

Нэгэнт л бэлчээрийн малын өсч үржих гол нөхцөл болсон байгаль, цаг уур, бэлчээр, ус нь ийнхүү богино хугацаанд өөрчлөгдөж муудаж байгаа бол ийм нөхцөлд цаашид мал маллагааныхаа арга барилыг хуучин хэв маягаар нь хадгалсаар байх уу, эсвэл... гэсэн асуулт зүй ёсоор тавигдах болно.

Хангайн бүсийн Архангай, Булган аймаг, Төвийн бүсийн Сэлэнгэ, Төв аймгийн гол, мөрний ай сав багасч, жалга, ам бүрт байдаг олон мянган булаг, шанд цөөрч, ойт хээрийн бүсийн зарим нутагт элсэрхэг хөрс үүссэн, бэлчээрийн агь, ерхөг, хиаг, нугын өвс зэрэг үндсэн ургамал үгүй болж лууль, шарилж зэрэг мал бага иддэг ургамал ихээр ургах болсон, алт олборлолтын үйл ажиллагааны уршгаар олон гол, горхи устаж үгүй болсон, бохирдсон, голдрил нь өөрчлөгдсөн зэрэг нь хүн бүрт шууд ажиглагдаж, муу үнэлэлт хийхэд хүргэж байна.

Харин эдийн засгийн баруун бүсэд хамрагдах Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд аймгууд нь ерөөс ойт хээр бага, булаг шанд цөөвтөр, говь, тал, Алтайн уулархаг нутгийн тогтоцтой, салхи шуургатай өдрийн тоо их, жилийн хур тунадасын хэмжээ харьцангуй бага, ургамлын бүрэлдэхүүнд тал, хээр, говийн бүсэд ургадаг, ганд гэсвэртэй дэрс, шаваг, харгана, таана, хөмүүл ихээр ургадаг зэргээс үүдэн малчид байгаль, цаг уур, бэлчээр, усны муудаж доройтсныг Хангайн бүсийн малчдаас арай багаар үнэлсэн байна. Тухайлбал бэлчээрийн ургамал муудсан гэж Хангайн бүсийн малчдын 94.1 хувь, Баруун бүсийн малчдын 82.7 хувь нь, өвөлдөө булаг шанд муудсан гэж Хангайн бүсийн малчдын 81.6 хувь, Баруун бүсийн малчдын 58.7 хувь нь үзсэн байна.

- 1.** Дэлхийн цаг уурын өөрчлөлт, агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламж ихэссэнээс үүдсэн дэлхийн цаг уурын дулаарал нь Монгол орны байгаль, цаг уурын байдалд шууд нөлөөлж сүүлийн жилүүдэд ган, зудын давтамж нэмэгдэж, байгалийн гамшгийн үзүүлэх хор хөнөөл ихэсч байна.
- 2.** Малчдын 75 орчим хувь нь байгаль, цаг уур муудаж, бэлчээр доройтож, ил задгай ус улам бүр ховордож байна гэж тодорхойлж байна.
- 3.** Монгол орны ойрын 20-50 жилийн цаг уурын төлөвөөс үзэхэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд үзүүлэх таагүй нөлөөлөл улам бүр идэвхжих хандлагатай байгааг харгалзан үзэж бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх өнөөгийн арга барилыг өөрчилж байгалийн эрсдлээс хамгаалах тогтолцоог бий болгох шаардлага тавигдаж байна.

**5.3. Дүгнэлт**

**МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ  
СААД БЭРХШЭЭЛ, ТИЙНИЙГ ДАВАН ТУУЛАХ  
ТАЛААРХ МАЛЧДЫН САНАА БОДОЛ**


**6.1. Мал аж ахуйн  
ийлдвэрлэл дэх  
хүнд хүчир  
ажил**

Судалгааны ажлын нэг зорилт нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн нийтлэг үйл ажиллагаануудыг хүнд хүчир байдлаар нь малчид өөрсдөө хэрхэн ангилж буйг тодорхойлж тэдгээр хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаар малчдын санаа бодлыг тодруулах явдал байв. Энэ зорилтыг хэрэгжүүлэх үүднээс мал аж ахуйн үйлдвэрлэлд нийтлэг тохиолдох ажлын жагсаалт гаргаж тэдгээрээс хамгийн нийтлэг гэсэн ажлуудыг сонгон авч эдгээр ажлын аль нь хамгийн хүнд хэцүү болохыг малчдаар эрэмбэлүүлж дүнг нэгтгэв.

*Танай өрхийн хувьд хамгийн хүнд хүчир ажил юу вэ? /Гол гэсэн 3 хүртэлх хариултыг эрэмбэлэн дугаарлана/ гэсэн асуултаар малчин өрхөөс хариулт авч хариултыг тэдний амьдарч байгаа эдийн засгийн бүс, өрхийн малын тоо, ам бүл зэрэг үзүүлэлттэй холбон судалж дүгнэлт хийв. Энэхүү асуултын хариуг дүгнэж үзэхэд нийт 770 гаруй малчнаас авсан асуулгын 720 орчим нь уг асуултын хувьд хүчинтэй, үлдэх хэсэг нь асуултад хариулаагүй буюу хариултыг ач холбогдлоор нь эрэмбэлээгүй зэрэг зөрчил гаргаснаас судалгаанд авах шаардлага хангаагүй байна. Ер нь судалгааны дүнгээс үзэхэд нийт малчин өрхийн 68.3 хувь буюу 492 өрх мал аж ахуйн үйлдвэрлэлийн хамгийн хүнд хүчир ажлыг хадлан тэжээл бэлтгэх гэж үзсэн байна /12 дугаар график/.*

**Мал аж ахуйн ажлын хүнд хүчир байдлын  
талаарх малчдын бодол**

График 12



Мөн түүнчлэн хүнд хүчир ажлын зэрэглэл эдийн засгийн бүс нутгаас хамаарч өөр өөр байгаа эсэхийг судалж үзэхэд өмнө тогтоосон дараалал бүс нутгаас хамаарч бага зэрэг өөрчлөгдөж байна.

Хангайн бүсийн малчдын 75.9 хувь нь хадлан, өвс бэлтгэх ажил хүнд хүчир гэж үзсэн нь бусад бүсээс хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Хадлангийн талбай харьцангуй элбэгтэй хангайн бүсэд энэ асуудал бусад бүсээс илүү хүндрэлтэй баймааргүй мэтээр төсөөлж болох авч судалгааны дүн ингэж гарсан байна. Хангайн бүсийн Булган, Архангай аймгийн малчдын 73.5-81.8 хувь нь хадлан, тэжээл бэлтгэх ажлыг хамгийн хүнд хүчир гэж үзсэн байхад Төвийн бүсийн говийн аймгууд, Баруун бүсийн аймгийн малчид хамгийн хүнд хүчир ажил нь



нүүдэл хийх гэж үзсэн байна. Тухайлбал Өмнөговь, Дундговь, Говь-Алтай, Ховд аймгийн малчид дээрх дарааллаар 82.9%, 83.0%, 82.7%, 69.4% нь нүүдэл хийх нь хамгийн хүнд хүчир ажил гэж үзсэн байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн ямар ажил хамгийн хүнд хүчир болох нь эдийн засгийн бүс бүслүүрээс бус газар зүйн бүс бүслүүрээс, мал маллагааны уламжлал, мал тэжээх байдал зэргээс шалтгаалж байна /23 дугаар хүснэгт/.

**Хүнд хүчир ажлын талаарх малчдын бодол**  
/малчин өрхийн оршин байгаа эдийн засгийн бүсээр/

Хүснэгт 23

Ажлын жагсаалт	Эдийн засгийн бүсийн нэр										Дүн	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мал хариулах	24	4.2	51	8.7	30	7.4	13	5.0	1	3.4	119	6.4
Мал услах	68	11.9	42	7.2	24	5.9	31	12.0	1	3.4	166	9.0
Төл бойжуулах	76	13.3	126	21.5	46	11.3	40	15.5	1	3.4	289	15.6
Нүүдэл хийх	141	24.7	150	25.6	107	26.3	48	18.6	3	10.3	449	24.3
Сүү цагаан идээ боловсруулах	27	4.7	25	4.3	17	4.2	13	5.0	1	3.4	83	4.5
Мал ноослох, самнах	39	6.8	72	12.3	52	12.8	23	8.9	6	20.7	192	10.4
Хадлан тэжээл бэлтгэх	173	30.3	112	19.1	120	29.5	74	28.7	12	41.4	491	26.5
Бусад	23	4.0	7	1.2	11	2.7	16	6.2	4	13.8	61	3.3
Хариултын тоо бүгд	571	100	585	100.0	407	100.0	258	100.0	29	100.0	1850	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	228	-	200	-	163	-	107	-	19	-	717	-

Ойт хээр, хангайн бүсийн аймгуудад өвс хадлан хадах асуудалд харьцангуй их санаа тавьдаг боловч сүүлийн жилүүдэд хадлангийн ургац бага байгаа, төвийн бүсийн Дундговь, Өмнөговь аймгууд, баруун бүсийн Говь-Алтай, Ховд аймгийн зарим сум хадлан хадах уламжлал ерөөс бага, бэлэн өвс худалдаж авдаг учир бэлтгэх асуудалд хүнд хүчир ажил гэж хариулах үндэслэл багатай байдаг зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Судалгаанд хамрагдсан аймгуудыг зөвхөн эдийн засгийн бүсээр төлөөлүүлж дүгнэлт хийх нь учир дутагдалтай тул зарим асуулгын дүнг аймаг тус бүрээр нарийвчлан тодорхойлсон юм. Тухайлбал, дээр дурдсан “Танай өрхийн хувьд хамгийн хүнд хүчир ажил юу вэ?” гэсэн асуултын хариуг аймаг бүрээр тооцож үзэхэд Төвийн бүсийн Төв, Сэлэнгэ аймгийн малчдын хувьд гол хүнд хүчир ажил нь хадлан, тэжээл бэлтгэх ажил /малчдын 83.3-87.9 хувь нь уг хариултыг сонгосон/ бөгөөд бусад нь тийм ч төвөгтэй биш гэж үзсэн байна. Гэтэл тухайн бүсэд хамрагдах Өмнөговь, Дундговь аймгийн малчдын хувьд хамгийн хүнд хүчир ажил нь нүүдэл хийх ажил байх жишээтэй /24 дүгээр хүснэгт/.

24, 25 дугаар хүснэгтийн бусад гэсэн хариултыг нийт санал асуулгад оролцогчдын 6.7-8.5 хувь нь ихэвчлэн 3 дугаар эрэмбээр сонгосон бөгөөд сонголтын учир шалтгаан нь тухайн өрх, оролцогчийн онцлогоос шалтгаалж янз бүр байв. Бусад гэсэн хариултын дотор ихэвчлэн машин техник үгүй, хүн бүл муутай, байгаль, цаг уурын өөрчлөлт их байгаа зэрэг тухайн асуултад оновчтой биш хариултауд байв.

**Хадлан тэжээл бэлтгэх ажил** яагаад хамгийн хүнд хүчир болохыг малчидтай хийсэн фокус ярилцлага, сурвалжлага ярилцлагаар тодруулахад тэд дараахь учир шалтгааныг тоочиж байна.

- Сүүлийн жилүүдэд хадлангийн өвсний ургац муудсан. Хадлангийн олдоц ховор. Хадлангийн талбайн талаар маргаан их гарах болсон.

**Хүнд хүчир ажлын талаарх малчдын бодол**  
/эдийн засгийн төвийн бүсийн аймгуудаар/

**Хүснэгт 24**

Ажлын жагсаалт	Эдийн засгийн бүсийн нэр								Дүн	
	Төв		Сэлэнгэ		Өмнөговь		Дундговь			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мал хариулах	8	10.7	4	4.8	9	8.0	10	7.1	31	7.5
Мал услах	5	6.7	9	10.8	18	16.1	7	5.0	39	9.5
Төл бойжуулах	11	14.7	13	15.7	7	6.3	15	10.6	46	11.2
Нүүдэл хийх	13	17.3	16	19.3	34	30.4	44	31.2	107	26.0
Сүү цагаан идээ боловсруулах	2	2.7	4	4.8	0	0.0	11	7.8	17	4.1
Мал ноослох, самнах	4	5.3	4	4.8	22	19.6	22	15.6	52	12.7
Хадлан тэжээл бэлтгэх	29	38.7	30	36.1	21	18.8	28	19.9	108	26.3
Бусад	3	4.0	3	3.6	1	0.9	4	2.8	11	2.7
Хариултын тоо бүгд	75	100.0	83	100.0	112	100.0	141	100.0	411	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	33	-	36	-	41	-	53	-	163	-

Маргааныг танил тал, хүч чадал, хөрөнгө хүчний ялгаа гэх мэт эрх зүйн бус байдлаар шийдвэрлэх байдал голлох болсон. Энэ нь малчдын сэтгэл зүйд дарамт, шахалт болдог. Зарим тохиолдолд хадлангийн талбай нийтийн эзэмшил учраас уралдаж хаддаг.


- Хадлан өвсийг гол төлөв гар аргаар хаддаг учраас хүнээс хар хүч их шаарддаг, бие эрүүл, залуу хүмүүсийн хийх ажил юм. Хадлангийн ажил нь зөвхөн өвс хадахаар зогсохгүй, бухалдах, нуруулдах, тээвэрлэх гээд олон шат дамжлагатай. Нэг өрхөд хадуур бариад өвс хадаад байх хүн бүл гэр бүр олон байдаггүй.
- Өвс хадлан хадахын зэрэгцээ ачиж тээвэрлэх, өвөлжөө хаваржаанд оруулахад тээврийн хэрэгсэл зайлшгүй хэрэглэдэг. Тээврийн хэрэгсэл хөлсөлж авахад хамгийн багаар бодоход шатахууны зардалд зайлшгүй бэлэн мөнгөний хэрэгцээ шаардагддаг. Энэ нь малчдад хүндрэл болдог байна. Мөн тээврийн хэрэгсэл хөлсөлж авахад хадлангийн талбай хүртэлх сул зай их, жолоочтой тохиролцоход түвэгтэй.
- Хадлан хадах цаг хугацаа давчуу, ажлаа зөв зохицуулж тохиромжтой хугацааг алдахгүй ажлаа амжуулахыг шаарддаг. Энэ нь чөлөөтэй, өөрсдийн тааваар аж амьдралаа зохион байгуулдаг малчдад сэтгэл зүйн хувьд бэрхшээлтэй байдаг.

Хадлан тэжээл бэлтгэх нь хүнд хүчир ажил мөн эсэхэд малчин өрхийн доторх ам бүл, хүн хүчний хүрэлцээ төдийлөн нөлөөлөхгүй байна. Тухайлбал судалгаанд хамрагдсан 2-5 ам бүлтэй өрхийн 70.5 хувь нь, 6-8 ам бүлтэй өрхийн 61 хувь нь, 9-10 ам бүлтэй өрхийн 75.0 хувь нь хадлан тэжээл бэлтгэх ажлыг хүнд хэцүү гэж үзсэн байна. Энэ нь хадлан, тэжээл бэлтгэх асуудал хүнд хэцүү байгаагийн гол шалтгаан нь хүн хүчний хүрэлцээндээ биш хадлангийн олдоц ховор, маргаан их гардаг, санхүүгийн бэрхшээл байгаа зэргийг нотлох нотолгоо гэж үзэж болох талтай.

**Нүүдэл хийх ажил** нь мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хүнд хүчир ажлын 2 дугаарт эрэмбэлэгдэж, оролцогсдын 62.2 хувь нь уг ажлыг хүнд хүчир гэж үзжээ. Нүүдэл хийх ажлын хүнд хүчир эсэх нь байгаль, цаг уурын бүстэй ихээхэн холбоотой байна.

**Малчин өрхийн нүүдлийн тоо**  
/Эдийн засгийн бүсээр/

График 13



Тухайлбал, баруун болон говийн аймгийн малчид нүүдэл хийх ажлыг хамгийн хүнд хүчир ажил гэж байхад Улаанбаатар болон хангайн аймгийн малчид уг ажлыг хамгийн хүнд хүчир гэж үзээгүй байна.

- Говийн болон баруун, зүүн аймгийн малчдын 50 гаруй хувь нь жилд 3-6 түүнээс дээш удаа нүүж байхад хангайн бүсийн аймгийн малчдын 30 орчим хувь, Улаанбаатарын малчдын дөнгөж 5.3 хувь нь 3-6 удаа нүүдэг аж.
- Алтайн нуруу, түүний баруун хязгаар, говь, тал хээрийн бүсэд нүүдлийн гол хэрэгсэл болох тэмээний тоо толгой сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд 366.1 мянгаас 255.6 мянга буюу 30 хувиар хорогдсон байна. Дунд зэргийн гэр бараатай нэг малчин өрх нүүхэд 6 тэмээ ачаалах шаардлагатай болдог. Гэтэл нас бие гүйцсэн, номхон, ачилганд сургасан 6 атан тэмээ гаргах айл өнөөдөр бараг үгүй. Айл, саахалтынхаа тэмээ, хөсгийг нийлүүлэн байж нүүдэл хийхэд хүрдэг. Нүүхэд ачлага олдохгүйгээс сэтгэл санааны дарамттай байдаг аж.
- Авто машинаар нүүх асуудал зарим нутагт байгалийн тогтоц, саад бартаанаас шалтгаалж огтболомжгүй. Тал хээр, говьд нүүдэл хийх нь талдаа 100 км, сум орон нутгаас нүүлгэх малчны хот хүртэл мөн 100 гаруй км явах нь ердийн үзэгдэл. Иймд машины сул явалтыг зохицуулах, тээврийн хөлсийг тохиролцох нь аль аль талдаа бэрхшээлтэй. Авто машинаар нүүдэл хийвэл шатахууны зардалд бэлэн мөнгө зайлшгүй шаардагддаг.

Гэр бараагаа ачаалж авч явах, малаа тууж шинэ бэлчээрт хүргэх зэрэг ам бүл цөөнтэй айлд нүүдэл хийх нь хүн хүчний хүрэлцээ дутагдсан хүнд хүчир ажил болдог аж. Судалгаанд оролцсон 2-5 ам бүлтэй өрхийн 61.4 хувь нь нүүдлийг хүнд хүчир ажил гэж үзэж байхад 9-10 ам бүлтэй өрхийн 35.0 хувь нь л нүүдлийг хүнд хүчир ажил гэж үзсэн байна.

**Төл бойжуулах ажил** нь мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хүнд хүчир ажлын 3 дугаарт эрэмбэлэгдэж, оролцогсдын 40.7 хувь нь уг ажлыг хүнд хүчир гэж үзсэн байна. Төл бойжуулах ажил нь цаг үеийн шинжтэй, тухайн үедээ хүн хүч нэлээд шаарддаг ажил юм. Үүний нотолгоо нь 2-5 ам бүлтэй өрхийн 41.3 хувь нь, 6-8 ам бүлтэй өрхийн 40.4 хувь нь, 9-10 ам бүлтэй өрхийн 30.0 хувь нь уг ажлыг хүнд хүчир гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, хүн хүчний хүрэлцээ илүү байх тутам уг ажлыг хүнд хүчир гэж үзэх нь багасах хандлага ажиглагдаж байна.

Баруун бүсийн малчин өрхийн 63.0 хувь, Төвийн бүсийн 28.2 хувь, Хангайн бүсийн 33.3 хувь нь төл бойжуулах ажлыг хүнд хүчир ажил гэж нэрлэсэн байна. Эдийн засгийн баруун бүсэд тэжээлийн өртөг зардал их, хүн хүчний боломж бага байдаг нь төл бойжуулах ажлыг хүндрүүлж байна.

**Мал ноослох, самнах** ажлыг нийт малчин өрхийн 26.8 хувь нь хүнд хүчир ажил гэж үзжээ. Ямаа самнах ажлыг хамгийн нягт нямбай хийвэл зохих бөгөөд олон ямаатай айл хүн хүч хөлсөлж ямаагаа самнуулдаг байна. Энэ дашрамд тэмдэглэхэд аливаа хамтарч хийх, хүнээр хийлгэх ажлыг хүнд хэцүү ажил гэж үздэг малчин нэлээд олон байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байлаа. Малчид хамтран ажиллах, хөдөлмөрөө хорших, хүнээр хөлсийг нь өгөөд ажил хийлгэх, харилцан тохиролцох, нэг нь өгч сурах, нөгөө нь хөлсөөр хөдөлмөрлөж сурах талаар туршлага, арга барил, хоорондын харилцаа илт дутмаг байна. Мал ноослох, самнах ажлыг Өмнөговь аймгийн малчдын 53.7 хувь нь хүнд хүчир ажил гэж сонгосон нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Харин Хэнтий /20.5 хувь/, Архангай /16.0 хувь/, Сэлэнгэ /11.1 хувь/ аймгууд уг үйл ажиллагааг төдийлөн хүнд хүчир гэж үзэхгүй байна. Энэ нь дээрх аймгуудад нэг өрхөд байх ямааны тоо цөөн, хүн хүчний хүрэлцээ харьцангуй их, хот айлууд хоорондоо ойрхон байдаг учир өөр хоорондоо туслалцах боломж их зэрэгтэй холбоотой байна.

**Мал услах ажил.** Малчдын 23.2 хувь нь мал услах ажлыг хүнд хүчир ажил гэж үзсэн. Тэдгээрийн дотроос Сүхбаатар аймгийн малчдын 41.2 хувь, Архангай аймгийн малчдын 34.0 хувь нь мал услах ажлыг хамгийн хүнд хүчир ажил гэсэн нь нэлээд өндөр үзүүлэлт болсон байна.

Гол горхи хамгийн ихтэй Хангайн бүсийн Архангай аймгийн малчид мал услах ажлыг хамгийн хүнд хүчир ажилд үзэж басхүү энэ үзүүлэлт нь бусад аймагтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт болсон нь судалгааны багийн сонирхлыг татаж байлаа. Учрыг тодруулах аваас Архангай аймагт сүүлийн жилүүдэд олон мянган горхи, булаг шанд ширгэж үгүй болсон нь худаг бус гол горхи, булаг шанд шүтэж нутагладаг хангай нутагт хүндээр туссан байна.

Их Тамир суманд гэхэд 1990 оноос өмнө 10 гаруй суурь мал өвөлждөг байсан “Их өлөнт” гэдэг газар өвөл усгүй болсноос айл өвөлжих аргагүй байдалд орсон байна. Хангай газрын өвөлжөө хаваржаанд тэр бүр худаг гаргаад байдаггүй учир байгалийн задгай ус үгүй болохоорус хамгийн сэтгэл зовоосон асуудал болж, усаа дагаж мал олноор нутаглаж бэлчээрээ талхалсан, мал услах ээлж дараа үүссэн бэрхшээл хүндрэлүүд гарч байна. Хангай нутагт мал услах ажил нь ховоо татах зэрэг механик ажил шаардахгүй боловч усны хомсдол үүсч байгаа нь малчид уг ажлыг хүнд хүчир гэж үзэхэд хүргэж байна.

Харин говийн аймгийн малчдын хувьд заавал худаг буюу ундарга нь ширгээгүй газрыг тооцож анхнаасаа өвөлжөө хаваржаандаа буудаг, ховоо татах ажлыг нэг их хүнд хүчир гэж үзэхгүй, дадаж заншсан, хийвэл зохих ажил гэж үздэг бололтой.

**Мал хариулах ажлыг** малчид төдий л хүнд ажил гэж үзэхгүй байна. Тэдний дийлэнх нь мал хариулах бол малчин хүний хийвэл зохих үндсэн ажил гэсэн сэтгэгдэлтэй байна. Нийт малчдын 16.5 хувь нь мал хариулах ажлыг хүнд хүчир ажил гэсэн байна. Уг асуултын хариултыг аймаг тус бүрээр авч үзвэл Баян-Өлгий, Ховд, Өмнөговь, Төв аймгийн малчдын 41.7 хувь, 33.3 хувь, 22.0 хувь, 21.2 хувь нь мал хариулах ажлыг тус тус хүнд хэцүү хөдөлмөр гэж үзсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

Чоно, шилүүс элбэгтэй нутагт болон алсын бараа багатай уулархаг газрын малчид малаа гэрээсээ дурандаж хариулах боломжгүй тул малаа эзгүй хаяж болохгүй, байнга хоньчлон хариулах шаардлага байдаг, төв, суурин, зам

харилцаанд ойр нутагт малын хулгай их байгаа нь малыг мөн л хоньчлон хариулахыг шаарддаг, хүн бүл цөөнтэй, хотондоо ганц гэр айл малын хариулгын ээлжгүй тул мал хариулах ажлыг хүнд гэж ярьж байлаа.


**Сүү, цагаан идээ боловсруулах.** Зуны цагт сүү, цагаан идээ борлуулах зах зээл багатай, монгол аргаар боловсруулсан цагаан идээ нь хадгалах хугацаа богино, амт чанарын хувьд зах зээлийн хэрэгцээг төдийлөн хангаж чадахгүй байгаа зэрэг нь гол хүндрэл бэрхшээл болдог байна. Өмнөговь аймгийн нэг ч малчин өрхсүү, цагаан идээ боловсруулах ажлыг хүнд хүчир гэж үзээгүй байхад Ховд аймгийн малчдын 27.8 хувь нь уг ажлыг хүнд хүчир ажил гэж сонгосон нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Үүний учрыг тодруулах талаар манай судалгааны баг хэд хэдэн малчинтай ярилцаж үзэхэд Ховд аймгийн сүү, цагаан идээ боловсруулах гол арга болох тос ялгах зорилгоор айраг бүлэх үйл ажиллагаа нь хамгийн хүнд хүчир ажил болохыг тогтоов. Тухайлбал нэг кг айргийн тос ялгаж авахын тулд бүтэн нэг цаг айраг бүлдэг байна.

Мал аж ахуй эрхлэхэд тохиолдож буй хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаар малчид ямар санаа бодолтой байгааг судлах зорилгоор малчдаас дараах асуулгаар санал асуулга авав.

**Мал аж ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаарх таны санал? /Гол гэсэн 2 хүртэлх хариулт өгнө/. Энэхүү асуултад хариулт өгсөн малчид хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаар ямар санаа бодолтой байгааг нэгтгэн дүгнэхэд дараахь байдалтай байна /14 дүгээр график/.**

**6.2. Мал аж ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаарх малчдын бодол**

**Мал аж ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаарх малчдын санал**  
График 14



Энэ судалгаанаас үзэхэд малчдын дийлэнх нь бусадтай хөдөлмөрөө хорших нь хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх хамгийн зөв арга мөн гэж үзэж байгаа аж. Мал хариулах, худаг гаргах, мал ноослох самнах, хадлан авах, нүүдэл хийх гээд бүхий л үйл ажиллагаанд хөдөлмөрөө хорших өргөн боломж, хэрэгцээ байдаг.

Малын бууц зайлуулах, хадлан хадах, нүүдэл хийх зэрэг хүнд хүчир ажилд техник хэрэгсэл ашиглах нь малчдын дийлэнхийн хүсэл сонирхолд нийцэж байгааг дээрх судалгаа нотолж байна.

“Монголын мал аж ахуйн ирээдүй” судалгааны баг малчин өрхийн нэг хүнд ногдох сарын орлого гэсэн үзүүлэлтийг ихэнхдээ сонгон авч малчдын санаа сэтгэлийг судлахад хэрэглэсэн болно. Судалгаанаас харахад хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаарх зарим асуудлаар малчдын санаа бодол орлогын түвшнээсээ

хамаарч өөр өөр байна. Тухайлбал, өрхийн нэг хүнд ногдох сарын орлого 150 мянган төгрөгөөс дээш 43 малчны 11 нь буюу 25.6 хувь нь хүнд хүчир ажлыг шийдвэрлэхдээ хөлсөөр хүн авч ажиллуулна гэсэн байхад өрхийн нэг хүнд ногдох сарын орлого 20-40 мянган төгрөгт хэлбэлзэх 180 өрхийн 21 нь буюу 11.6 хувь нь дээрх хариултыг сонгож байгааг 25 дугаар хүснэгтээс үзэж болно. Харин техник хэрэглэх, бусадтай хөдөлмөрөө хорших зэргээр хүнд хүчир ажлыг шийдвэрлэх сонирхол нь малчдын орлогын төвшнээс үл хамаарсан хэн бүхний хүсч байгаа шийдвэрлэвэл зохих асуудал болж байна.

**Мал аж ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаарх малчдын санал**  
/нэг хүнд ногдох орлогоор/

Хүснэгт 25

Өрхийн нэг хүнд ногдох орлогын бүлэглэл	Асуулгад оролцсон нийт малчин өрх		Үүнээс хүнд хүчир ажлыг шийдвэрлэх санал							
			Хөлсөөр хүн ажиллуулах санал		Бусадтай хөдөлмөрөө хорших санал		Хүнд хүчир ажилд техник хэрэгсэл ашиглах санал		Бусад	
	тоо	хувь	тоо	бүлгийн дүнд эзлэх хувь	тоо	бүлгийн дүнд эзлэх хувь	тоо	бүлгийн дүнд эзлэх хувь	тоо	бүлгийн дүнд эзлэх хувь
0-20000	194	26.9	18	9.3	151	77.8	124	63.9	19	9.8
20001-40000	180	24.9	21	11.7	158	87.8	120	66.7	8	4.4
40001-70000	160	22.2	27	16.9	134	83.8	114	71.3	6	3.8
70001-150000	145	20.1	33	22.8	115	79.3	93	64.1	4	2.8
150000-с дээш	43	6.0	11	25.6	32	74.4	27	62.8	2	4.7
Дүн	722	100.0	110	15.2	590	81.7	478	66.2	39	5.4

Хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаарх малчдын санаа бодлыг тэдний оршин байгаа бүс нутгаас хамааруулан судлахад онцын ялгаа гарахгүй байв. Харин Улаанбаатарын бүсийн малчдын дөнгөж 14.3 хувь нь бусадтай хорших гэсэн хариултыг сонгосон нь хамгийн бага үзүүлэлт болж байв.

**6.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөлмөр, хөрөнгөө хоршиж ажиллах асуудал**

Малчид хөдөлмөрөө болон хөрөнгөө хоршиж хамтран ажиллах талаар төдийлөн амжилт гаргаагүй боловч хамтрах, хөдөлмөрөө хорших нь маш чухал асуудал гэж судалгаанд оролцсон малчдын 81.7 хувь нь үзэж байгааг 6.2 дугаар дэд бүлэгт тусгасан байгаа.

Ийнхүү малчид өөрсдөө хамтрах, хорших хэрэгтэй гэж үзэх болсон нь нийгмийн харилцаан дахь өөрчлөлтөөр малчдын дунд бий болж байгаа сэтгэлгээний томоохон өөрчлөлт, хөгжлийн аятай нөхцлийн суурь тавигдаж байна гэж үзэж болох юм.

Малчид эрт дээр үеэс мал аж ахуйн үйлдвэрлэл дээр хамтарч, хөдөлмөрөө хоршиж ирсэн уламжлалтай. Тэд нийгмийн мал маллаж байсан 1990-ээд оноос өмнөх жилүүдэд хотоороо, сууриараа цаг үеийн чанартай мал аж ахуйн үйлдвэрлэлийн гол гол ажлуудыг хамтран хийж байлаа.

Нийгэм бүхлээрээ зах зээлийн эдийн засагт шилжиж, хүмүүсийн оюун санаа өөрчлөгдөж эхэлсэн 1990-ээд оноос хойшх 10 гаруй жилийн хугацаанд хөдөөгийн иргэдийн хувьд нэг нь нөгөөгийнхөө малыг хариулах, ноослох, услах зэрэг үйл ажиллагааг хийх сэтгэл зүйн бэлтгэл хараахан бүрдээгүй байсан юм. Учир юу гэвэл 1990 он гэхэд нийгмийн мал маллаж байснаас бус хувийн, эзний мал хариулж байгаагүй малчдын бүхэл бүтэн үе бий болоод байсан юм. Малчид баян, ядуу, овсгоотой, овсгоогүй ер нь ямар байх нь хамаагүй бүгд л адилхан нэгдэл нийгмийн мал маллаж байснаас бус айлын мал хариулж байсан нь үгүй, тийм болохоор малгүй нь малтайгийнхаа малыг маллах аваас нэг нь баян, нөгөө нь зарц болж байгаа сэтгэлгээ тэдний дунд байсан юм. Харин ойрын жилүүдэд малчид байгаа орчин, нийгмийнхээ харилцаанд дасаж


хөрөнгө, мал, хөдөлмөрөө хорших асуудал ажил хэрэг болох эхлэлүүд бий болоод байна.

Малчид өөр хоорондоо ямар төрлийн ажлыг одоогоор хоршиж хийж байна вэ? гэдгийг тодруулах зорилгоор тэднээс **Танайх хот айлтайгаа гол төлөв ямар ажлыг хамтран хийдэг вэ?** /3 хүртэлх хариултыг дугаарлана/ гэсэн асуултаар санал асуулга авав. Асуулгын дүнг 15 дугаар графикаар нэгтгэн харуулав.

Судалгаанд оролцсон малчдын 81.8 хувь нь мал хариулах ажлаа хот айлтайгаа хамтардаг, 53.1 хувь нь хадлан тэжээл бэлтгэхэд, 52.0 хувь нь мал ноослох, нядлах ажилд хамтардаг гэсэн хариулт өгсөн байна. Харин малчид хөрөнгө, мөнгө, малаар нийлж хамтрах асуудал бараг үгүй аж. Бусад гэсэн хариултыг нийт малчдын 3.5 хувь нь сонгосон боловч уг сонголтондоо нэмэлт тайлбар өгсөн малчин өрх хараахан үгүй байна.

### Малчдын хот айлтайгаа гол төлөв хамтран хийдэг ажил

График 15



Малчдын хэрхэн хамтардаг тухай хариултаас үзэхэд тэд ихэнхдээ хөдөлмөрөөрөө хамтарч байгаагаас бус эдийн засгийн харилцаанд хамтран оролцох, хорших талаар өнөөг хүртэл төдийлөн ахиц гаргаагүй байна гэж дүгнэж болохоор байна.

Аливаа тоног төхөөрөмжийг өөрт байхгүй л бол өөр хүнийхийг ашиглаж болохгүй, тухайн хүнтэй хамтарч болохгүй, аль эсхүл өөрт байгаа бол бусдад хэрэглүүлж, хурдан элэгдүүлж болохгүй гэсэн үзэл бодол малчдын дунд байсаар байна.

Төв аймгийн Жаргалант сумын 3 дугаар багийн 20 малчны дунд фокус ярилцлага хийх явцад тэдэнд “**Хэрэв Танд одоо ямар нэгэн эх сурвалжаас 10 сая төгрөгийн орлого эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр орж ирвэл Та яаж зарцуулах вэ?**” гэсэн асуулт тавьж хариултыг зарлага тус бүрээр тооцож нэгтгэж дүгнэсэн юм.

Энэхүү судалгаанд хамрагдсан нийт өрхийн 75 хувь нь буюу 15 өрх хадлангийн тоног төхөөрөмж худалдан авна гэсэн хариулт өгсөн байна. Энэ нь нэг талаар хадлан тэжээлийн техник, тоног төхөөрөмж малчдад хичнээн хэрэгцээтэй байгааг нотлохын зэрэгцээ нөгөө талаар өрх бүр бага оврын хадлангийн тоног төхөөрөмжтэй болох нь 1990-ээд оны үед аж ахуйн нэгж, хувиараа эрхлэх аж ахуй бүр гурилын жижиг тээрэмтэй болж, 2-5 жилийн дараа бараг 90 хувь нь ашгийг нь хүртэлгүй хаагдаж байсантай төстэй жишээ юм. Жилдээ нэг удаа хэрэглэх тоног төхөөрөмжийг аль болох хүчин чадлыг нь сайн ашиглаж, хоорондоо хоршиж, хөрөнгөө хамтран гаргаж ашиглах нь

хэн хэндээ хүртээмжтэй, нэг өрхөөс гарах зардал бага гэх мэт ашигтай үйл ажиллагаа юм.

Ер нь цаашид хөдөлмөрөө болон эд хөрөнгө, үйлдвэрлэлийн хэрэгслээ хорших талаар малчдад сургалт, мэдээлэл явуулах зайлшгүй шаардлагатай байгааг энэхүү судалгааны дүн харуулж байна

Дээрх асуултаар хэрхэн оюуны дайралт хийж малчдын нэн тэргүүний хэрэгцээг илрүүлэхэд ашигласан тухай дараагийн бүлэгт тодорхой авч үзэх болно.

**Малчид хоршиж ажиллахад юу саад болж байна вэ?** /ач холбогдлоор нь эрэмбэлэн, хамгийн саадтай гэж үзсэн 3 хүртэлх хариултыг өгнө/ гэсэн асуултаар мал аж ахуйн мэргэжилтэн, удирдах ажилтан нийт 225 хүнээс асуусан асуултын дүнг 26 дугаар хүснэгт, 16 дугаар графикаар үзүүлэв.

Судалгаанд оролцсон нийт 225 хүнээс 166 нь буюу 73.8 хувь нь малчдын дунд хоршиж ажиллах итгэлцэл бүрдээгүй, 130 хүн буюу 58.7 хувь нь хоршиж ажиллахад хөрөнгө дутагдалтай, 123 хүн буюу 54.7 хувь нь малчид хоршиж ажиллах арга ухаанаа олохгүй байна гэж хариулсан байна. **Малчдын дунд хоршиж ажиллах итгэлцэл байхгүй байна** гэсэн хариултыг хамгийн олон оролцогч буюу 82 хүн эн тэргүүний ач холбогдолтой гэж үзэж нэгдүгээр эрэмбээр хариулсан нь анхаарал татаж байна. Үнэхээр хүмүүс хоорондын өмчийн харилцааны асуудал хамгийн эмзэг, тэднээс мэдлэг мэдээлэл, хүнтэй харилцах арга туршлага, уужуу тайван ухаан, итгэл шаардах асуудал болох нь ойлгомжтой.

**Малчид хоршиж ажиллахад юу саад болж байна вэ?**

/салбарын мэргэжилтэн, удирдах ажилтан/


Хүснэгт 26

Хариулт	Хариултын эрэмбэ	Хариултын тоо	Нийт хариултын дүнд эзлэх хувь	Нийт 225 оролцогсдын дүнд эзлэх хувь
Хоршиж ажиллахад бэлчээрийн мал аж ахуйн онцлог саад болдог	1	36	5.6	16.0
	2	13	2.0	5.8
	3	15	2.3	6.7
	дүн	64	9.9	28.4
Малчид хоорондоо хоршиж ажиллах бодит сонирхол алга	1	35	5.4	15.6
	2	29	4.6	12.9
	3	17	2.6	7.6
	дүн	81	12.6	36.0
Малчдын дунд хоршиж ажиллах итгэлцэл бүрдээгүй	1	82	12.7	36.4
	2	53	8.2	23.6
	3	31	4.8	13.8
	дүн	166	25.7	73.8
Хоршиж ажиллахад удирдах сургагч хэрэгтэй	1	21	3.3	9.3
	2	34	5.3	15.1
	3	26	4.0	11.6
	дүн	81	12.6	36.0
Хоршиж ажиллахад хөрөнгө дутагдалтай	1	29	4.5	12.9
	2	54	8.3	24.0
	3	47	7.3	20.9
	дүн	130	20.1	57.8
Хоршоо байгуулах арга ухаанаа олохгүй байна	1	19	2.9	8.4
	2	30	4.7	13.3
	3	74	11.5	32.9
	дүн	123	19.1	54.7
Нийт дүн		645	100.0	-



**Малчид хоршиж ажиллахад юу саад болж байна вэ?**  
/салбарын, мэргэжилтэн, удирдах ажилтан/

График 16



Хоршиж ажиллах арга ухаанаа олохгүй байгаа нь малчдад учирч буй бодитой бэрхшээл мөн. Ийм ч учраас малчид хоорондоо хөдөлмөр, хөрөнгөө хэрхэн хоршиж ажиллавал зохих талаар тэдэнд мэдлэг олгох ажлыг хамгийн түрүүнд хийвэл зохистой байна.

Цаашид малчид ямар ажил дээр эдийн засгийн утгаараа жинхэнэ хамтарч, хамтын хөрөнгө гаргах бодолтой, сэтгэл зүйн бэлтгэлтэй байгааг тодруулах зорилгоор **Дараах боломжийн алинд нь Та бусадтай хамтран хөрөнгө гаргах вэ? /2 хүртэлх хариултыг сонгоно./** гэсэн асуултаар судалгаа хийж дүнг 27 дугаар хүснэгтээр үзүүлэв.

**Малчдын хот айлтайгаа хамтран хөрөнгө гаргах санал**  
/2 хүртэлх хариултыг сонгосон/

Хүснэгт 27

№	Хариулт	Хариултын тоо	Нийт хариултын дүнд эзлэх хувь
1.	МАА-н үйлдвэрлэлийн техник хэрэгсэл худалдан авахад	237	17.6
2.	Хашаа хороо барих, худаг гаргах	407	30.1
3.	Бүтээгдэхүүнээ борлуулах, худалдаа хийх	220	16.3
4.	Малын үүлдэр угсааг сайжруулах	308	22.8
5.	Хөрөнгөөр хамтрах сэтгэл зүйн бэлтгэлгүй	164	12.1
6.	Бусад	14	1.0
7.	Дүн	1350	100.0

Судалгаанд оролцсон нийт малчдын 1350 хариултын 30.1 хувь нь хашаа хороо худаг гаргахад, 22.8 хувь нь малын үүлдэр угсаа сайжруулахад, 17.6 хувь нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн техник хэрэгсэл худалдан авахад бусадтай хамтран хөрөнгө гаргана гэсэн бол 12.1 хувь нь хөрөнгөөр хамтрах сэтгэл зүйн бэлтгэлгүй байна гэж хариулсан байна.

Бидний судалгаагаар малчдад хамгийн их дутагдаж буй зүйл нь малын хашаа, хороо, бэлчээрийн усан хангамж болохыг “**Бэлчээр, хашаа, худгийн хангамж, ашиглалт**” гэсэн гуравдугаар бүлэгт нэгэнт бичсэн. Харин малчид дээрх дутагдаж буй асуудлаа хамтарч шийдвэрлэх хүсэлтэй байгаа нь дээрх судалгаагаар нотлогдож байна. Хашаа хороо барих, угшил сайтай хээлтүүлэгч мал хоорондоо солилцох зэрэг ажлыг малчид зах зээлийн харилцаанд орохоос өмнө хамтран хэрэгжүүлж ирсэн бөгөөд шинэ сэргэг асуудал биш юм.

Зах зээлд шилжсэнээс хойшх өнөөг хүртэлх хугацаанд малчид хамтрах хорших талаар уламжлалт арга хэлбэрээс сэтгэлгээний өөрчлөлт хийж тодорхой ахиц дэвшилд хүрээгүй байна гэж үзэж болохоор байна.

Судалгаанд хамрагдсан нийт 760 малчин өрхийн 21.6 хувь нь хөрөнгөөр хамтрах сэтгэл зүйн бэлтгэлгүй байна гэж хариулсан нь тэднийг хамтрах, зах зээлийн харилцаанд сургах шаардлагатайг харуулж байна. Мал, хөрөнгөөр хамтрах сэтгэл зүйн бэлтгэлтэй байгаа үгүйгээ ч одоохондоо илэрхийлж чадахгүй, асуултын мөн чанарыг бүрэн мэдэрч ойлгоогүй малчид ч олон байсан болно.

**6.4. Малчдын санааг зовоож буй асуудлууд**

Малчин хүний эн тэргүүний айдас гэдэг нь үйл ажиллагааны бэрхшээл гэхээсээ илүү хүний санаа зовоосон, түгшүүр төрүүлсэн, сэтгэл зүйн дарамттай, ирээдүйдээ итгэл муутай байх зэрэг байна.

Малчин хүнд ийм таагүй сэтгэгдэл төрүүлж байдаг асуудал юу байж болохыг урьдчилан судалсны үндсэн дээр **Таны санааг юу зовоож байна вэ? /хамгийн гол 3 хүртэлх хариултыг эрэмбэлэн дугаарлана/** гэсэн судалгааны асуултаар малчдаас хариулт авч дүнг 28, 29 дүгээр хүснэгтээр үзүүлэв.

**Малчдын санааг зовоож буй асуудлууд**

*/Ач холбогдлоорнь эрэмбэлэв/*

Хүснэгт 28

Хариулт	Хариултын эрэмбэ	Хариултын тоо	Нийт хариултын дүнд эзлэх хувь	Нийт 225 оролцогсдын дүнд эзлэх хувь
Малын хулгай	1	339	15.8	44.6
	2	90	4.2	11.8
	3	45	2.1	6.0
	Дүн	474	22.1	62.4
Танхай согтуу	1	17	0.8	2.2
	2	52	2.4	6.9
	3	23	1.1	3.1
	Дүн	92	4.3	12.2
Амьжиргааны доройтол	1	78	3.6	10.3
	2	85	4.0	11.3
	3	64	3.0	8.4
	Дүн	227	10.6	30.0
Бэлчээр, худаг усны хүрэлцээ	1	71	3.3	9.3
	2	127	5.9	16.7
	3	55	2.6	7.2
	Дүн	253	11.8	33.2
Хүүхдийн ирээдүй	1	67	3.1	8.7
	2	130	6.1	16.9
	3	113	5.3	14.7
	Дүн	310	14.5	40.4
Мэдээллийн хомсдол	1	16	0.7	2.1
	2	39	1.8	5.2
	3	70	3.3	9.3
	Дүн	125	5.8	16.6
Чоно, нохойн халдлага	1	36	1.7	4.8
	2	82	3.8	11.0
	3	119	5.5	15.8
	Дүн	237	11.0	31.6
Байгаль, цаг уурын хүндрэл	1	105	4.9	13.6
	2	119	5.6	15.5
	3	151	7.0	19.7
	Дүн	375	17.5	48.8
Бусад	1	16	0.7	2.2
	2	8	0.4	1.0
	3	27	1.3	3.6
	Дүн	51	2.4	6.9
Нийт дүн		2144		

Малчдын санааг зовоож байгаа хамгийн гол асуудал нь малын хулгай болох нь 28 дугаар хүснэгтээс харагдаж байна. Судалгаанд оролцсон малчдын 62.4 хувь нь малын хулгайгаас санаа зовж байна гэж хариулсан байна. 1 сая 500 мянгантөгрөгөөс бага эд зүйл хулгайлсан бол хоригдох ял эдлэхгүй байхаар Эрүүгийн хуульд орсон өөрчлөлт нь малын хулгай ихсэх гол нөхцөл болж байгаа талаар малчдын дунд зохиосон фокус группын ярилцлагаар хэлэлцэж байсан асуудал ийнхүү санал асуулгаар давхар батлагдаж байна. Түүнчлэн малчдын санааг зовоож байгаа хоёр дахь асуудал нь байгаль, цаг уурын хүндрэл гэнэ. Хүүхдийн ирээдүйн тухай асуудал ч малчдын санааг зовоосон асуудлуудын дотор эхний гуравдугаарт багтаж байна.

Малчдын санааг зовоож байгаа асуудлууд нь тэдний оршин байгаа эдийн засгийн бүс нутгаас хамаарч бага зэрэг өөрчлөгдөж байна. Тухайлбал судалгаанд хамрагдсан хангайн бүсийн нийт 245 өрхийн 210 буюу 85.7 хувь нь малын хулгайн асуудлаас болж сэтгэл санаа тайван биш байгаа нь нийт дунджаас 20 гаруй хувиар илүү байна. Гэтэл Төвийн бүсийн малчдын 55.2 хувь, баруун бүсийн малчдын 35.4 хувь нь л малын хулгайд санаа зовж байна гэсэн байна.

Төвийн бүсийн Төв аймгийн нутагт малын хулгай их, харин Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ аймагт харьцангуй бага байгаа нь судалгаагаар тогтоогдсон юм. Баруун бүсийн малчид хүүхдийн боловсрол, ирээдүйн асуудалд санаа их зовж байна гэсэн бол энэ асуудалд Улаанбаатар хотын малчдын дөнгөж 5.3 хувь нь, Зүүн бүсийн малчдын 24.8 хувь нь л санаа зовдог байна. Хүүхдийн ирээдүйн асуудалд санаа зовох нь тэдний хот суурингаас хэр зэрэг алслагдсан байдалтай холбоотой байна.

**Малчдын санааг зовоож буй асуудлууд**

Хүснэгт 29

Хариулт	Эдийн засгийн бүсийн аймаг										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мал хариулах	24	4.2	51	8.7	30	7.4	13	5.0	1	3.4	119	6.4
Мал услах	68	11.9	42	7.2	24	5.9	31	12.0	1	3.4	166	9.0
Малын хулгай	210	29.8	73	11.9	91	19.5	87	27.7	13	32.5	474	22.1
Бэлчээр, худаг усны хүрэлцээ	76	10.8	76	12.3	56	12.0	37	11.8	8	20.0	253	11.8
Танхай согтуу	29	4.1	29	4.7	21	4.5	9	2.9	4	10.0	92	4.3
Амьжиргааны доройтол	67	9.5	79	12.8	43	9.2	38	12.1	0	0.0	227	10.6
Хүүхдийн ирээдүй	82	11.6	127	20.6	73	15.6	27	8.6	1	2.5	310	14.5
Мэдээллийн хомсдол	26	3.7	63	10.2	10	2.1	21	6.7	2	5.0	122	5.7
Чоно нохойн халдлага	61	8.7	74	12.0	57	12.2	40	12.7	5	12.5	237	11.1
Байгаль цаг уурын хүндрэл	126	17.9	84	13.6	114	24.4	46	14.6	5	12.5	375	17.5
Бусад	27	3.8	11	1.8	2	0.4	9	2.9	2	5.0	51	2.4
Хариултын тоо бүгд	704	100.0	616	100.0	467	100.0	314	100.0	40	100.0	2141	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	245	-	206	-	165	-	109	-	19	-	744	-


Малын хулгай нь хамгийн их санаа зовоосон асуудал бөгөөд Хангай, Зүүн, Улаанбаатарын бүсийн нийт малчдын 85.7 хувь, 79.8 хувь, 68.4 хувь нь тус тус малын хулгай их байгаад санаа зовж байгаа нь бусад бүсээс их байна.

Түүнчлэн санаа зовоож байгаа асуудлуудаа ач холбогдлоор нь 1-3 хүртэл эрэмбэлсэн дүнгээс үзэхэд /28 дугаар хүснэгт/ малын хулгайг нэгдүгээр эрэмбээр 345 малчин буюу нийт малчдын 44.6 хувь, тухайн хариултыг сонгосон малчдын 71.6 хувь нь сонгосон байгаа нь энэ асуудал малчдын сэтгэл санаанд ихээхэн дарамттай асуудал болохыг нотолж байна.

Малчдын санааг зовоож байгаа хоёрдугаар эрэмбийн асуудал болох байгаль, цаг уурын хүндрэл нь нэгдүгээр эрэмбээр 105 удаагийн давтамжтай байна. Төвийн бүсийн Дундговь, Өмнөговь аймгийн малчид байгаль, цаг уурын бэрхшээлд илүү их санаа зовж байгаа нь дээрх аймгуудад сүүлийн 3-5 жилд дараалан ган, зуд болсонтой холбоотой байна.

**Малчдын санаа зовоож буй асуудлууд**

График 17



**6.5. Дигнэлт**

1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн ажлыг хүнд хүчир байдлаар нь малчид хадлан тэжээл бэлтгэх, нүүдэл хийх, төл бойжуулах гэсэн дарааллаар үнэлж байна.

2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн олон ажлын аль нь хамгийн хүнд хүчир болох нь байгаль, цаг уур, нутаг орны онцлог, малчин өрхийн ам бүл зэргээс ихээхэн хамаарч байна. Говь, тал хээр, Алтайн нурууны сав нутгийн малчдын хувьд хамгийн хүнд хүчир ажил нь нүүдэл хийх ажил байхад хангайн бүсийн аймгийн малчдын хувьд хадлан тэжээл бэлтгэх нь хамгийн хүнд хүчир ажил болдог байна.

3. Малчид өөр хоорондоо хөдөлмөрөө хоршиж ажиллаж байгаа боловч энэхүү хоршилт нь мал хариулах, хашаа хороо барих зэрэг уламжлалт хэлбэрээс цааш хөгжихгүй байна. Хорших, хамтрах үйл ажиллагааг эдийн засгийн харилцаанд оруулж хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай болж байна.

4. Хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх гол арга нь хөдөлмөрөө хорших явдал гэж малчид үзэж байна. Гэвч тэд хэрхэн хоршиж хамтарч ажиллах талаар мэдлэг, туршлага дутмаг, хоршиж ажиллах арга эвээ олохгүй байна. Иймд малчдын дунд хоршиж ажиллах талаар сургалт зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

5. Малыг хулгай нь малчдын санааг зовоож байгаа хамгийн төвөгтэй асуудал байна. Малчин өрхийн 63.7 хувь нь энэ асуудалд санаа зовж байна. Түүнчлэн байгалийн бэрхшээл, ган, зуд ч малчдын санааг сэтгэлийг түгшээж байдаг байна. Эдгээр асуудал нь мал аж ахуйг гаднын халдлага, байгалийн бэрхшээлээс хамгаалах менежментийг бий болгох зайлшгүй шаардлагатай байгааг нотолж байна.

6. Малчдын санааг зовоож байгаа гуравдугаар асуудал нь хүүхдийн ирээдүйн асуудал байна. Малчид хүүхдээ сайн боловсрол эзэмшүүлэх сургалтын орчин болон санхүүгийн боломж байхгүй, санхүүгийн хуримтлал үүсэхгүй байгаа нь тэдний санааг

зовоож байна. Сурлага сайн, авъяастай зарим хүүхдийн сургалт, боловсролын асуудалд төр, хувийн хэвшлийн байгууллагаас дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

7. Малчдын 30 гаруй хувь нь бэлчээр усны хүрэлцээ, чоно нохойн халдлага, амьжиргааны доройтол зэрэг асуудалд сэтгэл зовж айдас тээж явна. Иймд малчдыг айх аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг хангах талаар төр, засгийн байгууллагаас нийгмийн хэв журмыг сайжруулах, малын хулгайтай тэмцэх, бэлчээрийг хуваарилах, малчдын амьжиргааны байдлыг сайжруулах зах зээлийн эдийн засгийн бүтэц, нөхцлийг бүрдүүлэх талаар тодорхой бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай юм.

**МАЛЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ**


Энэхүү судалгаагаар малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа болон өөрсдийн ахуй нөхцөл, ашиг орлогын байдал, нийгмийн үйлчилгээний талаар хэр зэрэг сэтгэл хангалуун байгааг малчдаас өөрсдөөс нь асууж тодорхойлохыг зорив. Энэхүү мэдээлэл нь цаашид мал аж ахуйн салбарыг хэрхэн хөгжүүлэх асуудлаар шийдвэр гаргахад ашиглах үнэтэй баримт материал болно.

**7.1. Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл ханамжтай байдаг эсэх**

Энэ зорилтын хүрээнд малчин хүн өөрийн эрхэлж байгаа ажил мэргэжилдээ сонирхолтой буюу сонирхолгүй байгааг тодорхойлохыг зорьсон. Үүний тулд **Та мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа хэр сэтгэл хангалуун байдаг вэ? /дөрвөн сонголтоос зөвхөн нэг хариулт өгнө/** гэсэн асуултаар малчдын дунд социологийн судалгаа явуулж дүнг 18 дугаар графикаар тоймлон үзүүлэв.

**Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа хэр зэрэг сэтгэл ханамжтай байна вэ?**  
/Малчдын санал хувиар/

График 18



Судалгаанд оролцсон нийт 773 малчны 63.6 хувь нь сэтгэл хангалуун, 25.8 хувь нь яахав дээ дунд зэрэг, 6.8 хувь нь сэтгэл хангалуун бус байна гэсэн хариулт өгсөн байна. Малчдын дийлэнх олонх нь мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаа ажээ.

Энэхүү асуултын үр дүн нь мэргэжлийн зарим хүмүүс, иргэдийн төсөөлөн ярьдаг малчид мал маллах ажлаасаа залхаж байгаа, туйлдаж байгаа, аргагүйн эрхэнд л мал маллаж байгаа гэсэн ярианд няцаалт өгч байна.

Малчидтай уулзаж ярилцаж байх үед тэд мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа гутарсан байдал ажиглагдаагүй, харин ч мал багатай ядуу иргэд өөрсдийнхөө амьжиргааны байдлын доройтлыг өөрсдөөсөө, нийгмээсээ эрж хайсан, өөрсдийн овсгоо, санаачилгад шүүмжлэлтэй хандаж байв.

Судалгаа хийж байх явцад “Энэ хэдэн малаар л амь зуулгаа залгуулж байгаа атал мал маллаж байгаадаа сэтгэл дундуур байна гэж хэлэх нь алдас болно” гэж олон малчин ярьж байлаа.

“Яахав дээ, дунд зэрэг” гэсэн хариулт сонгосон малчдын олонх нь “сэтгэл хангалуун байна” гэсэн хариултад ойрхон санаа сэтгэлтэйгээ илэрхийлж байсныг онцлон тэмдэглэж байна. Өөрөөр хэлбэл “яахав дээ, дунд зэрэг” гэсэн хариулт өгч байгаа малчид нь сэтгэл хангалуун байна гэж хэлэх бүрэн дүүрэн итгэлтэй биш, гэсэн хэдий ч “сэтгэл хангалуун бус” гэж хэлж бүр ч чадахгүй малчид олон

байлаа. Манай тайланд санал, зөвлөмж өгсөн шүүмжлэгчид уг асуултын хариу эсрэг тэсрэг хоёр хувилбараар л авах ёстой, гуравдагч буюу дундаж хувилбар байх ёсгүй гэж үзэж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Уг асуулт нь хээрийн судалгаагаар нэгэнтээ асуултын 4 хувилбараар хийгдсэн учир гүйцэтгэлээр нь тайланд бичиж зөв буруу алин болохыг тунгаахыг уншигч танд үлдээж байна.

Мал аж ахуйн салбарт хашир туршлагатай малчид цөөрч, залуучууд голлох болсон. Залуучууд хөдөөд тогтохгүй болсон, тэд мал маллаж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаа гэсэн урьдчилсан таамаглал байсан хэдий ч судалгааны дүн өөрөөргарч байна. Малчид **“Та мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа хэр сэтгэл хангалуун байдаг вэ?”** гэсэн асуултын хариултыг насны бүлэглэлээр ангилж 30 дугаар хүснэгтээр үзүүлэв.

**Та мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа хэр зэрэг сэтгэл хангалуун байдаг вэ? /хувиар/**

Хүснэгт 30

Хариултын хувилбар	Судалгаанд оролцсон малчид /насны бүлэглэл/					Дүн
	18-25	26-35	36-50	51-60	60-аас дээш	
Сэтгэл хангалуун байдаг	59.2	64.9	68.2	55.5	57.9	63.6
Яахав дээ, дунд зэрэг	36.7	21.5	23.3	30.	31.6	25.8
Сэтгэл хангалуун бус байдаг	4.1	7.8	5.9	10.9	4.2	6.8
Хэлж мэдэхгүй		5.4	2.0	2.7	6.3	3.4
Хариулаагүй		0.5	0.7			0.4
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

18-25 насны залуучуудын бараг 60 хувь нь мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаа бөгөөд харин сэтгэл хангалуун бус гэсэн хариултыг залуучуудын дөнгөж 4.1 хувь нь л сонгосон байна. Түүнчлэн 26-35 насны малчдын 64.9 хувь, 36-50 насны малчдын 68.2 хувь, 51-60 насны малчдын 55.5 хувь нь мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байна гэж хариулсан байна.

Дээрх судалгааны дүнгээс үндэслэн мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаа эсэх нь малчдын насны байдлаас төдийлөн хамаарч өөрчлөгдөхгүй байна гэсэн дүгнэлт хийж болох байна.

**7.1.1. Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаагийн шалтгаан**

**Хэрэв сэтгэл хангалуун бол түүний шалтгаан?** /ач холбогдлоор нь эрэмбэлэн, хамгийн боломжтой гэж үзсэн 3 хүртэлх хариултыг дугаарлана/ гэсэн социологийн асуулгаар малчдын мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл ханамжтай байгаагийн учир шалтгаан, түүний дараалал, сэтгэл ханамжид нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн эрэмбийг тогтоож 19 дүгээр графикаар үзүүлэв.

Малчдын мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаагийн үндсэн шалтгаан нь мал ажахуй бол тэдний амьжиргааны гол эх үүсвэр, хоёрдугаар шалтгаан нь мал аж ахуйн үйлдвэрлэл ашигтай учраас гэх мэтээр тогтоогдож байгааг 19 дүгээр графикаас үзэж болно.


Судалгаанд оролцсон малчид дээрх асуултад хариулахдаа 3 хүртэлх хариултыг сонгож ач холбогдлоор нь 1-3 хүртэл эрэмбэлсэн. Энэхүү эрэмбээр сэтгэл хангалуун байгаа байдал хэрхэн тогтоогдсоныг 31 дүгээр хүснэгтээр үзүүлэв.

Нийт малчдын 56.1 хувь буюу 276 малчин амьжиргааны маань гол эх үүсвэр гэсэн хариултыг 1 дүгээр эрэмбээр сонгосон нь бусдаас хамгийн өндөр үзүүлэлт болсон байна.

Гэтэл сэтгэл хангалуун байгаагийн 2 дахь шалтгаан болсон мал аж ахуйн

**Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаагийн шалтгаан**

График 19



үйлдвэрлэл ашигтай учир гэсэн хариултыг 1 дүгээр эрэмбээр сонгосон малчдын тоо дөнгөж 52 буюу нийт малчны 6.7 хувь болж байгаа нь амьжиргааны маань гол эх үүсвэр гэсэн хариултын 1 дүгээр эрэмбийн давтамжаас даруй 224 малчнаар буюу 49.4 хувиар дутуу байна. Бусад хариултууд ч 1 дүгээр эрэмбээр төдийлөн олон санал авч чадаагүй байна. Судалгааны энэхүү дүн нь амьжиргааны маань гол эх үүсвэр учир гэсэн хариултын ач холбогдлыг улам бүр тодруулж байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл ашигтай учир гэсэн хариултыг сонгосон нийт 233 малчин уг сонголтоо эрэмбэлэхдээ 118 малчин буюу 24.1 хувь нь 2 дугаар эрэмбээр, 82 малчин буюу 19.7 хувь нь 3 дугаар эрэмбээр, дөнгөж 33 малчин буюу нийт оролцогчийн 6.7 хувь нь 1 дүгээр эрэмбээр уг хариултыг сонгосон байна.

**Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаа бол түүний шалтгаан**

Хүснэгт 31

Хариулт	Эрэмбийн дугаар	Хариултын тоо	Нийт хариултын дүнд эзлэх хувь	Нийт 492 оролцогсдын дүнд эзлэх хувь
Амьжиргааны маань гол эх үүсвэр учир	1	276	24.7	56.1
	2	41	3.7	8.4
	3	20	1.8	4.0
	дүн	337	30.2	68.6
МАА-н үйлдвэрлэл ашигтай учир	1	33	3.0	6.7
	2	118	10.6	24.1
	3	82	7.3	16.6
	дүн	233	20.9	47.3
Өв залгамжлан эрхэлж ирсэн учир	1	29	2.6	6.0
	2	55	4.9	11.1
	3	97	8.7	19.7
	дүн	181	16.2	36.7
Миний хамгийн сайн хийж чаддаг ажил	1	36	3.3	7.4
	2	86	7.7	17.5
	3	46	4.1	9.3
	дүн	168	15.1	34.2
Байнга эрүүл агаарт ажилладаг учир	1	16	1.4	3.2
	2	56	5.0	11.4
	3	45	4.0	9.1
	дүн	117	10.5	23.7
Ямар нэг дарамт шахалтад байдаггүй учир	1	6	0.5	1.2
	2	16	1.5	3.4
	3	48	4.3	9.7
	дүн	70	6.3	14.2
Бусад	1	0	-	-
	2	3	0.3	0.5
	3	6	0.5	1.3
	дүн	9	0.8	1.8
Бүгд	-	1115	100.0	-



31 дүгээр хүснэгтээс үзэхэд амьжиргааны маань гол эх үүсвэр гэснээс бусад хариултад малчид бараг нэг түвшинд хандаж байгаа нь харагдаж байна. Тухайлбал хариултыг сонгохдоо 1 дүгээр эрэмбийг хамгийн бага, 2 болон 3 дугаар эрэмбийг 1 дүгээр эрэмбээс олон давтамжтайгаар сонгосон байна.

Малчдын сэтгэл хангалуун байдал нь тэдний оршин байгаа бүс нутгаас хамаарч хэрхэн өөрчлөгдөж байгааг судалж үзэхэд бага зэрэг өөрчлөлтүүд байгааг 32 дугаар хүснэгтээр үзүүлэв.

**Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаагийн шалтгаан /эдийн засгийн бүсээр/**

Хүснэгт 32

Хариултын хувилбар	Бүс Судалгааны дундаж	Хангайн	Баруун	Төв	Зүүн	УБ
Амьжиргааны маань гол эх үүсвэр учир	68.6	87.2	84.1	54.1	93.3	77.8
МАН-н үйлдвэрлэл ашигтай учир	47.3	51.7	34.3	45.2	37.5	50.0
Өв залгамжлан эрхэлж ирсэн учир	36.7	57.2	70.9	57.4	53.8	33.3
Миний хамгийн сайн хийж чаддаг ажил	34.2	25.6	23.2	43.9	21.2	16.7
Байнга эрүүл агаарт ажилладаг учир	23.7	51.7	49.7	35.5	51.0	16.7
Ямар нэг дарамт шахалтад байдаггүй учир	14.2	10.6	28.5	14.8	19.2	16.7
Бусад	1.8	2.8	1.3	0.6	1.9	11.1

Судалгаанаас үзэхэд эдийн засгийн Зүүн бүсийн малчдын 93.3 хувь нь мал аж ахуй бол амьжиргааны маань гол эх үүсвэр гэсэн сонголт хийсэн нь судалгааны дундаж үзүүлэлтээс 24.7 хувиар их буюу хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Тус бүс нутагт байгалийн баялаг /самар, жимс, ан амьтан, ой мод гэх мэт/ ашиглана гэхээсээ илүү малаа шүтэж амьдарч байгааг энэхүү үзүүлэлт нотолж байна.

Харин төвийн бүсийн малчдын дөнгөж 54.1 хувь нь дээрх хариултыг сонгосон нь судалгааны дундаж үзүүлэлтээс 14.5 хувиар бага буюу хамгийн бага үзүүлэлт аж. Эдийн засгийн төвийн бүсэд зах зээл, зам харилцаа их хөгжсөн, мал аж ахуйн зэрэгцээ газар тариалан, хүнсний ногоо хослон эрхлэх боломжтой, нөгөө талаар 1999-2002 оны ган, зудад малаа хорогдуулсан төвийн бүсийн Дундговь, Өмнөговь аймгийн малчдын нэлээд хэсэг нь мал аж ахуйг амьжиргааны маань гол эх үүсвэр гэж үзэхгүй байгаа зэрэг нь дээрх байдал нөлөөлж байна.

Эдийн засгийн Улаанбаатар, Хангайн бүсийн малчдын 50.0-51.7 хувь нь мал аж ахуйн үйлдвэрлэл ашигтай байна гэж үзсэн нь тус бүс нутгийн малчид зах зээлд илүү ойр байгаагаар тайлбарлагдана.

Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаа эсэх нь малчин өрхийн малын тоо, өрхийн орлогоос хэрхэн хамаарч байгааг судалж үзэх нь энэхүү судалгааны ажлын үр дүнг бодитой болгоход чухал ач холбогдолтой юм. Иймд малчдын мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаадаа сэтгэл ханамжтай байгаа эсэхийг нэг хүнд ногдох малын тоо гэсэн үзүүлэлттэй холбон судалж дүнг 33 дугаар хүснэгтээр үзүүлэв.

Нэг хүнд ногдох мал 0-20 бог бүхий өрхийн 81 хувь, 40-70 бог бүхий өрхийн 87.7 хувь, 70-150 бог бүхий өрхийн 87.8 хувь, 150-аас дээш бог бүхий өрхийн 95 хувь нь мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаагаар амьжиргааны маань гол эх үүсвэр гэсэн хариулттай холбож хариулсан байна. Нэг хүнд ногдох малын тоо нэмэгдэх тутам мал аж ахуй бол амьжиргааны маань эх үүсвэр мөн гэсэн итгэл үнэмшил улам бүр нэмэгдэж байна.

**Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхдээ сэтгэл хангалуун байгаа нь нэг хүнд ногдох малын тооноос хамаарах нь**

*Хүснэгт 33*

Хариулт	Нэг хүнд ногдох малын тооны бүлэглэлт /богоор/										Дүн	
	0-20		21-40		41-70		71-150		150-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мал хариулах	24	4.2	51	8.7	30	7.4	13	5.0	1	3.4	119	6.4
Амьжиргааны маань гол эх үүсвэр учир	129	29.3	134	30.0	121	30.7	108	30.7	38	32.2	530	30.3
Миний хамгийн сайн хийж чаддаг ажил	62	14.1	60	13.4	61	15.5	64	18.2	17	14.4	264	15.1
Мал аж ахуй ашигтай учир	92	20.9	84	18.8	78	19.8	86	24.4	26	22.0	366	20.9
Байнга эрүүл агаарт ажилладаг учир	47	10.7	51	11.4	44	11.2	31	8.8	10	8.5	183	10.5
Өв залгамжлан эрхэлж ирсэн ажил	75	17.0	77	17.2	62	15.7	47	13.4	23	19.5	284	16.2
Ямар нэг дарамт шахалтад байдаггүй учир	30	6.8	39	8.7	22	5.6	16	4.5	3	2.5	110	6.3
Бусад	5	1.1	2	0.4	6	1.5	0	0.0	1	0.8	14	0.8
Хариултын тоо бүгд	440	100.0	447	100.0	394	100.0	352	100.0	118	100.0	1751	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	159		158		138		123		40		618	
Асуулгад оролцсон малчин өрхийн нийт дүнд эзлэх хувь	25.7		25.6		22.3		19.9		6.5		100	

Нэг хүнд ногдох малын тоо 20 хүртэлх малтай /богоор/ өрхийн амьжиргааны наад захын хэрэгцээ хангагдахгүй байгаа нь ойлгомжтой. Тийм атал яагаад тэд мал аж ахуй эрхэлж байгаадаа сэтгэл ханамжтай байна гэж хариулах болов? Тэд амьжиргааны хэрэгцээ, хэрэглээг мал аж ахуйн үйлдвэрлэлээр хангаж байгаа эсэхээр биш бусад олон учир шалтгааны хэмжүүрээр хэмжиж мал аж ахуй эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байна гэж хариулж байна. Тухайлбал, нэг хүнд ногдох малын тоо 20 толгойд /бог малд шилжүүлснээр/ хүрэхгүй малчин өрхийн 39.0 хувь нь мал маллах бол миний хамгийн сайн хийж чадах ажил учраас сэтгэл хангалуун байдаг гэсэн байхад, 47.2 хувь нь өв залгамжилж эрхэлж ирсэн учир мал аж ахуй эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байна гэж хариулсан байна.

Өрхийн нэг хүнд ногдох малын тоо өсөх тутам малчдын зүгээс **мал аж ахуйн үйлдвэрлэл ашигтай учир, миний хамгийн сайн хийж чадах ажил** гэсэн хариултыг сонгох хувь хэмжээ өссөн байна. Тухайлбал 20 хүртэл малтай 159 өрхийн 57.9 хувь буюу 92 өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл ашигтай учир гэсэн хариултыг сонгосон байхад 70-150 толгой малтай 123 өрхийн 69.9 хувь буюу 86 өрх дээрх хариултыг сонгосон байна.

**Малчдын сэтгэл ханамжид орлогын нөлөөлөл**  
/нэг хүнд ногдох орлогоор/

*Хүснэгт 34*

Малчдын мал аж ахуй эрхэлж буйд сэтгэл хангалуун байгаагийн шалтгаан	Нэг хүнд ногдох орлого /-өөр/					Дүн
	8000 хүртэл	8001-25000	25001-41500	41501-58300	58301-ээс дээш	
Амьжиргааныхаа гол эх үүсвэр учир	1	86	236	123	50	530
	2	16.2	44.5	23.2	9.4	85.8
	3	93.5	81.7	87.2	89.3	87.5
Мал аж ахуйн үйлдвэрлэл ашигтай учир	1	41	173	86	40	366
	2	11.2	47.3	23.5	10.9	59.2
	3	44.6	5-9.9	61.0	71.4	65.0

Тайлбар: 1 - Тухайн хариултыг сонгож хариулсан малчин өрхийн тоо  
2 - Тухайн хариултыг сонгосон малчин өрхийн дүнд эзлэх хувь  
3 - Тухайн бүлгийн малчдын дүнд эзлэх хувь

Малчдын мал аж ахуй эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгааг малчин өрхийн орлоготой холбон авч үзэхэд нэг хүнд ногдох сарын орлого 8000 төгрөг хүртэлх бүлэгт хамрах малчдын 93.5 хувь нь амьжиргааны гол эх үүсвэр учир мал маллаж байгаадаа сэтгэл ханамжтай байна гэсэн хариултыг сонгосон нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Мөн бүлгийн 44.6 хувь буюу 41 малчин мал аж ахуйн үйлдвэрлэл ашигтай учир гэсэн хариултыг сонгосон нь ач холбогдлоороо хоёрдугаар шалтгаан болж байна. Өөрөөр хэлбэл, сэтгэл хангалуун байгаагийн шалтгаан нь нэг хүнд ногдох малын тоогоор ч, нэг хүнд ногдох орлогоор ч авч үзсэн ижил байгаа нь харагдаж байна.

**7.1.2. Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаагийн шалтгаан**


Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл ханамжтай бус байгаа малчид басхүү байгаа билээ. Тэд яагаад ингэж хариулах болов гэдгийг тодруулах зорилгоор “Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаагийн шалтгаан?” гэсэн асуултаар нийт 52 малчнаас судалгаа авч хариултын нэгдсэн дүнг 20 дугаар графикаар, хариултыг ач холбогдлоор нь эрэмбэлсэн дүнг 35 дугаар хүснэгтээр тус тус үзүүлэв.

Санал асуулгад оролцсон нийт 52 малчны 38 нь буюу 73.0 хувь нь **байгалийн бэрхшээл ихтэйгээс** мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байна гэсэн хариултыг сонгосон нь хамгийн олон оролцогчийг хамарсан хариулт болсон байна. Байгалийн бэрхшээл ихтэй гэсэн хариултыг 1 дүгээр эрэмбээр 15 өрх буюу нийт өрхийн 22.3 хувь нь сонгосон байна.

Гэтэл **олсон орлого амьдрал ахуйд хүрэлцдэггүй** гэсэн хариултыг 1 дүгээр эрэмбээр 25 өрх буюу нийт өрхийн 41.1 хувь нь сонгосон нь хүмүүс энэхүү хариултад хандахдаа байгалийн бэрхшээл ихтэй гэсэн хариултаас илүү ач холбогдол өгч байгааг харуулж байна.

**Малчдын мал маллахдаа сэтгэл хангалуун бус байгаагийн шалтгаан**

График 20



Байгалийн бэрхшээлийн хор нөлөө нь жил бүр тохиолдоод байдаггүй, нөгөө талаар байгалийн бэрхшээлийг даван туулах боломж байгаа, харин амьдрал ахуйд мал аж ахуйн орлого хүрэлцэж байгаа эсэх асуудал хамгийн чухал хүчин зүйл болох нь эндээс харагдаж байна.

Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун гэж хариулсан малчдын дийлэнх /68.6 хувь/ нь **Яагаад?** гэсэн асуултад эдийн засгийн талаас нь хандаж **амьжиргааны маань гол эх үүсвэр учир** гэж хариулсан бол сэтгэл хангалуун бус гэж хариулсан малчдын дийлэнх нь /71.1 хувь/ уг асуултад мөн л эдийн засгийн талаас нь хандаж “олсон орлого амьдрал ахуйд хүрэлцдэггүй учир” гэсэн хариултыг сонгосон байна.

Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаагийн нэлээд хувийг мал аж ахуйн хөдөлмөр хүнд хүчир /30.7 хувь/, бөглүү, нийгмийн хөгжлөөс хоцордог /40.3 хувь/, хүүхдийн боловсролд муугаар нөлөөлдөг /36.5 хувь/ зэрэг хариултууд эзэлж байгаа бөгөөд, тэдгээр шалтгаан, хүчин зүйлсийг ач холбогдлын хувьд ихэвчлэн 2, 3 дугаарт эрэмбэлсэн нь 37 дугаар хүснэгтээс харагдаж байна. Энэ бүгдээс үндэслэн мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаа хүмүүсийн ийм байдалд хүрсэн гол шалтгаан нь мал аж ахуйгаас олсон орлого нь тэдний амьдрал, ахуйд хүрэлцдэггүй явдал гэж дүгнэж болох байна.

**Хэрэв сэтгэл хангалуун бус байгаа бол түүний шалтгаан**

**Хүснэгт 35**

Хариулт	Хариултын дүн /эрэмбээр/	Хариултын тоо	Нийт хариултын дүнд эзлэх хувь	Нийт 52 оролцогсдын дүнд эзлэх хувь
1	2	3	4	5
Олсон орлого амьдрал ахуйд хүрэлцдэггүй учир	1	25	18.8	49.1
	2	8	6.0	15.9
	3	4	3.0	7.3
	дүн	37	27.8	71.1
МАН-н хөдөлмөр хүнд учир	1	3	2.2	6.5
	2	10	7.6	18.1
	3	3	2.2	5.6
	дүн	16	12.0	30.7
Байгалийн бэрхшээл ихтэйгээс	1	15	11.3	29.3
	2	18	13.5	33.6
	3	5	3.8	10.3
	дүн	38	28.6	73.0
Бөглүү, нийгмийн хөгжлөөс хоцордог учир	1	2	1.5	3.0
	2	5	3.7	9.9
	3	14	10.6	25.0
	дүн	21	15.8	40.3
Хүүхдийн сургууль боловсролд муугаар нөлөөлдөг учир	1	5	3.8	9.0
	2	3	2.2	5.6
	3	11	8.3	21.6
	дүн	19	14.3	36.5
Бусад	1		-	-
	2	1	0.75	1.7
	3	1	0.75	2.1
	дүн	2	1.5	3.8
Дүн		133	100.0	-

Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл ханамжтай бус байна гэж хариулсан малчдыг нэг хүнд ногдох сарын орлогын түвшингээр нь ангилж үзэхэд 16 хувь нь нэн ядуу, 50.7 хувь нь ядуу, 20.4 хувь нь дундаж, 12.9 хувь нь дунджаас дээш амьжиргааны түвшинд хамрагдаж байна /36 дугаар хүснэгт/.

Мал маллаж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаа малчдын хувьд тэдний орлогын хэмжээ буурах тутам “олсон орлого амьжиргаанд хүрэлцдэггүй учир мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байна” гэж хариулсан малчны тоо нэмэгдэж байна. Тухайлбал 58.3 мянган төгрөгөөс дээш нэг хүнд ногдох сарын орлого бүхий өрхийн 37.5 хувь нь олсон орлого амьдрал ахуйд хүрэлцдэггүй гэсэн хариултыг сонгосон байхад 41-58 мянган төгрөгийн орлоготой өрхийн 61.9 хувь, 25-41 мянган төгрөгийн орлоготой өрхийн 63 хувь, 8.0 мянган төгрөг хүртэл орлоготой өрхийн /нэн ядуу өрх/ 88.9 хувь нь дээрх хариултыг сонгосон байна. Мал аж ахуйгаас олох орлогын хүрэлцээ ямар байх нь малчдын мал аж ахуйн үйл ажиллагаандаа сэтгэл ханамжтай байх эсэхийг шийдвэрлэх гол үзүүлэлт болохыг энэхүү судалгаа дахин нотолж байна /36 дугаар хүснэгт/.

**Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа  
сэтгэл хангалуун бус байгаагийн шалтгаан  
/нэг хүнд ногдох сарын орлогоор/**

**Хүснэгт 36**

Үзүүлэлт	Нэг хүнд ногдох сарын орлогын бүлэглэл					Ерөнхий дундаж
	8000 хүртэл	8001-25000	25001-41500	41501-58300	58301-ээс дээш	
Судалгаанд оролцсон малчин өрхийн орлогын бүлэглэл /хувиар/	16.0	50.7	20.4	9.3	3.6	100
Олсон орлого амьдрал ахуйд хүрэлцдэггүй учир /хувиар/	88.9	79.8	63	61.9	37.5	74.3
Мал аж ахуйн хөдөлмөр хүнд учир /хувиар/	19.4	26.3	41.3	42.9	62.5	32.8
Байгалийн бэрхшээл ихтэйгээс /хувиар/	86.1	73.7	76.1	66.7	75.0	72.5
Бөглүү, нийгмийн хөгжлөөс хоцрогдсон учир /хувиар/	38.9	37.7	39.1	47.6	37.5	37.9
Хүүхдийн сургууль, боловсролд муугаар нөлөөлдөг /хувиар/	36.1	33.3	47.8	38.1	37.5	37.9
Бусад /хувиар/	2.8	7.9	2.2	0	0	7.8

Нэг хүнд ногдох сарын орлого 58.3 мянган төгрөгөөс дээш атал олсон орлого амьдралд хүрэлцэхгүй байна гэж хариулсан малчидтай ярилцаж байхад тэдний дийлэнх нь зарлага их, үр хүүхэд нь их, дээд сургуульд суралцдаг, машин техниктэй, түүний шатах тослох материалын зардал их гардаг, гэр орноо тохижуулах, малын үүлдэр угсаа сайжруулах зэрэг ажилд орлого хүрэлцэхгүй байна, хоол хүнсний хангамж боломжтой ч ахуйн наад захын хэрэгцээгээ орлогоороо хангаж чадахгүй байна гэсэн тайлбар хэлж байна. Ер нь өрхийн орлого нэмэгдэхийн хэрээр тэдний элдэв төрлийн хэрэглээ нэмэгдэж зарлага өсч байгаа, хувь хүмүүсийн өөрсдийн сэтгэлгээний онцлог зэргээс хамаарч мал маллаж байгаадаа сэтгэл ханамжтай байгаа эсэхээ малчид өнөөдрийн бодит орлогоор тодорхойлох биш өөрсдийн бодол, санаа, үзэмжээр тодорхойлж болохыг дээрх жишээ харуулж байна.

Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаа малчин өрхийн 64.9 хувь нь 40 хүртэл малтай /богд шилжүүлсэн нэг хүнд ногдох малын тоогоор/, 16.9 хувь нь 40-70 толгой малтай, 12.9 хувь нь 70-150 толгой малтай, 5.3 хувь нь 150-аас дээш толгой малтай байна /37 дугаар хүснэгт/.

37 дугаар хүснэгтээс үзэхэд нэг хүнд ногдох малын тоо толгой буурахын хэрээр малчдын орлогын болон сэтгэл ханамжийн түвшин ерөнхийдөө буурах хандлага ажиглагдаж байна. Түүнчлэн олон малтай малчин өрх байгалийн бэрхшээлээс илүү их болгоомжилж байгаа нь ч дээрх хүснэгтээс харагдаж байна. Тухайлбал 20-40 толгой малтай өрхийн 68.5 хувь нь байгалийн бэрхшээлээс болж сэтгэл ханамжгүй байна гэсэн бол 150-иас дээш толгой малтай өрхийн 83.3 хувь нь уг шалтгааныг сонгосон байна.

Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл ханамжгүй байгаа малчин өрхүүд яагаад ингэж хариулах болсныг тэдний малын тоо толгой, нэг хүнд ногдох орлогын түвшингээс хамааруулж судлахад ерөнхийдөө ижил үр дүн гарч байна.

**Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл ханамжгүй байгаагийн шалтгаан**

*/нэг хүнд ногдох малын тоогоор, хувиар/*

Хүснэгт 37

Үзүүлэлт	0-20	20-40	40-70	70-150	150-аас дээш	Дүн
Олсон орлого амьдрал ахуйд хүрэлцдэггүй учир	82.6	92.6	50.0	58.6	50.0	75.9
Мал аж ахуйн хөдөлмөр хүнд учир	21.7	35.2	42.1	34.5	41.7	30.8
Байгалийн бэрхшээл ихтэйгээс	77.2	68.5	78.9	75.9	83.3	76.9
Бөглүү, нийгмийн хөгжлөөс хоцрогдсон учир	35.9	35.2	55.3	41.4	25.0	39.7
Хүүхдийн сургууль, боловсролд муугаар нөлөөлдөг	39.1	35.2	31.6	41.4	41.7	37.5
Бусад	3.3	9.3	2.6	6.9	0	6.1
Бүгд	40.9	24.0	16.9	12.9	5.3	100

**7.2. Малчид өөрсдийнхөө амьжиргааны түвшинг ийнэлсэн нь**

Малчид өөрийн амьдарч буй ахуй нөхцөлдөө хэр зэрэг сэтгэл хангалуун байгааг тодорхойлохын тулд судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн амьжиргааны түвшинг өөрсдөөр нь үнэлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Өөрсдийгөө дунджаас дээш амьжиргаатай гэж үзэж байгаа малчид ахуй байдалдаа сэтгэл ханамжтай байгаа, амьжиргааны дундаж түвшинд байна гэж тодорхойлсон бол ахуй байдалдаа дунд зэрэг ханамжтай, дундаас доош гэж үнэлсэн бол сэтгэл ханамжгүй байна гэж үзэж болох талтай.

Гэхдээ малчид ахуй байдалдаа хэр зэрэг сэтгэл ханамжтай буйг тодорхойлох энэхүү арга нь туйлын зөв гэж бид үзэхгүй байгаа бөгөөд тавьсан зорилтыг тодруулах нэг л оролдлого гэж үзэж байна. Судалгааг сонирхолтой болгох үүднээс малчдын өөрсдийнхөө амьжиргааны түвшинг тодорхойлсон тодорхойлолтыг Үндэсний статистикийн газраас тогтоосон жишигтэй харьцуулан судлав.

Үндэсний статистикийн газар /ҮСГ/-аас хэрэглээний сагсны бүтэц, өргөн хэрэглээний хүнс, барааны үнэ, нэг хүний хоол тэжээл бусад хэрэглээний наад захын зохистой норм, норматив зэргийг тусгай аргачлалаар тооцож амьжиргааны доод түвшинг /нэг хүнд ногдох сарын орлого/ эдийн засгийн бүсээр жил бүр тогтоодог бөгөөд 2003 онд дараахь байдлаар тогтоосон байна.<sup>16</sup> Үүнд:

Баруун бүс	19500 төгрөг
Зүүн бүс	20500 төгрөг
Төвийн бүс	19800 төгрөг
Хангайн бүс	19990 төгрөг
Улаанбаатар	25300 төгрөг

Үндэсний статистикийн газрын даргын тушаалаар батлагдсан 2003 оны амьжиргааны доод түвшин нь эдийн засгийн бүсээр бага зэрэг ялгаатай боловч ерөнхийдөө хөдөө, орон нутагт нэг хүний сарын хэрэглээ ойролцоогоор 20000 төгрөг гэж тогтоосон байна.

Засгийн газар, салбарын яамнаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоодгоос бус амьжиргааны баталгаажих доод түвшний өртгийг тогтоож өгдөггүй аж. Ийм учраас амьжиргааны баталгаажих доод түвшин гэсэн төрийн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ нь Үндэсний статистикийн газраас гаргасан амьжиргааны доод түвшин болдог бөгөөд өөр албан ёсны тодорхойлолт үгүй юм.


<sup>16</sup> ҮСГ-ын даргын 2003 оны 50-р тушаал

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.3-д “нэн ядуу хүн гэж тухайн хүнд ногдох орлогын хэмжээ нь амьжиргааны доод түвшингийн 40 хувиас доогуур, тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй хүнийг;” хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Энэ нь одоогийн жишгээр тооцож үзвэл ойролцоогоор өрхийн нэг хүнд ногдох сарын орлого 8000 төгрөг буюу түүнээс доош хэмжээтэй байна. Харин ямар өрхийг дундаж, дунджаас дээш гэж үзэх тухай ойлголт тодорхой бус байна.

**Та өөрийнхөө амьжиргааг ямар түвшинд байна гэж үзэж байна вэ? /зөвхөн нэг хариулт өгнө/** гэсэн асуултаар малчдаас социологийн судалгаа авахад манай судалгаанд оролцсон нийт 773 малчны 55 буюу 7.1 хувь нь дунджаас дээш, 530 буюу 68.6 хувь нь дундаж, 160 буюу 20.8 хувь нь ядуу, 28 буюу 3.5 хувь нь нэн ядуу гэж өөрсдийгөө тодорхойлсон байна /21 дүгээр график/.

**Малчид өөрсдийнхөө амьжиргааны түвшинг үнэлсэн байдал**

График 21



Судалгааны дүнг улсаас тогтоосон амьжиргааны түвшинтэй харьцуулж 38 дугаар хүснэгтээр үзүүлэв. Энэхүү судалгаанаас үзэхэд ҮСГ-аас тогтоосон жишгээр нэн ядуу /нэг хүнд ногдох сарын орлого 8000 төгрөг хүртэлх/ малчин өрхийн дөнгөж 6.6 хувь нь өөрсдийгөө нэн ядуу гэж үнэн зөв тодорхойлж харин 62.3 хувь нь дундаж, 1.6 хувь нь дунджаас дээш амьжиргаатай гэж бодит байдлаасаа илүү өөдрөгөөр амьжиргааны байдлаа тодорхойлсон байна.

**Малчид өөрийнхөө амьжиргааны түвшинг үнэлсэн байдал**  
/зөвхөн нэг хариулт өгнө/

Хүснэгт 38

Нэг хүнд ногдох сарын орлогын бүлэглэл /төгрөгөөр/	Судалгаанд хамрагдсан малчин өрхийн амьжиргааны түвшин /ҮСГ-ын жишгээр		Үүнээс: Малчин өрх өөрсдийнхөө амьжиргааны түвшингээ үнэлсэн байдал							
			Дунджаас дээш		Дундаж		Ядуу		Нэн ядуу	
			тоо	хувь**	тоо	хувь*	тоо	хувь*	тоо	хувь*
0-8000 /нэн ядуу өрх/	122	15.8	2	1.6	76	62.3	36	29.5	8	6.6
8001-20000 /ядуу өрх/	286	37.0	13	4.5	185	64.7	74	25.9	14	4.9
20001-33000	179	23.2	15	8.4	130	72.6	30	16.8	4	2.2
33001-58300	141	18.3	18	12.8	103	73.0	20	14.2	0	0.0
58301-83300	25	3.2	2	8.0	23	92.0	0	0.0	0	0.0
83301-с дээш	19	2.5	5	26.3	13	68.4	1	5.3	0	0.0
Дүн 772	100.0	55	7.1	530	68.6	161	20.8	26	3.5	

\* Асуулагд оролцсон тухайн бүлгийн малчин өрхийн дүнд эзлэх хувь

\*\* Асуулагд оролцсон нийт малчин өрхийн дүнд эзлэх хувь

ҮСГ-ын жишгийн дагуу нэн ядуу амьжиргаатай өрхөд тооцогдох 122 өрхөөс дөнгөж 8 өрх буюу 6.6 хувь нь өөрсдийнхөө амьжиргааг нэн ядуу гэж жишгийн дагуу зөв тодорхойлж, 36 өрх буюу 29.5 хувь нь ядуу, 76 өрх буюу 62.3

хувь нь дундаж амьжиргаатай гэж тодорхойлсон байна. Дээрх байдлаас үзэхэд нэн ядуу болон ядуу өрхийн малчид өөрсдийнхөө амьжиргааны байдлыг бодитой, зөв тодорхойлж чадахгүй, бодит байдлаасаа дээгүүр үнэлж байна.


Судалгаанд оролцсон 772 малчин өрхийн амьжиргааны түвшинг ҮСГ-ын жишгээр үнэлэхэд 15.8 хувь нь нэн ядуу, 37.0 хувь нь ядуу, 47.2 хувь нь дунд буюу дундаас дээш амьжиргаатай байгаа хэдий ч тэдний өөрсдийн амьжиргааны түвшингээ 3.5 хувь нь нэн ядуу, 20.8 хувь нь ядуу, 75.7 хувь нь дунд буюу дундаас дээш амьжиргаатай гэж тодорхойлсон байна.

Малчид өөрсдийн амьжиргааны түвшингээ бодит байдлаас дээгүүр үнэлж байгаа нь монгол хүний уужуу тайван ухаан, асуудалд өөдрөг ханддаг малчин хүний зан заншил, “болж байна, бүтэж байна” гэж ярьж хэлсээр ирсэн уламжлал, мэдээллийн хомс байдал, боловсролын түвшин бага, элдэв хэрэглээ бага, монгол зүйр цэцэн үгээр бол “мөр бүтэн, гэдэс цатгалан” тохиолдолд өөр илүү зүйл шаардаад байдаггүйтэй холбоотой аж. Түүнчлэн хүүхдийн сургалтын төлбөр зэрэг их хэмжээний зардал гаргаагүй малчин өрхүүд одоогийн байгаа байдлаа дунд чинээнд болоод байна гэж ойлгодог аж.

Харин өрхийн нэг хүнд ногдох орлогын хэмжээ нэмэгдэх тутам малчид өөрсдийнхөө амьжиргааны түвшинд өгөх үнэлэлт нь Үндэсний статистикийн газраас гаргасан шалгуурт нэлээд дөхөж байна. Тухайлбал амьжиргааны доод түвшнээс дээш 1.5-2.9 дахин их орлоготой /33001-58300төг/ 141 малчин өрхийн 20 нь буюу 14.2 хувь нь өөрсдийн амьжиргааны түвшинг ядуу гэж тодорхойлсныг эс тооцвол дийлэнх хэсэг нь амьжиргаагаа дунд буюу дундаас дээш гэж тодорхойлсон байна.

**Малчид өөрийнхөө амьжиргааны түвшинг үнэлсэн байдал**  
/зөвхөн нэг хариулт өгнө/

График 22



**7.3. Төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний талаарх малчдын сэтгэл ханамж**

Малчид сум, сургууль, хүн малын эмнэлэг, хууль хүчний байгууллага, харилцаа холбооны ажил үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг 23 дугаар график, 28 дугаар хавсралт хүснэгтээр харуулав. Малчдын үзэж байгаагаар хууль, хүчний байгууллагуудын үйл ажиллагаа боломжийн түвшинд, сумын ажил, мал эмнэлгийн үйлчилгээ ч дунд зэрэг харин харилцаа холбоо, сургуулийн үйлчилгээг судалгаанд оролцогсдын 80.4-86.1 хувь нь дунд зэрэг буюу хангалтгүй байна гэж үнэлсэн байна.

Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд малчид үнэлгээ өгөхдөө уг байгууллагуудынхаа талаар мэдээлэл хомс, ерөнхийдөө таамгаар асуудалд хандаж байгаа байдал нэлээд ажиглагдаж




байсныг тэмдэглэж байна. Хөдөө орон нутагт төрийн байгууллагын үйл ажиллагаанд малчид оролцдоггүй, сонирхдоггүй, тэгээд ч төрийн байгууллагаас иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар зохиож байгаа ажил хангалтгүй байна.

Хүүхдүүд нь өдөр тутам үйлчлүүлж байдаг болохоор сургуулийн үйл ажиллагааны талаар малчид зохих мэдээлэлтэй байдаг бололтой. Тэгээд ч сургуулийн үйл ажиллагаанд нэлээд шүүмжлэлтэй хандаж байв. Хамгийн гол шүүмжлэл нь сургалтын чанар муу, нарийн мэргэжлийн багш нарын хүрэлцээ хангалтгүй байдаг аж.

Харин судалгаанд хамрагдсан нийт малчдын дийлэнх нь хууль, хүчний байгууллагуудын үйлчилгээг сайн буюу боломжийн хэмжээнд байна гэж үнэлсэн нь төрийн бусад байгууллагаас хамгийн өндөр үнэлгээтэй байна. Гэхдээ дэд бүтэц сайн хөгжсөн, малын хулгай ихтэй нутгийн малчид хууль, хүчний байгууллагын үйл ажиллагааг ихэнхдээ муу гэж үнэлсэн байхад дэд бүтцээс алслагдсан, малын хулгай багатай нутгийн малчид сайн гэсэн үнэлгээ өгч байгаа нь тийм ч бодитой үнэлгээ бусын зэрэгцээ гэмт хэрэг, хулгай зэрэг асуудалд өртөөгүй хүмүүс хууль, хяналтын байгууллагын талаар муу сэтгэгдэлгүй байдаг зэрэг нөлөөлөл байна.

**Төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний талаарх малчдын санаа бодол**

График 23



Малчид төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд төдийлөн сэтгэл ханамжтай биш байгаа хэдий ч огт нийцэхгүй байна гэж үзэхгүй байна.

Малчдын хувьд эмчид цаг тухайд нь дуудлага өгөх боломж муу /42.2 хувь/, харин эмч дуудлага авмагц хугацаандаа ирэх боломж нь тэдний дуудлага өгөхөөс илүү найдвартай байгаа аж.

**Хүн эмнэлгийн үйлчилгээний талаарх малчдын үнэлгээ**

Хүснэгт 39

Үзүүлэлт	Үнэлгээ						Нийт дүн	
	Сайн		Дунд зэрэг		Муу			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эмчид цаг тухайд нь дуудлага өгөх боломж	125	16.2	322	41.7	326	42.2	773	100.0
Эмч дуудлага авмагц цаг хугацаандаа ирэх боломж	136	17.6	351	45.4	286	37.0	773	100.0
Эм тарианы олдоц	192	24.8	357	46.2	224	29.0	773	100.0
Эм тарианы үнэ	489	63.3	215	27.8	69	8.9	773	100.0

Эмч дуудлага авмагц хугацаандаа ирэх боломжийн талаар малчид “хугацаандаа ирэх нь ч ирдэг юмаа” гэж ярьж байгаа боловч хариулт өгөхдөө нэлээд хянамгай хандаж ихэвчлэн дунд зэрэг буюу муу гэсэн үнэлгээг өгч байсан юм. Гэтэл хөдөө сумын эмч нарын хувьд зайлшгүй түргэн тусламж үзүүлэх, хурц, цочмог өвчний үед дуудлага авмагц очих боломж байгаа боловч малчид архаг өвчин, биеийн ерөнхий доройтлын болон суурь өвчнөөр дуудлага өгөх нь элбэг байдаг гэж ярьж байлаа.

Эмнэлгийн тусламж авах боломжийн талаар малчдын 17.6 хувь нь сэтгэл хангалуун, 37.0 хувь нь сэтгэл хангалуун бус, 45.4 хувь нь эргэлзээтэй байгаа аж.

#### 7.4. Дігнэлт

1. Малчдын олонх /63.6 хувь/ нь мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл ханамжтай, тодорхой хэсэг нь /25.9 хувь/ сэтгэл ханамж дунд зэрэг, цөөнх нь /6.7 хувь/ сэтгэл хангалуун бус байна.

2. Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлэхдээ дийлэнх нь өөрийнхөө өрхийн малын тоо толгой их буюу бага, түүнээс улбаалан амьжиргааны түвшний байдлаар хандахгүй байна. Энэ нь тэдний боловсролын түвшин, монгол хүний уламжлалт ёс зүйтэй илүү холбоотой байж болох юм.

3. Мал аж ахуйн хөдөлмөрийн хүнд хүчир эсэх, уг ажил тэдний хамгийн сайн хийж чадах ажил мөн эсэх, хүүхдийн сургууль соёл, өөрийн мэдээллийн хоцрогдол, эрүүл агаарын эерэг нөлөө, мал маллах нь эцэг өвгөдөөс уламжилж ирсэн зэрэг хүчин зүйлс бүгд өөр өөрийн онцлогтой, хувь хүн, өрх бүрт ач холбогдлоороо өөр өөр үнэлэмж төрүүлж, цаг хугацаа, нийгмийн хөгжлийн чиг хандлагын дагуу тэрхүү үнэлэмж нь байнга өөрчлөгдөж ач холбогдол нь өсөх, буурах хандлагатай байна. Тухайлбал зарим малчин өрх хүүхдийн боловсролын асуудалд бүхий л анхаарлаа тавьж, хүүхдэдээ чанартай боловсрол эзэмшүүлэх нь мал маллахаас хамаагүй илүү эрхэм зорилго болж төв, суурин газарт нүүж байхад зарим малчин өрхөд дээрх асуудал огт хөндөгдөхгүй байна.

4. Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаа малчдын хувьдолсон орлого амьдрал, ахуйд хүрэлцэхгүй, байгалийн бэрхшээл зэрэг асуудал хамгийн гол шалтгаан болж байна.

5. Судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн 52.8 хувь нь /Үндэсний статистикийн төв газрын тогтоосон нэг хүнд ногдох сарын дундаж орлогоор/ амьжиргааны доод түвшингээс доогуур буюу ядуу, нэн ядуу амьдралтай, 47.2 хувь нь амьжиргааны доод түвшингээс дээш амьдралтай байна. Гэвч судалгаанд хамрагдсан малчид өөрсдийнхөө амьжиргааны түвшинг үнэлсэн дүнг нэгтгэн үзвэл 24.3 хувь нь ядуу буюу нэн ядуу, 75.7 хувь нь дундаж буюу дунджаас дээш амьдралтай гэж үнэлсэн байна.

6. Нэн ядуу, ядуу малчид өөрсдийнхөө амьжиргааны түвшинд бодитой үнэлэлт өгч чадахгүй байна. Тэдний 30 гаруй хувь нь амьдралынхаа түвшинд бодит байдлаас дээгүүр үнэлгээ өгчээ. Энэ нь тэдний хэрэглээ хязгаарлагдмал, боловсролын түвшин бага, сэтгэлгээний өөрчлөлт удаан байгаатай холбоотой.

7. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй малчдын орлого, амьжиргааны түвшин үндсэндээ малын тооноос хамаарч байна. Иймд мал хувьчлагдсанаас хойшх хугацаанд малчид малын чанарыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэхийг бус малын тоо толгойг өсгөхийг илүү эрхэмлэж иржээ.

8. Харьцангуй олон малтай малчдын дийлэнх нь мал аж ахуй эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байна. Энэ нь мал аж ахуйн салбар тэдний амьжиргааны гол эх үүсвэр болж буйтай холбоотой юм.

**9.** Малчдын үзэж байгаагаар хууль, хүчний байгуулагуудын үйл ажиллагаа боломжийн түвшинд, сумын ажил, мал эмнэлгийн үйлчилгээ ч дунд зэрэг харин харилцаа холбоо, сургуулийн үйлчилгээг судалгаанд оролцогсдын 80.4-86.1 хувь нь дунд зэрэг буюу хангалтгүй байна гэж үнэлсэн байна.

**10.** Малчдын олонх нь хүүхдээ сайн боловсрол эзэмшүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Малчин хүний өөрийнх нь эзэмшсэн боловсролын түвшин нэмэгдэх тутам тэдний үр хүүхдээ сайн боловсрол эзэмшүүлэх ёстой гэсэн бодол өсөх хандлагатай байна.

**11.** Эмнэлгийн түргэн тусламж цаг хугацаандаа авч чадах эсэх асуудалд малчид дунд зэрэг сэтгэл ханамжтай байна. Тухайлбал эмч дуудлага хүлээж авмагц цаг хугацаандаа ирэх боломжийн талаар малчдын 17.4 хувь нь сайн, 45.6 хувь нь дунд , 37.0 хувь нь муу гэсэн үнэлгээ өгч байна.

## НАЙМДУГААР БІЛЭГ:


### МАЛЧИН ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

#### 8.1. Малчин өрхийн орлого, түүний эх үүсвэр

Малчин өрхийн аж ахуйн санхүүгийн байдлыг илэрхийлэх хамгийн гол үзүүлэлт бол орлогын хэмжээ юм. Судалгаанд хамрагдсан малчдын зах зээлийн нөхцөл, малын тоо, бүтэц харилцан адилгүй болохоор тэдний орлогын түвшин ч ялгаатай байна. Малчин өрхийн орлогыг тодорхойлохдоо дараахь аргачлалыг хэрэглэв. Үүнд: Тухайн өрхийн малын тоо толгойн өөрчлөлтийг 2002 оны эцсийн “А” данснаас эхлэн тооцов. Бусад зарсан малыг тухайн орон нутгийн ханшаар буюу малчдын өөрсдийн мэдүүлсэн үнээр тооцон орлого авч, ашиг шимийн орлогыг тооцохдоо нэгжээс авах ашиг шимийн дундаж үзүүлэлтийг малын тоо болон нэгж бүтээгдэхүүний худалдах үнээр үржүүлж орлогод тооцов. Малчин өрхийн хэрэглэсэн мах, сүү, цагаан идээ, айраг зэргийг тухайн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтийг тухайн бүтээгдэхүүний орон нутгийн дундаж ханшаар тооцож орлого болгов.

Ердийн нэг малчин өрхийн жилийн дундаж орлого  
/мянган төгрөгөөр/

График 24



Таван бүсийн судалгаанд хамрагдсан малчдын дунджаар нэг малчин өрхийн жилийн дундаж орлого нь 2.4 сая төгрөг байна. Аль ч бүсийн малчин өрхийн орлогын үндсэн эх үүсвэр нь мал аж ахуйн үйлдвэрлэл байна. Тухайлбал, баруун бүсийн малчдын жилийн нийт орлогын дүнд мал аж ахуйн орлого 85.2 хувь, хангайн бүсэд 80.5 хувь, зүүн бүсэд 75.0 хувь тус тус эзэлдэг байна. Харин томоохон хот суурин газарт ойр байршилтай, дэд бүтэц сайтай малчдын хувьд жилийн нийт орлогод мал аж ахуйн бус орлогын эх үүсвэр зохих байр суурь эзэлж байгааг дээрх графикаас харж болно. Улаанбаатар орчмын болон төвийн бүсийн судалгаанд хамрагдсан малчдын орлогын эх үүсвэрт газар тариалан, худалдаа арилжаа эрхэлж олсон орлого болон цалин хөлс 50.0–54.7 хувьтай байгаа нь үүнийг нотолно.

Бидний судалгаанд хамрагдсан малчдын жилийн борлуулалтын орлогын дүнд малын төрөл тус бүр дараахь хувийг эзэлж байна. Үүнд:

- а. тэмээ 3.9 хувь,
- б. адуу 2.9 хувь,
- в. үхэр 10.4 хувь,
- г. хонь 23.5 хувь,
- д. ямаа 59.4 хувь байв.

Борлуулалтын орлогын бүтцийг бүтээгдэхүүн, түүхий эдийн төрлөөр авч үзвэл:

- а. борлуулсан мал 28.5 хувь,
- б. мах 5.4 хувь,
- в. арьс, шир 6.6 хувь,
- г. өлөн 0.4 хувь,
- д. ноос, хялгас, хөөвөр 5.1 хувь,
- е. ноолуур 51.9 хувь,
- ё. сүү, айраг, цагаан идээ 2.1 хувь байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогын дүнд ноолуур, мал, мах, арьс ширнээс олсон орлого 93.1 хувийг эзэлж байна. Иймд эдгээр бүтээгдэхүүн, түүхий эдийг зах зээлд борлуулсан тоо хэмжээ, чанар, үнийн түвшингээс малчин өрхийн аж ахуйн амьжиргаа, санхүүгийн байдал ихээхэн шалтгаалж байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүнээс зах зээлд борлуулах замаар өрхийн дотоод хэрэгцээг хангаж байна. Өрхийн дотоодод хэрэглэж байгаа бүтээгдэхүүн нь мал аж ахуйн бодит орлогын нэг хэсэг учраас мөнгөн орлогод шууд хамаарахгүй боловч нийт орлогыг тооцоход орох ёстой. Баруун, Хангай, Зүүн бүсийн малчин өрхийн мөнгөн орлогын 80 гаруй хувь нь мал аж ахуйгаас, 20-иод хувь нь бусад эх үүсвэрээс ордог байна. Малчин өрхийн орлогын бүтцэд мал аж ахуйгаас бусад үйлдвэрлэл, эх үүсвэрээс олсон орлого өчүүхэн бага хувийг эзэлж байгаа нь малчид мал аж ахуйн үйлдвэрлэлээр хэт дагнасан, бусад үйлдвэрлэлийг үндсэндээ эрхлэхгүй байгааг харуулна.

Судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн 122 нь буюу 15.8 хувь нь нэг хүнд ногдох мал аж ахуйн сарын орлого 8000 төгрөг хүртэл орлоготой буюу нэн ядуу амьжиргаатай малчид юм. Судалгаанд хамрагдсан нийт малчдын 46.4 хувийнх нь нэг хүнд ногдох сарын орлого 8001-25000 төгрөг байв. Жигнэгдсэн дунджаар тооцоход, судалгаанд оролцсон нэг малчин өрхийн дундаж ам бүл 4.7 хүнтэй, нэг хүнд ногдох жилийн дундаж орлого 0.510 сая төгрөг байна.

**Малчин өрхийн бүлэглэлт**

*/нэг хүнд ногдох сарын орлогын түвшингээр/*

*Хүснэгт 40*

Нэг хүнд ногдох орлого (төгрөгөөр)	Өрхийн тоо	Судалгаанд хамрагдсан өрхийн дүнд	
		эзлэх хувь	өссөн дүнд эзлэх хувь
8000 хүртэл	122	15.8	15.8
8001-25000	359	46.4	62.2
25001-41500	177	22.9	85.1
41501-58300	70	9.1	94.2
58301-ээс дээш	45	5.8	100.0
Дүн	773	100.0	-

Судалгаанаас үзэхэд бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчдын орлого нь үндсэн гурван хүчин зүйлээс хамаарч байна. Үүнд:

Орлого = Малын тоо X Нэгжийн ашиг шим X Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ (1) (2) (3)

Эндээс малчдын орлогод нөлөөлдөг хоёр дахь хүчин зүйл болох нэг малаас ашиглах ашиг шимийн хэмжээ бараг өөрчлөгдөхгүй үндсэндээ тогтвортой байна. Гурав дахь хүчин зүйл-түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн үнэ төдийлөн өсөхгүй, жил, улирлаар хэлбэлзэлтэй байна. Ялангуяа мөнгөний ханш уналттай харьцуулахад үнийн өсөлт тун бага гэж үзэж болно. Нэгэнт энэ хоёр гол хүчин зүйл малчдын хувьд тогтмол шинжтэй болсон тул тэд зөвхөн малынхаа тоо толгойг өсгөх замаар л орлогоо нэмэгдүүлэх аргыг сонгож, энэхүү арга олон жилийн турш хэрэглэж ирсэн бөгөөд цаашид ч энэ байдал үргэлжилсээр байх хандлагатай байгааг малчдын хэрэгцээг судалсан судалгааны дүн нотолж байгаа болно.

**8.2. Малчин өрхийн зарлага, түүний битэц**

Нэгэнт малчин өрхийн амьжиргааны гол эх үүсвэр мал аж ахуй учир тэдний орлого, зарлагын эх үүсвэрийг тодорхойлоход нэг жилийн дотор малын тоо толгойд ямар өөрчлөлт, хөдөлгөөн гарсныг судлах нь чухал ач холбогдолтой билээ.

**Эдийн засгийн баруун болон төвийн бүсийн малчин өрхийн малын тоо толгойн өөрчлөлт**

*/судалгаанд хамрагдсан нэг малчин өрхөд ногдох дундаж үзүүлэлт/*

**Хүснэгт 41**

	Бүс	1*	2*	3*	4*	5*	6*	7*	8*	9*
Бүгд	Баруун	140	28	69	28	14	9	17	31	138
	Төв	151	50	57	33	13	31	46	30	105
Тэмээ	Баруун	4	2	3	2	2	0	2	2	1
	Төв	9	2	3	2	0	2	3	2	6
Адуу	Баруун	9	2	4	2	2	2	2	3	4
	Төв	11	6	4	2	2	3	4	25	6
Үхэр	Баруун	14	2	6	3	2	2	2	5	10
	Төв	11	2	4	4	4	3	3	4	-1
Хонь	Баруун	57	8	29	9	3	3	5	12	62
	Төв	69	15	27	16	4	12	18	11	50
Ямаа	Баруун	56	14	27	12	5	2	6	11	61
	Төв	51	25	19	9	3	11	18	10	45


**Тайлбар:** 1\*-оны эхэнд байсан малын тоо, 2\*-худалдаж авсан малын тоо, 3\*-бойжуулсан төлийн тоо, 4\*-худалдсан малын тоо, 5\*-бусдад үнэгүй өгсөн малын тоо, 6\*-хулгайд алдсан малын тоо, 7\*-хорогдсон малын тоо, 8\*-хүнсэндээ хэрэглэсэн малын тоо, 9\*-оны эцсийн малын тоо

Бид малчдаас хүснэгтээр авсан судалгааны дүнд үндэслэн малчин өрх бүрийн 2003 оны эхэнд байсан малын тоонд жилийн турш ямар өөрчлөлт орж, оны эцэст үлдсэн малын тоог бүс бүрээр тооцож, ерөнхий дүр төрхийг тодорхойлсон юм. 41 дүгээр хүснэгтээр Баруун болон Төвийн бүсийн судалгаанд хамрагдсан нийт өрхийн дунджаар малын сүргийн эргэлт ямар байсныг харьцуулан харуулав.

Энэ хоёр бүсийн судалгаанд хамрагдсан дундаж нэг малчин өрхөд ногдох оны эхний малын тоо ойролцоогоор 140-151 толгой байжээ. Хоёр бүсийн дунджаар малчин өрхийн оны эхэнд байсан малын тоог 100 хувь гэж үзвэл, оны эхний нийт малынхаа 26.8 хувьтай тэнцэх мал худалдан авч, 43.3 хувьтай тэнцэх төл бойжуулан сүргээ сэлбэхийн зэрэгцээ 21 хувийг зах зээлд борлуулж, 9.3 хувийг бусдад үнэгүй бэлэглэж, 13.7 хувийг хулгайд алдаж, 21.6 хувийг зүй бусаар хорогдуулж, 21 хувийг хүнсэндээ хэрэглэжээ. Энд анхаарал татсан асуудал бол төвийн бүсийн малчдын бусдаас худалдан авсан, худалдсан малын тоо илүү байгаа нь зах зээлийн нөхцөл сайтай тул малыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар зохих арга ухаанд суралцаж буйг харуулна. Харин энэ бүсийн малчид оны эхэнд байсан малынхаа 20.5 хувийг хулгайд алдсан байхад уг үзүүлэлт Баруун бүсэд доогуур (6.4 хувьтай) түвшинд байна.

**Малчин өрхийн зарлага**  
/мянган төгрөгөөр/

25 дугаар график



Судалгаанд хамрагдсан малчдын жилийн зарлагын дүн дунджаар 2.7 сая төгрөг байна. Нэг өрхөд ногдох зарлага хамгийн өндөр бүсэд Улаанбаатар (3.3 сая төгрөг), хамгийн багад нь Баруун бүсийн малчин өрх (2.5 сая төгрөг) багтаж байна. Аль ч бүсэд малчин өрх орлогоороо зарлагаа бүрэн нөхөж чадахгүй байгаа бөгөөд нэг малчин өрхийн жилийн орлогоос давсан зарлага нь дунджаар 100.7-366.7 мянган төгрөг юм.

25 дугаар графикаас үзэхэд малчин өрхийн зарлагын бүтцэд хоол хүнс, хувцас хунар, гэр ахуйн эд хогшил худалдан авсан зэрэг зарлага давамгайлж, харин эрхэлж буй үйлдвэрлэлд оруулсан (зарцуулсан) хөрөнгийн хэмжээ, эзлэх хувь аль ч бүсэд хангалтгүй байна. Энэ бол малчид олсон бага хэмжээний орлогоо хэрэглээнд зарцуулж, үйлдвэрлэлээ өргөтгөх хуримтлал бий болгохгүй байгааг харуулах үзүүлэлт юм.

Бусад хэрэглэгчдийн нэгэн адил малчид ч хоол хүнс, хувцас хунар зэрэг хамгийн наад захын хэрэгцээгээ хангаад дараа нь бусад хэрэгцээгээ ач холбогдлоор нь эрэмбэ дараатай өөрийн төсөвтөө багтааж хангах нь зүйн хэрэг билээ. Тэгэхээр малчдын орлого нь тэдний янз бүрийн хэрэгцээний (зарлагын) төрлүүдээс чухам ямар хэсэгт хүрэлцэж байгааг мэдэх зорилгоор **“Танай өрхийн орлого доорх зарлагын алинд нь хүрэлцдэг вэ?”** гэсэн асуулт тавьж дүнг малчин өрх бүрийн нэг хүнд ногдох малын тоо, сарын орлоготой холбож 42, 43 дугаар хүснэгт, 26 дугаар графикаар үзүүлэв.

**Малчин өрхийн орлогын хүрэлцээ**  
/Нэг хүнд ногдох малын тоогоор/

Хүснэгт 42

Хариулт	Нэг хүнд ногдох малын тооны бүлэглэлт /богоор/										Бүгд	
	0-20		21-40		41-70		71-150		150-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй	47	22.1	23	12.2	4	2.3	5	3.4	3	6.1	82	10.6
Хоол хүнсэндээ л хүрэлцдэг	87	40.8	98	51.9	44	25.1	44	29.9	6	12.2	279	36.1
Хоол хүнс, хувцас хунартаа хүрэлцдэг	64	30.0	56	29.6	100	57.1	63	42.9	23	46.9	306	39.6
Хоол хүнс, хувцас хунар, хүүхдийн сургалтын төлбөрт хүрэлцдэг	9	4.2	8	4.2	17	9.7	14	9.5	9	18.4	57	7.4
Бүрэн хүрэлцээтэй	6	2.8	4	2.1	10	5.7	21	14.3	7	14.3	48	6.2
Хариулаагүй	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	1	2.0	1	0.1
Малчин өрхийн бүлгийн дүн	213	27.6	189	24.5	175	22.6	147	19.0	49	6.3	773	100.0


Нэг хүнд 0-20 толгой мал ногдох бүлэгт багтах нийт 213 өрхийн 47 өрх буюу 22.1 хувь нь олсон орлого хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй, 87 өрх буюу 40.8 хувь нь хоол хүнсэндээ л хүрэлцдэг гэж хариулсан байна /42 дугаар хүснэгт/.

Малчин өрхийн нэг хүнд ногдох малын тоо 40 толгой байхад хоол хүнсээ, 41-70 толгойд хүрэхэд хоол хүнс хувцасны зарлагаа нөхөх боломжтой болж, улмаар өрхийн нэг хүнд ногдох малын тоо 150 толгойд хүрч байж л малчдын хүсэн хүлээж буй хэрэгцээг хангаж чадахаар байгаа нь 42 дугаар хүснэгтээс харагдаж байна.

Судалгаанд оролцсон нийт малчин өрх өөрсдийн амьжиргааны хүрэлцээг хэрхэн тодорхойлсныг тоймлон 26-р графикаар үзүүлэв. 26-р графикаас харахад нийт малчин өрхийн 10.6 хувь нь олсон орлого хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй, 36.1 хувь нь хоол хүнсэндээ л хүрэлцдэг гэх мэтээр хариулсан байна.

**Малчин өрхийн орлогын хүрэлцээний бүдүүвч**

График 26



Нэг хүнд 20 хүртэл мал ногдож байгаа өрхийн 2.8 хувь нь олсон орлого бүрэн хүрэлцээтэй гэж хариулсан байтал нэг хүнд 150-иас дээш толгой мал ногдох малчин өрхийн 6.1 хувь нь олсон орлого хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй гэж хариулсан зэрэг нь логик авцалдаа муу, судалгааг бодитой биш гэмээр сэтгэгдэл төрүүлж болох юм. Гэвч эдгээр байдал нь дор бүрнээ учир



шалтгаантай байна. Тухайлбал, нэг хүнд 20 хүртэл толгой мал ногдож байгаа боловч олсон орлого ахуй амьдралд бүрэн хүрэлцээтэй гэж хариулсан нийт 6 өрхийн 5 нь өндөр ашиг шимтэй цөөн тооны малтай өрх, 1 нь өвс хадаж орлогын гол эх үүсвэрээ олдог өрх байв. Харин нэг хүнд 150-иас дээш толгой мал ногдож байгаа боловч олсон орлого хоол хүнсэндээ ч хүрдэггүй гэж хариулсан 3 өрх нь сүүлийн жилүүдэд малын тоо толгойг өсгөх асуудлыг голчилж, малаа зарлагдаж, эдийн засгийн эргэлтэнд оруулж ахуй амьдралдаа зориулах талаар ихээхэн учир дутагдалтай, зах зээлээс алслагдсан, зах зээлд өнөөг хүртэл зохицож ажиллаж төдийлөн чадаагүй өрхүүд байв.

Эдгээр учир шалтгааныг тооцох аваас малчдын олсон орлого амьжиргаанд нь хүрэлцэж байгаа эсэхийг зөвхөн өрхийн нэг хүнд ногдох малын тоотой холбож судлах нь басхүү учир дутагдалтай болох нь харагдаж байна. Ийм учраас малчдын амьжиргааны хүрэлцээг тэдний өрхийн нэг хүнд ногдох орлоготой холбож судлах нь илүү бодитой болох юм /43 дугаар хүснэгт/.

**Малчин өрхийн орлогын хүрэлцээ**  
*/Нэг хүнд ногдох сарын орлого/*

**Хүснэгт 43**

Хариулт	Малчин өрхийн нэг хүнд ногдох сарын орлогын бүлэглэл										Бүгд	
	0-8000		8001-20000		20001-40000		40001-60000		60001-ээс дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй	24	19.7	44	12.3	9	5.0	4	6.1	1	2.2	82	10.6
Хоол хүнсэндээ л хүрэлцдэг	49	40.2	150	41.8	49	27.1	16	24.2	10	22.2	274	35.4
Хоол хүнс, хувцас хунартаа хүрэлцдэг	44	36.0	127	35.3	88	48.6	38	57.6	14	31.1	311	40.2
Хоол хүнс, хувцас хунар, хүүхдийн сургалтын төлбөрт хүрэлцдэг	2	1.6	27	7.5	18	9.9	3	4.5	7	15.6	57	7.3
Бүрэн хүрэлцээтэй	3	2.5	11	3.1	17	9.4	5	7.6	12	26.7	48	6.2
Хариулаагүй	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	1	2.2	1	0.1
Малчин өрхийн бүлгийн дүн	122	100.0	359	100.0	181	100.0	66	100.0	45	100.0	773	100.0

Нэг хүнд ногдох сарын орлогоор 8000 төгрөг хүртлэх /нэн ядуу/ 122 өрхийн 24 нь буюу 19.7 хувь нь олсон орлого хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй гэж хариулсан байхад 49 өрх буюу 40.2 хувь нь хоол хүнсэндээ л хүрэлцдэг гэж хариулсан байна.

Өрхийн нэг хүнд сард 20001-40000 төгрөгийн орлого ногдож байгаа нийт 181 өрхийн 9 нь буюу 5 хувь олсон орлого хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй гэж хариулсан байна. Энэ мэтээр 46 дугаар хүснэгтээр үзүүлсэн судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан нийт малчдын 10.6 хувь нь олсон орлого хоол хүнсэндээ ч хүрэлцэхгүй, 35.4 хувь нь хоол хүнсэндээ л хүрэлцдэг, 40.2 хувь нь хоол хүнс хувцас хунартаа хүрэлцдэг, дөнгөж 6.2 хувь нь бүрэн хүрэлцээтэй гэж орлогын хүрэлцээгээ тодорхойлж байна.

Малчдын орлогын ихэнх нь мал аж ахуйгаас орж байгаа боловч зардал тун бага хувь эзэлдэг байна. Ер нь мал аж ахуйн үйлдвэрлэлд тэжээл, хөдөлмөр, эм тарилга, тээврийн зардал зонхилох боловч ихэнхдээ малчин өрх өөрийн ам бүлийн хүч хөдөлмөрөөр энэ ажлыг амжуулж байгаа болохоор шууд мөнгөн зардал гарах нь бага байдаг байна.

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн аж ахуйн жилийн дундаж зарлага нь малын тоо, байршлаас хамаарч 0.8-6.9 сая төгрөг байна.

Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчин өрх нь жилийн мөнгөн зарлагынхаа 9.4 хувийг л үйлдвэрлэлийн хэрэгцээнд, дийлэнх хэсгийг (90.6 хувь)

зөвхөн хүнсний болон ахуйн хэрэгцээндээ зарцуулсан байхад хот орчмын фермер өрхүүд 66.3 хувийг үйлдвэрлэлийн хэрэгцээнд зарцуулжээ.

Мал аж ахуйн үйлдвэрлэл нь биологийн нөхөн үйлдвэрлэл дээр суурилдаг болохоор хөрөнгө оруулалтын зардал бага шаарддаг, өөрөө өсөж үржиж байдаг онцлогтой билээ. Гэвч энэ хэмжээгээрээ эрсдэлд өртөж ихээхэн хохирол учирдаг. Ингэхээр мал аж ахуйг өсгөж үржүүлэх гэхээсээ илүү эрсдлээс хамгаалахын тулд гол хөрөнгө оруулалт шаардаж байна. Гэтэл малчин өрхүүд ийм хөрөнгө оруулалт хийх чадвар мөхөс байна.

**8.3. Малын гаралтай түүхий эд, битээгдэхийнгийг борлуулах зах зээл**

Хөдөө орон нутагт одоо хүртэл зах зээлийн харилцааны төлөвшил жигдрээгүй бөгөөд төвлөрсөн зах зээлээс алслагдах тутам мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ буурч, өргөн хэрэглээний барааны үнэ өсдөг, малчид зах зээлтэй оновчтой холбогдож чадаагүй, гол төлөв бараа солилцоогоор арилжаа хийгддэг, түүхий эдийн боловсруулалтын түвшин доогуур зэрэг олон асуудал малчдын амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж байна. Иймд хөдөө орон нутагдахь ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, малчдын орлогын тогтвортой өсөлтийг хангахын тулд харилцан нөхөн тэтгэж хөгжих чадавхтай хөдөө аж ахуй – аж үйлдвэрийн салбарыг бүрдүүлэн хөгжүүлэх, тэдгээрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь стратегийн чухал зорилт болж тавигдана.

Малчдын орлогод нөлөөлж буй бодитой хүчин зүйлсийн нэг бол түүхий эд, бүтээгдэхүүнээ зах зээлд хэр зэрэг үр ашигтай борлуулж байна вэ гэдэг асуудал юм. Малчин өрхийн аж ахуйд түүхий эд, бүтээгдэхүүнээ борлуулдаг үндсэн таван суваг байна. Энэ нь Улаанбаатар хот түүний ойролцоохот, суурин болон аймгийн төв, сумын төв, явуулын наймаачид, хилийн боомт зэрэг юм.

- **Улаанбаатарт** бүх төрлийн түүхий эдийг авчирч борлуулж байгаагийн дотор ноолуурын эзлэх хувийн жин илүү өндөр байна. Ноолуур нь харьцангуй овор бага, үнийн нягтрал ихтэй, Улаанбаатарт борлуулахад илүү үнэ хүрдэг, зах зээлийн зохион байгуулалт сайтай тул ойр нутагладаг малчид өөрсдийн унаагаар авчирч борлуулахын зэрэгцээ нийслэлд суралцдаг үр хүүхэд, ах, дүү, хамаатан саднаараа дамжуулан худалддаг гэж малчид тайлбарлаж байв.

- **Завсрын явуулын наймаачид** малчдын гар дээр түүхий эд бэлэн болох ид үеэр тэдэнд хамгийн эрэлт хэрэгцээтэй өргөн хэрэглээний бараа, гурил, будаа зэргийг ачааны машинд ачиж, малчдын хотонд шууд очиж үйлчилдгээрээ бусдаас онцлогтой бөгөөд давуу талтай юм. Зарим наймаачид бүр хэдэн сарын өмнө малчидтай урьдчилан гэрээ хэлцэл хийдэг ч тохиолдол байна. Үнэ, ханшны мэдээлэл багатай, төвөөс алс хол нутагладаг, хүн, хүч муутай малчид гол төлөв явуулын наймаачдад ноолуураа өгдөг ажээ.

- **Аймаг, сумын төвд** нэг талаар түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авах наймаачид, аж ахуйн нэгжүүд олон байдаг, нөгөө талаар малчдад харьцангуй ойр учир түүхий эдээ тэдэнд борлуулж, хэрэгцээт бараагаа худалдан авдаг байна.

- **Хилийн боомтоор** ихэвчлэн хилд ойрхон нутагладаг, хилийн гарц бүхий бүс нутгийн малчид ноолуур, арьс шир зэрэг түүхий эдээ борлуулдаг онцлогтой юм. Эдгээр малчдын ярианаас үзэхэд улиралд нэг удаа өөрсдийн машинаар хилийн боомт нээгдэхэд гарч, түүхий эдээ борлуулдаг байна.

Ийнхүү мал аж ахуйн гаралтай түүхий эд малчдаас боловсруулах үйлдвэр, экспортод гарах хүртэл олон суваг, салаа замаар дамждаг байна. Иймд малчид, дотоодын боловсруулагчдын хоорондын түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар малчдын бүтээгдэхүүн, түүхий эдийг үр ашигтай борлуулах суваг бүрдүүлэх нь чухал юм.

Ямар төрлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг аль сувгаар нь илүүтэй

борлуулж байна вэ гэдгийг өрхүүдээс авсан судалгааны дүнд тулгуурлан бүлэглэж гаргасныг 44 дүгээр хүснэгтээр үзүүлэв.

**Түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалтын сувгууд**  
/өрхөд эзлэх хувиар/

Хүснэгт 44

Борл-т суваг Түүхий эд, бүт.	Улаан-баатар	Аймаг, хот сууринд	Сумын төвд	Наймаа-чинд	Хил худалдаа	Бүгд	
Тэмээ	Ноос	8.9	14.3	19.6	55.4	1.8	100.0
Үхэр Адуу	Мал, мах	41.2	31.4	2.0	25.5	-	100.0
	Шир	20.0	14.5	18.2	45.5	1.8	100.0
Хонь	Мал, мах	35.4	26.2	6.2	32.3	-	100.0
	Ноос	7.7	30.8	6.4	55.1	-	100.0
	Нэжий	23.8	20.2	20.2	35.7	-	100.0
Ямаа	Мал, мах	28.9	18.4	15.8	36.8	-	100.0
	Ноолуур	47.7	14.0	7.0	25.6	5.8	100.0
	Арьс	24.7	19.2	15.1	39.7	1.4	100.0

Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тутам мал, мах зэрэг түүхий эдийг гэрээсээ борлуулах хэмжээ багасч харин Улаанбаатар хот, аймаг, сумын төвд хүргэж зах зээлд нийлүүлэх хувь хэмжээ нэмэгдсэн байна. Тухайлбал, 5 хүртэл ам бүлтэй судалгаанд хамрагдсан малчин өрхийн 31.7 хувь нь нядалсан малын махаа Улаанбаатарт хүргэж борлуулсан байхад 9-өөс дээш ам бүлтэй малчин өрхүүдийн 54.5 хувь нь нийслэлд хүргэж зах зээлд нийлүүлсэн ажээ. Энэ нь малчид түүхий эд, бүтээгдэхүүнээ зах зээлд үнэ хүргэж борлуулахад өрхийн ам бүлийн тоо, ажиллах хүчний хүрэлцээ чухал ач холбогдолтой болохыг илэрхийлж буй хэрэг мөн.

Иймд ганц нэгээрээ бүтээгдэхүүн, түүхий эдээ зах зээлд нийлүүлэхэд тохиолдож буй дээрх бэрхшээлийг арилгахад малчдын дунд хангамж, нийлүүлэлтийн хоршоо хөгжүүлэх санаачлагыг бүх талаар дэмжих нь нэн чухал гэж үзэж байна.

**1.** Өнөөг хүртэл Монголын малчдын орлогын үндсэн эх үүсвэр нь мал аж ахуйн салбар хэвээр байна. Гэхдээ малчид мал аж ахуйгаас олох орлогынхоо эх үүсвэрийг бүрдүүлэхдээ гол нь малын тоо толгойг өсгөх буюу эрчимгүй (экстенсив) аргыг голлон хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, малчдын мал аж ахуйн орлого нь үндсэндээ эрчимгүй аргаар хангагдаж байна.

**2.** Боломжтой бүс нутагт нутгийн шилмэл омгийн малыг өсгөн үржүүлэх, малын үүлдэр, угсааг сайжруулах замаар нэг малаас ашиглах ашиг шимийг нэмэгдүүлж, эрчимтэй аргаар олох мал аж ахуйн орлогын эх үүсвэрийг өсгөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

**3.** Малчдын мал аж ахуйн бус орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ өвөлжөө, хаваржааны нутагт төмс, ногоо, тэжээлийн ургамал тариалах, малчдад түшиглэсэн экотуризм хөгжүүлэх, байгалийн баялаг ашиглах зэрэг чиглэлээр тэдний чадавхийг бэхжүүлэх, идэвх санаачлагыг бүх талаар дэмжих шаардлагатай байна.

**4.** Малчдын амьжиргааны үндсэн эх үүсвэр болсон мал аж ахуйн байдлыг судалж үзэхэд сүргийн энгийн нөхөн үйлдвэрлэл явагдаж байна.

**5.** Судалгаанд оролцсон малчин өрхүүд олсон орлогын хүрэлцээний байдлаа өөрсдөө тодорхойлсон нь ҮСГ-ын жишгээр тэдгээр малчин өрхийн амьжиргааны түвшинг үнэлсэн бидний судалгаатай ойролцоо байна. Тухайлбал судалгаанд оролцсон нийт өрхийн 15.8 хувь нь нэн ядуу бүлэгт багтаж байгаа нь малчин өрхийн 10.6 хувь нь олсон орлого хоол хүнсэндээ ч

**8.4. Дігнэлт**

хүрэлцдэггүй гэсэн хариулттай, нийт өрхийн 37.0 хувь нь ядуу бүлэгт багтаж байгаа нь малчин өрхийн 36.4 хувь нь олсон орлого хоол хүнсэндээ л хүрэлцдэг гэж хариулсан хариулттай тус тус дүйж байна.

**6.** Зарлагын дийлэнх хэсгийг хувийн хэрэглээнд зарцуулж, үйлдвэрлэлээ өргөтгөх, шинэ техник, технологи нэвтрүүлэхэд хөрөнгө хүрэлцэхгүй байгаагийн зэрэгцээ тэдэнд тийм сэтгэлгээ ч төлөвшөөгүй байна.

**7.** Өргөн уудам нутагт тархай, бутархай байрших бэлчээрийн мал аж ахуйн онцлогоос улбаалан малчид түүхий эд, бүтээгдэхүүнээ зах зээлд оновчтой, үр ашигтай борлуулахад багагүй саад, бэрхшээлтэй тулгарч байна.

**8.** Уг бэрхшээлийг малчид дангаараа даван туулах боломжгүй тул тэд хамтарч ажиллах, хоршоонд нэгдэн орох асуудал нэн чухал хүчин зүйл болно. Ялангуяа, түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах, хэрэгцээт бараагаа ханган нийлүүлэх чиглэлээр тэдний үүсгэл санаачлагад тулгуурласан хоршоог хөгжүүлэх замаар зах зээлд өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх боломжтой юм.

**9.** Бүс нутгийн онцлог, зах зээлийн багтаамж, дэд бүтцийн хөгжлийг харгалзан хөдөө орон нутагт мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх замаар мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийг өсгөх, малчдын орлогыг нэмэгдүүлэх стратегийн зорилтыг шийдвэрлэх шаардлагатай байна.

## МАЛЧДЫН ЭН ТЭРГҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ


Малчдын хүсэн хүлээж байгаа эн тэргүүний хэрэгцээ юу вэ? гэсэн асуудлаар судалгааны баг хэлэлцүүлэг хийж, тандан судалгаа явуулсны үр дүнд тэдний хэрэгцээг ахуйн хэрэгцээ, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээ, малчдын нийгмийн хэрэгцээ гэсэн үндсэн гурван бүлэгт хуваах нь зүйтэй гэж үзэв. Эдгээр гурван бүлэг хэрэгцээ тусбүрийг дотор нь ямар ямар гол хэрэгцээ байж болох талаар малчдын саналыг урьдчилан авч хэлэлцүүлэг хийх аргаар тодорхойлж асуулга боловсруулж судалгаа явуулав.

Малчдын хувьд ахуйн ямар хэрэгцээ байгааг тодруулах зорилгоор тэдний гол гол хэрэгцээ юу болохыг тандан судалсны үндсэн дээр **Танд эн тэргүүнд ахуйн ямар хэрэгцээ байна вэ?** /ач холбогдлоор нь эрэмбэлэн 3 хүртэлх хариултыг дугаарлана/ гэсэн асуултаар судалгаа хийхэд тэдний хэрэгцээ дараахь дарааллаар тогтоогдож байна /27 дугаар график/.

### 9.1. Малчин ерхийн ахуйн хэрэгцээ

#### Малчдын эн тэргүүний ахуйн хэрэгцээ

График 27



Судалгаанд хамрагдсан нийт 773 өрхийн 521 өрх буюу 67.4 хувь нь гэрээ тохижуулах хэрэгцээг сонгосон нь уг хэрэгцээ малчдын хамгийн чухал хэрэгцээ болж байгааг харуулж байна. Түүнчлэн гэрээ тохижуулах хэрэгцээг сонгосон 521 өрхийн 405 буюу 77.7 хувь нь уг хэрэгцээг 1 дүгээрт эрэмбэлсэн нь уг хэрэгцээ хичнээн чухал болохыг давхар нотолж байна /45 дугаар хүснэгт/.

Малчдын ярьж байгаагаар гэрээ тохижуулах асуудлын дотор гэрийн шинэ брезент авах, эсгий давхаргаа шинэчлэх, гэрээ томруулах, гэрийн яс модыг сэлбэж засах буюу будаж өнгөлөх, гэрийн дотор шинэ эд хогшил авах зэрэг асуудлууд багтах аж. Энэ хэрэгцээ шаардлагыг хөдөөгийн бараг айл бүрт байнга байдаг хэрэгцээ гэж үзэж болох юм.

Үүний зэрэгцээ малчин өрх бага оврын цахилгааны эх үүсгэвэр, телевизтэй болох, авто тээврийн хэрэгсэлтэй болох сонирхол нэлээд байгаа нь харагдаж байна.

Малчдын эн тэргүүний ахуйн хэрэгцээ

Хүснэгт 45

Хариулт	Хариултын эрэмбэ	Хариултын тоо	773 өрхөд эзлэх хувь	Тухайн хариултын дүнд эзлэх хувь	Нийт хариултын дүнд эзлэх хувь
1	2	3	4	5	
Гэрээ тохижуулах /эсгий, брезент, тавилга авах г.м/	1	405	52.4	77.7	21.0
	2	84	10.9	16.1	4.4
	3	32	4.1	6.1	1.6
	Дүн	521	67.4	100.0	27.0
Өвөлжөөндөө байшинтай болох	1	83	10.7	30.6	4.3
	2	127	16.4	46.9	6.6
	3	61	7.9	22.5	3.1
	Дүн	271	35.1	100.0	14.0
Цахилгааны эх үүсгэвэр, телевизтэй болох	1	141	18.2	30.0	7.3
	2	223	28.8	47.4	11.5
	3	106	13.7	22.6	5.5
	Дүн	470	60.8	100.0	24.3
Авто хэрэгсэлтэй болох /машин, мотоцикл	1	66	8.5	19.8	3.4
	2	135	17.5	40.4	7.0
	3	133	17.2	39.8	6.9
	Дүн	334	43.2	100.0	17.3
Ачлагын мал, тэрэгтэй болох	1	43	5.6	16.6	2.2
	2	99	12.8	38.2	5.1
	3	117	15.1	45.2	6.1
	Дүн	259	33.5	100.0	13.5
Бусад	1	17	2.2	22.7	0.9
	2	8	1.0	10.7	0.4
	30	50	6.5	66.6	2.6
	Дүн	75	9.7	100.0	3.9
Дүн	-	1930	-	-	100.0

Малчин өрхийн ахуйн хэрэгцээ бүс нутгаас шалтгаалан ямар байдалтай байгааг 46 дугаар хүснэгтээр харуулав.

Малчдын ахуйн нэн тэргүүний хэрэгцээ бүс нутгийн байдлаас хамааран бага зэрэг ялгаатай байгаа боловч энэхүү ялгаа нь статистик магадлалын хувьд бодитой биш байна. Тухайлбал, баруун бүсийн малчдын нэн тэргүүний ахуйн хэрэгцээ нь гэрээ тохижуулах биш цахилгааны эх үүсгэвэр, телевиз болж өөрчлөгдсөн байна. Энэ нь тэдний амьдралын түвшин дээшилсэнтэй, нөгөө талаар, баруун бүсийн аймгийн малчид мэдээллээс хол байдгийн хэрээр бага оврын цахилгаан үүсгэвэр, телевизийг өргөн хэрэглэдэг, тэрхүү хэрэглээгээ дагаад хэрэгцээ нь их байдагтай холбоотой байж ч болох юм.

Хангайн бүсийн малчин өрхүүд гэр орноо тохижуулах хүсэл, сонирхлоор бусдаасаа илүү байхад баруун бүсийн малчид өвөлжөөндөө өвлийн байшинтай, авто хэрэгсэлтэй болох сонирхол бусдаас их байгаа нь анзаарагдаж байна. Эдгээр өөрчлөлтийг эс тооцвол малчдын ахуйн эн тэргүүний хэрэгцээ нь бүс нутгийн байдлаар төдийлөн ялгарахгүй байна.

**Малчдын эн тэргүүний ахуйн хэрэгцээ**  
/эдийн засгийн бүсээр/

Хүснэгт 46

Хариулт	Малчин өрхийн бүлэглэл /эдийн засгийн бүсээр/										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Гэрээ тохижуулах /эсгий, брезент авах г.м/	176	29.0	145	24.5	112	28.5	70	25.8	11	30.6	514	27.1
Өвөлжөөндөө байшинтай болох	82	13.5	102	17.2	53	13.5	22	8.1	6	16.7	265	14.0
Цахилгааны эх үүсгэвэр, телевизтэй болох	149	24.5	159	26.9	72	18.3	75	27.7	8	22.2	463	24.4
Авто хэрэгсэлтэй болох /машин, мотоцикл/	93	15.3	103	17.4	79	20.1	47	17.3	7	19.4	329	17.3
Ачлагын мал, тэрэгтэй болох	84	13.8	62	10.5	61	15.5	44	16.2	2	5.6	253	13.3
Бусад	23	3.8	21	3.5	16	4.1	13	4.8	2	5.6	75	3.9
Хариултын тоо бүгд	607	100.0	592	100.0	393	100.0	271	100.0	36	100.0	1899	100.0
Асуулгад оролцсон малчин өрх	247		208		164		103		19		741	

Малчдын ахуйн хэрэгцээ нь тэдний амьжиргааны түвшин, түүнийг тодорхойлох гол үзүүлэлт болох өрхийн ам бүлийн нэг хүнд ногдох орлого, аль эсвэл нэг хүнд ногдох малын тооноос хэрхэн хамаарч байгааг тодорхойлох нь нэлээд сонирхолтой асуудал юм. Судалгаанаас үзэхэд өрхийн нэг хүнд ногдох орлого нэмэгдэх тутам гэрээ тохижуулах, ачлагын мал, тэрэгтэй болох хэрэгцээ буурч харин өвөлжөөндөө байшинтай болох, цахилгааны эх үүсгэвэртэй болох хэрэгцээ нэмэгдэж байна /47 дугаар хүснэгт/.

**Малчдын нэн тэргүүний ахуйн хэрэгцээ**  
/өрхийн нэг хүнд ногдох жилийн орлогоор/

Хүснэгт 47

Хариулт	Малчин өрхийн нэг хүнд ногдох сарын орлогын бүлэглэл										Бүгд	
	0-100000		100001-300000		300001-500000		500001-700000		700001-ээс дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Гэрээ тохижуулах /эсгий, брезент авах г.м/	97	32.7	244	27.1	117	25.7	521	27.0	22	22.2	1001	27.2
Өвөлжөөндөө байшинтай болох	31	10.4	123	13.7	73	16.0	271	14.0	20	20.2	518	14.1
Цахилгааны эх үүсгэвэр, телевизтэй болох	66	22.2	214	23.8	110	24.1	470	24.4	30	30.3	890	24.2
Авто хэрэгсэлтэй болох /машин, мотоцикл/	41	13.8	148	16.5	90	19.7	334	17.3	12	12.1	625	17.0
Ачлагын мал тэрэгтэй болох	50	16.8	138	15.4	53	11.6	259	13.4	5	5.1	505	13.7
Бусад	12	4.0	32	3.6	13	2.9	75	3.9	10	10.1	142	3.9
Хариултын тоо бүгд	297	100.0	899	100.0	456	100.0	1930	100.0	99	100.0	3681	100.0
Асуулгад оролцсон малчин өрх	116		350		176		69		43		754	


Малчид эхний ээлжинд гэр орноо тохижуулах хэрэгцээгээ, түүний дараагаар ачилгын мал, тэрэгтэй болох хэрэгцээгээ хангадаг, дараа нь байшинтай болох хэрэгцээ урган гарч ирдэг гэх мэтээр хүмүүсийн сонирхол амьжиргааны түвшин, бодит боломждоо захирагдаж байгаа нийтлэг байдал эндээс харагдаж байна.

9.2. Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээ

Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор *Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дараахь үйл ажиллагааны аль нь Таны хувьд эн тэргүүний ач холбогдолтой вэ? /Ач холбогдлоор нь эрэмбэлэн эхний 3 хүртэлх хариултыг дугаарлана/* гэсэн асуултаар судалгаа хийхэд малчдын хэрэгцээ дараахь дарааллаар тогтоогдож байна /28 дугаар график/.

Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн эн тэргүүний хэрэгцээ

График 28



Судалгаанд хамрагдсан нийт 773 өрхийн 550 өрх буюу 71.2 хувь нь малын тоог нэмэгдүүлэх хэрэгцээг сонгосон нь уг хэрэгцээ малчдын хамгийн чухал үйлдвэрлэлийн хэрэгцээ болж байгааг харуулна. Малын тоог нэмэгдүүлэх хэрэгцээтэй нийт өрхийн 73.5 хувь нь уг хэрэгцээг 1 дүгээрт эрэмбэлсэн нь хамгийн олон давтамжтай байна /48 дугаар хүснэгт/.

Малын тоо толгойг нэмэгдүүлэх гэсэн малчдын хэрэгцээ яагаад бий болов, энэхүү хэрэгцээ нь малчин өрхийн малын тоо толгойг хэдий хэмжээнд хүргэж байж хангагдах вэ? Хэрэв малчин өрх бүрийн энэ хүсэлтийг хэрэгжүүлбэл Монгол улс хичнээн толгой малтай болох вэ? гэх мэтийн асуудал судлаачдын анхаарлыг татах сонирхолтой асуудал байж болох юм. Энэ сонирхлын дагуу малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээг тэдний одоо маллаж байгаа малын тоо толгойтой холбож судлахад өрхийн хөдөлмөрийн чадвартай нэг хүнд 1-20 толгой мал /богд шилжүүлснээр/ ногдох малчин өрхийн 79.5 хувь, 20-70 мал ногдох өрхийн 76.6 хувь, 150-иас дээш мал ногдох өрхийн 45.7 хувь нь малынхаа тоо толгойг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байгаа аж /48 дугаар хүснэгт/.

Хэдийгээр нэг хүнд ногдох малын тоо нэмэгдэх тутам малын тоог өсгөх хэрэгцээ шаардлага буурч байгаа хэдий ч нэг хүнд ногдох малын тоо 150-иас дээш толгойд хүрсэн малчин өрхийн 45.7 хувь нь малынхаа тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байгаа нь сонирхол татаж байна.

2002 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 243.2 мянган малчин өрх тоологдсоноос 100 хүртэлх малтай 168 мянган өрх байна. Эдгээр өрхийн нэн тэргүүний хэрэгцээ болсон малын тоо толгойг нэмэгдүүлж нэг хүнд ногдох малын тоог ядаж 100 богт хүргэх аваас зөвхөн эдгээр 168 мянган өрхийн хэрэгцээнд 60 гаруй сая бог мал шаардагдах, нийтдээ улсын хэмжээнд 120 сая орчим малтай болох ойролцоо тооцоо гарч байна. Гэтэл Монгол орны бэлчээрийн даац 60-70 сая толгой мал /богт шилжүүлснээр/ бэлчээрлүүлэх боломжтой гэсэн эрдэмтдийн судалгааг харгалзан үзэх аваас малчдын малын тоо толгойг өсгөх бодит боломж тун хомс байгаа болно.



Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн нэн тэргүүний хэрэгцээ  
Хүснэгт 48

Хариулт	Хариултын эрэмбэ	Хариултын тоо	Нийт хариултын дүнд эзлэх хувь	Нийт 773 оролцогсдын дүнд эзлэх хувь
1	2	3	4	5
Малын тоог нэмэгдүүлэх	1	404	19.6	52.2
	2	93	4.5	12.0
	3	53	2.6	6.8
	Дүн	550	26.7	71.2
Малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжүүлэх	1	228	11.0	29.5
	2	250	12.1	32.3
	3	59	2.9	7.6
	Дүн	537	26.0	69.5
Өөрийн эзэмшил худагтай болох	1	19	0.9	2.5
	2	95	4.7	12.3
	3	79	3.8	10.2
	Дүн	193	9.4	25.0
Өөрийн эзэмшил бэлчээртэй болох	1	22	1.0	2.8
	2	84	4.1	10.9
	3	99	4.8	12.8
	Дүн	205	9.9	26.5
Малыг эрүүлжүүлэх	1	49	2.4	6.3
	2	133	6.4	17.2
	3	198	9.6	25.6
	Дүн	380	18.4	49.2
МАН-н хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх техник хэрэгсэл	1	26	1.3	3.4
	2	58	2.8	7.5
	3	114	5.5	14.7
	Дүн	198	9.6	25.6
Бусад	1	2	0.1	0.3
	2	5	0.2	0.6
	3	12	0.6	1.5
	Дүн	19	0.9	2.5
Нийт дүн		2063	100.0	-

Малчдын тоо өсч, байгаль, цаг уур муудаж бэлчээрийн ургац багасч буй өнөө цагт малчдын хүсэн хүлээж байгаа мал аж ахуйн үйлдвэрлэлийн эн тэргүүний хэрэгцээ болсон малын тоо толгойг нэмэгдүүлэх асуудлыг өрх бүрт хэрэгжүүлэх үндэслэл муутай байна. Харин түүний оронд хөдөлмөрийн чадвартай нэг хүнд ногдох малын тоо толгойг нэмэгдүүлж хөдөлмөр эрхлэлтийг нягтруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулж нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

**Жич:** Малчдын аливаа санал, бодлыг тэдний өмчлөлд байгаа малын тоо толгойноос хамааруулан судлахдаа өрхийн малын бодит тоогоор биш бүх малыг богт шилжүүлж, өрхийн нэг хүнд ногдох богийн тоог авч ашигласан болно. Малын тоог бодит байгаагаар нь авч судалгаанд ашиглавал 100 богтой өрх, 100 бодтой өрхийг нэгэн адил авч үзэхэд хүрч арга зүйн алдаатай дүгнэлтэд хүрч болох юм. Нөгөө талаар өрхийн малын тоог шууд авч ашиглавал мөн л 100 малтай 5 ам бүлтэй өрхийг 100 малтай 10 ам бүлтэй өрхтэй адилд үзэхэд хүрч мөн л арга зүйн алдаанд хүрнэ. Иймд **өрхийн нэг хүнд ногдох богт шилжүүлсэн малын тоо** гэсэн үзүүлэлтийг судалгаанд өргөн ашиглав.

**Малчдын эн тэргүүний хэрэгцээ болж байгаа мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа /өрхийн нэг хүнд ногдох малын тоогоор/**

Хүснэгт 49

Хариулт	Нэг хүнд ногдох малын бүлэглэлт /богоор/										Бүгд	
	0-20		21-40		41-70		71-150		150-иас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Малын тоог нэмэгдүүлэх	163	29.3	144	27.1	127	27.2	95	23.7	21	16.7	550	26.4
Малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжүүлэх	131	23.5	126	23.7	123	26.3	119	29.7	38	30.2	537	25.8
Өөрийн эзэмшил худагтай болох	60	10.8	52	9.8	39	8.4	32	8.0	10	7.9	193	9.3
Өөрийн эзэмшил бэлчээртэй болох	57	10.2	57	10.7	44	9.4	36	9.0	11	8.7	205	9.8
Малыг эрүүлжүүлэх	84	15.1	99	18.6	88	18.8	80	20.0	29	23.0	380	18.3
МАА-н хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх техник хэрэгсэлтэй болох	57	10.2	47	8.9	44	9.4	35	8.7	15	11.9	198	9.5
Бусад	5	0.9	6	1.1	2	0.4	4	1.0	2	1.6	19	0.9
Хариултын тоо бүгд	557	100.0	531	100.0	467	100.0	401	100.0	126	100.0	2082	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	205		188		167		144		46		750	
Асуулгад оролцсон малчин өрхийн нийт дүнд эзлэх хувь	27.3		25.1		22.3		19.2		6.1		100	

Энэ мэтээр ажиглалт хийхэд малын тоо нэмэгдэх тутам малчдын хувьд малын үүлдэр угсааг сайжруулах, мал эрүүлжүүлэх ажлын хэрэгцээ нэмэгдэж байна. Харин цөөн малтай малчид өөрийн эзэмшил бэлчээр, хашаа хороо, худагтай болох хэрэгцээ ихтэй байгаа аж. Энэ нь цөөн малтай айл өрхүүд тэр бүр өрхийн эзэмшил өвөлжөө, хаваржаа, хашаа хороогүй байдагтай холбоотой болох нь малчидтай ярилцаж байхад ажиглагдаж байв.

Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээг тэдний оршин байгаа эдийн засгийн бүсээр харьцуулан судлахад онцын өөрчлөлт, ялгаа гараагүй болно.


**9.3. Малчдын нийгмийн үйлчилгээний хэрэгцээ**

Нийгмийн үйлчилгээний талаар малчдын хамгийн чухал хэрэгцээ юу болохыг тодорхойлох зорилгоор **“Дор дурдсан нийгмийн үйлчилгээнээс аль нь танд эн тэргүүний хэрэгцээтэй байна вэ?”** (Ач холбогдлоор нь эрэмбэлэн 3 хүртэлх хариултыг дугаарлана) гэсэн асуултаар малчдаас хариулт авч судалгаа явуулав.

Судалгаанд хамрагдсан малчин өрхүүд нийгмийн дээрх үйлчилгээнээс алийг нь хамгийн чухалд үзэж, ач холбогдол өгч байгаа байдлаар нь эрэмбэлэн тодорхойлоход дараахь байдалтай байна /29 дүгээр график/.

**Малчдын нийгмийн үйлчилгээний хэрэгцээ**

График 29



Нийгмийн үйлчилгээний хувьд хамгийн чухал, нэн тэргүүний хэрэгцээ болж байгаа асуудал бол хүүхдийн боловсролын асуудал болох нь ойлгомжтой байна. Судалгаанд оролцсон 773 өрхийн 609 буюу 78.8 хувь нь нийгмийн хамгийн чухал хэрэгцээ бол **хүүхдийн боловсрол** гэсэн хариултыг сонгосон байна. Уг хариултыг сонгосон 609 өрхийн 429 буюу 70.4 хувь нь уг хариултыг нэгдүгээр эрэмбээр, 117 буюу 19.2 хувь нь хоёрдугаар эрэмбээр, 63 буюу 10.4 хувь нь гуравдугаар эрэмбээр сонгож хариулжээ /50 дугаар хүснэгт/.

**Дор дурдсан нийгмийн үйлчилгээнээс аль нь танд нэн тэргүүний хэрэгцээтэй байна вэ?**

Хүснэгт 50

Хариулт	Хариултын эрэмбэ	Хариултын тоо	Нийт хариултын дүнд эзлэх хувь	Нийт 52 малчны дүнд эзлэх хувь
1	2	3	4	5
Хүүхдийн боловсрол	1	429	20.4	55.5
	2	117	5.6	15.1
	3	63	3.0	8.2
	Дүн	609	29.0	78.8
Харилцаа холбоо, мэдээлэл	1	37	1.8	4.8
	2	135	6.4	17.5
	3	68	3.2	8.8
	Дүн	240	11.4	31.0
Нийгмийн хэв журам, хууль	1	37	1.8	4.8
	2	124	5.9	16.0
	3	97	4.6	12.6
	Дүн	258	12.3	33.4
Хүн, малын эрүүл мэнд	1	178	8.5	23.0
	2	219	10.4	28.3
	3	135	6.4	17.5
	Дүн	532	25.3	68.8
Банк, санхүү, зээл	1	50	2.4	6.5
	2	92	4.4	11.9
	3	137	6.5	17.7
	Дүн	279	13.3	36.1
Худалдаа, үйлчилгээ	1	17	0.8	2.2
	2	22	1.0	2.8
	3	130	6.2	16.8
	Дүн	169	8.0	21.9
Бусад	1	3	0.1	0.4
	2	4	0.3	0.5
	3	9	0.4	1.2
	Дүн	16	0.8	2.1
Нийт дүн		2103	100.0	-

Хөдөөгийн сургуулийн сургалтын чанар нь хот суурин газрынхаас нэлээд хоцрогдож байгаа, нарийн мэргэжлийн багш, боловсон хүчний хангамж муу байдаг тухай асуудлыг фокус группын ярилцлага, харилцан санал солилцох явцад малчид өгүүлж байлаа.

Малчид хүүхдийнхээ суралцах боломжийг хангах үүднээс хөгшин аав, ээж аль эсвэл эцэг, эхийн аль нэг нь сум, багийн төвд гэр барьж хүүхдээ гэрээсээ хичээлд явах боломжийг хангадаг, ийм боломжгүй бол сургуулийн дотуур байранд эсвэл малаа маллуулж байгаа төв орон нутгийн ах дүү, танил айлд суулгах зэргээр янз бүрээр зохицуулдаг аж. Малчид сурч боловсрох сонирхолтой, сурлага сайтай хүүхдийг тэр бүр сургууль завсардуулаад байх сонирхолгүй байна. Үнэхээр ном эрдэм сурах авъяас муутай хүүхдийг сургуулиас нь гаргаж мал хариулахад сургаж мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа туслуулдаг байна.

Малчдын нийгмийн үйлчилгээний хэрэгцээг бүс нутгийн байдлаас хамааруулан судалсан дүнг 51 дүгээр хүснэгтээр үзүүлэв.

**Малчдын нийгмийн үйлчилгээний хэрэгцээ**

**Хүснэгт 51**

Хариулт	Хариултын тоо /эдийн засгийн бүсээр/										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хүүхдийн боловсрол	188	27.3	187	30.5	135	30.5	80	28.0	12	30.0	602	29.1
Харилцаа холбоо, мэдээлэл	81	11.8	87	14.2	38	8.6	28	9.8	3	7.5	237	11.4
Нийгмийн хэв журам, хууль	105	15.2	59	9.6	57	12.9	29	10.1	5	12.5	255	12.3
Хүн, малын эрүүл мэнд	176	25.5	129	21.0	129	29.2	72	25.2	13	32.5	519	25.1
Банк, санхүү, зээл	80	11.6	98	16.0	42	9.5	50	17.5	5	12.5	275	13.3
Худалдаа, үйлчилгээ	55	8.0	48	7.8	37	8.4	25	8.7	2	5.0	167	8.1
Бусад	4	0.6	6	1.0	4	0.9	2	0.7	0	0.0	16	0.8
Хариултын тоо бүгд	689	100.0	614	100.0	442	100.0	286	100.0	40	100.0	2071	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	248	-	206	-	162	-	103	-	19	-	738	-

Хангайн бүсийн 248 өрх уг асуултад тус бүр 3 хүртэл хариулт сонгож нийт 689 хариулт өгснөөс 188 хариулт буюу 27.3 хувь нь хүүхдийн боловсролын асуудал бол хамгийн чухал ач холбогдолтой нийгмийн асуудал мөн гэж үзсэн байхад уг асуудлыг Улаанбаатарын бүсийн малчдын 30 хувь нь л чухалд үзсэн байна. Харин эдийн засгийн Хангайн бүсийн аймгийн малчид нийгмийн хэв журам, хууль сахиулах үйлчилгээг бусад бүсээс илүүтэйгээр чухалчилсан байна /51 дүгээр хүснэгт/.

Нийгмийн үйлчилгээний олон хэрэгцээнээс нэг малчин нэн тэргүүнд хэрэгцээтэй гэж үзсэн 3 хүртлэх хариултыг сонгосон нийт 2071 хариултын 29.1 хувийг хүүхдийн боловсрол, 25.1 хувийг хүн, малын эрүүл мэндийн асуудал эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Худалдаа үйлчилгээний асуудал нийт хариултын 8.0 хувийг эзэлсэн нь уг асуудалд зах зээлийн харилцааны хөгжлөөр шийдэгдэж байгаатай холбоотой.

Бид малчдын нэн тэргүүний хэрэгцээг улам тодруулах зорилгоор Төв аймгийн Жаргалант сумын малчдын дунд фокус группын ярилцлага зохион байгуулж **“Танд яг одоо эргэж төлөгдөхгүй нөхцөлөөр 10 сая төгрөг олговол нэн тэргүүнд юунд зарцуулах вэ?”** гэсэн асуулт тавьж оюуны дайралт хийсэн юм. Малчид асуултад хэрхэн хариулсныг 52 дугаар хүснэгтээр үзүүлэв.

Малчдын хариултыг нэгтгэж үзэхэд тэд 10 сая төгрөгөөс юуны өмнө өрх гэрийнхээ тулгамдсан хэрэгцээнд зарцуулах бөгөөд энэ нь авгай, хүүхдүүддээ хувцас хунар авч өгөх, зарим нь өр зээлээ хаах, хүнсний зүйл базааж авах, хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулах, бага оврын цахилгаан үүсгэвэр авах, гэрийн тавилга авах зэрэг элдэв төрлийн хувийн хэрэгцээ юм.

Малчдын энэхүү хувийн хэрэгцээ нь нийт хэрэгцээний 20 хувийг эзэлж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан хүн бүрт их, бага янз бүрийн хэмжээгээр хувийн хэрэгцээ байгаа болох нь тогтоогдож байна.

Хүн бүрт байхгүй боловч нийт зарлагын хамгийн өндөр хувийг эзэлж байгаа зарлага нь автомашин, мотоциклийн /унааны/ хэрэгцээ байв. Хэдийгээр судалгаанд оролцсон 16 хүний 9 нь /56.25 хувь/ УАЗ-469 машин буюу мотоцикл худалдаж авна гэсэн боловч энэ нь нийт зарлагын 26,25 хувийг, тухайн хувь хүний зарлагын 50 орчим хувийг эзэлж байна.

**Фокус группын ярилцлагад оролцсон малчдын  
10 сая төгрөгийг зарцуулах төлөвлөгөө /сая төг-өөр/**

Хүснэгт 52

№	Зарлагын төрөл	Зарлагын дундаж	Нийт зардал /нэр төрлөөр/	Нийт зардалд эзлэх хувь	Саналын тоо	Саналын хувь
1.	Өөрийн хувийн хэрэгцээнд зарцуулах	2.0	32.0	20	16	100
2.	Малын үүлдэр угсааг сайжруулах	2.0	30.0	18.75	15	93.75
3.	Хадлангийн тоног төхөөрөмж авах	2.5	30.0	18.75	12	75.0
4.	УАЗ-469 автомашин, мотоцикл	4.6	42.0	26.25	9	56.25
5.	Мал худалдаж авах	1.5	10.5	6.56	7	43.75
6.	Банкинд хадгалуулах	3.162	12.65	7.9	4	25.0
7.	Цахилгаан үүсгүүр	0.950	2.850	1.78	3	18.75
8.	Дүн	-	160.0	100.0	-	-

Малчдын хамгийн хүнд хүчир ажил нь өвс хадлан бэлтгэх ажил болох нь санал асуулгын явцад болон фокус ярилцлагын үед тодорхой байсан бөгөөд энэхүү зарлагын хуваарилалтаар мөнл багтлагдаж байна. Тухайлбал, оролцогчдын 75 хувь нь хадлангийн тоног төхөөрөмж, бага оврын трактор авахад хөрөнгө зарцуулна гэсэн байна.

1. Малчид тохилог орчинд амьдрахаа ахуйн хамгийн чухал асуудал гэж үзэж байна. Малчдын ахуйн олон төрлийн хэрэгцээ байгаагийн дотор нэн тэргүүний хэрэгцээ нь **гэрээ тохижуулах** хэрэгцээ аж. Энэхүү гэрээ тохижуулах хэрэгцээнд гэрийн шинэ брезент авах, эсгий давхаргаа шинэчлэх, гэрээ томруулах, гэрийн яс модыг сэлбэж засах буюу будаж өнгөлөх, гэрийн дотор шинэ эд хогшил авах зэрэг хэрэгцээ орж байна. Малчид гэрээ тохижуулах хэрэгцээгээ хангасны дараа ачилгын мал, тэрэг, автомашин, байшинтай болох зэрэг хэрэгцээгээ хангах сонирхолтой байна.

**9.4. Дігнэлт**

2. Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн эн тэргүүний хэрэгцээ нь **малын тоо толгойг нэмэгдүүлэх** явдал байна. Судалгаанд оролцсон нийт малчдын 71.2 хувь нь дээрх асуудлыг нэн тэргүүний хэрэгцээ гэж үзсэн байна. Түүнчлэн малчин өрхийн нэг хүнд ногдох малын тоо 150 богоос багагүй хэмжээнд хүрч байж тэдний малын тоог нэмэгдүүлэх хэрэгцээг хангаж болох боловч энэ нь өнөөгийн Монгол орны бэлчээрийн даац, мал аж ахуйд ажиллаж амьдарч байгаа хүний тоо зэргийг тооцож үзэхэд бараг боломжгүй асуудал болно. Иймд цаашид мал аж ахуйн үйлдвэрлэл дэх нэг хүнд ногдох малын тоог өсгөх, нэг малын ашиг шимийг нэмэгдүүлэх замаар хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, малчдад мал маллахаас өөр ажлын байр шинээр бий болгох арга хэмжээ зохион байгуулах нь илүү оновчтой зам болно.

3. Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээ нь тэдний оршин байгаа бүс нутгаас хамаарч төдийлөн өөрчлөгдөхгүй байна.

4. Малчдын нийгмийн үйлчилгээний нэн тэргүүний хэрэгцээ нь хүүхдийн боловсрол болно. Хөдөөгийн хүн, малын эрүүл мэндийн үйлчилгээг ч малчид хамгийн чухал хэрэгцээ гэж үзэж байна.

5. Малчдын нийгмийн үйлчилгээг чухалчилж байгаа байдал нь тэдний оршин байгаа бүс нутгаас хамаарч бага зэрэг өөрчлөгдөж байгаа боловч статистик бодитой ялгаа гарахгүй байна.


## МАЛ АЖ АХУЙГ ЭРХЛЭХ АРГА, ХЭЛБЭРИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

### 10.1. Мал аж ахуйн эрчимжилт

Малчид мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрчимжилтийн талаар ямар ойлголттой байгааг тодруулах зорилгоор тэдэнд “Мал аж ахуйн эрчимжилт гэдгийг та юу гэж ойлгож байна вэ?” гэсэн асуулт тавьж хариулт авч дүнг 30 дугаар графикаар тоймлон үзүүлэв.

#### Мал аж ахуйн эрчимжилтийн талаарх малчдын ойлголт

График 30



30 дугаар графикаас үзэхэд малчдын олонх нь мал аж ахуйн эрчимжилтийг малын үүлдэр угсааг сайжруулж, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэн суурин ба хагас суурин аж ахуй эрхлэх гэсэн агуулгаар ойлгож байна. “Бусад” гэсэн хариултын дотор малыг төрөлжүүлэх, сүргийн бүтцийг сайжруулах, хамтарч ажиллах зэрэг санал багтсан байв.

“Танай нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломж байгаа эсэх?” гэсэн асуултаар малчдаас санал авахад Баруун бүсийн малчдын 33.8 хувь нь уг бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломжтой гэсэн бол Улаанбаатар хот орчмын малчдын 68.4 хувь нь, Төвийн бүсийн малчдын 61.2 хувь нь эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломжтой гэж хариулжээ. Харин Зүүн болон Хангайн бүсийн малчдын дийлэнх нь тухайн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломж дунд зэрэг байна гэж үзжээ /53 дугаар хүснэгт/.

Үүнээс харахад бүс бүрт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломж, нөхцөл ялгаатай байна гэж малчид үзэж байгаа ажээ. Ялангуяа, Төвийн бүс болон Улаанбаатар хот орчимд эрчимжсэн мал аж ахуйг фермерийн аж ахуйн хэлбэрээр хөгжүүлэх боломж илүүтэй байгааг малчид онцолж байв.

Гэхдээ нэг бүс дотор багтаж буй сум бүрийн байгаль, цаг уур, эдийн засгийн нөхцөл ялгаатай учир аль ч бүсэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зохих хэмжээний боломж байгааг үгүйсгэж болохгүй.

**Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломжийн талаарх малчдын бодол**  
Хүснэгт 53

Хариулт	Хариултын тоо /эдийн засгийн бүсээр/										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломж байгаа	109	43.6	71	33.8	101	61.2	54	47.0	13	68.4	348	45.8
Дунд зэрэг	70	28.0	52	24.8	46	27.9	34	29.6	1	5.3	203	26.7
Байхгүй	13	5.2	59	28.1	5	3.0	9	7.8	1	5.3	87	11.5
Мэдэхгүй	46	18.4	24	11.4	13	7.9	13	11.3	4	21.1	100	13.2
Хариулаагүй	12	4.8	4	1.9	0	0.0	5	4.3	0	0.0	21	2.8
Асуулгад оролцсон малчдын тоо	250	100.0	210	100.0	165	100.0	115	100.0	19	100.0	759	100.0

“Хэрэв танай нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломж байгаа бол эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээс аль нь илүү боломжтой вэ?” гэсэн асуултад ач холбогдлоор нь эрэмбэлэн 3 хүртэлх хариултыг сонгохдоо малчид дараах байдлаар сонголт хийжээ /54 дүгээр хүснэгт/.

**Эрчимжсэн мал аж ахуйг ямар чиглэлээр хөгжүүлэх нь илүү боломжтой вэ?**  
Хүснэгт 54

Хариулт	Эдийн засгийн бүс										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Сүүний чиглэлийн үхэр	79	16.4	93	25.3	68	19.7	40	21.6	14	66.7	294	21.0
Махны чиглэлийн үхэр	111	23.1	46	12.5	44	12.7	32	17.3	0	0.0	233	16.6
Махны чиглэлийн хонь	80	16.6	66	18.0	60	17.3	31	16.8	0	0.0	237	16.9
Нутгийн шилмэл омгийн мал	96	20.0	81	22.1	51	14.7	42	22.7	1	4.8	271	19.4
Эрчимжсэн мал аж ахуй+газар тариалан	80	16.6	64	17.4	77	22.3	25	13.5	5	23.8	251	17.9
Эрчимжсэн мал аж ахуй+бусад салбар	27	5.6	16	4.4	42	12.1	15	8.1	1	4.8	101	7.2
Бусад	8	1.7	1	0.3	4	1.2	0	0.0	0	0.0	13	0.9
Хариултын тоо бүгд	481	100.0	367	100.0	346	100.0	185	100.0	21	100.0	1400	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	182		127		147		73		14		543	
Асуулгад оролцсон малчин өрхийн нийт тоонд эзлэх хувь	33.5		23.4		27.1		13.0		2.6		100.0	

Энэ судалгаанаас үндэслэн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн талаарх малчдын саналыг бүс бүрээр тодорхойлж болох юм. Тухайлбал, Хангайн бүсэд дээрх асуултад 182 малчин давхардсан тоогоор нийт 481 хариулт өгснөөс энэ бүсэд махны чиглэлийн үхэр (23.1 хувь), нутгийн шилмэл омгийн мал (20.0 хувь), сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг (16.4 хувь) хөгжүүлэх боломжтой гэж үзжээ. Малчдын хариултыг үндэслэн бүс бүрт хөгжүүлэх боломжтой эрчимжсэн мал аж ахуйн чиглэлийг тодорхойлбол:

- Хангайн бүсэд:  
Махны үхэр, нутгийн шилмэл омгийн мал
- Баруун бүсэд:  
Сүүний үхэр, нутгийн шилмэл омгийн мал, махны чиглэлийн хонь
- Төвийн бүсэд:  
Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, сүүний үхэр, махны үхэр

- Зүүн бүсэд:  
Нутгийн шилмэл омгийн мал, сүүний үхэр, махны үхэр
- Улаанбаатарын бүсэд:  
Сүүний үхэр, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан

Баруун болон Хангайн бүсийн малчид сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа нь эрдэмтэд судлаачдын боловсруулсан үзэл баримтлалаас нэлээд зөрүүтэй байна. Сүүний үйлдвэрлэлийг зах зээлээс алс хол эрхлэх нь боруулалтад муугаар нөлөөлөх, тэгээд ч баруун бүсэд сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэж байсан уламжлал бага, байгаль цаг уурын байдал нь төдийлөн тохиромжтой биш зэргийг тооцож үзэхэд малчдын дээрх санал, бодол хэрэгжих үндэслэл бага байна. Харин баруун бүсэд хонь ямааны аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх өргөн боломж байгаа юм.

Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхийн тулд малчид юу хүсч байгааг тодруулах зорилгоор **“Эрчимжсэн мал аж ахуй эрхлэхийн тулд эн тэргүүнд ямар нөхцөл боломж бүрдүүлэх шаардлагатай гэж үздэг вэ? /ач холбогдлоор нь эрэмбэлэн 3 хүртэлх хариултыг сонгох/”** гэсэн асуултыг малчдад тавьж хариултыг 55 дугаар хүснэгтээр нэгтгэн харуулав.

Энэхүү судалгааны дүнгээс үзэхэд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхийн тулд зайлшгүй бүрдүүлэх эн тэргүүний нийтлэг гол нөхцөл нь:

- өндөр ашиг шимтэй үүлдрийн мал худалдан авах, өсгөж үржүүлэх,
- төрөөс зээл, татварын хөнгөлөлт үзүүлэх,
- сургалтад хамрагдах явдал хамгийн чухал гэж малчид тус тус үзсэн байна.

Эдгээр нийтлэг нөхцөл, боломжуудаас гадна эдийн засгийн бүсүүдээр зарим талаар онцлог зүйл ч байна. Тухайлбал, Төвийн болон Хангайн бүсэд бэлчээр хашиж услах, таримал тэжээл тариалах, Баруун бүсэд багаж, тоног төхөөрөмж худалдан авах,

**Эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд малчдад эн тэргүүнд шаардагдах нөхцөл, боломж**

*Хүснэгт 55*

Хариулт	Эдийн засгийн бүс										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Өндөр ашиг шимтэй үүлдрийн мал худалдан авах	157	29.3	161	27.7	136	33.8	72	30.1	11	28.2	537	29.9
Бэлчээр хашиж услах, таримал тэжээл тариалах	67	12.5	73	12.6	65	16.2	16	6.7	6	15.4	227	12.6
Сургалтанд хамрагдах	80	14.9	93	16.0	41	10.2	33	13.8	3	7.7	250	13.9
Багаж, тоног төхөөрөмж худалдан авах	37	6.9	82	14.1	48	11.9	34	14.2	4	10.3	205	11.4
Төрөөс зээл, татварын хөнгөлөлт үзүүлэх	123	22.9	90	15.5	72	17.9	55	23.0	4	10.3	344	19.1
Хувийн эзэмшлийн хашаа хороотой болох	63	11.8	78	13.4	36	9.0	29	12.1	9	23.1	215	12.0
Бусад	9	1.7	4	0.7	4	1.0	0	0.0	2	5.1	19	1.1
Хариултын тоо бүгд	536	100.0	581	100.0	402	100.0	239	100.0	39	100.0	1797	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	195	-	195	-	149	-	88	-	18	-	645	-
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	30.2	-	30.2	-	23.1	-	14.0	-	2.8	-	100.0	-



Улаанбаатарын бүсэд хувийн эзэмшлийн газар, хашаатай болох явдал эрчимжсэн аж ахуй эрхлэх чухал нөхцөл гэж үзсэн байна.

**Эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд нэн тэргүүнд шаардагдах нөхцөл, боломжийн талаарх салбарын мэргэжилтэн, удирдлагын үнэлгээ**

Хүснэгт 56

№	Хийх ажил	Хариултын тоо	Хариултын дүнд эзлэх хувь	Оролцсон хүний тоонд эзлэх хувь
1.	Малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулах	155	22.9	68.8
2.	Малын тэжээлийн нөөцийг бэхжүүлэх	138	20.4	61.3
3.	Бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлийн орчинг бүрдүүлэх	100	14.8	44.4
4.	Цахилгаан хангамж, зам харилцаа зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх	83	12.3	36.8
5.	Малчдыг өөрийн өмчлөл, эзэмшлийн газартай болгох	81	12.0	36.0
6.	Загвар аж ахуйн оновчтой хэлбэрийг бий болгох	69	10.3	30.6
7.	МАА-г эрхлэх талаар мэргэжлийн зөвлөгөө, сургалт зохион байгуулах	45	6.6	20.0
8.	Бусад	5	0.7	2.2
9.	Хариултын нийт дүн	676	100.0	-
10.	Асуулгад оролцсон мэргэжилтэн, удирдах ажилтны тоо	225		-

Мал аж ахуйн салбарын эрдэмтэн, мэргэжилтэн, орон нутгийн удирдах ажилтан нийт 225 хүнд дээрх асуултыг тавьж хамгийн боломжтой гэж үзсэн 3 хүртэл хариултыг сонгуулахад судалгааны дүн дараахь байдалтай гарсан байна /56 дугаар хүснэгт/.

Салбарын эрдэмтэн мэргэжилтэн, удирдах албаны хүмүүс мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэхэд юуны өмнө малын үүлдэр угсааг сайжруулах (68.8 хувь), малын тэжээлийн нөөцийг бэхжүүлэх (61.3 хувь) шаардлагатай гэсэн саналтай байгаа нь малчдын саналтай нэлээд ойролцоо байна.

**Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд төрөөс ямар дэмжлэг үзүүлэх нь зүйтэй вэ? /хоёр хүртэлх хариултыг сонгох/** гэсэн санал асуултыг удирдах ажилтан, эрдэмтэн, мэргэжилтэн, иргэдээс авахад төрөөс хөнгөлттэй зээл олгох саналыг 86.2%, татвараас эхний 3 жил чөлөөлөх саналыг 73.3% нь өгсөн нь малчдын санал хүсэлттэй нэгэн адил тохирч байна. Иймд эдгээр нөхцөл, боломжуудыг бүрдүүлэхэд онцгой анхаарвал зохино /57 дугаар хүснэгт/.

**Мал аж ахуйг эрчимжүүлэх талаар хөрөнгө оруулалт хийж байгаа иргэн, аж ахуйн нэгжид төрөөс үзүүлэх дэмжлэгийн талаар удирдах ажилтан, эрдэмтэн, мэргэжилтэн, иргэдийн санал**

Хүснэгт 57

Асуулга	Давхардсан тоогоор санал өгсөн хүний тоо	Хариултын дүнд эзлэх хувь	Санал асуулгад оролцогчын дүнд эзлэх хувь
Татвараас эхний 3 жил чөлөөлөх	165	41.9	73.3
Төрөөс хөнгөлттэй зээл олгох	194	49.2	86.2
Ямар ч дэмжлэг үзүүлэх шаардлагагүй, бусдын адилаар байх	18	4.6	8
Бусад	17	4.3	7.6
Хариултын нийт дүн	394	100	-

**10.2. Мал аж ахуйн даатгал**

Мал аж ахуйг эрсдлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх цогц асуудлын дотор малын даатгалын асуудал чухал байр суурь эзлэх ёстой. Бидний явуулсан судалгаагаар малчдын ихэнх нь малын даатгалын талаар тодорхой ойлголтугүй байгаагийн дээр даатгалын байгууллагатай хорогдсон малын талаар яаж тооцоо хийх, малын хорогдлын ямар тохиолдлыг даатгалын нөхөн олговор авах болзол хангасан гэж үзэх зэрэг асуудлаар янз бүрийн саналтай байна. Түүнчлэн даатгалын байгууллагууд ч малын даатгалын төрлийг төдийлөн сонирхохгүй байгаа юм.

Бидний судалгаанд хамрагдсан нийт малчдын 76.9 хувь нь мал сүргээ даатгалд огт хамруулаагүй байлаа /58 дугаар хүснэгт/.

Даатгал хэрэгжихгүй байгаагийн шалтгааныг малчид янз бүрээр илэрхийлсэн байна. Тухайлбал, малчдын 30.9 хувь нь мэдээлэл хомсоос гэсэн бол 32.3 хувь нь санхүүгийн боломж муугаас гэж хариулжээ.

**Малчид мал сүргээ даатгалд хамруулсан байдал**


Хүснэгт 58

Хариулт	Хариултын тоо	Хувь/санал асуулгад орсон өрхөөс/
Бүх малаа даатгалд хамруулсан	77	10.0
Зарим малаа даатгалд хамруулсан	89	11.5
Даатгалд хамруулаагүй	595	76.9
Хариулт өгөөгүй	12	1.6
Дүн	773	100.0

Энэ асуултад насны ялгаагаар хэрхэн хандаж байгааг авч үзэхэд 18-25 насны залуу малчдын 42.9 хувь нь мэдээлэл хомс байна гэсэн бол 50-иас дээш настай малчдын дийлэнх нь санхүүгийн боломж хомс гэсэн хариултыг сонгожээ.

**Малын даатгал хэрэгжихгүй байгаа шалтгаан**

График 31



Бэлчээрийн мал аж ахуйд учрах байгалийн эрсдлийн сөрөг нөлөөллийг бууруулах чухал хүчин зүйлийн нэг нь малын даатгал мөн. Иймд даатгагч, даатгуулагчийн аль алины эрх ашигт нийцүүлэн “Монгол улсын малын даатгалын хууль”-ийг батлуулж мөрдөх цаг болжээ. Малын даатгалын хуулийн төсөлд дараахь хэдэн асуудлыг онцгой анхаарч тусгамаар байна.

Бидний фокус ярилцлагад оролцсон мэргэжилтнүүдийн 50 хувь нь малыг заавал даатгах нь зүйтэй гэж үзсэн байхад малчдын 58 хувь нь сайн дураар даатгах нь зүйтэй гэж үзжээ. Бидний бодлоор одоогийн нөхцөлд сайн дураар болон заавал даатгах хэлбэрийг хослуулах хэрэгтэй.

Даатгалын байгууллага бүх төрөл, нас, хүйсийн малыг даатгалд хамруулах нь зүйтэй гэж үздэг. Гэтэл малчид, мал аж ахуйн зарим мэргэжилтнүүд зөвхөн хээлтэгч, хээлтүүлэгч, сүрэг сэлбэх өсвөр малыг хэсэгчлэн даатгахыг илүүд үздэг.


Бэлчээрийн мал аж ахуйд ган, зуд, байгалийн гэнэтийн аюул, халдварт өвчин зэрэг нь ихээхэн хохирол учруулж ирсэн билээ. Эдгээр хүчин зүйлээс шалтгаалж оны эхний мал хэвийн хэмжээнээс илүү ихээр хорогддог.

Гэхдээ зун нь ган болж, өвөл их хэмжээний цас орж, хэт хүйтрэхэд хорогдож буй мал нь гангаас шалтгаалсан уу, эсвэл их цас орж, хэт хүйтэрснээс болсон уу гэдгийг нарийн зааглан тогтоох нь практикийн хувьд тун төвөгтэй. Манай судалгаанд оролцсон малчид, мэргэжилтнүүдийн 60.4 хувь нь ган, зудаас, 39.4 хувь нь халдварт өвчнөөс малыг даатгах нь зүйтэй гэж санал өгсөн байна.

**Мал сүргийг даатгуулах талаарх таны бодол** гэсэн асуултаар малчдаас хариулт авч дүнг 32 дугаар графикаар нэгтгэн үзүүлэв.

**Малчдын мал даатгуулах талаарх бодол**

График 32



Нөгөө талаар, статистикийн олон жилийн мэдээ, судалгаанд тулгуурлан сум бүрээр, малын төрөл бүрээр хэвийн хорогдлын хэмжээний нормативыг ялгавартай тогтоож, уг хэвийн хэмжээнээс давсан тохиолдолд даатгах, малын даатгалын оновчтой хэлбэр байж болно. Үүнийг гадаад орнуудад индексийн даатгал ч гэж нэрлэдэг билээ. Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг байгалийн эрсдэл, малын даатгалын үүднээс бүсчилж, бүс нутгаар даатгалын ялгавартай механизм бүрдүүлэн хөгжүүлж болох юм. Энэ зарчмыг баримталсан Мал сүргийн даатгалын тухай хуулийн төслийг холбогдох яам, мэргэжлийн байгууллагууд боловсруулж УИХ-д өргөн барьж байгаа нь зөв зүйтэй алхам гэж үзэж байна.

**Даатгалын хураамжийн хувь хэмжээ.** Манай орны өнөөгийн нөхцөлд даатгалын хураамжийн хувь хэмжээг өндөр тогтоох нь даатгалын байгууллагуудад ашигтай ч, малчдад хүндрэлтэй. Уг асуудлыг малчин өрхийн санхүүгийн чадавх, амьжиргааны түвшин, даатгалын байгууллагын хохирол нөхөх, ашигтай ажиллах нөхцөл, боллоцоог харгалзан тогтоох шаардлагатай.

**Даатгалын хураамжийг төлөх хэлбэр, хугацаа.** Монгол Улсын Даатгалын ерөнхий хуулинд даатгалын хураамжийг зөвхөн мөнгөн хэлбэрээр төлнө гэж заасан байдаг. Энэ нь даатгалын байгууллагад илүү зохимжтой. Гэвч малчдын гар дээр тэр бүр бэлэн мөнгө байдаггүй тул даатгалын хураамжийг мал, малын гаралтай түүхий эдзэрэг бодит хэлбэрээр төлөхийг илүү сонирхдог. Энэ нь малчдад ашигтай ч даатгалын байгууллагад гэдгээрийг цуглуулахаас авахуулаад нэлээд бэрхшээлтэй.

Иймд энэ хоёр хэлбэрийг хослуулан хэрэглэхийг санал болгож байна. Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл улирлын чанартай тул малчдын орлого жилийн турш жигд байдаггүй, үүнтэй холбоотойгоор малын даатгалын хураамжийг төлөх бэлэн мөнгөний бололцоо ч жилийн улирлаар ялгаатай.

### 10.3. Мал аж ахуйн төрөлжилт

Мал аж ахуйн төрөлжилт нь уг салбарын хөгжлийн зөв хандлага, эдийн засгийн хамгийн үр өгөөжтэй зохион байгуулалтын нэг болох нь нэгэнтээ дэлхийн мал аж ахуйн хөгжлийн хандлага, түүхээр батлагдсан зүй тогтол юм.

Зах зээлд шилжихээс өмнө Монгол орны мал аж ахуйд төрөлжилт нэлээд эрчимтэй явагдаж байсан юм. Тухайлбал, саалийн механикжсан фермд үхрийг үнээ, эр өсвөр үхэр, өсвөр гунжны суурь болгож маллаж байсан бол бэлчээрийн монгол малын хувьд эр ба охин хурганы, төллөх эм хонины, хуцны суурь гэх мэтээр тусбүрт нь суурилж маллаж байсан. Ингэж малыг нас хүйсээр нь ялгаатай маллах нь уг малын өсөлт хөгжилтөд сайнаар нөлөөлж, малын нас, хүйс тус бүрт тохирсон маллагааны технологийг баримталдаг, нэг төрлийн мал маллах нь малчны хөдөлмөрийг хөнгөвчилж бүтээмжийг нэмэгдүүлдэг, салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлдэг, малчин хүн мэргэшдэг зэрэг олон давуу талтай.

Гэтэл өнөөгийн Монгол орны мал аж ахуйд малыг төрөлжүүлэн маллах ажиллагаа хуц ухныг тусад нь суурилан маллаж байгааг эс тооцвол үндсэндээ устаж үгүй болсон байна.

Сүүний чиглэлээр үхэр үржүүлж байгаа ихэнх малчид тугалаа бяруу болмогц хүнсэнд хэрэглэдэг учрыг тодруулан асуухад тугал, бяруу, шүдлэнг тэжээх тэжээл худалдан авах санхүүгийн боломж байхгүй, өсвөр үхэр тэжээснээс үнээгээ тэжээж хэдэн литр сүү илүү зарах нь өнөөгийн хамгийн чухал хэрэгцээ болоод байна гэж голчлон тайлбарлаж байв. Энэ бол мал аж ахуйд төрөлжилт байхгүй болсны тод жишээ, цаашлаад цэвэр, эрлийз үүлдрийн өсвөр гунжин үнээ өсч бойжих боломжгүй болж байгааг харуулж байна.

### 10.4. Дигнэлт

1. Мал аж ахуйг тодорхой бүс нутагт эрчимжсэн аргаар эрхлэх боломж байгааг малчид үгүйсгэхгүй байна. Тэд ялангуяа төвийн болон томоохон хот орчмын бүсэд эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх бүрэн боломжтой гэж үзжээ.

2. Эрчимжсэн мал аж ахуйг тухайн бүс нутгийн онцлог, нөхцөл, боломжид нийцүүлэн тодорхой салбаруудыг хосолсон, төрөлжсөн хэлбэрээр эрхлэх талаарх малчдын санал, дүгнэлт энэ талаарх эрдэмтэд, судлаачдын дүгнэлттэй үндсэндээ нийцэж байна. Тэгэхдээ өндөр ашиг шимтэй нутгийн шилмэл омгийн малыг бэлчээрийн мал аж ахуй эрхлэх бүсэд, цэвэр үүлдрийн малыг тэжээлийн нөөц сайтай газар тариалангийн бүсэд өсгөн үржүүлэхийг эрчимжилтийн чухал нөхцөл гэж дүгнэжээ.

3. Мал сүргийн даатгалыг индексжүүлсэн хэлбэрт шилжүүлэх нь малчид, даатгалын байгууллагын эрх ашигт нийцнэ гэж үзнэ.

4. Манайд малыг төрөлжүүлэн маллах, өсгөж үржүүлэх үйл ажиллагаа бог малын хээлтүүлэгчийг ялгаж маллаж байгааг эс тооцвол үндсэндээ устаж үгүй болсон байна. Цаашид малыг төрөлжүүлэн өсгөж үржүүлэх, энэ чиглэлээр малчдыг хорших, хамтран ажиллахад суралцуулах ажлыг төрөөс дэмжиж чиглүүлэх.

5. Өндөр ашиг шимтэй цэвэр, эрлийз малыг чиглэлтэй өсгөн бойжуулах талаар төр, засгаас зориуд бодлого боловсруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллага бий болгох.

## АРВАННЭГДГЭЭР БҮЛЭГ:

### АМЬЖИРГААНЫ ТАЛААРХ МАЛЧДЫН САНАА БОДОЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ


Сүүлийн жилүүдэд малчдын амьжиргааны түвшинд өөрчлөлт орсон эсэхийг тэдний нас, боловсрол, ам бүл, бүсийн ялгаатайгаар уялдуулан судалсан юм.

Судалгаанд оролцсон 762 малчны 58.4 хувь нь сүүлийн 3 жилийн хугацаанд амьжиргаандаа ямар нэгэн өөрчлөлт ороогүй хэвийн; 28.3 хувь нь амьжиргаа нь дордсон гэж хариулсан байхад, 13.1 хувь нь сайжирсан гэж хариулжээ /33 дугаар график/.

#### 11.1. Малчдын амьжиргааны түвшний өөрчлөлт

Малчдын амьжиргааны өөрчлөлт

График 33



Малчдын амьжиргаанд гарсан өөрчлөлтийг тэдний боловсролын түвшинтэй холбон судалж үзэхэд дээд боловсролтой малчдын 25.8 хувь нь амьжиргаагаа сайжирсан гэж тодорхойлсон нь амьжиргаа сайжирсан гэсэн хариултын ерөнхий дунджаас 2 гаруй дахин их байна. Гэтэл бага боловсролтой малчдын 11.3 хувь нь сайжирсан гэсэн бол 38.3 хувь нь муудсан гэсэн хариулт өгчээ /59 дүгээр хүснэгт/.

Малчид өөрсдийн амьжиргааны өөрчлөлтийг дүгнэсэн байдал

Хүснэгт 59

Хариулт	Малчдын боловсролын түвшин									
	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага		Дүн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Сайжирсан	8	25.8	9	12.0	65	12.9	15	11.3	97	12.8
Хэвийн	17	54.8	50	66.7	299	59.6	67	50.4	433	58.3
Муудсан	6	19.4	16	21.3	137	27.3	51	38.3	210	28.8
Хариулаагүй	0	0.0	0	0.0	1	0.2	0	0.0	1	0.1
Дүн	31	100.0	75	100.0	502	100.0	133	100.0	741	100.0

Эндээс мал маллахад ч малчдын боловсрол чухал нөлөөтэй хүчин зүйл гэдэг нь харагдаж байна. Иймд малчдад зориулсан сургалтын хэрэгцээ, шаардлага, хөтөлбөр, арга хэлбэрийг тодорхой болгож хэрэгжүүлж эхлэхгүй бол тэдний “өнөөдөр болж байна, цаашид ч энэ байдлаар болоод байна” гэсэн нэгэн хэвийн хэвшмэл сэтгэлгээ хэвээрээ байх болно.

“Сүүлийн 3 жилд таны амьжиргааны түвшинд өөрчлөлт орсон уу?” гэсэн асуултад малчид эдийн засгийн бүсийн байршлын ялгаанаас хамаарч харилцан адилгүй хариулт өгчээ /60 дугаар хүснэгт/.

Малчдын амьжиргааны өөрчлөлт /бүсээр/

Хүснэгт 60

Хариулт	Нэг хүнд ногдох малын тооны бүлэглэлт /богоор/										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Сайжирсан	18	7.2	26	12.4	12	7.3	33	28.9	8	42.1	97	12.8
Хэвийн	149	59.6	96	45.9	119	72.1	66	57.9	11	57.9	441	58.3
Муудсан	83	33.2	87	41.6	34	20.6	14	12.3	0	0.0	218	28.8
Хариулаагүй	0	0.0	0	0.0	0	0.0	1	0.9	0	0.0	1	0.1
Дүн	250	100.0	209.0	100.0	165.0	100.0	114.0	100.0	19.0	100.0	757.0	100.0

Энэ асуултад нийт 757 малчин хариулт өгснөөс 250 нь буюу 33.0 хувь нь хангайн, 209 нь буюу 27.6 хувь нь баруун, 165 нь буюу 21.8 хувь нь төвийн, 114 нь буюу 15.1 хувь нь зүүн, 19 нь буюу 2.5 хувь нь Улаанбаатарын бүсийн малчид байв. Судалгаанд хамрагдсан малчдын хариултаас үзэхэд Төвийн бүсийн малчдын 72.1 хувь нь амьжиргаагаа хэвийн түвшинд, Улаанбаатар орчмын бүсийн малчдаас амьжиргаа нь муудсан гэсэн хариулт өгөөгүй байхад, Баруун бүсийн малчдын 41.6 хувь нь муудсан гэж хариулжээ. Үүнийг өнөөгийн хот, хөдөөгийн оршин суугчдын амьдралын ялгаатай байдлын тод томруун тусгал гэж үзэж болно.

Малчдын амьжиргаанд тэдний ам бүлийн тоо төдийлөн нөлөө үзүүлэхгүй гэж тэд хариулжээ. Өөрөөр хэлбэл, цөөн болон олон ам бүлтэй малчдын амьжиргаанд сүүлийн жилүүдэд гарсан өөрчлөлтүүд нь хоорондоо тун ойролцоо байсан судалгааны дүн гарсныг дурдаж байна.


Улс орон зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойшх хугацаанд малчид нөхцөл байдалд хэрхэн хувирч ажил амьдралаа зохион байгуулж байгааг тодруулах зорилгоор тэднээс **“Зах зээлд шилжсэнээс хойш мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг харгалзан аж ахуйгаа хэрхэн зохицуулж байна вэ?”** гэсэн асуулт тавьж хариулсан дүнг 34 дугаар графикаар харуулав.

Судалгаанд оролцсон нийт малчдын 24.3 хувь нь мал сүргийн бүтэц, тоо, толгойг өөрчилсөн, 22.2 хувь нь малын үүлдэр, угсааг сайжруулах талаар зарим нэг оролдлого хийж байгаа, 17.4 хувь нь борлуулах аргаа өөрчилсөн гэж хариулсан байна.

Сүргийн бүтэц өөрчилсөн гэдэгт гол төлөв ямааны тоог нэмэгдүүлсэн, эсвэл өөрийн эрхлэж чадах чиглэлийн дагуу аль нэг төрлийн малыг түлхүү үржүүлэх болсон, тухайлбал хот сууринд ойр малчид сүүний үхэр үржүүлэх, айраг үйлдвэрлэх чиглэлээр адуугаа өсгөсөн зэргийг нэрлэж байлаа. Малын үүлдэр угсааг яаж сайжруулж байгаа талаар малчдаас асууж тодруулахад зэргэлдээ аймаг, сумаас хээлтүүлэгч мал авчирч мал сүрэгтээ ашиглаж байгааг голчлон өгүүлж байлаа.

Малчид зах зээлд шилжсэнээс хойш аж ахуйгаа хэрхэн зохицуулан эрхэлж байгаа байдал

График 34




Нийт малчдын 18.9 хувь нь зах зээлд зохицуулж мал аж ахуйгаа эрхэлж чадахгүй байна гэж хариулсан байна.

Малчдын хувьд мал аж ахуйгаас өөр амьжиргааны эх үүсвэр байгаа эсэх, цаашид мал маллахаа болих эсэхийг тандан судлах зорилгоор **“Ямар тохиолдолд та мал маллахаа болих вэ?”/зөвхөн нэг хариулт өгнө/** гэсэн асуултыг тэдэнд тавьсан юм /35 дүгээр график/.

**11.2. Мал маллахаас өөр амьжиргааны сонголтын талаарх малчдын ойлголт**

**Малчид мал маллахаа болих тохиолдол**

График 35



Судалгаанд хамрагдсан малчдын 47.5 хувь нь ямар ч тохиолдолд малаа орхихгүй гэсэн хариулт сонгожээ. Үүний зэрэгцээ тэд малаа ган, зудад алдаж хорогдуулсан (25.3 хувь), хүүхэддээ боловсрол, мэргэжил эзэмшүүлэхийн тулд (14.6 хувь) мал аж ахуйг цаашид эрхлэхээс татгалзаж болох юм гэж хариулжээ. Түүнчлэн мал аж ахуйгаас өөр хөдөлмөр эрхлэх бодолтой малчин тийм ч олон бус (9.0 хувь) байгаагаас үзэхэд малчдын дийлэнх нь ойрын үед мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхээс шууд татгалзах бодолгүй байна.

Нэг хүнд ногдох малын тоо нэмэгдэх тутам малаа орхихгүй гэсэн хариулт сонгосон малчдын тоо нэмэгдэж байгаа бөгөөд нэг хүнд ногдох малын тоо 151-ээс дээш малтай малчдын 61 орчим хувь нь ингэж хариулсан байна.

Хүүхдээ боловсролтой болгохын тулд мал маллахаас татгалзана гэсэн хариултыг дээд болон тусгай дунд боловсролтой малчдын 23.6-25.8 хувь нь буюу бараг 1/4 нь сонгожээ.

**Малчдын мал маллахаа болих тохиолдол**  
/малчдын боловсролын түвшингээр/

Хүснэгт 61

Хариулт	Малчдын боловсролын түвшин								Дүн	
	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага			
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Малаа хорогдуулсан тохиолдолд	4	12.9	17	23.6	143	28.9	18	13.7	182	25.0
Төв, суурин газарт боломжийн ажил олдвол	4	12.9	2	2.8	39	7.9	19	14.5	64	8.8
Хүүхдээ боловсролтой болгохын тулд	8	25.8	17	23.6	66	13.4	17	13.0	108	14.8
Ямар ч тохиолдолд малаа орхихгүй	15	48.4	33	45.8	231	46.8	67	51.1	346	47.5
Бусад	0	0.0	3	4.2	15	3.0	10	7.7	28	3.9
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	31	100.0	72	100.0	494	100.0	131	100.0	728	100.0

Аливаа бизнесийн үйл ажиллагааны эцсийн үр дүн нь урьдчилан тодорхойлсон бизнесийн зорилго, түүнийг хэрэгжүүлэхэд бүх нөөц, хүчээ төвлөрүүлэхээс шалтгаалдаг билээ. Бид малчдаас тэдний бизнесийн зорилго юу болох талаар асуухад судалгаанд хамрагдсан малчдын 61.5 хувь нь “малаа өсгөх”, 49.0 хувь нь “малынхаа үүлдэр, угсааг сайжруулах” гэж хариулжээ. Үүнээс үзэхэд малчид одоо ч ашиг орлогоо нэмэгдүүлэхэд малынхаа тоог өсгөх явдлыг чухал хүчин зүйл гэж үзсээр байна. Бэлчээрийн даац, хүрэлцээ муудаж байгаа өнөө үед малын тоог хэт өсгөх нь малчин өрхийн аж ахуйд ч, улс орны хэмжээнд ч бодолцох асуудлын нэг бөгөөд цаашид малын үүлдэр, угсааг сайжруулах замаар өндөр ашиг шимтэй, цөөн малтай байхыг малчид илүү их сонирхох болно гэх үндэстэй.

**“Хэрэв Та малгүй болсон тохиолдолд доорх арга замаас алийг нь сонгох вэ?” /ач холбогдлоор нь эрэмбэлэн 3 хүртэлх хариултыг сонгох/** гэсэн асуултад 751 малчин нийт 1976 хариулт өгсний 386 хариулт буюу 16.1 хувь нь л хот, суурин газар шилжиж өөр ажил эрхэлнэ гэж хариулсан нь тэдний мал маллах ажлаасаа хөндийрөх төдийлөн сонирхолгүй байгаа тухай бидний дээрх дүгнэлтийг давхар нотолж байна /62 дугаар хүснэгт/.

**Малгүй болсон тохиолдолд малчдын зүгээс хийх сонголт**  
Хүснэгт 62

Хариулт	Нэг хүнд ногдох малын тооны бүлэглэлт /богоор/										Хариулын дүн	
	0-20		21-40		41-70		71-150		150-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Зээл авах	110	20.0	106	20.2	94	21.0	68	19.4	22	21.2	400	20.2
Ах дүү хамаатнаасаа тусламж хүсэх	98	17.8	102	19.5	84	18.8	84	23.9	18	17.3	386	19.5
Хот, суурин газар шилжиж өөр ажил эрхлэх	73	13.3	93	17.7	79	17.7	54	15.4	19	18.3	318	16.1
Байгалийн баялаг ашиглах	95	17.3	83	15.8	75	16.8	47	13.4	11	10.6	311	15.7
Улсаас тусламж хүсэх	88	16.0	72	13.7	67	15.0	59	16.8	19	18.3	305	15.4
Хөлсөөр мал маллах	86	15.6	68	13.0	48	10.7	39	11.1	15	14.4	256	13.0
Хариултын тоо бүгд	550	100.0	524	100.0	447	100.0	351	100.0	104	100.0	1976	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	208	-	187	-	169	-	142	-	45	-	751	-
Асуулгад оролцсон малчин өрхийн нийт тоонд эзлэх хувь	27.7	-	24.9	-	22.5	-	18.9	-	6.0	-	100.0	-

Малчид малгүй болсон тохиолдолд хамгийн түрүүнд зээл авч өөр ажил төрөл эрхлэхийг сонирхож байгаа нь чухал хандлага юм. Сүүлийн үед банк, санхүүгийн байгууллагын тогтолцоо хамрах хүрээгээ тэлж, үйл ажиллагаа нь хөдөө рүү чиглэх нааштай эхлэл ажиглагдах болсон нь малчдад ач тустай үйл явц болж байна.

62 дугаар хүснэгтээс харахад малгүй болсон тохиолдолд ах дүү, хамаатнаасаа тусламж хүснэ гэсэн хариултыг малчдын нэлээд хэсэг нь сонгосон нь тэд бас л “бэлэнчлэх” сэтгэлгээнээс салаагүй болохыг нотолж буй хэрэг юм.

Цаашид мал аж ахуйн салбарт бизнес үйл ажиллагаа явуулах байгууллага, аж ахуйн нэгжийн тоо улам бүр нэмэгдэж үүний улмаас хөлсний малчны тоо өсөх, өөрийн өрхийн малыг маллах малчны тоо цөөрөх хандлага ажиглагдах болсон өнөө цагт малгүй болсон тохиолдолд бусдын мал маллах сэтгэл зүйн бэлтгэл малчдад төдий л бүрдээгүй байгаа бололтой. Тухайлбал, малгүй болсон тохиолдолд хэрхэх тухай малчдын нийт хариултын 13.0 хувийг л хөлсөөр мал маллах гэсэн хариулт эзэлж байна.




Бусдын малыг хөлсөөр хариулах тухайд одоогоор нарийвчилсан тооцоо, тогтоосон хөлс тариф байхгүй, өөр хоорондоо тохиролцох байдлаар зохицуудагдаж байна.

Малчин өрх малгүй болсон тохиолдолд ямар сонголт хийх нь тэдний нэг хүнд ногдох малын тооноос хамаарч төдийлөн өөрчлөгдөхгүй байна. Харин нэг хүнд ногдох малын тоо буурах тусам байгалийн баялаг ашиглана гэж хариулсан малчдын тоо нэмэгдэх хандлагатай байна. Үүнийг 36 дугаар графикаар харуулав.

**Малгүй болсон тохиолдолд байгалийн баялаг ашиглах эрмэлзлийн байдал /хувиар/**

График 36



Харьцангуй олон малтай малчид нь мал маллах арга, туршлага, хөдөлмөрч чанараараа цөөн тоотой малчдаас илүү учир тэд малгүй болсон тохиолдолд байгалийн баялаг ашиглах явдлыг гол сонголт гэж үзэхгүй байна. Харин цөөн малтай малчид нь аль болох бэлэн зүйл буюу байгалийн баялаг ашиглах замаар тулгамдсан асуудлыг шийдэх гэж эрмэлзэж байх шиг байна.

Малчдын амьжиргааг сайржуулах арга зам, орлогын өөр ямар эх үүсвэр байж болох, цөөн малтай, орлого багатай малчдын асуудлыг цаашид яаж шийдвэрлэх зэрэг асуудлын талаар төр, засгаас цаашид ямар ажил хийвэл үр дүнтэй байх тухай мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтэн, удирдах ажилтнуудын саналыг авч судалгаа хийв.


**Малчдын амьжиргааг сайржуулах талаар ямар ажил хийвэл зохистой вэ? /боломжтой гэж үзсэн 3 хүртэлх хариултыг өгнө/** гэсэн асуултад хариулсан салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, удирдах ажилтны 28.3 хувь нь малчдын амьдрах чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, 24.3 хувь нь малчдын хашаа, хороо, гэжээл, усан хангамжид дэмжлэг үзүүлэх хэрэгтэй гэж хариулсан байна /37 дугаар график/.

Харин эрдэмтэн, мэргэжилтэн, удирдах ажилтнууд цөөн малтай иргэдэд мал зээлээр олгох эсвэл тусламжаар олгох асуудал дээр зарчмын ялгаатай хариулт өгч байв. Тухайлбал, судалгаанд оролцогсдын 64 хувь нь малгүй буюу цөөн малтай иргэдэд зээлээр мал олгохыг зүйтэй гэсэн байхад малчдад тусламжаар мал олгохыг тэдний дөнгөж 19.4 хувь нь л дэмжсэн байна. Малчдад биет байдлаар шууд дэмжлэг үзүүлэх нь тэдний бэлэнчлэх сэтгэлгээг өөгшүүлсэн, үр дүнгүй ажил болно гэж олон хүн өгүүлж байв.

**11.3. Малчдын амьжиргааг сайржуулах, орлого нэмэгдүүлэх талаарх иргэдийн бодол**

**Малчдын амьжиргааг сайжруулах талаар хийвэл зохих ажил**  
*/Удирдах ажилтан, мэргэжилтний санал/*

График 37



Малчдад мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ орлогоо нэмэгдүүлэх өөр ямар боломж байж болох талаар малчдаас өөрсдөөс нь болон удирдах ажилтан, эрдэмтэн, мэргэжилтнүүдээс **“Малчдад мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ орлого олох өөр боломж бий юу?”** /Ач холбогдлоор нь эрэмбэлэн, хамгийн боломжтой гэж үзсэн 2 хүртэл хариултыг сонгоно уу?/ гэсэн асуулт тавьж дүнг 63 дугаар хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Судалгаанд оролцсон удирдах ажилтан, мэргэжилтэн нарын 78.7 хувь нь малчид мал маллахын зэрэгцээ төмс, хүнсний ногоо тариалах, 75.5 хувь нь хадлан тэжээл бэлтгэх, 41.8 хувь нь байгалийн баялаг ашиглах боломжтой гэж хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй хариултауд болсон байна.

Харин малчдын 37.4 хувь нь төмс, хүнсний ногоо тариалах, 33.9 хувь нь мал аж ахуй эрхлэхээс өөр орлого олох боломж байхгүй, 31.7 хувь нь худалдаа наймаа хийх гэсэн хариултаудыг сонгосон нь хамгийн өндөр давтамжтай үзүүлэлтүүд болсон байна.

Мал маллахын хажуугаар өөр ажил эрхлэх боломжгүй, малын хариулга онцгой чухал учраас ялангуяа хүн бүл багатай малчин өрх өөр ажил эрхлэх ямар ч боломжгүй гэж олон малчин ярьж байлаа.

Малчид мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ орлого олох өөр боломжийн талаар салбарын мэргэжилтэн, удирдах ажилтан болон малчдын санаа бодол ихээхэн зөрүүтэй байгаа нь бидний судалгаагаар тогтоогдож байна. Тухайлбал, салбарын мэргэжилтэн, удирдах ажилтан нарын 78.7 хувь нь малчид төмс, хүнсний ногоо тариалах боломжтой гэж үзсэн байхад малчдын дөнгөж 37.4 хувь нь уг ажлыг хийж болох юм гэж үзсэн байна. Түүнчлэн салбарын мэргэжилтний 36.5 хувь нь малчид мал маллахын зэрэгцээ туслах аж ахуй эрхэлж болно гэж үзсэн бол малчдын 12.0 хувь нь л уг ажлыг эрхэлж болно гэжээ. Түүгээр ч барахгүй малчдын 33.8 хувь нь мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ өөр ажил хийх ямар ч боломжгүй гэж хариулсан байна. Энэ бүхнээс үзэхэд малчдыг орлогын өөр боломж хайх үйл ажиллагаанд сургах, сэдээх нөхцөл боломжийг бүрдүүлэх талаар онцгой анхаарах шаардлага тавигдаж байна.

**Малчдын амьжиргааг дээшлүүлэхэд мал аж ахуйгаас өөр орлогын ямар эх үүсвэр боломжтой гэж үздэг вэ?**  
*/Малчид, удирдах ажилтан, мэргэжилтний санал/*


Хүснэгт 63

Хариулт	Хариултын эрэмбэ	Хариултын тоо		Нийт хариултын дүнд эзлэх хувь		Нийт оролцогчийн дүнд эзлэх хувь	
		Малчин	Бусад	Малчин	Бусад	Малчин 770	Бусад 225
Төмс, хүнсний ногоо тариалах	1	202	135	17.2	22.4	26.2	60.0
	2	82	26	7.0	4.3	10.6	11.6
	3	4	16	0.4	2.7	0.5	7.1
	Дүн	288	177	24.6	29.4	37.4	78.7
Хадлан, тэжээл бэлтгэх	1	-	57	-	9.5	-	25.3
	2	-	91	-	15.1	-	40.4
	3	-	22	-	3.6	-	9.8
	Дүн	-	170	-	28.2	-	75.6
Байгалийн баялаг ашиглах	1	99	14	8.5	2.3	12.9	6.2
	2	98	42	8.4	7.0	12.7	18.7
	3	27	38	3.2	6.3	3.5	16.9
	Дүн	224	94	19.1	15.6	29.1	41.8
Худалдаа, наймаа хийх	1	98	3	8.3	0.5	12.7	1.3
	2	124	24	10.6	4.0	16.1	10.7
	3	23	47	2.0	7.8	3.0	20.9
	Дүн	245	74	20.9	12.3	31.8	32.9
Гахай, шувуу зэрэг туслах аж ахуй эрхлэх	1	31	5	2.6	0.8	4.0	2.2
	2	52	24	4.4	4.0	6.8	10.7
	3	10	53	0.9	8.8	1.3	23.6
	Дүн	93	82	7.9	13.6	12.1	36.4
Мал аж ахуйгаас өөр орлого олох ямар ч боломж байхгүй	1	209	-	17.8	-	27.1	-
	2	39	-	3.3	-	5.1	-
	3	13	-	1.2	-	1.7	-
	Дүн	261	-	22.3	-	33.9	-
Бусад	1	19	3	1.6	0.5	2.5	1.3
	2	37	2	3.2	0.35	4.8	0.9
	3	4	2	0.3	0.35	0.5	0.9
	Дүн	60	7	5.1	1.2	7.8	3.1
Нийт дүн	-	1171	603	100.0	100.0	100.0	100.0

Мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ орлого олох өөр боломжийн талаар малчид, салбарын мэргэжилтэн, удирдах хүмүүсийн өгсөн хариултын дүнг тоймлон 38 дугаар графикаар үзүүлэв.

**Мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ орлого олох өөр боломж**  
*(малчид, салбарын ажилтны санал)*

График 38



Мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ орлого олох боломжийн талаарх малчдын хариулт нь бүс нутгийн байдлаас хамаарч нэлээд өөрчлөгдөж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, хангайн бүсийн малчдын 45.7 хувь нь байгалийн баялаг ашиглах боломжтой гэсэн байхад энэ сонголтыг зүүн бүсийн малчдын дөнгөж 16.3 хувь нь сонгож, 52.3 хувь нь өөр ажил хийх боломжгүй гэсэн хариултыг сонгосон байна. Төвийн бүсийн малчдын 25.5 хувь нь байгалийн баялаг ашиглах гэсэн хариултыг сонгосон. Энэ бүхэн нь малчдын мал аж ахуйгаас өөр ашиг орлого олох боломж нь бүс нутаг, байгаль, цаг уур, байгалийн баялгаас шалтгаалж байгааг харуулж байна.

2003 оны эхний байдлаар Монгол улсад 100 хүрэхгүй толгой малтай өрх 168.0 мянга байгаа нь нийт малтай өрхийн 69.1 хувийг эзэлж байна. Эдгээр өрхийн дотор мал аж ахуйгаас өөр орлогогүй, ядуу болон нэн ядуу өрх олон бий. Тэдгээрийн амьжиргааг ямар аргаар хэрхэн сайжруулах тухай асуудал анхаарал татаж байгаа юм. Энэ талаар салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, удирдах ажилтнууд ямар бодолтой байгааг тодорхойлох зорилгоор тэднээс **“Цөөн малтай, орлого багатай малчид амьжиргааны ямар сонголт хийх нь зохистой вэ? /хоёр хүртэл хариултыг сонгох/”** гэсэн асуултаар санал авч дүнг 64 дүгээр хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Давхардсан хариултаар тооцвол санал асуулгад оролцогсдын 65.8 хувь нь малаа өсгөх нь зүйтэй, 50.7 хувь нь малчид өөрсдөө зах зээлд зохицож амьдрах ёстой гэсэн саналыг хэлсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Өөрөөр хэлбэл ядуу, нэн ядуу амьдралтай малчид малаа өсгөх буюу өөр арга хэлбэрээр өөрсдөө л амьжиргаагаа сайжруулах ёстой гэсэн санал дийлэнх хувийг эзэлж байна. Цөөн малтай малчдад тусламж дэмжлэг олгох гэсэн хариултыг оролцогсдын 32 хувь нь сонгосон бол цөөн малтай малчдыг мал аж ахуйгаас өөр ажил эрхлүүлэх санал 16.9 хувь, мал аж ахуйг орхиж хот сууринд шилжүүлэх ёстой гэсэн санал 3.1 хувийг эзэлж байна. Малчдад тусламж үзүүлэх, хот сууринд шилжүүлэх зэрэг төрийн зохицуулалттай үйл ажиллагааг салбарын мэргэжилтэн, удирдах ажилтнууд төдийлөн таашаахгүй байна.

**Орлого хангалтгүй, цөөн малтай малчид амьжиргааны ямар сонголт хийх нь зохистой вэ?**

*/Удирдах ажилтан, мэргэжилтний санал/*


Хүснэгт 64

Асуулга	Санал өгсөн хүний тоо	Нийт 432 хариултад эзлэх хувь	Санал асуулгад оролцсон 225 хүнд эзлэх хувь
Малаа өсгөх	148	34.3	65.8
Бусдын мал хөлсөөр хариулах	48	11.1	21.3
Мал аж ахуйгаас өөр ажил эрхлэх	38	8.8	16.9
Тусламж дэмжлэг олгох	72	16.7	32.0
Малчид өөрсдөө зах зээлд зохицож амьдрах	114	26.4	50.7
Тэд мал аж ахуйг орхиж хот сууринд шилжиж амьдрах	7	1.6	3.1
Мэдэхгүй	2	0.5	0.9
Бусад	3	0.6	1.3
Бүгд	432	100.0	

**Орлого хангалтгүй, цөөн малтай малчид амьжиргааны ямар сонголт хийх нь зохистой вэ?**

/Удирдах ажилтан, мэргэжилтний санал/

График 39



Малчин өрхийн хувьд амьжиргаагаа тогтвортой байлгах гол арга байгалийн бэрхшээлээс хараат байдлаа аль болох багасгах, мал аж ахуйгаа эрсдлээс хамгаалах явдал юм. Энэ талаар малчдын бодол санааг тодорхойлох зорилгоор **“Бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс хамгаалахын тулд та юу хийх вэ?”** гэсэн асуулт тавьж үр дүнг 65 дугаар хүснэгтээр үзүүлэв.

Асуултад хариулсан малчдын 73.7 хувь нь отор нүүдэл хийх, 68.7 хувь нь хадлан тэжээл бэлтгэх, 55.4 хувь нь малаа чанаржуулах гэсэн хариултыг сонгосон нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

**Бэлчээрийн мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах талаарх малчдын санаа бодол**

Хүснэгт 65

Үзүүлэлт	Хариултын эрэмбэ	Хариултын тоо	Нийт хариултын дүнд эзлэх хувь	Нийт 773 оролцогчийн дүнд эзлэх хувь
Отор нүүдэл хийх	1	412	19.5	53.2
	2	120	5.7	15.5
	3	38	1.8	4.9
	дүн	570	27.0	73.7
Хадлан тэжээл бэлтгэх	1	154	7.3	19.9
	2	304	14.4	39.3
	3	73	3.5	9.4
	дүн	531	25.2	68.7
Малаа чанаржуулах	1	95	4.5	12.3
	2	152	7.2	19.7
	3	181	8.6	23.4
	дүн	428	20.3	55.4
Мөнгө санхүүгийн бэлтгэлтэй байх	1	22	1.1	2.8
	2	75	3.5	9.7
	3	137	6.5	17.7
	дүн	234	11.1	30.3
Суурин ба хагас суурин хэлбэрт шилжих	1	19	0.9	2.5
	2	42	2.0	5.4
	3	108	5.1	14.0
	дүн	169	8.0	21.9
Малаа даатгуулах	1	30	1.4	3.9
	2	28	1.3	3.6
	3	94	4.5	12.2
	дүн	152	7.2	19.7
Бусад	1	9	0.4	1.2
	2	1	0.05	0.1
	3	14	0.65	1.8
	дүн	24	1.1	3.1
Дүн	-	2108	100.0	100.0

Ер нь малаж ахуйг тогтвортой, эрсдлээс хамгаалагдсан байдлаар эрхлэхэд юуны өмнө малын тарга хүчийг сайн авахуулах отор нүүдэл хийх, тэжээлийн нөөц бэлтгэх асуудал хамгийн чухал гэж малчид үзэж байгаа нь янз бүрийн асуулт, судалгааны үр дүнгээр нотлогдсоор байна.

**11.4. Хүүхдийнхээ ирээдүйн талаарх малчдын бодол**

Малчид өөрсдийнхөө үр хүүхдийн ирээдүйн талаар ямар санаа бодолтой байгааг тодруулах зорилгоор тэднээс **“Хүүхдийнхээ ирээдүйн талаарх Таны бодол?” /хоёр хүртэлх хариултыг сонгоно уу?/** гэсэн асуултаар саналыг нь авав. Судалгаанд оролцсон нийт 730 малчин 1305 хариулт өгсөн байна. Нийт хариултын 43.4 хувийг сайн боловсрол эзэмшүүлэх, 35.0 хувийг хүүхдүүд өөрсдөө шийдэг, 12.7 хувийг өөрийн ажлыг залгамжлах малчин болгох, 7.4 хувийг фермерийн аж ахуйн эзэн болгох гэсэн хариулт тус тус эзэлсэн байна. Үүнээс үзэхэд үр хүүхдээ боловсрол эзэмшүүлэх нь зүйтэй гэдэгт малчдын олонх нь санал нэгтэй байгаа нь харагдаж байна. Малчин хүний өөрийнх нь эзэмшсэн боловсролын түвшин нэмэгдэх тутам тэдний үр хүүхдээ сайн боловсрол эзэмшүүлэх ёстой гэсэн бодол өсөх хандлагатай байна. Тухайлбал дээд боловсролтой малчдын 50.9 хувь нь хүүхдүүдээ сайн боловсролтой болгох гэсэн хариултыг сонгосон байхад дунд бага боловсролтой малчдын 40.2-43.3 хувь нь дээрх хариултыг сонгосон байна.

Нийт хариултын 77.7 хувь нь хүүхдүүдээ сайн боловсрол эзэмшүүлэх, амьдралаа өөрсдөө шийдэхийг илүүд үзэж үр хүүхдээ мал аж ахуйтай холбоод байх сонирхол бараг үгүй байна. Энэ нь дийлэнх малчин өрхийн малын тоо толгой цөөн, мал аж ахуйгаас олсон орлого амьдрал ахуйд нь төдийлөн хүрэлцээтэй биш байгаатай холбоотой /66 дугаар хүснэгт/.

**Хүүхдийн ирээдүйн талаарх малчдын бодол**

Хүснэгт 66

Хариулт	Малчдын боловсролын түвшин								Дүн	
	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Өөрийн ажлыг залгамжлах малчин болгох	5	8.8	10	7.7	117	13.0	34	15.5	166	12.7
Фермерийн аж ахуйн эзэн болгох	3	5.3	5	3.8	73	8.1	16	7.3	97	7.4
Хүүхдүүд өөрсдөө шийдэг	20	35.1	51	39.2	309	34.4	77	35.2	457	35.0
Сайн боловсрол эзэмшүүлэх	29	50.9	60	46.2	389	43.3	88	40.2	566	43.4
Бусад	0	0.0	4	3.1	11	1.2	4	1.8	19	1.5
Хариултын тоо бүгд	57	100.0	130	100.0	899	100.0	219	100.0	1305	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	31		74		496		129		730	

Малчдын ахуй байдалдаа сэтгэл ханамжтай байгаа эсэхийг тодорхойлох гол зүүллэлтийн нэг нь хүүхдүүдийн боловсролын асуудал гэж үзэж болохоор байна.

Хүүхдийн ирээдүйн асуудлаар малчидтай ярилцаж байхад тэдний зарим нь нэг хүүхдээрээ малаа маллуулж голомтоо сахиулах, бусад нь өөрсдийнхөө хүсэл сонирхлоор ажил төрлөө эрхлэх хэрэгтэй гэж байхад нөгөө хэсэг нь ерөөсөө өөрсдөө л шийдэг гэх мэтээр янз бүрийн бодолтой байлаа.

Малчид үр хүүхдийнхээ ирээдүйн талаар ямар бодолтой байгааг тэдний өрхийн ам бүлийн тооноос хамааруулан судалж үзэхэд 2-5 ам бүлтэй өрхийн малчдын хариултын 12.4 хувь нь, 6-8 ам бүлтэй өрхийн хариултын 13.3 хувь

нь, 9-10 ам бүлтэй өрхийн хариултын 7.9 хувь нь үр хүүхдийнхээ аль нэгийг өөрийн ажлыг залгамжлах малчин болгох гэсэн байна /67 дугаар хүснэгт/.

**Хүүхдийн ирээдүйн талаарх малчдын бодол**

Хүснэгт 67

Хариулт	Ам бүлийн бүлэглэл						Дүн	
	2-5		6-8		9-10			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Өөрийн ажлыг залгамжлах малчин болгох	113	12.4	53	13.3	3	7.9	169	12.6
Фермерийн аж ахуйн эзэн болгох	74	8.1	25	6.3	2	5.3	101	7.5
Хүүхдүүд өөрсдөө шийдэг	312	34.3	145	36.4	16	42.1	473	35.2
Сайн боловсрол эзэмшүүлэх	395	43.5	171	43.0	17	44.7	583	43.3
Бусад	15	1.7	4	1.0	0	0.0	19	1.4
Хариултын тоо бүгд	909	100.0	398	100.0	38	100.0	1345	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	507	-	223	-	20	-	750	-
Асуулгад оролцсон малчин өрхийн нийт тоонд эзлэх хувь	67.6	-	29.7	-	2.67	-	100	-

Үүнээс үзэхэд малчид өөрсдийн хүүхдийг малчин болгож мал маллуулах гэсэн зорилго нь тэдний ам бүлийн тооноос төдийлөн хамаарахгүйн дээр ер нь үр хүүхдээ заавал малчин болгоно гэсэн хүсэл эрмэлзлэл төдий л их биш байна.

Малчид ойрын ирээдүйд ямар төлөвлөгөөтэй байгаа, тэдний ойрын зорилт, чиг хандлага ямар байгааг тодруулах зорилгоор **“Таны ойрын үед (1-5 жилд) хийхээр төлөвлөж буй гол ажил, зорилго юу байна? (Энэ талаар товч тодорхой бичнэ үү?)”** гэсэн нээлттэй асуултыг малчдад тавьж хариулт авсан юм.

Нээлттэй асуулт бүрийн хариултыг түүвэрлэн авч, ижил төстэй байдлаар нь 9 бүлэгт ангилж малчдын ойрын ирээдүйн зорилтыг тодорхойлохыг оролдов. Уг нээлттэй асуултад хариулсан нэг малчин өрх “ойрын хэдэн жилдээ малынхаа тоо толгойг өсгөж, чанарыг нь сайжруулах, өөрийн эзэмшил худагтай болох бодолтой байна” гэх мэтээр 1-3 хүртлэх санаа бодлыг нэгэн зэрэг илэрхийлэх нь олонтаа тохиолдож байв. Түүнчлэн 225 малчин өрх буюу судалгаанд оролцсон нийт малчин өрхийн 29.1 хувь нь уг нээлттэй асуултад огт хариулаагүй байгаа нь анхаарал татаж байна. Уг асуултад хариулт өгөхгүй байгаагийн шалтгаан нь малчин өрхийн ойрын ирээдүйн зорилт тодорхой бус, эсвэл зорилтоо илэрхийлэхэд төвөгтэй байсан зэрэгтэй холбоотой гэж үзэж байна.

Судалгаанаас үзэхэд малчдын хувьд хамгийн гол зорилт нь малынхаа тоо толгойг өсгөх (65.7 хувь), малын үүлдэр, угсааг сайжруулж ашиг шимийг нь нэмэгдүүлэх (43.6 хувь), малын хашаа хороо барих буюу томсгох (24.7 хувь) зэрэг асуудлууд байна. Малчдын бусад зорилтыг 68 дугаар хүснэгтээр тодорхой үзүүлэв. Малчдын ойрын үеийн зорилтын доторх бусад гэсэн бүлэгт хүүхдэдээ сайн боловсрол эзэмшүүлэх, гэр бүлийн нэг гишүүнээ эмчлүүлэх, хүүхдээ гадаадад явуулж ажил хийлгэх, хүүхдээ гэр бүл болгохын тулд шинэ гэр төхөөрөх, байшин барих, машин, мотоцикл авах, үнэт эдлэл /хөөрөг, хурдан морь гэх мэт/ худалдан авах зэрэг нийтлэг бус саналууд хамрагдаж байна.

**11.5. Малчдын ойрын ирээдүйн зорилт**

Малчдын ойрын ирээдүйн зорилт

Хүснэгт 68

Хариултууд	Хариултын тоо	Судалгаанд оролцсон малчдын дүнд эзлэх хувь	Хариултын дүнд эзлэх хувь
Малын тоог өсгөх	508	65.7	32.5
Малаа чанаржуулах	337	43.6	21.6
Малын хашаа барих, томсгох	191	24.7	12.2
Хорших, хамтрах	50	6.4	3.2
Хадлан, өвс бэлтгэх техниктэй болох	59	7.6	3.8
Төв, суурин бараадах	34	4.4	2.2
Эзэмшил худагтай болох	42	5.4	2.7
Эзэмшил бэлчээртэй болох	56	7.2	3.6
Бусад	59	7.6	3.8
Хариулаагүй	225	29.1	14.4
Бүгд	1561	-	100.0

Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа малчдын хувьд орлогоо нэмэгдүүлэх, ахуй амьдралаа сайжруулах хамгийн гол арга нь малын тоо толгойг нэмэгдүүлэх асуудал байсаар ирсэн, цаашдаа ч тэдний бодол мөн л малын тоо толгойг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгааг дээрх судалгааны дүн харуулж байна. Дийлэнх малчин өрхийн ойрын үеийн зорилтод мал маллах ажлаасаа түдгэлзэж өөр ажилд шилжих санаа бодол огт байхгүй, харин ч тогтвор суурьшилтай байж малаа маллах бодолтой байгаагаас шалтгаалж тэдний зорилт нь малаа, малчин ахуйгаа тойрсон шинжтэй байна. Гэхдээ малчдын ойрын ирээдүйн зорилтын дотор малын үүлдэр угсааг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх гэсэн хүсэл эрмэлзэл дүүрэн байгаа нь зөв чиг хандлага юм.

Төв, орон нутгийн төрийн байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтэн, эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан нийт 224 хүнээс **“Мал аж ахуйн хөгжлийн ирээдүйг та хэрхэн төсөөлж байна вэ?”** гэсэн нээлттэй асуултаар асуулт асуухад тэдний дийлэнх нь (86.3 хувь) мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх шаардлагатай гэсэн хариултыг өгсөн байна. Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх гэсэн хариултын дотор малын үүлдэр угсааг сайжруулах, нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэх, суурин мал маллагааны аргад шилжих, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх зэрэг багц асуудлууд орж байна.

Малчид малын тоо толгойг нэмэгдүүлэхийг эрхэм болгож байгаа бол удирдах ажилтан, эрдэмтэн, мэргэжилтний дөнгөж 6.4 хувь нь уг асуудлыг дэмжиж байгаагаараа зарчмын ялгаатай байна. Энэхүү нээлттэй асуултад хариулсан нэлээд олон удирдах ажилтан, эрдэмтэн мэргэжилтэн “төр, засгаас анхаарал тавихгүй, бэлчээрийн мал аж ахуйг энэ хэвээр нь хөгжүүлэх аваас удахгүй мал аж ахуй сүйрэлд хүрнэ. Цаг хугацаа алгуурлалгүй бэлчээр ашиглах, эзэмших эрх зүйн орчинг шинэчлэх, эрсдлийг бууруулах, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх далайцтай арга хэмжээ авах хэрэгтэй” гэсэн санаа дэвшүүлж байсныг тэмдэглэж байна. Тэр ч бүү хэл оролцогсдын 5.5 хувь нь **“мал аж ахуй энэ байдлаараа байвал сүйрнэ”** гэсэн адилхан хариултыг нээлттэй асуулгаар өгч байгаа нь анхаарал татаж байна.



**Мал аж ахуйн хөгжлийн ирээдүйн төсөөлөл**  
*/Удирдах ажилтан, эрдэмтэн, мэргэжилтний санал/*

Хүснэгт 69

Хариултууд	Хариултын тоо	Нийт оролцогсдын дүнд эзлэх хувь	Нийт саналын дүнд эзлэх хувь
Малын тоог өсгөх	508	65.7	32.5
Эрчимжүүлэх	202	86.3	56.8
Фермер, хоршоо байгуулах	70	29.9	19.5
Малаа эрүүлжүүлэх	18	7.7	5.1
Малын тоог өсгөх, нүүдлийн мал аж ахуйг хөгжүүлэх	15	6.4	4.2
Малчдад тусламж дэмжлэг үзүүлэх	13	5.5	3.7
Энэ байдлаараа байвал сүйрнэ	13	5.5	3.7
Бусад	16	6.8	4.5
Хариулаагүй	9	3.8	2.5
Бүгд	356	-	100.0

1. Сүүлийн 3 жилийн хугацаанд судалгаанд оролцсон малчин өрхийн 12.8 хувь нь амьдрал сайжирсан, 58.3 хувь нь хэвийн, 28.8 хувь нь муудсан гэж хариулжээ. Малчдын амьжиргаа сүүлийн жилүүдэд төдийлөн сайжраагүй нь байгаль, цаг уурын хүндрэлээс болж мал сүргийн тоо толгой 2000 оныхоос 30 хүртэл хувиар хорогдсонтой холбоотой. Иймд байгаль, цаг уурын хүндрэлийг даван туулах эрсдлийн менежментийг бий болгох нь мал аж ахуйн салбарын тулгамдсан асуудал болж байна.

2. Малчдын амьжиргааны түвшинд тэдний боловсролын түвшин нөлөөлж байна. Тухайлбал, судалгаанд оролцсон дээд боловсролтой нийт малчин өрхийн 25.8 хувийнх нь амьжиргаа сүүлийн 3 жилд сайжирсан байхад бага боловсролтой өрхийн 11.3 хувь нь л амьжиргаагаа сайжирсан гэж үзсэн байна. Иймд цаашид малчдын боловсролын түвшинг нэмэгдүүлэх, малчдыг мал аж ахуйн үйлдвэрлэл, технологийн тусгай мэргэжлийн сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах нь тэдний амьдрах чадавхийг сайжруулах нэн чухал нөхцөл мөн. Салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, удирдах ажилтнуудаас авсан санал асуулгаар малчдын амьжиргааг сайжруулах талаар хийх нэн тэргүүний ажлын жагсаалтыг “малчдын чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах” гэсэн хариулт тэргүүлж байгаа нь ч дээрх саналын нотолгоо юм.

3. Малчдад ямар нэг гэнэтийн нөхцөл байдал /ган зуд болж малгүй болох, хүүхдийн ирээдүйн асуудал гэх мэт/ үүсэхгүй бол тэд ойрын үед мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхээс шууд татгалзах бодолгүй байна. Малчдын дөнгөж 9.0 хувь нь л өөр боломжийн ажил хотод олдвол мал маллахаас татгалзаж болох юм гэж хариулсан нь малчдын тогтвор суурьшил өндөр байгааг харуулж байна.

4. Мал маллахын зэрэгцээ өөр орлого олох боломж байгаа эсэх талаар малчдын санаа бодлыг судалсан дүнгээс үзэхэд тэдний 33.9 хувь нь мал аж ахуйгаас өөр давхар ажил эрхлэх боломжгүй гэж хариулсан байна. Энэ нь мал аж ахуйн хөдөлмөр нь нэлээд нарийн төвөгтэй, цаг хугацаа, хүч хөдөлмөр шаардсан ажил болохыг харуулж байна. Цаашид мал аж ахуйн салбар эрчимжин хөгжиж төрөлжихийн хэрээр мал маллахын зэрэгцээ өөр ажил эрхлэх боломж улам бүр багасана гэж бид үзэж байна.

5. Мал маллахын зэрэгцээ орлого олох өөр ажил эрхлэх боломжийн талаар мал аж ахуйн мэргэжилтэн, удирдах хүмүүс малчдаас өөр бодолтой байна. Тэдний дийлэнх нь малчид мал маллахын зэрэгцээ төмс, хүнсний ногоо тариалах, туслах аж ахуй эрхлэх боломжтой гэж үзсэн төдийгүй мал маллахын зэрэгцээ давхар ажил хийх боломжгүй гэсэн хариултыг нэг ч хүн сонгоогүй байна. Хүнсний ногоо

**11.6. Дигнэлт**

тариалах, газар тариалан эрхлэх, туслах аж ахуй хөгжүүлэх зэрэг нь нарийн мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх ажил байж болох тул цаашдаа малчид мал малахын зэрэгцээ дээрх ажлуудыг давхар эрхлэх боломж хязгаарлагдмал байх болов уу гэж бид үзэж байна.

**6.** Малчдын дийлэнх нь (77.5 хувь) үр хүүхдээ сайн боловсрол эзэмшүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгаагийн дээр хүүхдүүд ямар ажил мэргэжилтэй болох нь тэдний өөрсдийнх нь шийдэх асуудал гэж 62.6 хувь нь үзэж байна. Харин малчдын 22.7 хувь нь үр хүүхдээ өөрийн ажлыг залгамжлах малчин болгох сонирхолтой байна. Энэхүү судалгаанаас харахад малчид үр хүүхдээ малчин болгох сонирхол төдийлөн үгүй байна.

**7.** Малчдын ойрын үеийн нийтлэг зорилго нь малын тоо, толгойг өсгөх асуудал хэвээр байна. Гэвч бэлчээрийн нөөц бага, эрсдэл их байгаа өнөөгийн нөхцөлд малын үүлдэр, угсааг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх замаар малчдын хүсэл сонирхлыг хангахаас өөр боломжгүй байна.

**8.** Удирдах ажилтан, мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтнүүд мал аж ахуйн хөгжлийн ойрын ирээдүйн талаар “Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, тэжээлийн нөөцийг бэхжүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах” гэсэн ерөнхийдөө нэгдмэл төсөөлөлтэй байна.

ЕРӨНХИЙ ДІГНЭЛТ

**12.1.1.** Монгол орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсноос хойш 10 гаруй жилийн хугацаанд мал аж ахуйн салбарын материал техникийн бааз /түүний дотор тэжээлийн үйлдвэрлэл, суурин маллагааны цогцолбор байгууламжууд гэх мэт/ тоногдож, устаж үгүй болсон байна. Дээрх хугацаанд мал аж ахуйн салбарын хөгжлийн чиг хандлага алдагдаж ашиг шим багатай цөөн тооны мал бүхий, амиа аргацаасан сул дорой эдийн засгийн чадавхитай малчин өрхийн тоо 3 дахин нэмэгдэж, өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоо толгой хорогдож, үржил-селекцийн ажил ерөнхийдөө зогсонги байдалд орсон байна.

**12.1.2.** Ерээд оноос хойш малын үржил-селекцийн ажлын талаар төр, засгаас авч хэрэгжүүлж байгаа ажил нь улсын төсвөөс санхүүждэг мал аж ахуйн мэргэжлийн байгууллагын тогтолцоо, аппаратыг авч үлдэх төдийгөөр хязгаарлагдаж малын үүлдэр угсааг сайжруулах, үржлийн ажилд шинжлэх ухааны ололт, шинэ технологи нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ явуулах ажлууд үндсэндээ орхигдсон байна. Засгийн газраас мал аж ахуйг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг малчдын 29.0 хувь нь хангалттай, 38.3 хувь нь хангалтгүй, 21.0 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн нь дээрх дүгнэлттэй ойролцоо байна. Харин малын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар төр засгаас зохион байгуулж буй арга хэмжээний төсөв, зардлын хэмжээ жил тутам нэмэгдэж байна.

**12.1.3.** Мал аж ахуйн үйлдвэрлэлд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжууд нь Монгол орны хөдөөгийн нийгмийн амьдралд төдийлөн бүрэн нийцэхгүй байна. Малчдын 51.0 хувь, мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтэн нарын 40.2 хувь нь мал аж ахуйн талаарх эрх зүйн орчныг өөрчлөн сайжруулах шаардлагатай гэж үзэж байгаа нь үүний нотолгоо болно.

**12.1.4.** Олон улсын байгууллагаас мал аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ нь үр өгөөжтэй, чухал асуудалд чиглэгдэж, нийтийг хамарсан ажил болж чадаж байгаа эсэхэд олон нийтийн өгөх үнэлэлт нэг мөр бус байна. Тухайлбал, мал аж ахуйн салбарын эрдэмтэн мэргэжилтэн, орон нутгийн удирдах ажилтан нарын 40.9 хувь нь төсөл арга хэмжээ чухал асуудалд чиглэгдэхгүй байна гэж дүгнэсэн байна.

**12.2.1.** Малчид мал аж ахуй эрхлэхэд дутагдаж байгаа, зохицуулахад нэн түвэгтэй асуудлаа илэрхийлэхдээ гол төлөв бэлчээрийн хүрэлцээ, ашиглалтын тухай сэдвийг хөнддөг боловч бодит байдал дээр тэдэнд хамгийн дутагдалтай, хүрэлцээгүй зүйл нь малын хашаа хороо /59.5 хувь нь хүрэлцээгүй/, дараагийн дугаарт худаг усны хүрэлцээний асуудал /өвөлжөө хаваржааны 30.8 хувьд, зуслан намаржааны 36.7 хувьд хүрэлцээгүй/ болох нь судалгаагаар нотлогдож байна.

**12.2.2.** Бэлчээрийн маргааныг бодит амьдрал дээр гол төлөв малчид өөрсдөө зохицуулж байна. Бэлчээрийг хуваарилах, маргааныг зохицуулах талаарх Газрын тухай хуулийн заалт хангалтгүй хэрэгжиж байна.

**12.2.3.** Дэлхийн цаг уурын дулаарал нь Монгол орны байгаль, цаг уурын байдалд сөрөг нөлөө үзүүлж сүүлийн жилүүдэд ган, зуд, гэнэтийн аюул зэрэг байгалийн гамшгийн давтамж нэмэгдэж хор хөнөөл нь улам бүр ихсэх хандлагатай байна. Байгаль, цаг уур муудаж, бэлчээрийн ургац доройтож, ил задгай ус улам

**12.1. Монгол орны мал аж ахуйн өнөөгийн байдал**

**12.2. Бэлчээр, хашаа, худгийн эзэмшилт, ашиглалтын талаарх олон нийтийн санал, бодол**

бүр ховордож байна гэж судалгаанд оролцсон малчдын 75 орчим хувь нь тодорхойлсон нь дээрх дүгнэлтийг давхар нотолж байна. Малчдын тодорхойлсноор Төвийн болон Хангайн бүсэд байгаль, цагуур, бэлчээр, усны доройтол илүү ихээр ажиглагдаж байна.

**12.3. Мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн битээмж**

**12.3.1.** Мал аж ахуйн салбарын бүтээмжийг өсгөж, эрчимжүүлэн хөгжүүлэх зохион байгуулалтын гол хэлбэр болох мал сүргийг төрөлжүүлэн маллах арга хэлбэр үндсэндээ үгүй болсон байна.

**12.3.2.** Мал аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд 3-5 дахин буурч хөдөлмөрийн чадвартай малчдын 80 гаруй хувь нь өөрсдийн хөдөлмөрийн чадвараас харьцангуй бага тооны мал маллаж, тэр хэмжээгээр амьжиргааны доройтолд орсоор байна. Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйд нэг малчин дунджаар 200-550 толгой мал /богт шилжүүлснээр/ маллаж байсан бол бидний судалгаагаар хөдөлмөрийн чадвартай нэг малчинд дөнгөж 70 толгой мал /богт шилжүүлснээр/ ногдох болсон нь дээрх дүгнэлтийг нотолж байна. Нөгөө талаар сүүний чиглэлийн хувийн хэвшлийн цөөн тооны фермерийн аж ахуйг эс тооцвол Монгол орны мал аж ахуйн салбарт хөдөлмөрийн бүтээмжийг нэгжээс авах ашиг шимийн гарцаар тооцох боломжгүй байна.

**12.4. Мал аж ахуй эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийн талаарх малчдын санал, бодол**

**12.4.1.** Мал аж ахуйн үйлдвэрлэлийн 10 гаруй ажлаас хамгийн хүнд хүчир нь хадлан гэжээл бэлтгэх ажил гэж малчдын дийлэнх нь /68.3 хувь/ үзэж байна. Гэхдээ мал аж ахуйн хүнд хүчир ажил нь байгаль, цагуурын онцлогоос шалтгаалж өөрчлөгдөж байна. Эдийн засгийн Баруун болон Төвийн бүсийн говийн аймгуудад хамгийн хүнд хүчир ажил нь нүүдэл хийх ажил байхад төвийн бүсийн хойд хэсэг, хангайн бүсийн малчдын хувьд хадлан гэжээл бэлтгэх ажил хамгийн хүнд хүчир ажилд тооцогдож байна.

**12.4.2.** Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх хамгийн оновчтой арга бол бусадтай хөдөлмөрөө хорших явдал /81.7 хувь/ гэж малчид үзэж байна. Түүнчлэн хүнд хүчир ажилд техник хэрэгсэл ашиглахыг ч /66.4 хувь/ малчид чухалд үзсэн байна.

**12.4.3.** Мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтэн, удирдах ажилтан нарын үзэж байгаагаар мал аж ахуйн үйлдвэрлэлд хорших, хамтрах харилцаа хөгжихгүй байгаагийн гол шалтгаан нь тэдэнд хорших, хамтрах итгэлцэл бүрдээгүй /73.8 хувь/, хорших хөрөнгө, санхүүгийн боломж муу /57.8 хувь/, хорших арга ухаанаа олохгүй байгаа /54.7 хувь/ явдал юм.

**12.4.4.** Малчдын санааг зовоож байгаа олон асуудлаас хамгийн ихээр санаа зовоож байгаа нь малын хулгай гэж тэдний 63.7 хувь нь үзсэн байна. Түүнчлэн хүүхдийн боловсрол, бэлчээр усны хүрэлцээ, чонын халдлага, амьжиргааны доройтол зэрэг асуудал нь тус бүрдээ малчдын 30 хүртлэх хувийнх нь санааг зовоож байдаг байна. Харин мэдээллийн хомсдол /16.8/, хүмүүсийн танхай, согтуу, хэв журмын зөрчил /12.4 хувь/ зэрэгт малчид төдийлөн санаа зовохгүй байна.

**12.5. Малчдын сэтгэл хангалуун байгаа эсэх**

**12.5.1.** Судалгааны дүнгээс үзэхэд малчдын олонх /63.6 хувь/ нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун, тодорхой хэсэг нь /25.9 хувь/ сэтгэл ханамж дунд зэрэг, цөөнх нь /6.7 хувь/ нь сэтгэл хангалуун бус байна.

**12.5.2.** Малчид мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаагийн үндсэн шалтгаан нь мал аж ахуй бол тэдний амьжиргааны гол эх үүсвэр болж байгаагаар /68.5 хувь/ холбоотой байна. Харин

мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун бус байгаагийн шалтгаан нь олсон орлого амьдрал ахуйд хүрэлцэхгүй байгаа явдал /72.4 хувь/ юм.

**12.5.3.** Малчдын үзэж байгаагаар хөдөө орон нутагт хууль, хүчний байгууллагуудын үйл ажиллагаа боломжийн түвшинд /хангалттай 46.1 хувь, дунд зэрэг 39.3 хувь/, сумын болон мал эмнэлгийн ажил дунд зэрэг /хангалттай 20.7 ба 22.9 хувь, дунд зэрэг 53.3 ба 53.2 хувь/, харин сургуулийн ажил, харилцаа холбооны үйлчилгээ хангалтгүй /дунд зэрэг 45.9, ба 40.8 хувь, хангалтгүй 40.2 ба 39.5 хувь/ байна.

**12.5.4.** Эмчид дуудлага өгмөгц эмч цаг хугацаандаа ирэх боломж сайн гэж малчдын 17.6 хувь, дунд зэрэг гэж 41.6 хувь нь хариулсан байна. Энэ нь эмнэлгийн үйлчилгээний түргэн шуурхай байдлын талаарх малчдын үнэлгээ болно.

**12.5.5.** Малчдын нийгмийн үйлчилгээний талаарх санал, бодлыг илэрхийлсэн дээрх дүгнэлтүүдээс үндэслэн тэдний ахуй орчин, нийгмийн үйлчилгээний байдалдаа хандах сэтгэл хангалуун байдал дунд зэрэг байна гэж дүгнэж болно.

**12.6.1.** Бидний судалгаагаар малчин өрхийн жилийн дундаж орлого ойролцоогоор 2.4 сая орчим төгрөг байна. Малчин өрхийн орлогын 80 гаруй хувийг малын ашиг шимээс орох орлого эзэлж байна.

**12.6.2.** Малчдын үзэж байгаагаар өрхийн нэг хүнд ногдох малын тоо 40 толгой /богт шилжүүлсэнээр/ байхад хоол хүнсээ, 41-70 толгойд хүрэхэд хоол хүнс, хувцасны зарлагаа нөхөж болох юм. Харин малчин өрхийн нэг хүнд ногдох малын тоо 150 ба түүнээс дээш толгойд хүрч байж л малчдын хүсэн хүлээж буй хэрэгцээг хангаж чадахаар байна.

**12.6.3.** Малчдын 60 гаруй хувь нь өрхийн орлогын хувьд амьжиргааны нэн ядуу болон ядуу өрхийн түвшинд амьдарч байгаа хэдий ч тэд өөрсдийнхөө амьжиргааны түвшинг үнэлэхдээ өөдрөгөөр хандаж байна. Тухайлбал, ҮСГ-аас тогтоосон жишгээр нэн ядууд тооцогдох /нэг хүнд ногдох сарын орлого 8000 төгрөг хүртэлх/ судалгаанд хамрагдсан малчин өрхийн дөнгөж 6.6 хувь нь өөрсдийгөө нэн ядуу гэж үнэн зөв тодорхойлж харин 62.3 хувь нь дундаж, 1.6 хувь нь дунджаас дээш амьжиргаатай гэж бодит байдлаасаа илүү өөдрөгөөр амьжиргааны байдлаа тодорхойлсон байна. Ийнхүү малчид өөрсдийн амьжиргааг өөдрөгөөр үнэлж байгаа нь тэдний боловсролын дундаж түвшин бага, элдэв хэрэглээний нэр төрөл цөөн, хэрэгцээ хязгаарлагдмал, мэдээллийн хомсдолд байгаа зэрэг хүчин зүйлийн нөлөөлөл болон монгол хүний уужуу тайван ухаан, асуудалд өөдрөг ханддаг зан заншилтай холбоотой байна.

**12.6.4.** Өнөөгийн байдлаар малчдын олсон орлого нь амьжиргааныхаа наад захын хэрэгцээг хангахад бүрэн хүрэлцэхгүй байгаа тул тэдэнд мал аж ахуйн үйлдвэрлэлээ өргөтгөх, шинэ техник, технологи нэвтрүүлэхэд зарцуулах санхүүгийн эх үүсвэр илт үгүйлэгдэж байна.

**12.6.5.** Малчдад мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ орлого олох өөр боломж байгаа эсэх талаар салбарын мэргэжилтэн, удирдах ажилтан болон малчдын санаа бодол ихээхэн зөрүүтэй байна. Тухайлбал, салбарын мэргэжилтэн, удирдах ажилтан нарын 78.7 хувь нь малчид төмс, хүнсний ногоо тариалах боломжтой гэж үзсэн байхад малчдын дөнгөж 37.4 хувь нь уг ажлыг хийж болох юм гэж үзсэн байна. Түүгээр ч барахгүй малчдын 33.8 хувь нь мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ өөр ажил хийх ямар ч боломжгүй гэж хариулсан байна. Энэ бүхнээс үзэхэд малчдыг орлогын өөр боломж хайх үйл ажиллагаанд

**12.6. Малчин өрхийн орлого, зарлага**

сургах, сэдээх, нөхцөл боломжийг бүрдүүлэх, мал аж ахуйг төрөлжүүлэх замаар малчны хөдөлмөрийн хуваарийг зохистой бүрдүүлэх талаар онцгой анхаарах шаардлага тавигдаж байна

#### **12.7. Малчдын хэрэгцээ**

**12.7.1.** Малчдад ахуйн олон төрлийн хэрэгцээ байгаагийн дотор эн тэргүүний хэрэгцээ нь гэрээ тохижуулах /67.4 хувь/, цахилгааны эх үүсгэвэртэй болох /43.2 хувь/ хэрэгцээ байна. Малчин өрхийн нэг хүнд ногдох орлого нэмэгдэх тутам гэрээ тохижуулах, ачлагын мал, тэрэгтэй болох зэрэг эн тэргүүний хэрэгцээ буурч харин өвөлжөөндөө байшинтай болох, цахилгааны эх үүсгэвэртэй болох зэрэг хэрэгцээ урган гарч байна.

**12.7.2.** Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн эн тэргүүний хэрэгцээ нь малын тоо толгойг нэмэгдүүлэх /71.2 хувь/ явдал байна. Малчин өрхийн нэг хүнд ногдох малын тоо 150 богоос багагүй хэмжээнд хүрч байж тэдний малын тоог нэмэгдүүлэх хэрэгцээг хангаж болох боловч энэ нь өнөөгийн Монгол орны бэлчээрийн даац, мал аж ахуйд ажиллаж амьдарч байгаа хүний тоо зэргийг тооцож үзэхэд бараг боломжгүй асуудал гэж үзэж байна.

**12.7.4.** Малчдын нийгмийн үйлчилгээний эн тэргүүний хэрэгцээ нь хүүхдийн боловсрол болно. Хөдөөгийн хүн, малын эрүүл мэндийн үйлчилгээг ч малчид хамгийн чухал хэрэгцээ гэж үзэж байна.

#### **12.8. Малчдын цаашдын зорилт**

**12.8.1.** Малчид ойрын үед мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхээс шууд татгалзах бодолгүй байна. Тухайлбал, судалгаанд оролцсон малчдын 47.5 хувь нь ямар ч тохиолдолд малаа орхихгүй гэсэн хариулт өгсөн байна. Харин малчдын нэлээд хэсэг нь малаа ган, зудад хорогдуулсан /25.3 хувь/ буюу хүүхдээ боловсрол эзэмшүүлэх зайлшгүй шаардлага гарсан /14.6 хувь/ тохиолдолд мал аж ахуйг орхино гэсэн бол цөөнх нь л төв суурин газарт боломжийн ажил олдсон /9.0 хувь/ тохиолдолд мал аж ахуйн ажлаа орхих бодолтой байна.

**12.8.2.** Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн ойрын үеийн нийтлэг зорилго нь малын тоо толгойг өсгөх /61.5 хувь/ асуудал хэвээр байна. Гэвч бэлчээрийн нөөц бага, эрсдэл их байгаа өнөөгийн нөхцөлд малын үүлдэр, угсааг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх замаар малчдын хүсэл сонирхлыг хангахаас өөр боломжгүй байна.

**12.8.3.** Удирдах ажилтан, мал аж ахуйн эрдэмтэн, мэргэжилтнүүд мал аж ахуйн хөгжлийн ойрын ирээдүйн чиг хандлагын талаар “Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, тэжээлийн нөөцийг бэхжүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах” гэсэн ерөнхийдөө нэгдмэл төсөөлөлтэй байна.

**САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

**13.1.** Сүүлийн жилүүдэд малын үржил-селекцийн ажилд шинэ техник, технологи турших, нэвтрүүлэх, сайн үүлдрийн өндөр ашиг шимтэй мал, үр хөврөл гадаадаас импортлох, таримал тэжээл үйлдвэрлэх зэрэг үйл ажиллагаанд төр, засгаас харьцангуй бага хөрөнгө зарцуулж ирснийг тэмдэглэж, малчид, мал аж ахуйн салбарын эрдэмтэн мэргэжилтэн нарын санал бодлыг үндэс болгон мал үржлийн ажлыг шинэ шатанд гаргахад цаг алгуурлалгүй онцгойлон анхаарч улсын төсвөөс жил бүр 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний хөрөнгө гаргах шаардлагатай болсон байна.

**13.2.** Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх хууль, эрх зүйн үндсийг улам бүр боловсронгуй болгож, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мал аж ахуй эрхлэх боломж, сонирхлыг хангах.

**13.3.** Бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн амьдрахад байгалийн бэрхшээлийг /ган, зуд, бусад гамшиг/ даван туулахуйц эрсдлийн менежментийн тогтолцоог төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагын идэвхтэй хамтын ажиллагаагаар буй болгох.

**13.4.** Бэлчээрийг зөвзохистой хуваарилан ашиглах асуудлыг шийдвэрлэх үндсэн арга зам нь малын хашаа хороо, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх замаар идэвхтэй ашиглах бэлчээрийн талбайг тэлэх явдал мөн.

**13.5.** Мал аж ахуйг нүүдлийн байдлаар эрхлэх тохиолдолд бэлчээрийг нийтээр эзэмших, суурин хэлбэрт шилжихийн хэрээр бэлчээрийг ашиглах, эзэмшүүлэх асуудлыг эрх зүйн хувьд баталгаажуулах.

**13.6.** Мал аж ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөхийн тулд юуны өмнө хадлан, тэжээл бэлтгэх, нүүдэл хийх хэрэгцээг хангахуйц үнэ хямд, бага оврын механикжсан техник хэрэгслийг өргөн нэвтрүүлэх нь малчдын хэрэгцээнд нийцсэн арга хэмжээ болно.

**13.7.** Мал аж ахуйн салбарт хамтрах, хорших үйл явцыг идэвхжүүлэн хөгжүүлэх гол арга нь хоршоог удирдах мэдлэг боловсролтой боловсон хүчин бэлтгэх, малчдын дунд хамтрах, хорших арга хэлбэр, итгэлцэл бүрдүүлэх асуудлаар сургалт зохион байгуулах явдал мөн.

**13.8.** Хөдөөд малын хулгайг таслан зогсоох талаар шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх аваас малчдын айх аюулгүй амар тайван амьдрах нэг гол асуудал шийдэгдэнэ.

**13.9.** Малчдын ашиг орлогыг нэмэгдүүлж, ахуй амьдралыг сайжруулах бодлогын үндсэн чиглэл нь нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, хөдөлмөр зохион байгуулалтын зөв хэлбэрийг нэвтрүүлэх зэрэг аж ахуйг эрчимжүүлэн боловсронгуй болгох үйлдлүүд байна.

**13.10.** Малчдыг орлогын өөр боломж хайх үйл ажиллагаанд сургах, сэдээх, хөдөлгөөнд оруулах талаар төр, олон нийтийн байгууллагаас идэвхтэй үйл ажиллагаа зохион байгуулах.

**13.11.** Малчин өрх бүр мал, малын захтай байх гэсэн уламжлалт сэтгэлгээ, өнөөгийн бодит байдлыг өөрчилж, тодорхой төрлийн малыг дагнан үржүүлж мал аж ахуйн төрөлжилтийн үйл явцыг эрчимжүүлэх шаардлага ойрын 3-5 жилд шийдвэл зохих чухал асуудлын нэг мөн. Мал аж ахуйн

төрөлжилт нь мал аж ахуйн салбарын эрчимтэй хөгжлийн зүй тогтол хандлага бөгөөд уг үйл явцыг хурдасгах зорилгоор нэг төрлийн мал өсгөж үржүүлэх үйл явцыг бодлогын хувьд дэмжиж, чиглүүлэх шаардлагатай.

**13.12.** Бэлчээр эзэмшүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, бэлчээр ашиглалтын төлбөрийг бүс нутгийн байдлаас хамааруулж ялгавартай тогтоох, эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа иргэн, байгууллагын бэлчээрийн асуудлыг тэдний аж ахуйн үйл ажиллагаа явуулах баталгаа болгож олон жилээр ашиглуулах, эзэмшүүлэх тогтолцоог бий болгох зэргээр мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх таатай орчинг бүрдүүлэх шаардлагатай.

**13.13.** Мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь тус салбарт шинэ технологи, суурин мал маллагааны арга хэлбэр түргэн нэвтэрч, тэжээл бэлтгэл, ус худаг, хашаа хороо, материаллаг баазын бэхжилт сайжирч, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэх үйл явцыг хурдасгах үндсэн хөшүүрэг мөн. Энэ үйл явцын нөлөөгөөр мал аж ахуйд байгаа далд ажилгүйдэл илрэх, малчдын сэтгэлгээ зах зээлийн харилцаанд зохицон тэлэх, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн хослох үйл явц түргэсэх зэрэг эерэг үр дүнгүүд гарна.

**13.14.** Фермерийн аж ахуйн эрх зүйн байдлыг тодорхой болгох нь мал аж ахуйн хөгжлийн цаашдын үйл явцад чухал нөлөө үзүүлнэ.

**13.15.** Эдийн засгийн бүсийн хөгжлийн тулгуур төв, хотуудын ойролцоо болон газар тариалангийн бүсийг түшиглэн эрчимжсэн мал аж ахуйн загвар фермийн аж ахуйг үүсгэн хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, мал аж ахуйн шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагааг үйлдвэрлэлтэй шууд холбох, загвар аж ахуйн нэгжүүдийг мал аж ахуй эрхлэгчдэд байнга таниулж, туршлага судлуулж байх нь хөгжлийг хурдасгах үндсэн нөхцөл болно.

**13.16.** Малчид болон мал аж ахуйн салбарын эрдэмтэн, мэргэжилтэн, удирдах ажилтны саналыг судалсан дүнгээс үзэхэд Монголын мал аж ахуйн ирээдүйн хөгжлийн чиг хандлага дараахь байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Монголын мал аж ахуйн анхан шатны бүтэц нь амиа аргацаасан өрхийн аж ахуйгаас ашиг орлого олох бизнесийн шинэ салбар болох хувийн хэвшлийн төрөлжсөн аж ахуй руу аажмаар шилжих хандлагатай байна.
- Мал аж ахуйн эрчимжилт гэдэг нь зөвхөн мал аж ахуйг үйлдвэржсэн аргаар эрхлэх буюу гадаад улс орноос импортоор оруулж ирсэн өндөр ашиг шимтэй малыг өсгөж үржүүлэх асуудал төдий биш бэлчээрийн мал аж ахуй болон суурин мал аж ахуйд шинжлэх ухааны ололт амжилтыг ашиглан аль болох үр ашигтай хөтлөн удирдах цогц арга хэмжээ гэж ойлгож болох байна.
- Мал аж ахуйн салбар нь хувийн хэвшлийн бизнесийн салбар болохын хэрээр малын бэлчээр, хадлан тэжээлийн талбайг ашиглах, эзэмших асуудал нь бизнесийн тогтвортой, баталгаатай орчинг шаардсан эрх зүйн зохицуулалтыг улам бүр шаардаж байна. Иймд бэлчээр, хадлангийн талбайг эзэмшүүлэх ашиглуулах асуудлыг мал аж ахуйн салбарын хөгжлийн хурдтай нийцүүлэхийн тулд одооноос эрх зүйн шинэтгэлийн судалгаа хийж, хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байна.
- Монголын мал аж ахуй цаашдаа төрөлжих хандлагатай байна. Аж ахуйн нэгж байгууллагууд таван төрлийн малын аль алийг нь өсгөж үржүүлэх биш зөвхөн нэг төрлийн мал сонгон өсгөж үржүүлэх хандлага улам бүр нэмэгдэнэ. Ингэснээр нэг малчинд ногдох малын тоо нэмэгдэж



хөдөлмөрийн бүтээмж өсөх хандлага бий болно. Энэ байдлаас болж 2010 он гэхэд 60 гаруй мянган малчин ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж болох юм. Нөгөө талаар үржлийн ажлын үр дүнд нэг малаас авах ашиг шим нэмэгдэж нэг хүний маллах малын тоо буурч ажлын байр шинээр бий болох хандлага ч бий болно. Гэхдээ энэ байдлаас болж шинээр бий болох ажлын байрны тоо нь ажилгүйдэлд нэрвэгдсэн малчдын 20-30 хувийг л ажилтай болгохоос хэтрэхгүй. Иймд цаашдаа ажилгүйчүүдийн эгнээнд шилжих малчдын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар төр, засгаас одооноос онцгой анхаарч ажиллах шаардлага тавигдаж байна.

- Мал аж ахуйн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх боломж нь зөвхөн нэг малчинд ногдох малын тоог нэмэгдүүлэх төдийгөөр хязгаарлагдахгүй бөгөөд цаашдаа нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж бүтээмжийг дээшлүүлснээр ажлын байр шинээр бий болгох нөөц боломж харагдаж байна.
- Мал аж ахуйн салбар нь бизнесийн шинэ салбар болон хөгжиж өрсөлдөөн нэмэгдэхийн хэрээр эдийн засгийн чадавх, боловсролын түвшин багатай амиа аргацаасан малчин өрхүүд өрсөлдөөнд нэрвэгдэж амьжиргааны түвшин доошилж ядуу өрхийн тоо нэмэгдэх төлөвтэй байна. Энэ үйл явц нэгэнтэй эхэлсэн гэж үзэж болно. Иймд цаашид олон арван мянгаараа бий болж болох ядуу малчдын асуудлыг шийдвэрлэх, тэднийг ажлын байраар хангах, амьдрах ухаанд сургах асуудал нь төр, засгийн бодлогын анхаарлын төвд байх ёстой гэж үзнэ.

## НОМ ЗҮЙД ХАМРАГДСАН БИТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Адьяа Ю., Малчин өрхийн аж ахуйн бүтээмжийн хүчин зүйлийн ашиглалтыг дээшлүүлэх асуудалд, Докторын (Sc.D) диссертаци, УБ, 1999, ШУА, 249 хууд., Монгол.
2. Бакей А., Малчин өрхийн эдийн засаг, санхүүгийн асуудлууд, “Nomadic Studies” сэтгүүл, 2002, №04, УБ, НСИСОУХ., 118-120 хууд., Өгүүлэл., Монгол.
3. Гунгаадорж Ш., Мал аж ахуйг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын зарим асуудал, Market-Economy Nomads-Technology товхимол, УБ, 2002, НСИСОУХ., 111-116 хууд., Англи.
4. Насанжаргал Д., Хөдөөгийн хөгжлийн стратеги, Монголд хандивлагчдын зөвлөлдөх уулзалтад хэлсэн үг, УБ., 2002, ХХААЯ., 1-14 хууд., Англи, Монгол.
5. Самбуу Ж., Мал аж ахуй дээрээ яаж ажиллах тухай ардад өгөх сануулга, сургааль, Нэг сэдэвт бүтээл, УБ, 2000, ХХААЯ., ЖЭМР ХХК, 172 хууд., Монгол.
6. Сүхбаатар Ц., Монголын хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хэтийн төлөв, тулгамдсан зорилтууд, Монгол Улсын хөгжлийн судалгаа, 2002, №1, УБ, ШУА-ийн Үндэсний хөгжлийн хүрээлэн., 113-126 хууд., Монгол.
7. Адьяа Ю., Малчин өрхийн аж ахуйн төрх, эрэлт хэрэгцээний өнөөгийн байдал, “Монголын эдийн засаг: өчигдөр, өнөөдөр, маргааш” сэтгүүл, УБ, 1997, №1, 38-42 хууд., СЭЗДС., Өгүүлэл., Монгол.
8. Баасандаш Д., Малчин өрхийн амьжиргааны түвшинг өөрсдийнх нь үнэлэмжээр судалсандун, Эрдмийн бичиг, №1, ХААИС, Эдийн засгийн факультет, УБ, 1998. 60-66 хууд., Өгүүлэл, Монгол.
9. Бат-Эрдэнэ Ц., Малчдын дунд явуулсан социологийн судалгаа, Эрдмийн бичиг, №1, ХААИС, Эдийн засгийн факультет, УБ, 1998, 66-69 хууд., Өгүүлэл, Монгол.
10. Баянмөнх П., Хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах асуудалд, “Мал аж ахуйн шинжлэл” товхимол, №5, УБ, 2003, ХААИС, 273-277 хууд., Монгол.
11. Ганчимэг Г., Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, түүний сөрөг нөлөөлөөс сэргийлэх, Магистрын ажил, ХААИС, Хуудас 99, УБ, 2000, Монгол.
12. Туваансүрэн Г., Мижиддорж.Р., Эрдэнэцогт.Н., Монголын мал аж ахуйн үйлдвэрлэлд цаг уурын үзүүлэх нөлөө, “Nomads and Use of Pastures Today”, товхимол, УБ, 2000, НСИСОУХ, 181-191 хууд., Өгүүлэл, Англи.
13. Бизъяа Г., Бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн хөдлөл зүй, Эрдэм шинжилгээний бичиг, №1, ХААИС, УБ, 1998, 29-38 хууд., Монгол.
14. Чагдаа Х., Монгол малчны амьдрахуйн ухаан, Нэг сэдэвт бүтээл, УБ, 2002, 343 хууд., Монгол.
15. Логи Н., Монголын бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд хөдөө аж ахуйн хоршоог хөгжүүлэх үндсэн асуудлууд, Доктор (Sc.D)-ын диссертаци, УБ, 1999, Гэгээрлийн яам, ШУА, 224 хууд., Монгол.
16. Баасандаш Д., Хөлсний малчин ажиллуулж байгаа зарим хэлбэрүүд, Эрдэм шинжилгээний бичиг, № 31, ХААИС, УБ, 2002, 91-94 хууд., Өгүүлэл, Монгол.

17. Бакей А., бусад, Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөцийг зохистой ашиглах тухай, Төслийн тайлан, УБ, 2000, ХААИС, ЭЗФ, 2000, 41 хууд., Монгол.
18. Хандсүрэн С., Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөц ашиглалт, Доктор(Ph.D)-ын диссертаци, УБ, ХААИС, 1998, 182 хууд., Монгол.
19. Нямаа Н., Ямааны аж ахуйн эдийн засаг, Нэг сэдэвт бүтээл, ХААИС, УБ, 2001, 46 хууд., Монгол.
20. Адъяа Ю., Пүрэв.Б., Тулга.Г., Малчин өрхийн аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх зарим боломж, Эрдмийн бичиг, №1, ХААИС, УБ, 1998, 3-10 хууд., Өгүүлэл Монгол.
21. Дорлигсүрэн Д., Хот айл фермерийн аж ахуй, Төслийн тайлан, ХААИС, УБ, 1995, 102 хууд., Монгол.
22. Нансалмаа Ц., Малчин өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн менежементийн асуудал (Говийн бүсийн жишээн дээр), Доктор (Ph.D)-ын диссертаци, ХААИС, УБ, 1998., Монгол.
23. Нямбат Л., Наранхүү Л., Пүрэв Б., бусад. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нэгжийг фермерийн хэлбэрт шилжүүлэх онцлог, хэлбэр, арга зам, Төслийн тайлан, УБ, 2002, ХХААЯ, 84 хууд., Монгол.
24. Баатар И., Монголын хөдөө аж ахуйн хөгжлийн хандлага, “Олон улс судлал” сэтгүүл, 2003, №1, УБ, 102-108 хууд., Өгүүлэл, Монгол.
25. Батаа.Д., Бэлчээрийн мал аж ахуйг эрхэлж ирсэн монголчуудын уламжлалт арга, Нэг сэдэвт бүтээл, УБ, 1998, 152 хууд., Монгол.
26. Эрдэнэцогт Н., Монголын нүүдлийн мал аж ахуй, Нэг сэдэвт бүтээл, УБ, 1998, 302 хуудас, Монгол.
27. Нансалмаа Ц., Малчин өрхийн аж ахуйгаа эрхлэн хөтлөх төлөв байдал, Эрдэм шинжилгээний бичиг, №31, УБ, 2002, ХААИС, 129-131 хууд., Өгүүлэл, Монгол.
28. Нямаа Н., Малчин өрхийн орлогод ноолуурын үзүүлэх нөлөөлөл, Эрдмийн бичиг, №1, ХААИС, УБ, 1998, 51-56 хууд., Өгүүлэл, Монгол.
29. Нямаа Н., Монгол ноолуур: эдийн засаг, стратегийн асуудлууд, Нэг сэдэвт бүтээл, УБ, 2002 он, ХААИС, 103 хууд., Монгол.
30. Ринчиндорж Д., Аюулаас хамгаалах тэжээлийн фондын талаарх зарим асуудалд, “Мал аж ахуйн шинжлэл” товхимол, №5, УБ, 2003, 177-181 хууд., Монгол.
31. Жигжидсүрэн С, Бэлчээрийн менежментийн хөгжлийн тулгамдсан асуудлууд, Эрдмийн бүтээл, №29, ХААИС, УБ, 1998, 44-52 хууд., Монгол.
32. Эрдэнэбаатар Б., Батжаргал Н., Бэлчээрийн маргаан зөрчил, Нэг сэдэвт бүтээл, УБ, 2001, Азийн сан, 107 хууд., Монгол.
33. Бакей А., Моёбуу Д., Мал аж ахуйн татвар, даатгалыг төгөлдөржүүлэх асуудал, Төслийн тайлан, ХААИС, ЭЗФ, УБ, 2000, 24 хууд., Монгол.
34. Наранхүү Л., Баасанжав Б., Малжуулалтаар малчин өрхүүдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг баталгаажуулах стратегийн үр дүнг үнэлэх нь, Төслийн тайлан, УБ, 2003, СЭЗЯ, Монгол.
35. Эрдэнэбаатар Б., Батжаргал Н., Амарсанаа Б., Оролцооны арга онол практикийн үндэслэл, хэрэглэх аргачлал, Нэг сэдэвт бүтээл, УБ., 2001, Монгол.
36. “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газрын бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, 2001, Монгол.

37. Ариунтуул Б., Дашдулам Б нар, Хүнс, хөдөө аж ахуйн ажилтны лавлах, Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, УБ, 2004, Монгол.
38. Чадраабал Г. Арилдий Ч., БНМАУ-ын мал аж ахуйг хөтлөх систем, Нэг сэдэвт бүтээл, 1982, УБ, Монгол.
39. Санхүү, эдийн засгийн яам, Эдийн засгийн хөгжлийг дэмжих болон ядуурлыг бууруулах стратеги Зөвлөлдөх группийн уулзалтын эмхтгэл, 2003, УБ, Англи
40. Санхүү, эдийн засгийн яам, Монголын хөгжлийн туслалцаанд оруулсан хувь нэмэр, үр дүн, Зөвлөлдөх группийн уулзалтын эмхтгэл, 2003, УБ, Англи

*Интернет эх сурвалж*

1. <http://open-government.mn/>
2. <http://www.lgate-mongolia.mn/>
3. <http://www.monmne.com/tosol.htm>
4. <http://www.env.pmis.gov.mn/elink.php>
5. <http://env.pmis.gov.mn/esubdb.php>
6. <http://env.pmis.gov.mn/Clem/>
7. <http://env.pmis.gov.mn/Meteoins/Images/Day/5daymon.html>
8. <http://www.un-mongolia.mn/undp>
9. <http://www.gbn.mn>

1. Судалгаанд оролцсон удирдах ажилтан, мал аж ахуйн эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжилтний респондент судалгаа

Хавсралт хиснэгтгид

	Хүйс			Мэргэжил					
	Эр	Эм	Бүгд	ХАА-салбар	Нийгэм, улс төр	Эдийн засаг	Инженер	Бусад	Дүн
<b>Тоо</b>	157	68	225	100	54	26	21	24	225
<b>Хувь</b>	69.7	60.3	44.4	44.4	24.0	11.6	9.3	10.6	100.0

	Боловсрол					Насаар					
	Дээд	Т/Дунд	Дунд	Бага	Дүн	18-25	26-40	41-55	56-60	61-ээс	Дүн
<b>Тоо</b>	142	49	29	5	225	6	79	96	35	9	225
<b>Хувь</b>	63.1	21.8	12.9	2.2	100.0	2.7	35.1	42.7	15.5	4.0	100.0

2. Судалгаанд оролцсон малчдын респондент судалгааны дүн

	Хүйс			Ам бүл			
	Эр	Эм	Бүгд	2-5	6-8	9-с дээш	Дүн
<b>Тоо</b>	629	146	773	521	232	20	773
<b>Хувь</b>	81.1	18.9	100.0	67.4	30.0	20.6	100.0

	Боловсрол					Насаар					
	Дээд	Т/Дунд	Дунд	Бага	Дүн	18-25	26-35	36-50	51-60	61-ээс	Дүн
<b>Тоо</b>	32	78	523	140	773	50	207	308	111	97	773
<b>Хувь</b>	4.2	10.1	67.7	18.0	100.0	6.4	26.8	39.9	14.4	12.5	100.0

	Ажилласан жил			Бүсээр					
	1-5	6-10	11-сдээш	Хангай	Баруун	Төв	Зүүн	УБ	Дүн
<b>Тоо</b>	85	200	488	254	214	168	117	20	773
<b>Хувь</b>	11.0	25.9	63.1	32.9	27.7	21.7	15.2	2.5	100.0

	Аймгаар												
	Ар	Бу	ГА	Ду	Хо	БӨ	Тө	Өм	Хэ	Сэ	УБ	СБ	Дүн
<b>Тоо</b>	183	67	110	53	37	63	33	41	81	38	33	34	773
<b>Хувь</b>	23.7	8.7	14.2	6.9	4.8	8.2	4.2	5.3	10.5	4.9	4.2	4.4	100.0

3. Бэлчээрийн маргааныг хэн зохицуулж чадах вэ?

Хариулт	Эдийн засгийн бүс										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Радиогаос	213	35.4	198	33.3	138	31.7	104	36.2	12	50.0	665	34.2
Телевизээс	56	9.3	49	8.2	39	8.9	66	23.0	12	50.0	222	11.4
Сонин, хэвлэлээс	87	14.5	130	21.9	65	14.9	54	18.8	0	0.0	336	17.3
Баг, сумын Засаг дарга, ажилнуудаас	68	11.3	55	9.3	92	21.1	37	12.9	0	0.0	252	13.0
Явуулын хүмүүсээс	159	26.4	144	24.2	91	20.9	23	8.0	0	0.0	417	21.5
Бусад	19	3.2	18	3.0	11	2.5	3	1.0	0	0.0	51	2.6
Хариултын тоо бүгд	602	100.0	594	100.0	436	100.0	287	100.0	24	100.0	1943	100.0
Асуулгад оролцсон малчин өрхийн тоо	182		127		147		73		14		543	
Асуулгад оролцсон малчин өрхийн нийт тоонд эзлэх хувь	33.5		23.4		27.1		13.0		2.6		100.0	

4. Бэлчээрийн маргааныг хэн зохицуулж чадах вэ?

Хариулт	Дээд		Тусгай		Дунд		Бага		Дүн	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Сум, багын Засаг дарга	14	45.2	33	44.0	199	39.6	49	36.6	295	39.7
Нутаг усандаа нөлөөтэй хүмүүс	1	3.2	3	4.0	27	5.4	10	7.5		0.0
Малчид өөрсдөө	8	25.8	26	34.7	222	44.1	58	43.3	314	42.3
Аль нь ч чадахгүй, өөр арга олох хэрэгтэй	8	25.8	10	13.3	45	8.9	12	9.0	75	10.1
Бусад	0	0.0	2	2.7	5	1.0	2	1.5	9	1.2
Хариулаагүй	0	0.0	1	1.3	5	1.0	3	2.2	9	1.2
Асуулгад оролцсон малчдын тоо	31	100.0	75	100.0	503	100.0	134	100.0	743	100.0
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	4.2		10.1		67.7		18.0		100.0	

5. Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээ

Хариулт	Эдийн засгийн бүс											
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Малын тоог нэмэгдүүлэх	181	27.2	163	27.5	113	24.4	76	27.0	8	17.0	541	26.4
Малын үүлдэр угсааг сайжруулах нэмэгдүүлэх	164	24.6	132	22.3	130	28.0	84	29.8	15	31.9	525	25.6
Өөрийн эзэмшлийн худагтай болох	53	8.0	62	10.5	54	11.6	15	5.3	9	19.1	193	9.4
Өөрийн эзэмшил бэлчээртэй болох	59	8.9	84	14.2	37	8.0	16	5.7	7	14.9	203	9.9
Малыг эрүүлжүүлэх	130	19.5	92	15.5	89	19.2	58	20.6	5	10.6	374	18.2
МАН-н хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх техниктэй болох	67	10.1	58	9.8	36	7.8	32	11.3	3	6.4	196	9.6
Бусад	12	1.8	1	0.2	5	1.1	1	0.4	0	0.0	19	0.9
Хариултын тоо бүгд	666	100.0	592	100.0	464	100.0	282	100.0	47	100.0	2051	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	245		206		164		104		18		737	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	33.2		28.0		22.3		14.1		2.4		100.0	

6. Малчдын ахуйн хэрэгцээ  
/ам бүлийн бүлэглэлээр/

Хариулт	Ам бүлийн бүлэглэл						Бүгд	
	2-5		6-8		9-10			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Гэрээ тохижуулах /эсгий, брезент авах г.м/	358	27.9	152	26.2	5	10.4	515	28.1
Өвөлжөөндөө байшинтай болох	182	14.2	76	13.1	11	22.9	269	14.7
Цахилгааны эх үүсгүүр, телевизтэй болох	313	24.4	138	23.8	15	31.3	466	25.4
Авто хэрэгсэлтэй болох /машин, мотоцикл/	207	16.1	112	19.3	12	25.0	331	18.0
Ачлагын мал тэрэгтэй болох	171	13.3	81	14.0	3	6.3	255	13.9
Бусад	51	4.0	21	3.6	2	4.2	0	0.0
Хариултын тоо бүгд	1282	100	580	100	48	100	1836	100
Асуулгад оролцсон малчин өрх	504		222		20		746	

**7. Малчид мал сүргээ даатгалд хамруулсан байдал**  
/Малчдын боловсролын байдлаар/

Хариулт	Боловсролоор								Бүгд	
	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүх малаа даатгалд хамруулсан	2	6.5	13	17.3	43	8.5	18	13.4	76	10.2
Зарим малаа даатгалд хамруулсан	8	25.8	8	10.7	57	11.3	12	9.0	85	11.4
Даатгалд хамруулаагүй	21	67.7	53	70.7	393	78.1	101	75.4	568	76.4
Бусад	0	0.0	0	0.0	4	0.8	0	0.0	4	0.5
Мэдэхгүй	0	0.0	1	1.3	6	1.2	3	2.2	10	1.3
Хариултын тоо бүгд	31	100.0	75	100.0	503	100.0	134	100.0	743	100.0

**8. Мал сүргийн даатгалын талаарх малчдын бодол**  
/боловсролоор/

Хариулт	Боловсролоор								Бүгд	
	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Завал даатгалд хамруулах	6	19.4	21	28.0	102	20.3	29	21.6	158	21.3
Сайн дураар даатгуулах	18	58.1	43	57.3	294	58.4	72	53.7	427	57.5
Даатгуулах шаардлагагүй	2	6.5	3	4.0	35	7.0	12	9.0	52	7.0
Мэдэхгүй	5	16.1	6	8.0	64	12.7	16	11.9	91	12.2
Бусад	0	0.0	0	0.0	1	0.2	0	0.0	1	0.1
Хариулт өгөөгүй	0	0.0	2	2.7	7	1.4	5	3.7	14	1.9
Хариултын тоо бүгд	31	100.0	75	100.0	503	100.0	134	100.0	743	100.0

**9. Ямар тохиолдолд малчид мал маллахаа болих вэ?**

Хариулт	Насаар										Бүгд	
	18-25		26-35		36-50		51-60		60-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Малаа ган зудад алдаж хорогдуулсан тохиолдолд	15	31.3	63	31.2	75	27.1	20	18.7	16	17.2	189	25.3
Хот суурин газарт боломжийн ажил олдвол	6	12.5	25	12.4	42	15.2	7	6.5	6	6.5	86	11.5
Хүүхдээ өндөр боловсрол мэдлэгтэй болгохын тулд	7	14.6	30	14.9	21	7.6	17	15.9	13	14.0	88	11.8
Ямар ч нөхцөлд малаа орхихгүй	18	37.5	82	40.6	148	53.4	59	55.1	48	51.6	355	47.5
Бусад	2	4.2	2	1.0	12	4.3	4	3.7	10	10.8	30	4.0
Хариултын тоо бүгд	48	100.0	202	100.0	298	107.6	107	100.0	93	100.0	748	100.0

**10. Малгүй болсон тохиолдолд малчдын сонголт хийх байдал**  
/насны бүлэглэлээр/

Хариулт	Насаар										Бүгд	
	18-25		26-35		36-50		51-60		60-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Ах дүү хамаатнаасаа тусламж хүсэх	27	23.5	111	20.1	158	19.3	44	16.5	43	17.6	383	19.2
Зээл авах	21	18.3	100	18.1	170	20.8	54	20.2	51	20.9	396	19.8
Хот суурин газар шилжиж, өөр ажил эрхлэх	17	14.8	93	16.8	132	16.1	40	15.0	33	13.5	315	15.8
Байгалийн баялаг ашиглах	27	23.5	84	15.2	115	14.0	46	17.2	33	13.5	305	15.3
Хөлсөөр мал маллах	8	7.0	75	13.6	109	13.3	37	13.9	25	10.2	254	12.7
Улсаас тусламж хүсэх	14	12.2	84	15.2	115	14.0	38	14.2	50	20.5	301	15.1
Бусад	1	0.9	5	0.9	20	2.4	8	3.0	9	3.7	43	2.2
Хариултын тоо бүгд	115	100.0	552	100.0	819	100.0	267	100.0	244	100.0	1997	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	48		195		302		103		95		743	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	6.5		26.2		40.6		13.9		12.8		100.0	

**11. Малгүй болсон тохиолдолд малчдын сонголт хийх байдал**  
/малын тоогоор/

Хариулт	Малын тоогоор										Бүгд	
	0-20		21-40		41-70		71-150		150-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Ах дүү хамаатнаасаа тусламж хүсэх	98	17.3	102	19.2	84	18.4	84	23.3	18	17.0	386	19.1
Зээл авах	110	19.4	106	20.0	94	20.6	68	18.9	22	20.8	400	19.8
Хот суурин газар шилжиж, өөр ажил эрхлэх	73	12.9	93	17.5	79	17.3	54	15.0	19	17.9	318	15.7
Байгалийн баялаг ашиглах	95	16.8	83	15.6	75	16.4	47	13.1	11	10.4	311	15.4
Хөлсөөр мал маллах	86	15.2	68	12.8	48	10.5	39	10.8	15	14.2	256	12.7
Улсаас тусламж хүсэх	88	15.5	72	13.6	67	14.7	59	16.4	19	17.9	305	15.1
Бусад	17	3.0	7	1.3	9	2.0	9	2.5	2	1.9	44	2.2
Хариултын тоо бүгд	567	100.0	531	100.0	456	100.0	360	100.0	106	100.0	2020	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	208		187		169		142		45		751	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	27.7		24.9		22.5		18.9		6.0		100.0	

**12. Малгүй болсон тохиолдолд малчдын сонголт хийх байдал**  
/боловсролын бүлэглэл/

Хариулт	Боловсролоор								Дүн	
	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Ах дүү хамаатнаасаа тусламж хүсэх	11	14.7	18	9.2	268	20.1	68	20.1	365	18.8
Зээл авах	15	20.0	52	26.7	254	19.0	64	18.9	385	19.8
Хот суурин газар шилжиж, өөр ажил эрхлэх	16	21.3	40	20.5	204	15.3	48	14.2	308	15.9
Байгалийн баялаг ашиглах	15	20.0	37	19.0	204	15.3	49	14.5	305	15.7
Хөлсөөр мал маллах	7	9.3	22	11.3	176	13.2	47	13.9	252	13.0
Улсаас тусламж хүсэх	8	10.7	20	10.3	203	15.2	56	16.5	287	14.8
Бусад	3	4.0	6	3.1	25	1.9	7	2.1	41	2.1
Хариултын тоо бүгд	75	100.0	195	100.0	1334	100.0	339	100.0	1943	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	29		72		493		128		722	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	4.0		10.0		68.3		17.7		100.0	

**13. Хүнд хүчир ажлын талаарх малчдын бодол**  
/малын тоогоор/

Хариулт	Нэг хүнд ногдох малын тооны бүлэглэлт /богоор/										Бүгд	
	0-20		21-40		41-70		71-150		150-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мал хариулах	22	4.5	38	7.8	29	6.6	28	7.9	4	3.7	121	6.5
Мал услах	47	9.6	36	7.4	41	9.4	31	8.8	14	13.0	169	9.0
Төл бойжуулах	64	13.1	76	15.6	81	18.5	57	16.1	17	15.7	295	15.7
Нүүдэл хийх	128	26.2	134	27.6	97	22.1	82	23.2	12	11.1	453	24.2
Сүү, цагаан идээ боловсруулах	16	3.3	27	5.6	20	4.6	11	3.1	9	8.3	83	4.4
Мал ноослох, самнах	50	10.2	53	10.9	43	9.8	34	9.6	13	12.0	193	10.3
Хадлан тэжээл бэлтгэх	140	28.7	117	24.1	111	25.3	95	26.8	35	32.4	498	26.6
Бусад	21	4.3	5	1.0	16	3.7	16	4.5	4	3.7	62	3.3
Хариултын тоо бүгд	488	100.0	486	100.0	438	100.0	354	100.0	108	100.0	1874	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	194		184		165		141		44		728	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	26.6		25.3		22.7		19.4		6.0		100.0	



**14. Малчин өрхийн зүгээс хот айлтайгаа гол төлөв хамтран хийдэг ажил**

Хариулт	Нэг хүнд ногдох малын тооны бүлэглэлт /богоор/										Бүгд	
	0-20		21-40		41-70		71-150		150-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Малаа хариулах	170	31.2	147	28.9	152	34.0	119	32.2	35	27.1	623	31.2
Сүү, цагаан идээ бэлтгэх	25	4.6	34	6.7	26	5.8	16	4.3	5	3.9	106	5.3
Төл бойжуулах	75	13.8	75	14.8	68	15.2	54	14.6	26	20.2	298	14.9
Хадлан тэжээл бэлтгэх	120	22.0	101	19.9	82	18.3	79	21.4	23	17.8	405	20.3
Түүхий эдээ зах зээлд худалдан борлуулах	41	7.5	45	8.9	26	5.8	22	5.9	10	7.8	144	7.2
Мал ноослох, мал нядлах	101	18.5	101	19.9	89	19.9	77	20.8	28	21.7	396	19.8
Бусад	13	2.4	5	1.0	4	0.9	3	0.8	2	1.6	27	1.4
Хариултын тоо бүгд	545	100.0	508	100.0	447	100.0	370	100.0	129	100.0	1999	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	209		189		172		144		48		762	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	27.4		24.8		22.6		18.9		6.3		100.0	

**15. Малчин өрхийн зүгээс хот айлтайгаа гол төлөв хамтран хийдэг ажил**

Хариулт	Ам бүлийн бүлэглэл						Бүгд	
	2-5		6-8		9-10			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Малаа хариулах	428	32.2	172	28.3	17	37.8	617	37.2
Сүү, цагаан идээ бэлтгэх	65	4.9	39	6.4	0	0.0	104	6.3
Төл бойжуулах	199	15.0	91	15.0	6	13.3		0.0
Хадлан тэжээл бэлтгэх	255	19.2	132	21.7	13	28.9	400	24.1
Түүхий эдээ зах зээлд худалдан борлуулах	97	7.3	42	6.9	4	8.9	143	8.6
Мал ноослох, мал нядлах	265	20.0	124	20.4	5	11.1	394	23.8
Бусад	19	1.4	7	1.2	0	0.0	0	0.0
Хариултын тоо бүгд	1328	100.0	607	100.0	45	100.0	1658	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	507		227		20		754	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	67.2		30.1		2.65		100	

**16. Малчин өрхийн зүгээс хот айлтайгаа гол төлөв хамтран хийдэг ажил**

Хариулт	Эдийн засгийн бүс										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Малаа хариулах	231	35.2	173	28.3	99	27.0	100	33.3	11	33.3	614	31.2
Сүү, цагаан идээ бэлтгэх	23	3.5	48	7.8	16	4.4	14	4.7	2	6.1	103	5.2
Төл бойжуулах	49	7.5	122	19.9	39	10.7	73	24.3	5	15.2	288	14.6
Хадлан тэжээл бэлтгэх	161	24.5	104	17.0	69	18.9	60	20.0	6	18.2	400	20.3
Түүхий эдээ зах зээлд худалдан борлуулах	60	9.1	36	5.9	36	9.8	8	2.7	3	9.1	143	7.3
Мал ноослох, мал нядлах	131	19.9	127	20.8	88	24.0	43	14.3	4	12.1	393	20.0
Бусад	2	0.3	2	0.3	19	5.2	2	0.7	2	6.1	27	1.4
Хариултын тоо бүгд	657	100.0	612	100.0	366	100.0	300	100.0	33	100.0	1968	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	248		207		161		115		19		750	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	33.1		27.6		21.5		15.3		2.5		100.0	

**17. Малчдын хот айлтайгаа хамтран хөрөнгө гаргах санал**  
/2 хүртэлх хариултыг сонгосон/

Хариулт	Эдийн засгийн бүс										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
МАН-н үйлдвэрлэлийн техник хэрэгсэл худалдан авах	62	15.2	72	18.8	53	17.1	41	20.8	5	16.1	233	17.5
Хашаа хороо барих, худаг гаргах	107	26.2	122	31.9	104	33.5	54	27.4	13	41.9	400	30.1
Бүтээгдэхүүнээ борлуулах, худалдаа хийх	75	18.4	58	15.2	47	15.2	36	18.3	1	3.2	217	16.3
Малын үүлдэр, угсааг сайжруулах	99	24.3	82	21.5	81	26.1	39	19.8	5	16.1	306	23.0
Хөрөнгөөр хамтрах сэтгэл зүйн бэлтгэл алга	61	15.0	48	12.6	22	7.1	24	12.2	5	16.1	160	12.0
Бусад	4	1.0	0	0.0	3	1.0	3	1.5	2	6.5	12	0.9
Хариултын тоо бүгд	408	100.0	382	100.0	310	100.0	197	100.0	31	100.0	1328	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	247		207		164		111		19		748	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	33.0		27.7		21.9		14.8		2.5		100.0	

**18. Малчдын хот айлтайгаа хамтран хөрөнгө гаргах санал**  
/2 хүртэлх хариултыг сонгосон/

Хариулт	Эдийн засгийн бүс								Дүн	
	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
МАН-н үйлдвэрлэлийн техник хэрэгсэл худалдан авах	9	17.6	28	21.7	159	17.8	36	15.9	232	17.9
Хашаа хороо барих, худаг гаргах	12	23.5	38	29.5	267	30.0	70	30.8	387	29.8
Бүтээгдэхүүнээ борлуулах, худалдаа хийх	7	13.7	16	12.4	154	17.3	38	16.7	215	16.6
Малын үүлдэр, угсааг сайжруулах	12	23.5	26	20.2	208	23.3	49	21.6	295	22.7
Хөрөнгөөр хамтрах сэтгэл зүйн бэлтгэл алга	11	21.6	20	15.5	96	10.8	29	12.8	156	12.0
Бусад	0	0.0	1	0.8	7	0.8	5	2.2	13	1.0
Хариултын тоо бүгд	51	100.0	129	100.0	891	100.0	227	100.0	1298	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	29		74		497		131		731	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	4.0		10.1		68.0		17.9		100.0	

**19. Малчдын хот айлтайгаа хамтран хөрөнгө гаргах санал**  
/2 хүргэлх хариултыг сонгосон/

Хариулт	Нэг хүнд ногдох малын тооны бүлэглэлт /богоор/										Бүгд	
	0-20		21-40		41-70		71-150		150-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
МАН-н үйлдвэрлэлийн техник хэрэгсэл худалдан авах	50	14.2	58	16.7	62	20.3	51	19.7	16	18.6	237	17.6
Хашаа хороо барих, худаг гаргах	112	31.9	111	31.9	98	32.0	64	24.7	22	25.6	407	30.1
Бүтээгдэхүүнээ борлуулах, худалдаа хийх	59	16.8	54	15.5	51	16.7	42	16.2	14	16.3	220	16.3
Малын үүлдэр угсааг сайжруулах	68	19.4	83	23.9	65	21.2	70	27.0	22	25.6	308	22.8
Хөрөнгөөр хамтрах сэтгэл зүйн бэлтгэл алга	56	16.0	39	11.2	26	8.5	31	12.0	12	14.0	164	12.1
Бусад	6	1.7	3	0.9	4	1.3	1	0.4	0	0.0	14	1.0
Хариултын тоо бүгд	351	100.0	348	100.0	306	100.0	259	100.0	86	100.0	1350	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	208		189		172		144		47		760	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	27.4		24.9		22.6		18.9		6.2		100.0	

**20. Мал аж ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаарх малчдын санал**

Хариулт	Ам бүлийн бүлэглэл						Бүгд	
	2-5		6-8		9-10			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хөлсөөр хүн ажиллуулах	70	8.7	37	10.2	3	10.0	110	9.5
Бусадтай хөдөлмөрөө хорших	397	49.1	174	47.8	12	40.0	583	50.1
Хүнд хүчир ажилд техник хэрэгсэл ашиглах	317	39.2	139	38.2	15	50.0	471	40.5
Бусад	24	3.0	14	3.8	0	0.0	0	0.0
Хариултын тоо бүгд	808	100.0	364	100.0	30.0	100.0	1164	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	480		214		20		714	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	67.2		30		2.8		100.0	

**21. Мал аж ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх талаарх малчдын санал**

Хариулт	Эдийн засгийн бүс										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хөлсөөр хүн ажиллуулах	33	9.1	38	9.9	24	9.3	10	5.9	1	6.3	106	8.9
Бусадтай хөдөлмөрөө хорших	185	51.1	183	47.7	127	49.0	84	49.4	2	12.5	581	48.8
Хүнд хүчир ажилд техник хэрэгсэл ашиглах	135	37.3	155	40.4	100	38.6	73	42.9	9	56.3	472	39.6
Бусад	9	2.5	8	2.1	8	3.1	3	1.8	4	25.0	32	2.7
Хариултын тоо бүгд	362	100.0	384	100.0	259	100.0	170	100.0	16	100.0	1191	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	237		201		158		101		14		711	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	33.3		28.3		22.2		14.2		2.0		100.0	

**22. Зах зээлд шилжсэнээс хойш мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг харгалзан аж ахуйгаа хэрхэн зохицуулан эрхэлж байна вэ?**

Хариулт	Эдийн засгийн бүс										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Сүргийн бүтэц, тоо толгойг өөрчилсөн	71	18.6	125	31.8	74	27.0	26	15.3	6	24.0	302	24.3
Үүлдэр, угсааг сайжруулж байгаа	67	17.6	81	20.6	77	28.1	41	24.1	9	36.0	275	22.1
Зах зээлд ойртон шилжиж байгаа	53	13.9	75	19.1	35	12.8	25	14.7	8	32.0	196	15.8
Бүтээгдэхүүн, түүхий эдээ борлуулах арга хэлбэрээ өөрчилсөн	85	22.3	73	18.6	37	13.5	22	12.9	0	0.0	217	17.5
Зохицуулж чадахгүй байгаа	96	25.2	37	9.4	50	18.2	49	28.8	1	4.0	233	18.7
Бусад	9	2.4	2	0.5	1	0.4	7	4.1	1	4.0	20	1.6
Хариултын тоо бүгд	381	100.0	393	100.0	274	100.0	170	100.0	25	100.0	1243	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	238		206		161		109		19		733	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	32.5		28.1		22.0		14.9		2.6		100.0	

**23. Зах зээлд шилжсэнээс хойш мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг харгалзан аж ахуйгаа хэрхэн зохицуулан эрхэлж байна вэ?**

Хариулт	Малчдын боловсролын түвшин								Дүн	
	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Сүргийн бүтэц, тоо толгойг өөрчилсөн	18	34.0	36	30.8	188	22.6	57	26.3	299	24.5
Үүлдэр, угсааг сайжруулж байгаа	16	30.2	36	30.8	179	21.5	43	19.8	274	22.5
Зах зээлд ойртон шилжиж байгаа	6	11.3	13	11.1	137	16.4	33	15.2	189	15.5
Бүтээгдэхүүн, түүхий эдээ борлуулах арга хэлбэрээ өөрчилсөн	7	13.2	16	13.7	147	17.6	36	16.6	206	16.9
Зохицуулж чадахгүй байгаа	4	7.5	12	10.3	171	20.5	45	20.7	232	19.0
Бусад	2	3.8	4	3.4	11	1.3	3	1.4	20	1.6
Хариултын тоо бүгд	53	100.0	117	100.0	833	100.0	217	100.0	1220	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	29		66		493		130		718	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	4.0		9.2		68.7		18.1		100.0	

**24. Зах зээлд шилжсэнээс хойш мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг харгалзан аж ахуйгаа хэрхэн зохицуулан эрхэлж байна вэ?**

Хариулт	Насаар										Бүгд	
	18-25		26-35		36-50		51-60		60-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Сүргийн бүтэц, тоо толгойг өөрчилсөн	44	38.3	178	34.2	256	33.2	95	33.1	93	37.3	666	34.3
Үүлдэр, угсааг сайжруулж байгаа	15	13.0	52	10.0	85	11.0	40	13.9	29	11.6	221	11.4
Зах зээлд ойртон шилжиж байгаа	15	13.0	90	17.3	134	17.4	53	18.5	43	17.3	335	17.2
Бүтээгдэхүүн, түүхий эдээ борлуулах арга хэлбэрээ өөрчилсөн	15	13.0	71	13.7	108	14.0	27	9.4	30	12.0	251	12.9
Зохицуулж чадахгүй байгаа	25	21.7	111	21.3	170	22.0	64	22.3	49	19.7	419	21.6
Бусад	1	0.9	18	3.5	19	2.5	8	2.8	5	2.0	51	2.6
Хариултын тоо бүгд	115	100.0	520	100.0	772	100.0	287	100.0	249	100.0	1943	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	49		202		301		109		95		756	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	6.5		26.7		39.8		14.4		12.6		100.0	

**25. Хүүхдийн ирээдүйн талаарх малчдын бодол**

Хариулт	Эдийн засгийн бүс										Бүгд	
	Хангай		Баруун		Төв		Зүүн		УБ			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Өөрийн ажлыг залгамжлах малчин болгох	44	10.4	26	6.5	67	21.8	26	14.0	4	16.0	167	12.5
Фермерийн аж ахуйн эзэн болгох	31	7.3	31	7.8	32	10.4	6	3.2	1	4.0	101	7.5
Хүүхдүүд өөрсдөө шийдэг	147	34.7	172	43.1	86	28.0	61	32.8	5	20.0	471	35.1
Сайн боловсрол эзэмшүүлэх	190	44.8	166	41.6	119	38.8	93	50.0	15	60.0	583	43.5
Бусад	12	2.8	4	1.0	3	1.0	0	0.0	0	0.0	19	1.4
Хариултын тоо бүгд	424	100.0	399	100.0	307	100.0	186	100.0	25	100.0	1341	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	245		209		165		110		19		748	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	32.8		27.9		22.1		14.7		2.5		100.0	

**26. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаа нь малчдын наснаас хамаарах нь**

Хариулт	Насаар										Бүгд	
	18-25		26-35		36-50		51-60		60-аас дээш			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Амьжиргааны маань гол эх үүсвэр учир	30	28.6	144	31.3	227	30.7	66	29.7	57	27.9	524	30.3
Миний хамгийн сайн хийж чаддаг ажил	16	15.2	72	15.7	107	14.5	35	15.8	31	15.2	261	15.1
Мал аж ахуй ашигтай учир	19	18.1	92	20.0	155	20.9	51	23.0	44	21.6	361	20.9
Байнга эрүүл агаарт ажилладаг учир	12	11.4	53	11.5	72	9.7	19	8.6	23	11.3	179	10.3
Өв залгамжлан эрхэлж ирсэн ажил	21	20.0	61	13.3	129	17.4	35	15.8	37	18.1	283	16.3
Ямар нэг дарамт шахалтанд байдаггүй учир	6	5.7	34	7.4	42	5.7	16	7.2	11	5.4	109	6.3
Бусад	1	1.0	4	0.9	8	1.1	0	0.0	1	0.5	14	0.8
Хариултын тоо бүгд	105	100.0	460	100.0	740	100.0	222	100.0	204	100.0	1731	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	40		161		259		80		71		611	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	6.5		26.4		42.4		13.1		11.6		100.0	

**27. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаадаа сэтгэл хангалуун байгаа нь малчдын боловсролоос хамаарах нь**

Хариулт	Малчдын боловсролын түвшин								Дүн	
	Дээд		Тусгай дунд		Дунд		Бага			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Амьжиргааны маань гол эх үүсвэр учир	17	29.3	57	32.9	360	31.0	81	26.8	515	38.6
Миний хамгийн сайн хийж чаддаг ажил	11	19.0	12	6.9	182	15.7	49	16.2	254	19.0
Мал аж ахуй ашигтай учир	17	29.3	47	27.2	238	20.5	57	18.9		0.0
Байнга эрүүл агаарт ажилладаг учир	3	5.2	11	6.4	118	10.2	39	12.9	171	12.8
Өв залгамжлан эрхэлж ирсэн ажил	7	12.1	29	16.8	184	15.9	54	17.9	274	20.5
Ямар нэг дарамт шахалтанд байдаггүй учир	3	5.2	16	9.2	65	5.6	22	7.3	106	7.9
Бусад	0	0.0	1	0.6	13	1.1	0	0.0	14	1.0
Хариултын тоо бүгд	58	100.0	173	100.0	1160	100.0	302	100.0	1334	100.0
Асуулгад оролцсон малчдын тоо	21		59		412		106		598	
Асуулгад оролцсон малчдын нийт тоонд эзлэх хувь	3.5		9.9		68.9		17.7		100.0	

**28. Төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын  
үйлчилгээний талаарх малчдын санаа бодол**

№	Үйлчилгээний төрөл	Үнэлгээ					
		Хангалттай		Дунд зэрэг		Хангалтгүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1.	Сумын ажил	160	20.7	412	53.3	201	26.0
2.	Сургуулийн үйл ажиллагаа	107	13.9	355	45.9	311	40.2
3.	Мал эмнэлгийн үйлчилгээ	177	22.9	411	53.2	185	23.9
4.	Хууль, хүчний байгууллагуудын үйлчилгээ	356	46.1	304	39.3	113	14.6
5.	Харилцаа, холбооны үйлчилгээ	152	19.7	315	40.8	306	39.5

**ХУУЛИЙН ЛАВЛАГААНЫ ХАВСРАЛТ****Хуулийн лавлагаа  
№ 1**

**Газрын тухай хууль:** Газар ашиглах, бэлчээрийг хэрхэн хуваарилан ашиглах, орон нутгийн засаг захиргааны байгууллага, иргэдийн эрх, үүргийн талаар Газрын тухай хуульд дараахь байдлаар тусгасан байна.

**4 дүгээр зүйл. Төрөөс газрын талаар баримтлах зарчим**

- 4.1. Төрөөс газрын талаар дараахь зарчмыг баримтална:
- 4.1.2. Газар төрийн хяналт, хамгаалалтад байх;
- 4.1.3. Газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;

**5 дугаар зүйл. Газар өмчлөгч**

- 5.1. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн.
- 5.2. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.

**6 дугаар зүйл. Газар эзэмшигч, ашиглагч**

- 6.2. Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана:
- 6.2.1. бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир, мараа бүхий газар;
- 6.2.2. хот, тосгон, бусад суурины нийтийн эдэлбэрийн газар;
- 6.2.3. зам, шугам сүлжээний газар;
- 6.2.4. ойн сан бүхий газар;
- 6.2.5. усны сан бүхий газар.

**7 дугаар зүйл. Газрын төлбөр**

- 7.1. Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зохих хууль тогтоомж, гэрээний дагуу газрын төлбөр төлнө.
- 7.2. Газрын төлбөрийн хэмжээ, түүнийг хөнгөлөх, чөлөөлөх, зарцуулах журмыг хуулиар тогтооно.

**8 дугаар зүйл. Хилийн цэс, газар усны нэр, газар усны нэрийн болон газрын сангийн зураг**

- 8.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр хилийн цэс, газар усны нэрийн болон газрын сангийн зурагтай байна.

**16 дугаар зүйл. Тусгай хэрэгцээний газар**

- 16.1.6. аймаг дундын отрын бэлчээр;
- 16.1.7. улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай.

**52 дугаар зүйл. Бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалах**

- 52.1. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална.



- 52.2. Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн Иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно.
- 52.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал маллагааны бүс нутгийг тогтоож болно.
- 52.5. Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх зорилгоор хашсан бэлчээрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад улирал харгалзахгүй тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно.
- 52.6. Энэ хуулийн 52.1-д заасан ерөнхий хуваарь, 52.4, 52.5-д заасан газрын хэмжээ болон уг газрыг ашиглуулахтай холбогдсон журмыг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.
- 52.10. Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

**Газрын төлбөрийн тухай хууль:** Энэ хуульд бэлчээрийн зориулалтаар ашиглаж буй газрын төлбөрийг хуульчлан тогтоож өгсөн байдаг .

**Хуулийн лавлагаа**  
№ 2

*6 дугаар зүйл. Газрын төлбөр тооцох үзүүлэлт, тэдгээрийг тодорхойлох*

1. Газрын төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжийг дараахь байдлаар тооцож тодорхойлно:
  - 1/ бэлчээрийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрийг уг бэлчээрийн нэгж талбайн суурь үнэлгээний хувиар хонин толгойд шилжүүлсэн малын толгой тутамд;
2. Бэлчээрийн газраас авах газрын төлбөрийг хонин толгойд шилжүүлсэн малын толгойн тоонд ногдуулахдаа өмнөх жилийн эцэст тоологдсон адууг 6,0, үхрийг 6,0, тэмээг 5,0, ямааг 0,9 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлж тооцно.

*8 дугаар зүйл. Газрын төлбөрөөс чөлөөлөх*

1. Дараахь төлбөр төлөгчийг дор дурдсан газрыг эзэмшиж, ашигласны төлбөрөөс чөлөөлнө:
  - 1/ малчин өрхийг бэлчээр, хадлангийн газрын;
  - б/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хөрсний бүтцийг сайжруулах, бэлчээрт шилжүүлэх зорилгоор олон наст болон буурцагт ургамал тариалсан талбайг эзэмшиж, ашигласны төлбөрөөс эхний 5 жил хүртэлх хугацаанд.

**Хуулийн лавлагаа  
№ 3**

*3.4. Хоршоо нь дараахь терлийн үйл ажиллагаа эрхэлж болно:  
/Энэ хэсэгт 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон  
ба энэ хэсгийн заалтуудын дугаарт өөрчлөлт орсон/*

- 3.4.1. түүхий эд боловсруулалтын;
- 3.4.2. үйлдвэрлэлийн;
- 3.4.3. хадгаламж, зээлийн;
- 3.4.4. борлуулалт, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн;
- 3.4.5. үйлчилгээний;
- 3.4.6. орон сууц барих зориулалтын;
- 3.4.7. эд хэрэглэгчдийн;
- 3.4.8. дүрэмд заасан үйл ажиллагаа

**Хуулийн лавлагаа  
№ 4**

*7 дугаар зүйл. Агнуурын амьтан агнах, барих зөвшөөрөл*

- 7.1. “Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл тус тус авч, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад гэрээ байгуулна.”
- 7.3. “Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль орчны улсын байцаагч гарал үүслийн тодорхойлолт /цаашид “тодорхойлолт” гэх/ олгоно.